



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,  
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



## Энэ дугаарт:

### Төрийн байгуулалтын хууль тогтоомж

**Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ЁС**  
(ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
гавьяат хуульч, доктор, профессор  
Б.ЧИМИД).....3-16

**ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН  
ХУУЛЬ ДАХЬ СПОРТЫН ЗОХИЦУУЛАЛТ**  
(“Аварга” дээд сургуулийн  
захирал, докторант Б.ВАТ-ЭРДЭНЭ).....17-21

**УКРАИНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ**  
(Үндсэн хуулийн цэцийн ажилтан  
Э.ЛХАГВАСҮРЭН)..... 22-24

### Пргэний хууль тогтоомж

**ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА ДАХЬ  
ТӨЛӨӨЛӨЛ** (Удирдлагын Академийн эрх зүйн  
тэнхимийн ахлах багш, докторант  
Ц.ОЮУНЧИМЭГ).....25-28

**ХӨРШИЙН ЭРХ**  
(МУИС-ийн магистрант Б.ГЭРЭЛ).....29-31

**ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ  
ХУГАЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**  
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний  
ажилтан П.БАТТОГТОХ).....32-37

**ГЭРЛЭЛТИЙН ХАРИЛЦААНААС ҮҮССЭН  
МАРГААНТАЙ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД  
АНХААРАХ АСУУДАЛ**  
(Нийслэлийн шүүхийн шүүгч  
Л.БЯМБАА).....38-40

**ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**  
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан  
Ч.НАРАНТУЯА) .....41-44

### Шүүх эрх мэдэл

**ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ**  
(ХЗҮТ-ийн захирал, Академич  
Ж.АМАРСАНАА).....45-52

**ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛЫН  
ҮНДЭСЛЭЛ БА ШҮҮХЭЭС ГАРАХ  
ДҮГНЭЛТ**  
(Улсын дээд шүүхийн шүүгч  
Д.ВАТСАЙХАН).....53-54

### Прокурорын хяналт

**МӨРДӨН ВАЙЦААЛТЫН АЖИЛЛАГААНД ТАВИХ  
ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ**  
(Нийслэлийн прокурорын газрын хяналтын  
прокурор Ё.САГСАЙ).....55-57

**ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ПРОКУРОРЫН ГҮЙЦЭТГЭХ  
ҮҮРЭГ**

(Улсын ерөнхий прокурорын орлогч,  
Төрийн хууль цаазын шадар зөвлөх  
В.ЦЭРЭНБАЛТАВ).....58-60

### Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

**ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН  
ХӨГЖИЛ, ХАНДЛАГА, МОНГОЛ УЛСЫН  
ОРОЛЦОО**

(Олон улсын эрүүгийн шүүхийг дэмжих  
үндэсний эвслийн зөвлөх, хууль зүйн доктор  
Ж.ЭНХСАЙХАН).....61-66

**ОЛОН УЛСЫН ШИНЖТЭЙ ИРГЭНИЙ  
ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭХ НЬ**  
(МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд  
профессор, хууль зүйн доктор  
Т.МЭНДСАЙХАН).....67-75

**КОНСУЛЫН ХИЙХ НОТАРИАТЫН ҮЙЛДЭЛ**  
(Гадаад хэргийн яамны мэргэжилтэн  
А.ТӨМӨР).....76-77

### Криминологи

**ЭРҮҮГИЙН БА ЭРҮҮГИЙН БАЙЦААН  
ШИЙТГЭХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**  
(ШУА-ийн Бага чуулганы гишүүн,  
хууль зүйн шинжлэх ухааны доктор  
профессор С.ЖАНЦАН).....78-84

**ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРАХ ОЮУН  
САНААНЫ ГЭМ ХОРЫН АСУУДАЛ**  
(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний  
ажилтан Ц.ОДГЭРЭЛ).....85-86

**ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХИЛ  
ДАМЖУУЛАН ХУДАЛДАХ АСУУДАЛ БА  
ХҮНИЙ ЭРХ**  
(Хүний эрх, хөгжил төвийн  
тэргүүн Г.УРАНЦООЖ).....87-90

### Эрх зүйн үйлчилгээ

**АРДЧИЛСАН НИЙГЭМД ӨМГӨӨЛЛИЙН  
ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**  
(Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах  
зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч  
В.ГАНВААТАР).....91-92

**НОТАРИАТЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ**  
(Монголын Нотариатчдын танхимын  
мэдээллийн албаны ажилтан  
П.ОТГОНЖАРГАЛ).....93-95

**ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН НЭР  
ТОМЪЕОНЫ ДАГАЛГА**  
(Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч  
Ю.ЭНХТҮВШИН).....96-101

## Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн бүрэлдэхүүн:

<b>Ц.Бат-Орших</b>	- Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн ерөнхий эрхлэгч
<b>А.Доржготов</b>	- Улсын дээд шүүхийн шүүгч
<b>Н.Ганбаяр</b>	- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
<b>Б.Цэрэнбалтав</b>	- Улсын ерөнхий прокурорын орлогч
<b>Ж.Амарсанаа</b>	- Хууль зүйн үндэсний төвийн захирал
<b>Ж.Энхнасан</b>	- Хууль зүйн үндэсний төвийн Захиргааны хэлтсийн дарга
<b>Т.Мэндсайхан</b>	- Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч
<b>Б.Балган</b>	- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга
<b>Э.Лхагвасүрэн</b>	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
<b>П.Цэцгээ</b>	- Улсын дээд шүүхийн Судалгааны төвийн захирал
<b>А.Энхжав</b>	- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга
<b>Ж.Сайнжаргал</b>	- Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга
<b>Б.Пүрэвням</b>	- Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч
<b>А.Оюунчимэг</b>	- Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч
<b>Д.Мандахбаяр</b>	- Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Дугаарыг эрхэлсэн: Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн **Б.Цэрэнбалтав**

## Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс



Хууль зүйн үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор **Б.ЧИМИД**

### §1. Учирлаж улируулан үзэх нь

Аливаад хэмжээ хязгаар байдаг. Түүнийг дутаах, хэтрүүлэх хоёрын аль нь ч ёс бус. Энэ нь эрх зүйт, ардчилсан төрт ёсыг төлөвшүүлэн хөгжүүлэхэд түүний эрхэм дээд хязгаар нь юусан билээ гэдэгт нэгэн адил хамаатай. Үүнтэй уялдан Монгол овог аймгууд төр улсад нэгдсэн цагаас түүхийн урт аяны турш төр, хууль ёсны талаар чухам юуг туйлын хязгаар болгож, дээдлэн шүтэж ирснийг ул суурьтай улируулан судлах нь чухал болов.

Сүүлийн жилүүдэд энэ талын судалгаа идэвхжсэнийг дэмжүүштэй. Зөвхөн хууль зүйн хүрээ дэх ойрмогхоны зарим баримтыг дурдахад шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж, доктор Х.Сэлэнгэ нар монголчуудын төр, хууль ёсны сэтгэлгээний түүхийг сөхөж тус тусдаа эрдмийн зохиолууд туурвижээ.<sup>1</sup> Бусад салбарын эрдэмтэд жишээлбэл, Чингисийн улс төрийн үзэл, тэнгэрийг шүтэх үзэл гэхчлэн сонирхолтой судалгаа хийх болжээ.<sup>2</sup>

Энэ мэтээс болон эх түүхээс дүгнэн үзвэл Монголчуудын төрт ёс, хууль зүйг дээдлэн шүтэх үзэл гурван их үеийг туулж уу? гэлтэй:

**Нэгд:** Монгол овогтнууд нэгдэж, тулгар төрийнхээ тулгын чулууг тавьснаас хойш 720-оод жил гагцхүү хаан төрд нэгдэн оршсоны учир “Мөнх тэнгэр”-ийг дээдлэн, “Тэнгэрийн хүү”<sup>3</sup> гэх нэрээр хаант ёсыг шүтэж өнгөрөөсөн ажгуу.

**Хоёрт:** 1924 онд Оройн дээд очир дарь Богд ламтан таалал төгссөний хойно хаант ёсыг халж, нэг намт Бүгд найрамдах ёсыг тогтоосон цагаас “нам засаг” нэрийн доор улс төрийн дээд удирдагчдийг шүтэн биширч, үг сургаалийг нь сүсэглэн дагасаар нэгэн

жарныг элээсэн билээ. Энэ үед төрийн дээр нам, намын дээр удирдагч, хуулийн дээр намын шийдвэр оршиж, ард түмнийг дагуулж байлаа. “Цаг цагаараа” гэдгийн учир энэ буюу.

**Гуравт:** 1980-аад оны дундуураас хууль дээдэлсэн ардчилсан ёсны жишгээр “өөрчлөлт шинэчлэлт” гэсэн лоозонгийн доор төр улсаа тэгшлэн засах хөдөлгөөнд нэгдэж, 1992 онд ардчилсан Үндсэн хуулийг батлан гаргаснаар Монгол түмний тэрхүү дээдлэн шүтэх ёсон үндсээрээ шинэчлэгдэж эхлэв.

Тэрхүү дээдлэх ёс нь удирдагчийг, засаг төр баригчдыг бус, харин төр хийгээд иргэний нийгмийн аль алиных нь оршин тогтнолын үндсийг бэхжүүлсэн гол хууль Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн шүтэх явдал юм. Яагаад ийм болсон тухайд олон учир шалтгаан буй.

### §2. Хууль дээдлэх ёсны учир

Эзэн Чингис “Бүх улсын доторхи өмчийг хувааж заргыг шийтгэж түүнийг хөх дэвтэрт бичигтүн. Надтай зөвлөж, Шигихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн

1. Н.Лүндэндорж “Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага”, УБ., 2002 он, Х.Сэлэнгэ “XVII зууны үеийн Монголын төр, эрх зүйн сэтгэлгээ” /докторын зэрэг горилсон диссертаци/ УБ., 2003 он

2. Ч.Жүгдэр “Монголын феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ” УБ., 1987 он, С.Дулам “Мөнх тэнгэрийн шүтлэг хийгээд...”, Улаан -Удэ, 1996 он, “Монголын төр ёс, сэтгэлгээний зарим асуудал”, МУИС-ийн багш нарын хамтын бүтээл. УБ., 2002 он зэрэг бусад.

3. Ч.Жүгдэр, “Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг”, УБ., 1990 он, 26 дахь тал

урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчил” гэж нэгэнтээ зарлиг буулгасан байдаг.<sup>1</sup>

Тэр зарлиг Их Монголыг (тулгар төрийг) төдийгүй эзэнт гүрнийг /империйг/ дагуулсан аж.<sup>2</sup> Үүнээс улбаалан хууль дагаж шийтгүүлэх ёсон нэвтэрч, түүхийн нугачаанд янз янзын өнгөөр хувьсан өөрчлөгдсөн гэх түүхэн баримтууд бий. Тэр бүхэн нь үзэл бодлын хувьд орчин цагийн хууль дээдлэх ёс зарчмын агуулгатай яг адилгүй, харин “Хуулийн аргаар дарангуйлах ёс”-ыг бататгасан шинжтэй байсныг тэмдэглэвэл зохино. Жишээлэхэд Манжийн төрөөс Монголд хүчээр дагуулсан “Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг” хэмээх олон хуулийг монголчуудад тулган “үг дуугүй” гүйцэтгүүлж агсныг хууль дээдлэх ёсон хэмээн үзвэл харалган санаа болох буй заа. “Бухын хүзүү бүдүүн боловч буулган дор, хүний хүзүү бүдүүн боловч хуулийн доор” гэсэн сэтгэлгээ үүнээс үүдэлтэй байж ч мэднэ.

Хууль дээдлэх үзэл XVIII зуунд хэмжээгүй эрхт хаант ёсны эсрэг тэмцлийн нэг лоозон болон гарч ирсэн байна. Тухайлбал засаг төрийн бүх эрх мэдлийг хаан гагцаар атгаж дур зоргын шийдвэрээр дарангуйлах ёсыг халж “засаг төрийг үндсэн хуулийн хязгаарлалтад оруулахын төлөө тэмцэл ХҮИ-ХҮИШ зуунд эх газрын орнуудад өрнөж улмаар ялсан түүхтэй.<sup>3</sup>

Тэр цагаас хууль тогтооход ард түмний шууд ба шууд бус

/төлөөлүүлэн/ оролцоо, үүний тулд бүх нийтийн санал асуулга /референдум/, сонгууль, парламент, эрх мэдэл хуваарилах зарчим мэтийг санаачлан бүтээжээ. Үүний үр дүнд хууль, зарлигийг нэгэн их тушаалтан зоргоор гаргаж хүссэнээрээ хүчлэн дагуулахыг хязгаарлан, засаг төрийн салаадын харилцан хяналт тэнцэл тогтоож, иргэний нийгмийн хяналт, хязгаарлалтад оруулж, түүнийгээ Үндсэн хууль /“конституция”/ гэх төрийн гол хуулиар бэхжүүлж авсан аж. Анхны үндсэн хууль нь 1787 онд АНУ-д гарч дараа нь бусад улс оронд дэлгэрчээ.

Ингэснээр хууль бол дур зоргын буюу нэг удирдагчийн санаа зоргийн бус харин төр нийгмийн хөгжлийн жам ёсыг тусган тухайн улсын Үндсэн хуульд нийцэн бодит чанарыг олж эхэлсэн байна. Хуулийн ийм утга чанар нь түүнийг дээдлэх ёсыг нийтээрээ баримтлахад хүргэжээ. Энэ нь угтаа дур зоргын хандлагыг хууль ёсоор халсан хэрэг болсон юм.

Францын эрдэмтэн Жан Брежел: “Эрх зүй бол байгаа хууль нь, харин хууль нь ямар байх ёстой вэ? гэдэг нь эрх зүйн гүн ухаан болно”<sup>4</sup> гэж өгүүлжээ. Үүнийг ургуулан бодоход зоргоор томъёолсон “болох, болохгүй”<sup>5</sup> хууль заалтыг бус, зүй зохисыг үзэж жам ёсыг тусган боловсруулсан бодит хуулийг дээдлэн хүндлэх нь гарцаагүй мэт. Үүнийг л хууль дээдлэх, хууль хүлээн зөвшөөрөгдөхгүйн үндэс хэмээн үзэж болно. Ийм чанарын

хуулийг төр, иргэний нийгмийн бүх байгууллага, албан тушаалтан, хувь хүн нийтээр хүндэтгэн сахиж, нийгмийн бүх хэм хэмжээнээс дээгүүр тавьж сахин биелүүлэх нөхцөл бүрэлдэнэ.

Хуулийн бодит чанарыг дүүрэн хангасан байх нь төр хийгээд түүний хууль тогтоогчдоос ард түмнийхээ өмнө хүлээсэн гол хариуцлага мөн. Түүний гол шалгуур, алсын /дээд/ хязгаар нь Үндсэн хууль мөн билээ. Үндсэн хууль жам ёсны байх, түүнийгээ бусад хууль баглан гаргах хийгээд гүйцэтгэлийг нь хангах, хэрэглэхдээ нарийн чанд баримтлах нь ардчилсан эрх зүйт төр байгаагийн гол илрэл мөн гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг билээ.

Ардчиллын үнэт зүйлүүдийг бэхжүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь “Хууль дээдлэх ёс”<sup>5</sup> мөн гэж заажээ. Хууль дээдлэх ёс нь өөрийн бодит агуулга, хэмжээ хязгаартай. Бидний ойлгож байгаагаар:

1. Эрх зүйн хэм хэмжээгээр тохируулбал зохих алив харилцааг элдэв дэд акт, заавраар биш хуулиар буюу хууль тогтоомжийн актаар зохицуулах;

2. Аливаа хууль нь Үндсэн хуульд, эрх зүйн бусад /дэд/ бүх акт нь хуульд нийцсэн буюу захирагдмал байх, хүний жам ёсны эрх, эрх чөлөө, хууль зүйн тэгш байдлыг хүлээн зөвшөөрч хуулиар бэхжүүлэн хангах;

3. Үндсэн хууль болон түүнд нийцсэн хууль

1. Монголын нууц товчоо. Дөрөв дэх хэвлэл. 1990 он, 203 дугаар зүйл.

2. Чингисийн зарлигуудыг нэгтгэсэн “Их засгийн хууль”-ийг Монгол хийгээд түүний харьяанд орсон улсуудын нутаг дэвсгэр даяар удтал дагаж мөрдөж байсан гэж түүхэнд өгүүлдэг. Энэ тухай “Монгол улсын түүх”, дэд боть. МУШУА-ийн түүхийн хүрээлэн, 2003 он. 102 дахь талд, “Эзэн Богд Чингис хааны Их засаг хууль, МУИС, 1995 он. 14 дахь тал.

3. Общее административное право. Мюкхен Брюль, серия. Том-4. 2000 г., стр.26-29.

4. Жан Брежел “Общая теория права” /перевод с французского языка/, 2001 г.

5. “Монгол Улсын Үндсэн хууль”, 1992 он, 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

тогтоомжийн аливаа актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр хүчин төгөлдөр дагаж мөрдөх;

4. Парламент нь Үндсэн хуулиа, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага нь Үндсэн хууль ба бусад хуулийг гуйвалтгүй биелүүлэх, зөв хэрэглэх;

5. Хууль зөрчсөн гэм буруутай хэн боловч /олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, Монгол Улсын олон улсын гэрээгээр дипломат халдашгүй дархлаа, эрх ямба эдлэхээс бусад/ хууль зүйн зохих хариуцлага хүлээх;

6. Хүний эрх, эрх чөлөө нь шударга, алагчлалгүй шүүхээр хамгаалагдсан байх;

7. Үндсэн хууль зөрчсөнийг нотолсон Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, ердийн хууль зөрчсөнийг тогтоосон бусад шүүхийн шийдвэр хүчин төгөлдөрт тооцсон өдрөөс эхлэн холбогдох бүх этгээдэд заавал биелүүлэх хүчинтэй байх, хууль зүйн үндэстэй бол түүнийг албадан биелүүлэх;

8. Шударга ёс, зүй ёсны хийгээд нийгмийн бусад хэм хэмжээ Үндсэн хуулийн хүрээнд багтсан байх зэрэг гол шинж бүрдсэн байвал хууль дээдлэх ёс хэрэгжиж байгаа нь тэр.

Түүнийг ойролцоо бусад ойлголт, зарчмаас ялгах нь бас чухал. “Хууль дээдлэх”, “хууль сахин биелүүлэх”, “хууль ёсны байх” /“Верховенство закона”, “соблюдение закона”, “законность”/ гэсэн орос үг хэллэгээр дамжиж Монголын эрх зүйд хэдий нь нэвтэрсэн ойлголт зарчмууд бий. МУИС-ийн ХЗС-ийн багш докторант

Х.Тэмүүжин эдгээр зарчмыг “... манай зарим хуульч, судлаачид ... давхардсан буюу нэг утгатай үзэгдэл тул өөр өөр хэлбэрээр томъёолох шаардлагагүй гэж үзэх явдал байгааг” тэмдэглээд “... хоорондох ялгаа заагийг нь гаргахыг хичээнгүйлэн зорьж” хүлээн зөвшөөрөхүйц оновчтой санаа, дүгнэлтүүд дэвшүүлэн илэрхийлжээ.<sup>1</sup>

Миний бодоход /Би ч гэсэн “самуураад” хаа нэгэнтээ хольж хутгасан байж магадгүй л дээ?/ эдгээр ойлголт “хууль” гэсэн язгуур нэгтэйгээрээ “төрөлхийн” холбоотой ч гэсэн тус тусын агуулга, “үүрэгтэй” бөгөөд түүнийг нь ялгахгүй бол “хууль дээдлэх” ёсны онцгой чанарыг олж харгахгүйд хүрэх бус уу. Утгачилбал: “Хууль ёсны байх” гэдэг нь хууль ба түүнд үндэслэсэн эрх зүйн бусад алив актыг холбогдох бүх этгээд нэг мөр ойлгож, биелүүлэх, хэрэглэх зарчмыг; “Хууль сахин биелүүлэх” гэж бүх нийтээс “хууль хэрэгжүүлэх” үйл ажиллагааны нийтээр хэрэглэдэг нэг гол шаардлага арга замыг илэрхийлдэг. Тэгвэл “хууль дээдлэх” нь тэр бүхнээс өндөр дээд түвшний үнэлэмж түгээмэл зарчим мөн. Энэ нь энгийн хэлбэл элдэв актыг үл оролцуулан зөвхөн хуулийг эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээнээс дээгүүрт тавьж ухамсарласан дотоод итгэлийн үндсэн дээр нийтээр, юуны өмнө засаг төр өөрөө сахин биелүүлэх, хэрэглэх, хамгаалах ёсыг хэлж, ойлгож байна. Төрийн үйл ажиллагааны Үндсэн хуулийн зарчим болгосны учир шалтгаан энэ буюу.

Хууль дээдлэх үзэл эцсийн дүнд эрх зүйн ухамсар, түүгээр дэмжигдсэн ёс суртахууны үнэлэмж мөн гэвэл ойлгоход илүү дөхөмжтэй болов уу. Мэдээж дээдлэх гэдэг нь үзэгдэл өөрөө тухайн субъект өөрийн болон бусдын оршихуй, мөн чанарт ашиг тустай хэмээн уг зүйлд итгэн үнэлж, түүний хүчин чадалд бишрэх, хайрлах, хүндэтгэх байдлаар хандах төдийгүй энэ хандлага нь уг хүний дотоодод өөрийн хүлээн зөвшөөрсөн уг зүйлтэй зөрчилдөхөөс эмзэх сэтгэцээр дэмжигдсэн ёс суртахуун, сэтгэл зүйн нөлөөллийг агуулсан байдаг.<sup>2</sup> гэснийг дэмжиж болох. Энэ бүх шаардлагын манлайд нь Үндсэн хууль “заларч”, түүнийг “мэдэгтүн”, “сахигтун” гэсэн уриа буюу зарлиглал “цууриатаж” байгаа шүү дээ. Иймд хууль дээдлэхэд тавигдах бүх шаардлагуудыг ойлгож, тууштай хангаж амьдруулахад Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс хууль зүйн хийгээд үзэл баримтлалын гол суурь болно. Монгол Улсын өмнөх болон өдгөөгийн Ерөнхийлөгч “Сайн төрийн толгойд хууль, муу төрийн толгойд удирдагч” /Н.Багабанди/; “Үндсэн хууль бол ... Монгол төрийн үзэл баримтлалын тулгуур баримт бичиг мөн”<sup>3</sup> /П.Очирбат/ гэж хэлснийг онч үг хэмээн ишлэх нь зүйн хэрэг болов уу.

### §3. Үндсэн хуулиа дээдлэн шүтэхийн учир

Хууль дээдлэх зарчмын суурь нь Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс гэж бий. Энэ бол ямар нэгэн мухар сүсгийн тухай таамаглаж байгаа хэрэг

1. Х.Тэмүүжин. Jus frast буюу Ёст үг. УБ., 2004 он, 17-20 дахь тал

2. Х.Тэмүүжин. Jus frast буюу Ёст үг. УБ., 2004 он, 19 дэх тал

3. Н.Багабанди “Би Монгол төрийн толгойд хууль байхыг хүсч байна”, “Өдрийн сонин”, 2004-01-02 №001/1504/; П.Очирбат “БНМАУ-ын Ардын Их Хурлын 1992-10-07 ны өдрийн II хуралдаанд тавьсан илтгэл Алдаж болохгүй агшин” УБ., 1997. 254 дэх тал.

биш билээ. Харин оршин буй улс нийгэмд бодитойгоор үйлчилж буй эрхэм дээд үзэл, зарчмын тухай асуудал юм. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх нь хууль дээдлэх ёсны суурь хэмээн тооцоход наанадаж хоёр гол шалгуур буюу учир шалтгаан байна.

Юуны өмнө Монголын нийгмийн улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл, оюуны үндсүүдийн шинэчлэгдсэн нь, нөгөөтэйгүүр уул шинэтгэлийг дагалдан төр нийгмийн оршин, бэхжихэд үндсэн хуулийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол эрс өөрчлөгдөж, өсөн нэмэгдсэнээс шалтгаалав.

Монголын нийгмийн байгууллын үндсүүд шинэчлэгдсэн тухайлб гэвэл:

- Нийгэм бүхэлдээ нэг төрлийн өмч, эдийн засгийн тогтолцоо, нийгэмшлийн нэгэн төрлийн бүтцэд үндэслэж байснаас өмч, аж ахуйн олон янзын төрөл хэлбэр, хэвшил, өөр өөрийн сонирхол бүхий бүх анги давхраанд суурилсан шинэ тогтолцоонд шилжиж орсон. Өөрөөр хэлбэл Монголын нийгмийн байгуулалтын эдийн засаг, нийгэмшлийн суурь үндсээрээ шинэчлэгдэж эхэлсэн;

- Нэг нам дангаар ноёрхсон тоталитари дэглэмтэй улс төрийн тогтолцооноос хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хамгаалсан, парламентат ёсны харилцаанд үндэслэсэн, ардчилсан дэглэмтэй, олон намт улс төрийн тогтолцоонд шилжсэн;

- Нийтийн засаг буюу эрх мэдэл, удирдах, удирдуулах /үйлчлэх, үйлчлүүлэх/ ёсны үүднээс нийгмийг засаг төр, иргэний нийгэм гэж хуваан үзэх болсон;

- Засаг төр буюу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн тогтолцоо нь ард түмнээс үүсч гараад "тэдний

сайн дурын нэгдэл, зохион байгуулалт" нь болох иргэний нийгэмд үйлчлэх болсон. Өөрөөр хэлбэл захиргаадаг тогтолцооноос тэдэнд үйлчилдэг ардчилсан тогтолцоонд шилжсэн;

- Ард түмэн нэг үзэл суртлын хүлээнзэс нийтээр хөндийрч ургальч үзлийг нийгмийн оюун санааны үндэс болгосон зэргийг хэлж болно. Шинэ Үндсэн хуулиар Монгол Улс оршин хөгжих жам ёсны үндсийг зангидаж бэхжүүлсэнд түүнийг нийтээр дээдлэн шүтэх ёс төлөвших болсны нэгэн шалтгаан оршино.

Дээдлэн шүтэхийн зайлшгүйд хүргэсэн хоёр дахь шалтгаан гэвэл Үндсэн хуулийн нийгэм, эрх зүйн чиг үүрэг юм. Үүнд:

Нэгдүгээрт: Үндсэн хууль нийгмийн улс төрийн харилцааны үндсийг бэхжүүлж, хамгаална. Хураангуйлбал төр, ард түмний бүрэн эрхт байдал, нийгэмд хүний эзлэх байрыг тодорхойлж төр ба нам, улс төр-нийгмийн үндсэн бүлэглэлүүд засгийн салаадын хоорондын харилцааны үндсэн зарчмууд, төрийн байгуулал, байгууламж, нутгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэн хамгаалах явдал энэ чиг үүрэгт хамаарна.

Нийгмийн улс төрийн хүчнүүдийн харьцааг оновчтой тодорхойлж чадваас төр нь бодит үндсэн хууль болно гэсэн германы социалист Ф. Лассалийн номлол бий.

Хоёрдугаарт: Үндсэн хуулийн эдийн засгийн чиг үүрэг нь Монголын нийгмийн эдийн засгийн харилцааны үндсийг хуульчлан бэхжүүлж, хамгаалахад оршино:

- уг харилцааны суурь болсон өмчийн бүх төрөл, хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хамгаалах;

- аж ахуйн /эдийн засгийн/ олон хэвшилд тулгуурласан зах зээлийн харилцааг бэхжүүлэх;

- эдийн засагт төрийн оролцоог хязгаарлан чиглэлийг нь тогтоох;

- төрийн өмч, байгаль түүний байлгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааны үндсийг тодорхойлон зохицуулах нь энэхүү чиг үүргийн гол агуулга болно. Эдгээр үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулийн 5-7 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 2, 3, 4 болон 25 дугаар зүйлийн 7, 8, 38 дугаар зүйлийн 2-4 дэх хэсэгт тусгалаа олсон байна.

Гуравдугаарт: Үндсэн хуулийн нийгэмшлийн чиг үүрэг нэн олон талтай юм. Түүний агуулга нь ард түмний засаг төрийн үндэс байх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ хүний нийгэм соёлын эрх, эрх чөлөөг бататгаж, түүнийг хангах баталгаа, нийтийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын талаархи засаг төрийн байгууллагын үндсэн үүргийг тогтоон бэхжүүлэхэд оршино. Энэ нь үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1.7, 16 дугаар зүйлийн 7, 4-8, 11, 15, 25 дугаар зүйлийн 7, 38 дугаар зүйлийн 2-ын 2, 7, 55 дугаар зүйлийн 1, 62 дугаар зүйлийн 1 зэрэг бусад зүйлд тусгалаа олж томъёологдсон байгаа. Гэхдээ энэ бүхэн зөвхөн үг үсгэндээ биш хуулийн үзэл баримтлалд агуулагдана.

Дөрөвдүгээрт: Үндсэн хуулийн "хууль зүйн чиг үүрэг" гэж чихэнд бараг хоногшоогүй томъёолол байдаг. "Үндсэн хууль бол хууль биш" гэж манай зарим улс төрч маргадгийг үзвэл энэ нь шинжлэх ухааны зохих тайлбар нотолгоо шаардаж буй бололтой.

Нэрт шог зохиолч, АИХ-ын депутат агсан Ч.Барамсай

эрдмийн зэрэг горилсон зохиолын хэлбэрдлийг шоглон бичихдээ “Үхэр” диссертацийн дүгнэлт болгон “Үхэр бол амьтан мөн, амьтан амьтандаа бүр амьд амьтан мөн” гэж бичсэн шиг “Үндсэн хууль бол хууль мөн, хууль хуульдаа бүр гол хууль мөн” гэж болно. АНУ-ын Үндсэн хууль бол хуулийн сонгодог хэлбэр мөн<sup>1</sup> гэж Францын харьцуулсан эрх зүйн нэрд гарсан эрдэмтэн агсан Рене Давидын хэлснийг иш татахад илүүдэхгүй боллолтой.

Чухамхүү нийгмийн бүх харилцааны үндсүүдийг бэхжүүлэн оршин хөгжих суурийг хамгаалдаг тэрхүү онцгой чанарт нь түүний хууль зүйн чиг үүрэг төвлөрдөг бөгөөд энэ нь дараах байдлаар илэрнэ. Үндсэн хууль нь:

· Төрийн хууль тогтоомжийн бүх акт /үндсэн хуульчилсан болон ердийн материаллаг хийгээд процессын хууль, УИХ-ын тогтоол, хөтөлбөр зэрэг/;

· Хуулийн бүх дэд акт /Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, сайд, агентлагийн дарга, бүх шатны засаг дарга нарын тушаал, захирамж/;

· Монгол Улс үндсэн хуульдаа харчилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй гэж Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4-т заасан ёсоор Монгол Улсын олон улсын бүх гэрээ;

· Нутгийн өөрөө удирдах байгууллага, ТББ, хувийн хэвшлийн үйлдвэр, албан газрын захиргааны бүх акт.

Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэний өдөр тутмын үйл ажиллагаа тус тус Үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл энэ

бүхний хууль зүйн үндэс суурь нь Үндсэн хууль бөгөөд “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино. “Мэдэгтүн, сахигтүн”<sup>2</sup> гэж “Үндсэн хууль”-ийн сүүлчийн зүйлд тунхаглан зааснаас асуудал тодорхой билээ. Үндсэн хууль бол хууль зүйн дээд хүчин чадалтай акт гэдэг нь үүнд холбоотой.

Тавдугаарт: Бас нэгэн ээдрээтэй, маргаантай боловч бодитоор илэрч буй чиг үүрэг бий. Энэ бол төрийн үзэл суртал буюу ард түмний туйлын “хүслэн” /идеал/ гэж байх уу, үгүй юу? гэдэгтэй холбоотой. “Идеалогия” гэдгийг монголчууд үзэл суртал, “Идеал” гэдгийг туйлын хүслэн гэж хэлж, ойлгож, иржээ. Энэ хос ойлголтыг тайлбарлахыг азнаад нэг намын буюу коммунист үзэл суртлын ноёрхолоос татгалзан /олон/ урьгалж үзлийг хүлээн зөвшөөрсөн нөхцөлд Монголын ард түмнийг нэгэн зүгт нийтээр тэмүүлэхэд хөтлөн дагуулах үзэл байх ёстой юу? Эцсийн дүнд биднийг урагшлахад уриалан дуудах туйлын хүслэн /ideal/ байна уу гэсэн холбоотой талаас нь асуудлыг авч үзье.

Улс төрийн плюрализм буюу урьгалж үзэл гэдэг бол хэдийгээр хүмүүс, нийгэмшлийн бүлгүүд өөрсдийн итгэл үнэмшилтэй байж, түүнийгээ хамгаалахыг хүлээн зөвшөөрөх нь ардчилсан ёсны нэгэн чухал шинж мөн. Гэвч иргэний нийгмийг бүрдүүлж буй бүхэл бүтэн ард түмнийг нэгтгэгч хүчин зүйл болсон туйлын хүслэн байхгүй бол тэр ард түмэн зүг бүр зүтгэсэн

хэсэг бусад бүлэглэл болон хувирах магадлал бий. Монголын ард түмэн бол улс орныхоо өнө удаан оршин тогтнолын төлөө гэх сэтгэл оюунд нэгдсэн, бүрэн эрхт тусгаар улсын нийгэмшлийн үндэс бөгөөд түүхэн ёсоор тогтсон хэл, соёлын нийтлэг, улс төр, эдийн засгийн нийтлэг язгуур ашиг сонирхол бүхий биеэ даасан үндэстэн, иргэний нийгмийн цогц мөн. Энэ хувьдаа нэгдмэл нэг туйлын хүслэнтэй байдаг.

#### §4. Үндсэн хуульд ард түмний туйлын хүслэнг тодорхойлсон нь

Грек гаралтай “IDEAL” гэдэг үг монголоор “хүслэн” “туйлын зорилго”, “өв тэгш зүйл”, “туйл” гэсэнтэй дүйх аж. Энэ үг алив хүн, хамт олон, нийгмийн амьдрал, тэмцлийн эрхэм дээд зорилго, нийтээр сүсэглэн тэмүүлэх чин эрмэлзэл гэх утгыг илэрхийлнэ. Гадаад хэлний тайлбар тольд “төгс байдал”, үйл ажиллагаанд тэмүүлэх “дээд зорилго” гэх утгаар тайлжээ. Энэ сүүлчийн утгаар үзвэл<sup>3</sup> Монголын ард түмний туйлын хүслэн буюу эрхэм дээд зорилго тэмүүлэл нь чухам юу юм бэ? Үүнийг хэн, хаанаас юугаар, хэрхэн тодорхойлдог вэ? гэдэг бодит шалгууртай ойлголт юм. Өмнөх дэглэмийн үед нэг нам ноёрхсоны учир Монгол түмний хэтийн зорилгыг тодорхойлж байв. Тэр нь “коммунизмын гэрэлт ирээдүй” билээ. Гэтэл өдгөө өөр өөрийн үзэл бодолтой, /либерал, радикал, консерватив, баруун, зүүн, социалист, коммунист, төв үзэл гэх зэрэг/

1. Рене Давид Камилла Жозеффе-сплюзи. Основные правовые системы современности “Международные отношения. М., 1990 г., с. 397, 399

2. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он. 70 дугаар зүйлийн 1.2.,

3. Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. “Орос-Монгол толь”, 1982 он, 182 дугаар талд



улс төрийн өвөрмөц сонирхол бүхий олон нам байгаа үед ганц нам ард түмнийг бүхэлд нь төлөөлөн хүн амыг нийтэд нь алсын алсад дагуулах боломжгүй юм. Түүнчлэн хүн бүр шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй, өөр өөр шашин оршин буй учир нэг нь бүгдийг дагуулах чадваргүй. Эл нөхцөлд Монголын ард түмний язгуур ашиг сонирхлыг чухамхүү төрийн гол баримт бичгээр хуульчлан томъёолж, дагуулахаас өөр зам одоогоор нээгдээгүй гэж хэлж болно. Аль нэг ердийн хуулиар ч үүнийг орлуулах боломжгүй билээ. Иймээс өгүүлэн буй туйлын хүслэнг тодорхойлон хуульчлах үүргийг чухамхүү Үндсэн хууль гүйцэтгэж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд манай ард түмний туйлын хүслэнг дараах томъёоллоор илэрхийлэн бататгажээ. Үүнд:

“Монголын ард түмэн бид:

-Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,

-Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,

-Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,

-Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.” гэсэн байдаг.

Ард түмний нэрийн доор тунхагласан эдгээр үндэслэл өөр өөрийн өргөн агуулга, гүн утга бүхий дээд эрмэлзэл тул тус, тусын нухацтай тайлбар шаардана. Тэдгээрээс хүмүүс

олон янзаар төсөөлөөд байна уу даа гэж ажиглагддаг иргэний нийгмийн талаархи заалтын учрыг цухас дурдъя.

“Иргэний ардчилсан нийгэм” /ИАН/ гэдгийн тухайд бол Үндсэн хуульд түүнийг “байгуулах” тухай биш, “төлөвшүүлэн хөгжүүлэх”-ийн зорилго болгон тунхагласан байна. Гэтэл энэ үндэслэлд “социализм байгуулна” гэдгийн урьдын загварчилсан сэтгэлгээгээр хандаж Монгол оронд өдгөө ИАН байгуулж байгаа мэтээр ярих, бичих улиг болжээ.

Иргэний нийгэм бол амьдралын гүнд байсаар ирсэн төр, нийгмийн зөв оршихуйн үндэс аж. Гэтэл өмнөх үед түүнийг жинхэнэ утгаар нь тухайлбал, засаг төрийг төрүүлэн гаргаад хянаж нөлөөлөх үндсэн дээр өөрсөдөө үйлчлүүлдэг тийм ардчилсан тогтолцоо бүхий нийгэмшлийн зохион байгуулалт болгож, байр суурийг нь эзлүүлэн хөгжүүлэх ойлголт, зарчим байсангүй. Зөвхөн засаг төр л ард түмнийг удирдан захирч төр нийгмийн төлөө ажиллуулдаг гэсэн үзэл зарчмаар иргэний нийгэмд хандаж ирсэн байна. Энэ хандлагаас ангижран иргэний нийгэм нь засаг төрийн байгууллагын эх үүсвэр байж, үйл ажиллагаанд хяналт тавьж, түүнийг өөрсөдөө үйлчилдэг “зарц” болгож чадсан тийм ардчилсан цогц тогтолцоо болгон төлөвшүүлж бэхжүүлэхийг л “цогцлуулан хөгжүүлэх” гэсэн томъёоллоор ард түмэн эрхэм зорилгоо болгожээ. “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн үндэслэл бол зөвхөн сонгох ёсыг хэлж байгаа нь бус, засаг төр ИАН-д үйлчилнэ гэсэн зарчмыг тусган илэрхийлжээ гэж болно.

ИАН ба засаг төр хоёрын хоорондын харилцааны язгуур зарчмын үүднээс авч үзвэл:

- Парламент /гишүүд/ нь ард түмнээс бүрэн эрх /мандат/ авч гараад тэднийг эргэн захирч давамгайлж байх бус, харин төрийн мэргэшсэн аппаратын болзошгүй дарамтаас нийт иргэний нийтлэг ашиг сонирхлыг хууль журамд тусган хамгаалж хянаж байх;

- Гүйцэтгэх /захиргааны/ төв, орон нутаг, салбар хүрээний байгууллага, аппарат нь хуулийг биелүүлэн, төрөөс үзүүлэх нийтийн үйлчилгээ, нийгмийн /халамж, хангамж/ хамгааллыг зохих ёсоор зохион байгуулж хүн амд үйлчлэх;

- Шүүх эрх мэдлийн байгууллагууд нь шударга ёс, эрх зүйн үндсэн дээр гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг засаг төрийн дур зорын ажиллагаа, “хуульд дуулгаваргүй этгээд”-ийн халдлагаас хамгаалах гэхчилэн иргэний нийгэмдээ хүчин зүтгэх жам ёсны үүрэгтэй. Үүнийг ардчилсан Үндсэн хуульд байгуулалт иш үндэс болгоно. Засаг захиргааны түшмэл, мэргэжлийн хянан шалгагч, цагдаа, шүүгч хэн боловч “би хүмүүсийг захирч байна” гэж ойлгож ихэмсэг, дээрэлхүү, “цэвдэг хүйтэн” хандах биш, харин “тэдэнд үйлчилж, тусалж байна” гэж өгөөмрөөр сэтгэж дадахыг, өөрөөр хэлбэл урьдын захиргаадлын арга барилаа үндсээр нь эргүүлэн энэрэнгүйжүүлэх буюу хүмүүнлэгжүүлэх нь төрийн албаны ёс зүй нийгмийн сэтгэл зүйн шинэтгэл болох ёстой. Үүнд бас “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм” гэсний уг чанар оршино. Мэдээж хүн

“хязгааргүй эрх чөлөөтэй” гэж андуурч “балмадлан явах” бус, харин Үндсэн хуулиар бататгасан:

1) Эрх, эрх чөлөөгөө “... үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг...” гажуудуулахгүйгээр эдэлж;

2) “... шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн...” нийгэмд хүлээсэн үндсэн хийгээд журамт үүргээ ёсчлон биелүүлэх<sup>1</sup> нь мөн л үндсэн хууль дээдлэн шүтэх ёс биелж байгаа нь болно.

Иргэн хүний үүргийн тухай дурдсан үндэслэл нь:

1. Хүн бүр нийгмийн өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй өв тэгш хөгжлийг хангана”

“2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх чөлөөг эрх зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана”<sup>2</sup> гэсэн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын заалтад ч нийцэж байгаа билээ.

### §5. Үндсэн хуулийг дээдлэн сахих үзлийг төлөвшүүлэн бэхжүүлэх алхам

Ёс, зарчим, үзэл баримтлалыг тунхаглаж, лоозондох нь хагас алхам. Харин гүйцэд алхах буюу бодит үр дүнд хүргэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргахыг шаардана.

Шинэ Үндсэн хуулийг батлан дагаж мөрдсөн 10 гаруйхан жилийн хугацаанд Монгол орон улс төрийн ардчилсан тогтолцоо зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн нь үнэнхүү том амжилт мөн. Үүгээрээ бахархаж болно, гэлээ ч сэтгэл цадаж, санаа сагаж болохгүй.

Бид чинь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, оюуны “өөрчлөлт шинэчлэлт”-ийг эхэлж, гүнзгийрүүлэхдээ бүхнийг нэгэн их татах хүчинд зангидаж, тухайлбал “Үндсэн хуулийн шинэтгэл” гэсэн дээдлэх ёс зарчимд нийт ард түмний хүч анхаарлыг төвлөрүүлж зангидах замаар хийж гүйцэтгэсэн бил үү, эсвэл хэсэг бусад шийдвэр, төслөөр амжуулав уу гэвэл байдал арай өөрөөр ойлгогдож байгааг нуух юун.

Тоймолж үзэхэд хууль тогтоохоос бусад хүрээнд төрийн гол хуулийнхаа заалт, үзэл баримтлал, түүгээр тунхагласан ард түмний туйлын хүслэнг өргөн олонд тайлбарлан таниулах, төрийн болон орон нутгийн албан хаагчдад зааж сургах талаар тухайлж хөтөлбөржүүлэн нэгдмэл дорвитой ажил зохиосонгүй юу даа гэж үзэхээр байна.

Үндсэн хууль баталсны дараа түүнийг хэрэгжүүлж эхлэх нэн анхны арга хэмжээг 1992 онд халаагаа өгөх нь тодорхой болоод байсан. Улсын бага хурал, Засгийн газар төлөвлөн баталж зарим эхлэл тавьсан. Түүнээс уламжлан:

- Хуучин хуулиудыг үндсэнд нь шинэчилсэн;

- Нийгмийн шинэ харилцааг тусгасан хууль олныг гаргасан;

- “Өөрчлөлт шинэчлэлт”-ийн зарим салбар үзэл баримтлал, цөөнгүй хөтөлбөр гаргасан;

- Үндсэн хуулийг 3 удаа хэвлэн нийтэлсэн;

- Судлаач багш нар зарим ном зохиол санаачлан нийтлүүлсэн;

- Хуульч бэлтгэхдээ зааж зөвлөж судлуулж ирсэн;

- Жил бүр Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэх үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр ганц хоёр өдөр “сурталчилж” заримдаа хурал цуглаан зохиож дадсан;

- Төв музейд 2001 оны 1 сард Үндсэн хуулийн булан нээж үзмэр дэлгэсэн /саяхан буулгачихсан харагдсан/ гэх зэргээр түүгээд байвал нэрлэх ажил нэлээдгүй.

Гэсэн хэдий ч өнгөрсөн 12 жилд Үндсэн хуулиа сурталчилж түүнд сургах хэвшүүлэх ажлыг баг, хороо, айл өрх хүртэлх улсын хэмжээний өргөн цартай, улирал жил дамнанас “урт” хугацаатай, шахаж шаардаж, шалган дүгнэдэг эзэн шалгууртай тогтмол ажил хараахан болгосонгүй алгуурлажээ гэхэд хилсдэхгүй.

Улс төр, эдийн засаг, нийгэмшлийн хүрээнд “Үндсэн хуулийн шинэтгэл” гэх хөтөлбөр бүхий мэргэжлийн удирдлага зохицуулалттай нэгдсэн арга хэмжээ үгүйлэгдэж билээ. Үүнийг харгалзан үзээд Улсын Ерөнхийлөгчөөс 1996 онд дэвшүүлсэн санал болон 1997 онд өргөн мэдүүлсэн төслийг УИХ анхаарч хүлээн аваагүйгээр үл барам харин ч сүрхий үгүйсгээд хэсэг бусад арга хэмжээгээр орлуулсан нь

1. “Монгол Улсын Үндсэн хууль”, 1992 он, арванесдүгээр зүйл

2. “Хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл”, НҮБ, ЮНЕСКО, УВ., 1993 он, 8 дахь тал

хоорондоо зөрчилдөхөд хүрсэн үзэгдэнэ.

Төрийн ба нутгийн байгууллага, албан хаагчдыг Үндсэн хуулиар хангах, тэднийг энэ талаар зохих хэмжээний мэдлэгтэй болгоход зориуд анхаарсангүй. Бидний хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд төв, орон нутгийн олонхи албан хаагч тэр дундаа эрх бүрд хүрдэг багийн засаг даргад, бас сумдын, Засаг даргын Тамгын газрын сан хөмрөгт Үндсэн хууль байхгүй нь судлах бүү хэл “үзээгүй” едий хүрсэн нь цөөнгүй тохиолдов. Үндсэн хуулийг хэвлэн баг, хорооныхоо Засаг даргад үнэгүй гараачих соёл, нүнжиг дутагдаа юу гэлтэй. Тэдэнд зориулан аймгаас гаргасан ажлын дэвтэрт юу ум, төвөөс гаргасан эмхтгэлд “Үндсэн хуулиас” гэсэн гарчгийн дор ганц хоёрхон /Засаг даргын ба иргэний үүргийн тухай/ зүйл, сайндаа л “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” бүлгийг нийтэлсэн байх жишээтэй.<sup>1</sup>

Төрийн албанд хүмүүсийг шалгаруулан шилж авах, улс төрийн ажилтан бэлтгэхэд энэ асуудлыг тодорхой болзол, шалгуур болгож анхаардаггүй байна. Үндсэн хуульд үнэнч байх нь албан хаагчийг төрийн хүн болгож буй ухамсрын гол хүчин зүйл, онцлох шалгуур, засаг төр нь нэг бодлого журамтай ажиллахын зайлшгүй нөхцөл мөн билээ. Энэ нь төрийн хүн эрх зүйт төрдөө зүтгэх жам ёсны шаардлагаас урган гарч буй хэрэг. Тиймээс ч манайд бол Үндсэн хуулийг гуйвалтгүй биелүүлэхээ тангарагладаг

бөгөөд ардчилсан зарим орон иргэнийг Төрийн албанд ороход нь Үндсэн хуульд үнэнч эсэхийг тусгайлан шалгадаг хуультай байдаг.<sup>2</sup>

Манай улс төрч болон төрийн албанд горилгоч зарим хүн энгийн байхдаа Үндсэн хуулиа сайтар судлаагүй байж “зад муулчихаад”, дараа нь түүнийг магтаж, үндэслэл, заалтын нөмрөгт нь сонгууль, шалгаруулалтад орж элдвийг амалдаг. Тэгээд ялангуут Үндсэн хуульдаа үнэнч байхыг тангараглаж гарын үсэг зурснаар эрх мэдэл олж авдаг. Тэгснээ удалгүй өөрчлөх ухааны юм яриад, ингэснээрээ бусдад зохисгүй нөлөөлөөд явах нь бий. Энэ бол албаны хэлээр өгүүлбэл Үндсэн хуулийн нэр барьж өргөмжлөгдөөд эрх тушаал эзэлмэгц эргээд дайрч буй хэрэг, энгийнээр хэлбэл “Амар байна уу гэсэн биш, гай болов” гэдэгтэй агаар нэгэн. Хуулийг сайжруулах тухай нийтэд хандан ярьж бололгүй яахав. Гэвч энэ нь иргэдийн эрх болохоос, уг хуулийг биелүүлэхээ тангараглаж, үүрэг хүлээсэн төрийн албан хаагчийн хашгирч явдаг үг бишсэн билээ. Юм бүхэн хэмжээ хязгаартайн нэг нь энэ.

Үндсэн хуулийн нэрээр өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцыг албан ёсоор нэгтгэн дүгнэж, алдаа оноог нягтлан тодорхойлсон төрийн дээд төвшний шийдвэр гарсангүй. Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал ойшоон үзэхгүй алгуурладаг муу зуршил сүүлийн 8 жилд мэр сэр үзэгдээд цаашдаа архагших янзтай.

Хуулийн бус дээд сургуульд Үндсэн хуулийн сургалт

үгүйлэгдэж заримд нь нэр төдий зүйл болж байгааг судалгаа харуулжээ. Өдгөө Соросын сангийн явуулсан бэлтгэл, туршилтын хөтөлбөр хийгээд сурах бичгүүдэд 8-9-дүгээр ангид Үндсэн хуулийн зарим сэдвийг орж буй нь сайшаалтай боловч эргэж харууштай зүйл байгаад байна. Хэнтий аймгийн Өндөрхаан дахь дунд сургуулиудын нийгмийн ухааны багш нартай хийсэн уулзалт, ярилцлагаас үзэхэд аймагт Үндсэн хуулийн боловсролд санаа тавьдаг хүн нь цөөн тооны багш нар л байдаг бололтой.

Энэ мэтийг болон бусад орны жишгээс үзвэл Үндсэн хууль дээдлэх үзэл дадлыг нийт иргэн, төрийн албан хаагч, улс төрчид, ялангуяа залуу үеийнхэнд төлөвшүүлэхэд зориуд анхаарал тавьж төрийн бодлогын түвшинд зохих шийдвэр гарган хэрэгжүүлбэл ардчиллын үнэт зүйлсүүдийг ард түмний хүртээл болгож шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд чухал тус үзүүлнэ. Үүний тул:

- Үндсэн хуулийн агуулга, заалт, ач холбогдол иргэд, төрийн албан хаагч, сурагч оюутан залууст тайлбарлан таниулах, сургалт явуулах агуулга бүхий “Үндсэн хуулийн сургалтын хөтөлбөр”-ийг Засгийн газрын хэмжээнд төлөвлөн санхүүжүүлж тодорхой хугацааны давтамжтайгаар явуулах;

- Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагыг Үндсэн хуулиар хангах “төрийн хэрэг” хөтлөх журамд хүндэтгэл, хариуцлагатай байр эзлүүлэх;

1. “Багийн Засаг дарга нарын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн эмхтгэл” МЗГ-ын ХЭГ. УБ., 2002 гэсэн гарын авлага гаргасан нь сайшаалтай. Гэвч “хууль тогтоомж”-д ордоггүй олон акт,сайд нарын том, том тушаал зааврыг оруулсан атлаа 70 зүйлтэй Үндсэн хуулиас зөвхөн 6 зүйлийг нийтэлжээ. Багийн засаг даргад чиг нь хүний эрх, эрх чөлөө, Монголын төрийн байгуулалт, Үндсэн хуулийг сахин биелүүлэх тухай заалтууд хамаагүй гэж үү? ... гэмээр. В.Ч

2. ХБНГУ-ын Бавари муж улсын “Үндсэн хуулийг хамгаалах тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3-1

Төрийн ба нутгийн албан хаагчдын “Үндсэн хууль” сургалт семинарыг жил бүр сум, дүүргийн Засаг даргын болон яам, агентлагийн шугамаар зохион явуулж, шалгаж дүгнэж байх;

Үндсэн хуулийн өмнө андгай, тангараг өргөх ёс журмыг хянан үзэж нэр хүндийг нь дээшлүүлэхүйц хэлбэр, журамд оруулах, ёс болгох хандлагаас ангижрах;

- Төрийн шүтээний зан үйлийг дэмжиж зөв хэвшүүлэх (сүлд залах, төрийн туг, далбаа мандуулах, тахиx, Үндсэн хуулийн өмнө тангараг, андгай өргөх, сүлд дуулал эгшиглүүлэх, УИХ-ын чуулган, нутгийн Хурлын хуралдаан эхлэхэд Үндсэн хуулийн өмнө хүндэтгэлийн ёслол үйлдэх гэх зэрэг)

- Үндсэн хуулийг зөв тайлбарлах замаар Цэцийн эрх, үүргийг үндсэн хуульчилсан актаар дэлгэрүүлэн тогтоож, түүний үйл ажиллагааны цар хүрээ, онолын түвшин, практик үндэслэлийг дээшлүүлэх;

- Үндсэн хуулийг хүн амын янз бүрийн давхраанд зориулан уншиж судлах, залж, “тахиx”-д дөхөмтэй хэлбэр, хэмжээгээр хэвлэн нийтлэх, болж өгвөл үнэгүй түгээх (Жишээ нь: Шинээр гэрлэгчдэд зориулан баринтаглан хэвлэж, гэрлэх ёслолын ордонд тавьж түгээх нь “бөгжнөөс” яахин дутах билээ. Түүнтэй зүйрлэх ч аргагүй мэт)

- Ном товхимол гарын авлага боловсруулах энэ чиглэлийн эрдэм шинжилгээний чанарлаг ажлыг хөхиүлэн дэмжих;

- Аймаг, сум, багийн засаг захиргааны газруудыг Үндсэн хуулийн мэдээллийн булан, сантай болгох нийслэлд олон нийтэд зориулсан

“Танхим” бий болгож, иргэдэд үйлчлэх зэргээр уг ажлыг шинэ хөдөлгөөнд оруулж, эрчимжүүлэн тогтмолжуулах нь чухал. Түүнчлэн Үндсэн хуулийн байгууллыг сахин хамгаалж буй байдалд төрийн тусгай албаны хяналт тогтоох асуудлыг жич судалж шийдвэрлэх нь улс орны аюулгүй байдалд чухал учир холбогдолтой болов уу!

- Улсын Их Хурал өөрөө Үндсэн хуулиа, Засгийн газар, шүүх эрх мэдлийн байгуулагууд Үндсэн хууль, түүнд нийцсэн хууль, олон улсын гэрээг ёсчилон биелүүлж хяналт тавьж зөрчил гаргасанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зэргийн олон хэлбэрийн үр нөлөөтэй ажил зохиомор. Ер нь ердийн хууль зөрчсөний учир гэм буруутныг тогтоож, хариуцлага ногдуулдаг атал Үндсэн хууль зөрчсөний учир энэ талаар чимээ ч гаралгүй өнгөрдөг хачирхалтай явдлыг халах цаг болсон буй заа. Чингэх нь Монголын ард түмэнд хууль дээдлэх үзэл, дадал төлөвшүүлэхэд хамгийн үр нөлөөтэй байх билээ.

Сахилга хариуцлага гэгч дээрээсээ эхэлж тэндээс үлгэр жишээ, “очрол” авдгийг төрт ёсны түүхэн уламжлал харуулдаг байжээ. “Зэм ирвэл ахад, зуд ирвэл хуцанд” гэдэг нь талаар үг биш болов уу.

## §6. Доор, дээргүй судалж, дээрээсээ үлгэр үзүүлэх нь

Миний бие бодон бодон явсаар нэгэнтээ хэдэн багш, хэсэг хуульчийн хамт Берлин дэх Чөлөөт их сургуулийн Үндсэн хуулийн профес соруудтай уулзахдаа “Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй

илэрхийлэх... эрхтэй. Урлаг, шинжлэх ухаан, шинэчлэл судлал, багшлахуй нь чөлөөтэй. Багшлах эрх чөлөө нь Үндсэн хуульд үнэнч байхаас чөлөөлөхгүй”<sup>1</sup> гэж танай улсын Үндсэн хуульд заасан нь ямар учир утгатай юм бэ? гэж асуулаа. Тэд:

- Үндсэн хууль төрийн гол хууль, ХВНГУ-ын үндсэн хуулийн байгууллын үндэс учир түүнийг гуйвуулсан дуу хоолой их сургуулийн хананаас гарах ёсгүй гэсэн утгатай гэхчилэн тайлбарлаж өгсөн билээ. Нээрээ л тиймдээ гэлтэй. Ард түмний дээдлэн шүтэж явах нэгэн гол шүтээн байхгүйгээр үндэсний эв нэгдэл, тусгаар улс оршин тогтноход бэрхтэй юм.

Тийм шүтээн бол солигдоод байдаг удирдагч, гурван салаанд хуваагдсан засаг төрийн дээд газрууд, өөр өөр үзэлтэй намууд, янз янзын номлол бүхий шашны аль нь ч биш, гагцхүү үндсэн хууль бөгөөд түүнийгээ “бут аваад” байвал улс гүрэн хямарч тогтворгүйтэх магадлал их. Иймд гол хуулиа нийтээр сүсэглэн дагуулахын тул Үндсэн хуулийг тайлбарлан таниулах хийгээд сургалт зохион явуулахад шинжлэх ухааны үнэн зөв хандлага онцгой чухал ач холбогдолтойг эрх зүйт төрийг төлөвшүүлсэн улс орнууд нотолсон аж.

Коммунист үзэл, социализм бүхэлдээ мухардалд орсонтой уялдан гүнзгий хямрал хууль зүйн амьдрал, эрх зүйн талаарх нийгмийн сэтгэл зүйг тойрч өнгөрөөгүй. Өөрөөр хэлбэл, хоёр зууны заагаар улс төр, эдийн засагт нүүрлэсэн хямрал нь хууль зүйн хямралыг дагуулсан билээ. Энэ нь эрх зүйн социалист тогтолцоог ардчилсан тогтолцоогоор

1. ХВНГУ-ын Үндсэн хууль. 1949 он. 5 дугаар зүйлийн 1.2 хэсэг.

шинэтгэн буйтай шууд холбоотойг гүнээ ухаарах учиртай. Уул хямрал нь бас хууль хийгээд эрх зүйг үгүйсгэх, туйлшруулах (бүхнийг хуульчлах гэх) буюу эрх зүйн нигилизм, абсолютизм хоёрыг үзэж, туулж өнгөрөөхөд хүргэсэн байна.

Нөгөөтэйгүүр хүмүүс ардчиллын ачаар олж авсан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө хэрэг дээр эдлэх болсноор хууль зүйн амьдралд олон түмний өгөх үнэлэмж ил тод болжээ.

Энэ үйл явцыг судалгааны зорилгоор ажиглахад Үндсэн хуулийн утга санааг гуйвуулан "тайлбарлах", үгүйсгэх хандлага ч илэрдэг. Хууль дээдлэх, Үндсэн хууль дээдлэн шүтэх гэдэг бол Монгол төр, иргэний нийгэм, ард түмнийг нэгдмэлээр авч үзсэн, Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхол, туйлын зорилгын үүднээс эрхэмлэсэн ойлголт бөгөөд харин зарим хүн зарим асуудлаар хувийн үзэл бодлоо илэрхийлэхийг хориглоно гэсэн агуулгатай бишийг тэмдэглэх нь зүйтэй. Үүний хамт учрыг үл ухан үгүйсгэх, зориуд гуйвуулах хандлага төслийг хэлэлцэх үеэс эхэлж, өнөөг хүртэл цухалзсаар буй нь Үндсэн хуулийг дээдлэн шүтэх, сахин биелүүлэх явдалтай зөрчилдөж байна. Тэр дундаа шинжлэх ухааны нэр барьж Үндсэн хуулийг мушгин гуйвуулах хандлагаар түүний зарим заалт, үндэслэлийг бүдүүлгээр дайрч, үгүйсгэх явдал мэр сэр үзэгдэгийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж буйн илрэл хэмээн хүндэтгэн үзэж болох хэдий ч

төрийн эрх зүйн онолын үүднээс хүлээн зөвшөөрсөн мэт хүлцэнгүй суух боломжгүй.

ШУА-ийн философи, социологи эрх зүйн хүрээлэнгээс гаднын байгууллагын санхүүжилтээр боловсруулж гаргасан "Монгол Улсын төрийн байгууллагуудын чадавхи: Ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага боломж" /УБ-1998 он/ хэмээх номын зарим санааг жишээ болгон хэлж болно. Энэ номын төрийн байгууллагуудын талаархи хуулиудыг сайжруулахад хэрэг болохоор эгэл жирийн санаанууд нэлээд байгааг үгүйсгээд яахав. Гэхдээ түүний хуудсанд Үндсэн хуулийг "Зээлдэх, дууриах, хуулбарлах оролдлогын нэгэн том жишээ...", "бусад улс гүрний Үндсэн хуулиас түүвэрлэн авч, ур дүй муутайхан шиг эвцэлдүүлэн зохиомжилсон..."<sup>1</sup> гэх зэргээр басамжлан гуйвуулж, үгүйсгэхийг оролдсон хийгээд үндэслэл, заалтын нь хазгай ухаарсан санаа цөөнгүй тохиолдоно. Хамгийн хачирхалтай нь түүнийг зохиогч нь эхлээд Үндсэн хуулийг (төрийн хэлбэрийн хувьд ерөнхийлөгчийн засаг тогтоох, нам нь УИХ-ыг тараах, гишүүнийг эгүүлэн татах, гишүүн нь императив мандаттай байх\*) гэх зэргээр зарчмыг эргүүлэн) өөрчлөх тухай хувийнхаа бодол санааг эхлээд дугаарлан жагсаагаад<sup>2</sup> түүнийгээ "нотлох"-ын тулд элдэв хоёроор хэлжээ. Хувьд бодогдсоноо нотлохыг биш харин шинжлэн судлаад арга буюу хүрсэн дүгнэлтийг санал болгох нь шинжлэх ухааны арга зүйн гол шаардлага болов

уу. Жагсаасан саналын ихэнх нь хууль зүй, жам ёсонд үл нийцэх, хуучнаа сэргээхийг эрмэлзсэнээс гадна уг хуулийн төслийг боловсруулахад оролцсон болон хэлэлцэн батлалцсан хууль тогтоогчдыг "боловсрол ч үгүй, туршлага ч үгүй" хүмүүс гэх өнгөөр дургүйцлээ илэрхийлсэн мөрүүд уг номонд орсон нь гайхалтай ("Зэмлэсэн" өгүүлбэрүүдийг уншаад байхад шинжлэх ухааны хандлагатай биш, харин улс төрийн тодорхой бүлгийн өмнөөс донгодож шийтгэх нь үү дээ гэмээр өнгө аяс мэдрэгдээд байдгийг хэлэх юун). Эрдэм шинжилгээний бүтээлээс гадна энгийн зарим өгүүлэл, мэдээнд Үндсэн хуулийн үзэл баримтлалыг андуурч тайлбарласан нь бас бий. Цөөн баримтыг дурдвал:

"Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй гэснийг "шүүмжлэх" нэрээр Үндсэн хуулийг бүхэлд нь "хар бичээс", "... хүний эрхийг хөсөрт хаясан харгис цааз", "Нүгэл буян", "Улаанбаатарын үдэш" 1996 оны 6 дугаар сар, Д.Энхбат/ гэх буюу засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжүүдийг нутаг дэвсгэрийн зарчмаар нэг мөр болгон тогтоож, хотуудын тухай жич заасны үл ажиглан "хотгүй улс" /"ЗГМ" сонин, 1998 он, Цэвлээ/, Үндсэн хуулийн зохицуулах зүйл, үүргийг дутуу төсөөлснөөс ч тэрүү "Хот тохижуулалтын асуудал Үндсэн хуульд хасагдсан нь "ажил хэрэгт их бэрхшээл учруулж байна. /"Үнэн" сонин, 1999 он, №127/ гэх зэргээр гуйвуулсан, үгүйсгэсэн явдал үзэгдэнэ. Энэ

1. Дээр нэр дурдсан зохиолын 13, 14 дэх болон бусад хуудаснаа үзнэ үү.

\*. "сонгосон иргэд нь гишүүнийг эгүүлэн татах эрхээр хаягдах" гэсэн нь императив мандаттай болгох гэсэн утгатай.

2. Мөн тэнд 24 дэх тал.

мэт нь Үндсэн хуулийн эрх зүйн талаархи хувь хүний ухамсрын төвшинтэй холбоотой байхаа\* Гэхдээ энэ үндсэн хууль хэлэлцэх, батлан гаргах явцад зарчмын зарим асуудлаар өөр саналтайгаар цөөнх болж үлдсэн улс төрийн зарим зүтгэлтний ялагдлаа хүлээн зөвшөөрөхгүй байсаар үе үе цухалзуулдагтай ч холбоо, сүлбэтэй нь мэдрэгддэг. Ийм хандлагыг хүний эрхийн талаас нь хүндэтгэн үзэх хэдий ч Үндсэн хуулийг дээдлэн шүтэх үндэсний нийтлэг язгуур ашиг сонирхлын үүднээс дэмжих аргагүй юм.

Учир нь энэ бол Монголын төр, нийгмийн суурийг бэхжүүлж нэгэнт баталсан төрийн хүчин төгөлдөр гол хууль мөн бөгөөд Монголчууд бид түүнийгээ баримтлан улс орноо ардчилсан хэмээн нотолж, хөтөлж яваа билээ. Ер нь бид үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёсыг эрхэмлэхдээ түүнийг төрийн тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсыг бататгасан ардчилсан төрийн гол хууль мөн, бүх хуулийн манлай, манай нийгмийн суурь баримт бичиг гэсэн үнэлэмжийг иш үндэс болгосноос биш, бүхнээс төгөлдөр, мөнхөд өөрчлөгдөшгүй хэмээн даваадуулж хөөрөгдөөгүй. Нөгөөтэйгүүр түүнд байгаа зарим бүдэг бүрхэг, мэргэжлийн бус хүрээнд төдийлөн ойлгомжтой биш үг хэллэг байдгийг далимдуулан бүхэлд нь үгүйсгэн “доош нь хийх”, тэгснээрээ засаг төрийн хэлбэр тогтолцооны зарчмын өөр хувилбарыг оруулж ирэх, өнгөрөн төгссөн хуучныг сэргээх оролдлогыг бид

эсэргүүцэж байгаагаа ил тод хэлэх нь зүйтэй. Үндсэн хуулийн бүрхэг мэт зарчмын суурь үндэслэлүүдийн эргэлзээг тайлах арга зам нь шууд л үндсэн хуулиа дайрч давшлаад байх биш, Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн, Засгийн газрын, Цэцийн, шүүхийн, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн, нутгийн удирдлагын, сонгуулийн зэрэг “хуулиар тодорхойлно”, “зохицуулна” гэхчилэн өөрт нь бичсэн бөгөөд шинжлэх ухаанд “үндсэн хуульчилсан” гэх хуулиуд, түүнчлэн бусад ердийн хуулиар нарийвчлан тодруулах нь маш чухал. Энэ бол жам ёс мөн. Чингээд хүч үл хүрэлцэх аваас гол хуулийнхаа үзэл баримтлалаас гажихгүй, улс төрийн аль нэг нам, бүлгийн явцуу сонирхол, албан тушаалын төлөөх шохоорхолд автахгүйгээр онол-мэргэжлийн өндөр төвшинд боловсруулсан, ард түмний олонхийн санаа бодол, олон намын зүй ёсны нийтлэг сонирхолд буюу ашиг сонирхлын огтлолцолд тохирсон зайлшгүй нэмэлт тодруулалт хийж болох нь мэдээж. Харин эцсийн дүнд дордуулсан биш, сайжруулсан л байх ёстой. Тэгэхдээ улс, улсын жишгийг тусгана гэж тал тал руу савлаж болохгүй билээ. 2000 оны өөрчлөлтийг хийхдээ парламентын хаант засагт<sup>1</sup> Английн, хийгээд Холбооны улс болох хоёр танхимт парламентын хаант засагт Германы жишгийг харгалзсан гэж маргадаг. Тэгээд бас Америк маягаар Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Улс болно гэгцгээх<sup>2</sup>. Нэг улсад төрийн удирдлагын хоёр,

гурван хэлбэрийг зэрэгцүүлэн хэрэглэж болохгүй шүү дээ. Сонгосноо л туйлд нь хүргэх хэрэгтэй болно. Гэтэл өөрсдийн сонирхолд нийцүүлэн өөрчлөх гэсэн тодорхой бүлгийн санаархал оршсоор буйн улмаас Үндсэн хуульд олонд төр бүр тод бус гэнэтийн цочмог, нэмэлт, өөрчлөлт оруулсан явдал ч нэгэнтээ тохиолдов. Одоо ч тийм эрмэлзэл байна гэдцэх болсон нь сэжигтэй. 1996-2000 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Парламентад суудалтай (олонхи, цөөнх) гурван намын бүлэг “үгсэн” Үндсэн хуульд оруулсан “нэмэлт, өөрчлөлт”-ийг Цэцээс хүчингүй болгосон. Гэтэл хэсэгхэн хугацааны дараа дахин сэргээсэн нь дэндүү болхи санагдана. Уг нэмэлт, өөрчлөлт “сайжруулсан” бол ч яриад байх юм юу байх вэ, магтах л хэрэг гарна. Гэтэл хүний эрхийг хангах гол баталгаа, өөрөөр хэлбэл, засаг төрийн байгууллагын зүгээс хүний эрх зөрчихөөс сэргийлэх гол үндэслэл болсон төрийн эрх мэдэл хуваарилах зарчимд нийцэхгүй байгааг одоо хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болжээ. Ялангуяа парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг “үнээ, тугал нийлүүлсний” адил хольж хутгасан нь харьцангуй олон гишүүнтэй парламент, цөөн гишүүнтэй Засгийн газар хоёрын харилцан хяналт тавьж, сөрөн зогсож, тэнцвэржиж зарчимд үнэхээр харшилжээ. Түүний дээр хуулийг УИХ-ын гишүүдийн бараг дөрөвний нэгийн бүрэлдэхүүнтэй (20 гишүүн) батлах\* болгож ардчиллын нэг гол шинж гэгддэг

\* Төрийн “Эрх мэдэл хуваарилах зарчим”, “байнгын парламент”, “императив мандат”, “мажоритар зарчим”, “хараат бус шүүгч” гэх мэт хэлэхэд хялбар ч хэрэг дээрээ эрх биш мэргэжил шаардах, оношлоход хялбар бус ухагдахуунууд бий. Иймд мэргэжлийн бус хүмүүстэй маргах нь илүүц мэт бодогдоно.

1. В.Е. Чиркин, Конституционное право зарубежных стран. “Юристы”, Москва, 1997 г, стр.142.

2. Монгол Улсын төрийн байгууллагуудын чадавхи: Ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх шаардлага боломж. (ШУА.ФСЗХ) 1998 он, 24 дэх тал.

“мажоритари” зарчмыг үгүйсгэсэн, Засгийн газрын бүрэлдэхүүний талаар Улсын Ерөнхийлөгчийн саналыг үл хэрэгсэн эцсийн дүнд нам шийдэх болсон, хүн үзэл бодол, хүсэл зоригоо хамгийн чөлөөтэй илэрхийлэх арга болсон нууц санал хураалтыг парламентын төвшинд хаалттай болгосон парламент байнга ажиллах (чуулах) хугацааг 1/3-ээр богиносгосон зэргийг даруйхан эргэж харууштай. Иймд дүгнэлтэд ундууцах бус, улс орныхоо төлөө уян хатан, ухаалаг байх нь түүхийн өмнө нэр бүтэн үлдэх төдийгүй, төрд зүтгэж буйн утга учир оршино. Алдаж магадгүй, засах нь зайлшгүй гэж нэмүүштэй. “Хүн хэдий сайн ч хэлэхээс наашгүй” гэдэг.

Төрийн эрх мэдлийг засгийн гурван салаанд хуваарилах онолыг үндэслэгч Монтеские “Парламент, Засгийн газар хоёрыг нийлүүлбэл эрх чөлөөний тухай яригтгүй, ... Нэгэнт эрх чөлөөгүй нөхцөлд шударга шүүх оршихгүй...”<sup>1</sup> гэж бичсэн буй. Түүний төрөлх эх орны Үндсэн хуульд Засгийн газрын гишүүний чиг үүрэг нь парламентын мандаттай, улс үндэсний хэмжээний ажил мэргэжлийн төлөөлөх албан тушаалтай, төрийн аливаа албаны болон мэргэшлийн үйл ажиллагаатай хавсармал байж болохгүй<sup>2</sup> хэмээн тунхагласан байдгийг дурдахад илүүдэхгүй. Гэтэл энэ зарчимд сөрөг өөрчлөлтийг улс төрийн бусад олон нам, ард түмэнд урьдчилан таниулж, санаа бодлыг нь авалгүйгээр гэнэт

өөрчилсөн нь яав ч зөвтгөх аргагүй. Түүнчлэн уг өөрчлөлтийг цэц нэгэнтээ хүчингүй болгосны дараа дахин тэр чигээр нь сэргээж, мөн л гэнэт баталснаа “нийгмийн захиалга” гэж зарласан нь даан ч үнэмшилгүй. Уул өөрчлөлтийн төсөлд УИХ-ын гишүүдийн дийлэнхи олонхийн буюу 60 гаруй гишүүний гарын үсгийг “зөвшөөрнө” гэж зуруулсныг чуулганы бус аргаар хууль батлуулсан буюу ам тангаргийг нь авсан гэхээс өөр дүгнэлт гарахгүй бөгөөд эл нөхцөлд үнэн хэрэгтээ гишүүд үгээ хэлж, шүүн хэдэлцэх боломжтой байсан гэх үндэслэл олдомгүй. Дараа нь энэ чинь буруу байна шүү гэсэн Улсын Ерөнхийлөгчийн үндэслэл бүхий хоригийг Улсын Их Хурал хэлэлцээд хүлээж аваагүй, Цэцээс хянан үзэх сэжүүр байсан ч “Үндсэн хууль бол хууль биш”, “түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт бол Үндсэн хууль” гээд тээг тавьж амыг нь тагласан. Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулдаг Монголын парламентын өмнөх үеийн заншил, бусад орны хууль зүйн жишгийг ч хайхарсангүй. Эрх зүйн ямар нэг актын нэр өгөлгүй “нэмэлт, өөрчлөлт” гээд л гаргачихсан. Хэрэв зохих журмаар боловсруулж, ард түмний болон улс төрийн хүчнүүдийн санаа бодлыг сонсож харгалзан тусгаж, хуулиа гаргаж ёс төртэйгээр хүчин төгөлдөр болгосон аваас дараа нь тийм “хүчинтэй” гэх нь зөв л дөө. Үдийн завсарлагыг эс тооцвол 2-3 -хан цагт “маналзуулсан” нэргүй актыг сар, жилээр

боловсруулж 6 сар дамжуулан хэлэлцэж, баталсны хойно 1 сарын дараа хүчин төгөлдөр болгон мөрдсөн Үндсэн хуультай адилтана гэдэг арай дэндсэн шалтаг.

Гэнэтийн энэ өөрчлөлтөө “төрийг гацаанаас гаргасан” мэргэн арга, ард түмний захиалга мэтээр тайлбарлацгаадаг. Үнэндээ бол Үндсэн хууль гацаасан биш, ард түмэн шаардсан, “захиалсан”<sup>3</sup> ч биш, төрийн томчуудын үзэл бодол, арга ухаан нь гацаасан хэрэг. Тэд огцорсон Ерөнхий сайдын оронд нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч зөвшөөрсөнгүй, тийм байтал Улсын Их Хурал дахь олонхи суудалтай нам /эвсэл/ өөр хүнийг биш өмнөхөө л дахин дахин дэвшүүлснээс огцорсон Засгийн газар хэдэн сар “үүрэг гүйцэтгэгч”-ээр ажилласныг “Үндсэн хуулийн гацаа” гэдэг. Хэрэв намаас/эвслээс/ нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхийлөгч цаг тухайд дэмжсэн бол; эвсэл зөвшөөрөгдөхүйц өөр хүний нэрийг тэр дор нь дэвшүүлсэн бол; хамгийн гол нь Засгийн газрыг огцруулахдаа Үндсэн хуулийн холбогдох заалтыг ёсчлон баримталсан бол “гацаа” гэх зохиомол шалтаг буюу санамсаргүй гай тохиолдохгүй байсан билээ. Юу гэвэл тухайн тохиолдолд Засгийн газрыг шууд л огцруулчих ёсгүй байсан. Харин түүнд итгэл үзүүлэх эсэх талаар (“вогум доверия”) УИХ-ын тогтоолын төсөл оруулж санал хураах, эсхүл Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэхийн талаар Үндсэн хуулийн Цэцэд хандаж дүгнэлт

\*Хэрэв ингэх л байсан юм бол тэр үлдсэн 50 гаруй гишүүнийг цалинжуулж, илүүдсэн юм бол сонгохын хэрэг юун гэлтэй. Тэд бол урьдынх шиг тойрогт ажиллах, орон нутгийн байгууллагын ажлыг орон хийж гэж сонгогдсон бус чухамхүү хууль тогтоох албан тушаалтан, Улсын Их Хуралд байнга суух үүрэгтэй ард түмний элч.

1. Монгол Улсын шүүгчийн ном 1998 он, 9 дэх талд иш татсанаар авав.

2. БНФУ-ын 1958 оны Үндсэн хууль, 23 дугаар зүйл.

3. “Зууны мэдээ”. 2000-09-13, №292/559/

гаргуулах зэрэг бусад заалтыг<sup>1</sup> хэрэглэх учиртай, боломжтой байв. Хэрэв итгэл үзүүлэх эсэх талаар санал хураахад оролцсон гишүүдийн олонхи нь "итгэл үзүүлэхгүй" гэвэл Засгийн газар огцрох нь гарцаагүй болж энэ тухай хууль гаргах л үлдэж байгаа нь мэдээж болно. Чингэвээс Засгийн газрын залгамжлах бүрэлдэхүүнийг яаралтай товлосны дараа хуучнаа "огцруулсугай" гэж шийдвэрлээд шинэ бүрэлдэхүүнээ ёстой л "бариа, зөрөөн дээр" томилдог. Үндсэн хуульд ийм заалт байтал түүнийг хэрэгсээгүйг мэдлэг, дадлага дутсан гэлтэй биш дээ. Юутай ч гэсэн энэ асуудлыг Үндсэн хуулиа дээдлэх эрх зүйн ухамсрын үндсэн дээр шийдвэрлэхийн оронд зоргоор хандах арга барилд автсаныг харуулжээ. Ийм асуудлыг цаашдаа нарийн журамлана гэвэл Үндсэн хуульдаа огт халдахгүйгээр УИХ, Засгийн газрын хуульд төдийгүй, Улсын Их Хурлын чуулганы дэгэд л холбогдох журмыг нэмээд оруулчихад л болох билээ. Гэтэл маргааш яахыгаа сайтар товлоогүйгээр Засгийн газраа огцруулсны улмаас шинэ бүрэлдэхүүнийг томилох ажил бүтэлгүйтэн угжирсны бурууг Үндсэн хуульд түлхэцгээн, "улс төрийн хариуцлагаас мултарч", түүний гол үзэл баримтлалд нийцэхгүй нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг хольж, улмаар нам төрийн ажил үйлсийг хутгах үндсийг тавьсан, мажиратори зарчмыг үгүйсгэсэн, парламентын тасралтгүй, байнгын ажиллагааг сулруулсан

зэргийн өөрчлөлтийн сөрөг тал нь өдгөө нэлээд мэдрэгдэж байгаа бололтой. "Газрын ойр, гайны бага дээр нь" гэдэгчлэн засаж залруулаасай, дахин ийм юм бүү тохиолдог гэж л залбирахаас өөр яах билээ. Парламент хууль тогтоохдоо Үндсэн хуулиа ягштал баримтлах нь эрх зүйт төрийн эрхэм шинж болохоор энэ нь бас Улс Их Хурлын эрхэм гишүүдийн хууль зүйн болон ёс зүйн үүрэг, хариуцлагын гол шалгуур болно. Сахилга, хариуцлага дээрээс эхэлж, доош үлгэрлэдэг, хууль, журам нь дээдэст хатуу, доодост нигүүлсэнгүй байх нь төрт ёсны эрхэм чанар, нэгэн зүйл урлаг гэж үздэг тийм уламжлал ч бий. Их дээр үеэс нэхэн үзвэл суут богд Чингис хаан "ажил үүргээ биелүүлж чадахгүй, хууль зөрчсөн" ноёд, жанжингуудыг хатуугаар зэмлэн цээрлүүлэх зарлиг буулгаж, мөрдүүлж байсныг судлаачид тэмдэглэжээ<sup>2</sup>. Үүнийг тэр цагт хууль дээдлэн төр барих нэгэн арга болгосон гэж болно.

### §7. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх нийгэмсэтгэл зүйн үндэс

Монгол Улсын Үндсэн хууль бол ард түмний сонголт, хамтын бүтээл мөн. Өөрөөр хэлбэл түүнийг төрийн (ордны) эргэлтийн аргаар гэнэт батлаагүй. Түүнийг боловсруулж баталсан үйл явцын голыг тоймловол:

- Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг төрийн хийгээд улс төрийн олон намын төлөөлөгч оролцсон улсын

комисс зохион байгуулж, хянаж чиглүүлсэн;

- Монгол төрийн хуримтлуулсан туршлага, бусад орны жишиг болон ардчилсан хөдөлгөөний явцаар бэлтгэгдсэн үзэл баримтлалд суурилсан;

- Энэ бүх үе шатны ажилд Монголынхоо хууль зүй, түүх, улс төр, эдийн засаг, хэл шинжлэл, урлаг, утга зохиол, гадаад харилцааны болон бусад мэргэшлийн цөөнгүй эрдэмтэн, мэргэжилтнийг янз бүрийн үүрэгтэйгээр татан оролцуулсан;

- Ард түмэн 3 сар хэлэлцсэнийг нэгтгэн дүгнэж зарчмын маргаантай асуудлыг тэдний олонхийн саналыг эш үндэс болгон шийдвэрлэсэн;

- Ардын Их Хурлын депутат нийт аймаг, сумын эрх баригчдын 6 газар бүсчилэн хийсэн зөвлөгөөнөөр урьдчилан хэлэлцүүлж санаа бодлыг нь авсан;

- НҮБ-ын хууль зүйн комиссын шинжээчидтэй болон 1991 оны 9 сард Улаанбаатарт зохиосон "Монгол Улс ардчилалд шилжихэд шинэ Үндсэн хуулийн гүйцэтгэх үүрэг, байр суурь" сэдэвт Олон улсын бага хуралд оролцсон 10 гаруй орны эрдэмтэд, олон улсын байгууллагуудын төлөөлөгч нартай төслөөр санал солилцож, санаа бодлыг нь тандсан зэргээр нягтлан боловсруулсан.

Төслийг боловсруулах дунд болон эцсийн шатанд Монгол Улсын Бага Хурал /1, 2 дугаар хэлэлцүүлгийг нэмээд/ 4 удаа, Ардын Их Хурлын 420 гаруй депутат 70 шахам хоног 2 удаа хэлэлцэж, 1992 оны 1 дүгээр

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2; 43 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэг; 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3.4

2. Гарольд Дэмб. Дэлхийн эзэн Чингис хаан. /Цуврал-10."Төр засгийн ҮААЭГ-ын хэвлэх үйлдвэр"/ УБ.,2003.168-169



сарын 13-ны өглөөнөөс цэг, таслалыг хүртэл хэлж, үг бүрийг дуудан уншуулж сонсоод 1-ээс бусад нь санал нэгтэй баталсан төрийн гол хууль мөн билээ. П.Очирбат төрийн тэргүүн, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын даргын хувиар "Монгол Их цаазын\* төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай" Ардын Их Хурлын II хуралдаанд 1992 оны 10 дугаар сарын 7-нд тавьсан илтгэлдээ: "Монгол Улсын Их цааз"-ын тухай төсөл бол Монгол Улсын оюуны чадавхийг бүхэлд нь дайчилсан Монголын хөдөлмөрчид, эрдэмтэн, мэргэжилтэн, та бидний хамтын бүтээл" гэж тэмдэглэсэн<sup>1</sup> юм.

Шинэ Үндсэн хууль нь бүтээн туурвигдсан эш үндэс, арга замын хувьд "социалист орнуудын зохицуулсан бодлого", "нэг үзэл суртал" нэрийн доор Зөвлөлт маягийг даган дууриасан (түүнд захирагдсан) өмнөх хуулиас ялгаатай бөгөөд манай ард түмний өөрсдийн бие даасан бүтээл гэх бүрэн үндэстэйг дээрх баримтууд нотолно. Энэхүү "төрөлх" чанараараа Монгол Улсын Үндсэн хууль бол манай ард түмэн нийтээрээ дээдлэн шүтэж, ёсчилон сахих нийгэм сэтгэл зүйн гүн үндэстэй байна. Иймд түүнийг үеэс үед залгамжлан дээдэлж хэвшүүлвээс нэгэн зүйл үндэсний бахархал болно. Энэ нь түүний ихэд хураангуйлсан зарим томъёоллыг Үндсэн хуульчилсан болон ердийн хуулиар үзэл зарчмыг нь гуйвуулахгүйгээр нарийвчлан тодруулах шаардлагыг огт

үгүйсгэхгүйг өмнө дурдсан. Тийм ч шаардлага бий.

Монгол Улсын хууль тогтоох, гүйцэтгэх дээд байгууллагууд Үндсэн хуулиа дээдлэн шүтэх ёсыг "дээр дооргүй", "хот, хөдөөгүй" нийтээр хэвшүүлэхэд онцгой анхаарал тавьж, бүх талаас нь онц анхааралтай хандаж, энэ үйлсийг байнга чиглүүлж байх нь төрт ёс, хууль дээдлэх ёсны анхдагч шаардлага мөн болов уу хэмээн үзнэ. Чингис хаан "Засаг хууль" -ийн хамгаалагчаар өөрийн ууган хүү Цагаадайг томилж, биелэлтийг нь ноёдын чуулганаар жил бүр хэлэлцүүлдэг байсан гэдэг<sup>1</sup> "Засаг хууль"-ийн заалт гэсэн түүвэрт "Засаг хуулийн биелэлтэд хяналт тавьж байхыг хүү Цагаадайдаа тэрээр зарлиг болгосон байна"<sup>2</sup> гэснээс үзэхүд энэ хамгаалалтыг "амаар" биш хуулиар бэхжүүлсэн байжээ.

Хэдийгээр нийгэм, төрийн, хуулийн мөн чанар "танигдашгүй болтлоо" өөрчлөгдөн хувьссан ч хууль дээдлэх төрт ёсны уламжлалаа сэргээж буй шинэ цаг үед үндэсний ухамсар, сэтгэл зүйн хувьд, өв уламжлалын учиг бийг энэ мэтээс харж ухамсарлаж болно.

Өдгөө Үндсэн хуулиа дээдлэн сахих үйлсийг Монгол Улсын Их Хурал хянан чиглүүлж, биелэлтийг зохион байгуулж хангах үүргийг Засгийн газрын тэргүүн хариуцаж, зөрчил гажуудлаас хамгаалах үйлсийг Үндсэн хуулийн Цэц эрхэлж байгаа нь дам утгаараа түүхэн уламжлалтай төстэй бус уу.

-Яагаад Улсын Их Хурал хянан чиглүүлнэ гэсэн хэмээвээс: "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах"

явдлыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-ийн 8-д Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн нэг болгон заасныг;

-Яагаад Засгийн газрын тэргүүн биелэлтийг хариуцна гэж хэлэв гэвэл: "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна" гэж Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1-д заасныг;

-Яагаад цэц хамгаална гэвэл "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага; Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1-д заасныг тус тус эш үндэс болгов.

Хууль дээдлэх ёсон бол засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм. "Чингис хааны од гялалзаж төр хүмүүс тушаал зарлигийг дагах болсноор хатуу тогтоосон засаг ёсын\* тусламжаар тэрээр хүмүүсийг удирдан захирах болов" гэснийг санахад илүүдэхгүй. Чингисийн билэг сургаалд "хатуу чанд, яв цав байдалтай бол хамаг улс бат бэх болой"<sup>1</sup> гэж бий. Энэ бүхнээс үүдэн төр барьж, түмэнд үйлчлэх урлагт суралцахад Үндсэн хууль судлал, тэр дундаа түүхэн хийгээд харьцуулсан судлалыг хөгжүүлэн түшиглэх шаардлага өссөөр буйг харгалзан нэгийг бодох цаг болжээ.

\* Үндсэн хуулийн төслийг Ардын Их Хурал ийм нэртэй өргөн мэдүүлсэн бөгөөд түүнийг тус Их Хурал хэлэлцэн өөрчилсөн юм. /П.Очирбат "Алдаж болохгүй агшин", УБ., 1997 он, 254 дэх тал

1. П.Очирбат "Алдаж болохгүй агшин", УБ., 1997 он, 259 дэх тал

2. Эзэн богд Чингисийн "Их засаг" МУИС, ХЗДС. УБ., 1997 он, 31 дэх тал

3. Эрэнджен Хара-Даван. Сод жанжин Чингис хаан, түүний үлдээсэн өв. УБ., 2003 он, "Мон судар" хэвлэлийн газар. 175 дахь тал.

## Дэлхийн зарим орны Үндсэн хууль дахь спортын зохицуулалт



"Аварга" дээд сургуулийн захирал, докторант  
Б.БАТ-ЭРДЭНЭ

Аливаа Үндсэн хууль нь тухайн улс орны бүх салбар эрх зүй, хууль тогтоомжийн үндэс болсон үзэл баримтлал, зарчмыг агуулдаг билээ. Академич С.Нарангэрэл "Үндсэн хууль нь хууль зүйн хувьд хамгийн дээд хүчин чадалтай, улс орны бүх нутаг дэвсгэрт шууд дээдлэгдэн үйлчилдэг эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дээд зэрэглэлийн акт мөн" гэж бичсэн байна. Доктор Б.Чимид Үндсэн хуулийг "Хүн ба төр, нийгмийн амьдрал, үйл ажиллагааны гол тохируулагч" гэсэн байна. Доктор С.Төмөр "Үндсэн хууль бол тухайн төрийн дотоод, гадаад бодлого, улс төр, эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлсон улс төр, эрх зүйн баримт бичиг юм" хэмээн бичжээ.

Дэлхийн янз бүрийн улс орны Үндсэн хуулийн хөгжилд хэвшмэл болж буй үндсэн чиг хандлага нь нийгэмшсэн, ардчилсан, интернациональчлагдаж байгаа явдал хэмээн судлаачид үзэж байна.

Нийгэмших /нийгмийн чиг баримжаа барих/ үйл явц мэдэгдэхүйц хүчтэй явагдаж буй улс орны үндсэн хуульд нийгэм, эдийн засаг, соёлын хүрээн дэх иргэдийн эрхэд зориулагдсан зүйл, хэсгийг түлхүү оруулсан байдаг.

Дэлхийн улс орнуудад удирдлагын үйл ажиллагааг ардчилах /төвлөрлийг сааруулах/, засаг төрийг удирдах үйлсэд иргэдийн оролцоог өргөжүүлэх бодлогыг тууштай баримтлах болжээ.

Дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийн хөгжил нь интеграцчиглагдах үйл явцын нийтлэг чиг хандлагыг илэрхийлэх болов. Үүнтэй уялдан сүүлийн жилүүдэд улам бүр интеграцчиглагдах явдал дэлхийн улс орнуудын үндсэн хуулийн хөгжлийн ил тод чиг хандлага болж байна. Энэхүү чиг хандлага ялангуяа үндэсний эрх зүйн тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох нийт Европын эрх зүйн стандартыг төлөвшүүлж буй Европын улс орнуудад улам тодорхой ажиглагдаж байна. Энэ нь юуны өмнө хүний ба иргэний эрх, эрх чөлөөг үндсэн хуулиар зохицуулах гол зүйл болгож байгаагаар илэрнэ.

Ийнхүү дэлхийн янз бүрийн улс орны Үндсэн хуулийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага нь хүний болон иргэдийн эрх, эрх чөлөөг цаашид тал бүрээр хөгжүүлэх, хамгаалах явдлыг тэргүүн зэрэгт тавьсанд оршино.

Хүн бүрийн нэгэн үндсэн эрх бол бие бялдарын хүмүүжил, спорт эрхлэх явдал болохыг бие бялдарын хүмүүжил, спортын

олон улсын Хартийн 1 дүгээр зүйлд тунхаглажээ. Энэхүү Хартийг 1978 онд батлахдаа ЮНЕСКО-ын Ерөнхий бага хурал "Хүний эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь эрэгтэй, эмэгтэй хүн бүр өөрийн бие махбодь, оюун санаа, зан суртахууны чадвараа чөлөөтэй хөгжүүлэх боломжоо хадгалах ба энэ үүднээс бие махбодийн хүмүүжил, спорт бүх хүмүүст хүртээлтэй, нээлттэй хэрэгжих ба баталгаатай байх боломжоос үлэмжхэн хэмжээгээр шалтгаална" гэдэгт итгэлтэй байгааг тэмдэглэжээ. Хартийн 9 дүгээр зүйлд "Төрийн байгууллагын бүх төвшинд ба төрийн бус тусгай байгууллагууд биеийн тамир, спортын арга хэмжээ, үзтэл илэрхий хүмүүжлийн ач холбогдолтой арга хэмжээг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх ёстой. Тэдгээрийн оролцоо нь хууль, тогтоолыг амьдралд хэрэгжүүлэх, материаллаг дэмжлэг үзүүлэх, урамшуулах, шагнах, хяналт тавих бусад бүх арга хэмжээг авахад оршино" гэж тогтоожээ. Үүнтэй уялдан дэлхийн янз бүрийн улс орнуудын үндсэн хуульд биеийн тамир, спортын талаар чухам ямар хэм хэмжээ байгааг олж судлахыг эл ажлын нэг гол зорилт болгосон юм.

Энэхүү судалгааг хийх явцад дэлхийн (60) улс орны үндсэн хуульд биеийн тамир, спортын тухай заалт буй эсэхийг эрж хайх шинжилгээ хийсэн болно. Эдгээр улс орон бол Европын бүх улс, хуучин ЗХУ-д багтаж байсан тусгаар

тогтносон бүх улс тэрчлэн Ази /Индонез, БНХАУ, БНСУ, Япон/ ба Америк /АНУ, Бразил/ тивийн хэд хэдэн улс юм.

Бидний хийсэн судалгааны үр дүнд өмнө дурдсан улс орнуудаас 28 улс орон /46,6% / үндсэн хуульдаа биеийн тамир, спортын хүрээний янз бүрийн эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээтэй болохыг тогтоосон болно.

Бид дэлхийн улс орнуудын биеийн тамир, спортын тухай заалт бүхий Үндсэн хуулийг дараах шалгуураар ангилан авч үзсэн болно.

1. Монгол Улстай хөрш улс орны Үндсэн хууль (ОХУ, БНХАУ);

2. Хөгжлийн өндөр төвшинд хүрсэн улс орны (Австри, Андоррагийн Вант Улс, Голланд, Ирланд, Швейцарь) Үндсэн хууль;

3. Спортын олон улсын хөдөлгөөнийг санаачилсан буюу спорт хөгжсөн улс орны Үндсэн хууль (Грек, Бразил, Португал, Испани);

4. Хуучин социалист байсан улс орны Үндсэн хууль (Албани, Болгар, Македон, Польш, Румын, Унгар, Хорват);

5. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан тусгаар тогтносон хамтын нөхөрлөлийн улс орны Үндсэн хууль (Армени, Беларусь, Кыргыз, Литви, Молдав, Таджик, Туркмен, Украин);

6. Исламын улс орны Үндсэн хууль (Иран, Турк);

1. Монгол Улстай хөрш улс орны Үндсэн хууль

Манай улсын хойд их хөрш Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн /1993.12.12/

“Хүний ба иргэний эрх, эрх чөлөө” гэсэн II бүлгийн 41 дүгээр зүйлд “2.Оросын Холбооны Улс нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах ба бэхжүүлэх, холбооны хөтөлбөрийг санхүүжүүлж, эрүүлийг хамгаалах төрийн, муниципалийн, хувийн тогтолцоог хөгжүүлэх талаар арга хэмжээ авч, хүний эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир, спорт, экологийн ба эрүүл ахуй, халдваргүйжилтийн сайн сайхныг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлсэн үйл ажиллагааг хөхиүлэн урамшуулна”; “Төрийн байгууламж” гэсэн III бүлгийн 72 дугаар зүйлд “1.Оросын Холбооны Улс ба Оросын Холбооны Улсын субъектын хамтарсан эрх хэмжээнд:

...е/хүмүүжил, боловсрол, шинжлэх ухаан, соёл, биеийн тамир, спорт ... гэж заасан байна.

Манай улсын урд их хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндсэн хуулийн /1982.12.04/ “Нийтлэг үндэслэл” гэсэн I бүлгийн 21 дүгээр зүйлд... “Төрөөс биеийн тамир, спортын үйлсийг хөгжүүлж, спортын бүх нийтийн арга хэмжээг хэрэгжүүлж, үндэстний эрүүл мэндийг бэхжүүлнэ”; Иргэдийн үндсэн эрх, үүрэг хэмээх II бүлгийн 46 дугаар зүйлд “Төрөөс залуучууд, өсвөр насныхан, хүүхдийн ёс суртахуун, оюун ухааны болон бие бялдрын бүх талын хөгжлийг хангана” гэсэн байна.

Ийнхүү Монгол Улсын хоёр хөрш ОХУ, БНХАУ Үндсэн хуульдаа биеийн тамир, спортын талаар тодорхой хэм хэмжээ оруулсан байна.

2. Хөгжлийн өндөр төвшинд хүрсэн улс орны Үндсэн хууль

Австри улсын холбооны Үндсэн хуулийн /1920.11.10/ 11 дүгээр зүйлд Холбооны хууль тогтоомж болон земелийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд “...2.Хэрэв мэргэжлийн төлөөлөл 10 дугаар зүйлийн үйлдэлд хамаарагдахгүй байвал хөдөө аж ахуй, ойн аж ахуй, түүнчлэн земелийн өөрийнх нь мэдэлд байгаа спортын сургалт, альпанизм, цанын спортын бальпаагчдын үйл ажиллагаанаас бусад мэргэжлийн төлөөлөл ...” гэсэн байна.

Андоррагийн Вант улсын Үндсэн хуулийн /1993.03.14/ “Нутаг дэвсгэрийн байгууллага” гэсэн VI титулын 80 дугаар зүйлд” Автономит общин нь өөрийн захиргааны болон санхүүгийн хүрээнд тусгай хуулиар тодорхойлсон бүрэн эрхтэй байна. Тухайлбал тэрхүү эрх хэмжээнд дараах асуудлууд орно.

...к/ соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаа ...” гэсэн байна.

Голландын Үндсэн хуулийн /1983.02.13/ “Үндсэн эрх” гэсэн I бүлгийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн байгууллагууд нийгмийн нийгэм ба соёлын хөгжил, чөлөөт цаг, амралтын хүрээг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх ёстой гэжээ.

Ирландын Үндсэн хуулийн /1937.12.29/ 42 дугаар зүйлд “Төрөөс гэр бүлийг хүүхдийн анхны ба жам ёсны хүмүүжүүлэгч болохыг бататгаж, эцэг, эх өөрсдийн үр хүүхдэдээ шашны, ёс суртахууны, оюун санааны, бие бялдрын ба нийгмийн

хүмүүжил олгох, тэдний боломжид нийцүүлэн эцэг, эхийн салшгүй эрх ба үүргийг хүндэтгэн баталгаа жуулна” гэж тодорхойлжээ.

**Швейцарийн Үндсэн хуулийн /1999.04.18/ 68 дугаар зүйлийг “Спорт” хэмээн нэрлэж**

“1.Холбоо нь спортыг ялангуяа спортын бэлтгэлийг урамшуулна.

2.Холбоо нь спортын сургуулийг удирдана.

3.Холбоо нь залуучуудын спортын талаар заалт гаргаж, сургуульд спортыг заавал сургахаар мэдэгдэж болно” гэж заажээ.

**3.Спортын олон улсын хөдөлгөөнийг санаачилсан буюу спорт хөгжсөн улс орны Үндсэн хууль**

Грекийн Үндсэн хуулийн /1975.06.11/ “Хувийн ба нийгмийн эрх” гэсэн II ангийн 16 дугаар зүйлд “2.Бодовсрол бол төрийн нэн чухал зорилт бөгөөд грекчүүдийг ёс суртахуун, оюун санаа, мэргэжил, бие махбодийн талаар хүмүүжүүлэх, тэдний үндэсний ба шашны ухамсрыг хөгжүүлэх, тэднийг эрх чөлөөтэй ба хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх зорилготой.

9.Спорт нь төрийн хамгаалалт, дээд хяналтад байна.

Төр нь энэ тухай хуульд заасан бол спортын нийгэмлэгийн аливаа холбоодод санхүүгийн туслалцаа үзүүлж, хяналт шалгалт хийнэ. Түүнчлэн нийгэмлэгт зориулан олгосон татаас бүрийг зохих ёсоор ашиглаж байгаа эсэхийг хуулиар тодорхойлно” гэж заажээ.

**Испанийн Үндсэн хуулийн /1978.12.27/ 43 дугаар зүйлд “Засаг төрийн байгууллага нь эрүүл ахуйн гэгээрэл, биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлж түүнчлэн чөлөөт цагийг зөв ашиглахад тусална”, 148 дугаар зүйлд “1.Автономит хамтлагийн эрхлэх хүрээнд дараах асуудлыг хамааруулна: ...19/спортыг хөгжүүлэх, амралтыг зохион байгуулах ...” хэмээн тогтоожээ.**

**Португалийн Үндсэн хуулийн /1976.04.02/ “Үндсэн эрх үүрэг” гэсэн I ангийн “Нийгэм - эдийн засгийн эрх, үүрэг, соёлын салбар дахь үүрэг” хэмээх III хэсгийн “Социал эрх, үүрэг” гэсэн II бүлгийн “Эрүүл мэндийг хамгаалах” гэсэн 64 дүгээр зүйлд “2.Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг дараах байдлаар хэрэгжүүлднэ:**

...b/хүүхэд, залуучууд, хөгшдийг хамгаалах явдлыг хангахуйц эдийн засаг, нийгэм соёлын ба экологийн нөхцөлийг буй болгох замаар амьдрал ба хөдөлмөрийн нөхцөлийг байнга сайжруулах, сургуулиуд, нийгэмд бүхэлд нь биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд тус дөхөм болгох, түүнчлэн эрүүл ахуйн гэгээрэл, эрүүл аж төрөх ёсны практикийг хөгжүүлэх замаар ...”.

“Залуучууд” хэмээн нэрлэсэн 70 дугаар зүйлд “Залуучууд нь өөрсдийн эдийн засаг, нийгмийн эрх, соёлын салбар дахь эрхийг хэрэгжүүлэхдээ онцгой хамгаалалтад байх бөгөөд чухамхүү энэ нь:

...x/ бие бялдарын хүмүүжил, спорт ...

“Биеийн тамир, спорт” гэж тусгайлан гарчигласан Португалийн Үндсэн хуулийн

“Соёлын салбар дахь эрх, үүрэг” гэсэн 3 дугаар бүлгийн 79 дүгээр зүйлд “Хүн бүр биеийн тамир, спорт эрхлэх эрхтэй.

Төр нь сургууль, спортын хамтлаг, хамт олонтой хамтран ажиллаж, биеийн тамир, спорт эрхлэх явдлыг урамшуулж, чиглүүлж, дэмжиж тэдгээрийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлж түүнчлэн спортод хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй” гэж заасан байна.

**Бразилийн Үндсэн хуулийн /1988/ “Хувийн ба хамт олны эрх, үүргийн тухай” I бүлгийн 5 дугаар зүйлд “Тус улсад оршин амьдарч буй бразильчууд, гадаадын иргэд ялгаварлан гадуурхагдахгүйгээр хуулийн өмнө бүгд эрх тэгш бөгөөд дараах үндэслэлд нийцүүлэн амьдрах эрх, эрх чөлөө, тэгш эрх, аюулгүй байдал, өмчийг баталгаа-жуулна.**

... а/Хамтын бүтээлд хувиараа оролцогчийн эрхийг хамгаалах ба спортыг оролцуулан хүн төрөлхтний дуу хоолой ба дүрслэлийн нөхөн үйлдвэрлэлийн эрхийг хамгаалах ...

“Холбооны тухай” II бүлгийн 24 дүгээр зүйлд Холбоо, штат, холбооны тойргийн хууль тогтоомжийн акт гаргах асуудлаархи өрсөлдөх эрх хэмжээнд

... IX – боловсрол, соёл, сургалт, спорт ...” гэж заасан байна.

**4.Хуучин социалист байсан улс орны Үндсэн хууль**

**Албанийн Үндсэн хуулийн /1998.10.21/ “Нийгмийн зорилго” гэсэн V бүлгийн 59 дүгээр зүйлд**

"1.Төрөөс үндсэн хуулийн эрх мэдлийн хүрээнд ба өөрт буй хөрөнгө санхүүгийн мэдэл түүнчлэн хувийн санаачилгыг хэрэгжүүлэхээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилготой.

...с/эрүүл мэндийг хамгаалах, бие махбодийн болон оюун санааны хөгжлийн түвшинг боломжийн хэрээр дээгүүр байлгах;

i) спорт, эрүүл мэндийг нөхөн сэргээх арга хэмжээг хөгжүүлэх ..." гэжээ.

**Болгарын Үндсэн хуулийн /1997.07.12/ "Иргэдийн үндсэн эрх", үүрэг гэсэн II бүлгийн 52 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Төрөөс иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, спорт ба жуулчлалыг хөгжүүлэх явдлыг урамшуулна" гэж тогтоожээ.**

**Македоны Үндсэн хуулийн /1991.11.17/ 47 дугаар зүйлд "Македоны Бүгд Найрамдах Улс нь техникийн соёл, спортод тус дөхөм үзүүлж тусална" хэмээн заажээ.**

**Польшийн Үндсэн хуулийн /1997.04.02/ 68 дугаар зүйлд "5.Засаг төрөөс ялангуяа хүүхэд, залуучуудын дунд биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ" гэж тодорхойлжээ.**

**Румыны Үндсэн хуулийн /1991.11.21/ "Үндсэн эрх, эрх чөлөө" гэсэн II бүлгийн "Хүүхэд, залуучуудыг хамгаалах" хэмээн нэрлэсэн 45 дугаар зүйлд "5.Засаг төрийн байгууллага залуучууд улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, спортын амьдралд чөлөөтэй оролцох нөхцөлийг хангахад тус дөхөм үзүүлэх үүрэгтэй" гэсэн байна.**

**Унгарын Үндсэн хуулийн /1949.08.18/ Иргэдийн үндсэн**

эрх, үүрэг гэсэн XII бүлгийн 70/D дугаар зүйлд:

"1.Бүгд Найрамдах Унгар Улсын нутаг дэвсгэрт амьдарч буй хүн бие махбодийн болон оюун санааны эрүүл мэндээ дээд зэргийн боломжийн өндөр төвшинд байлгах эрхтэй.

2.Энэ эрхийг Бүгд Найрамдах Унгар Улс хөдөлмөр хамгааллын байгууллага, эрүүлийг хамгаалах, эмнэлгийн үйлчилгээний байгууллагаар дамжуулан биеийн тамираар тогтмол хичээллэх явдлыг хангах, түүнчлэн хүнийг хүрээлэн буй байгалийн унаган болон буй болгосон орчныг хамгаалах зорилгоор хэрэгжүүлнэ" гэсэн байна.

**Хорватын Үндсэн хуулийн /1990.12.22/ "Хүний ба иргэний үндсэн эрх чөлөө, эрх" хэмээх III бүлгийн "Эдийн засаг, нийгэм, соёлын эрх" гэсэн 68 дугаар зүйлд "Төрөөс биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар тус дөхөм үзүүлж, анхаарал халамж тавина" гэжээ.**

**5.Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан хамтын нөхөрлөлийн улс орны Үндсэн хууль**

**Армений Үндсэн хуулийн /1995.06.05/ Хүний ба иргэний үндсэн эрх, эрх чөлөө гэсэн 2 дугаар бүлгийн 34 дүгээр зүйлд "төрөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлж, биеийн тамир, спортын хөгжилд тус дөхөм үзүүлнэ" гэж заажээ.**

**Белорусын Үндсэн хуулийн "Бие хүн, нийгэм, төр" гэсэн II хэсгийн 45 дугаар зүйлд "Бүгд Найрамдах Белорус Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, түүнчлэн**

биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх арга хэмжээ, нөхөн сэргээх байгууллагыг ашиглах боломж, хөдөлмөр хамгааллыг боловсронгуй болгох явдлаар хангагдах эрхтэй" гэж тодорхойлжээ.

**Кыргызийн Үндсэн хуулийн /1993.05.05/ "Иргэдийн эрх ба үүрэг" гэсэн 36 дугаар зүйлд "2.Төр нь түүхэн дурсгалт зүйлийг хамгаалж, уран зохиол, урлаг, шинжлэх ухаан, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ба спортыг хөгжүүлэхэд анхаарал халамж тавьж, зайлшгүй чухал нөхцөлийг бүрэлдүүлнэ" гэж заажээ.**

**Литвийн Үндсэн хуулийн /1992.12.15/ "Улс ардын аж ахуй ба хөдөлмөр" гэсэн IV бүлгийн 53 дугаар зүйлд "Төрөөс биеийн тамирыг хөхиүлэн урамшуулж, спортод тус дөхөм үзүүлнэ" гэж тогтоожээ.**

**Молдавын Үндсэн хуулийн /1994.07.29/ 50 дугаар зүйлд "Засаг төр нь залуучууд улс орны нийгэм, эдийн засаг, соёл, спортын амьдралд чөлөөтэй оролцох нөхцөлийг хангана" гэж тогтоожээ.**

**Таджикийн Үндсэн хуулийн "Хүний ба иргэдийн эрх, эрх чөлөө, үндсэн үүрэг" гэсэн II бүлгийн 38 дугаар зүйлд "Хүн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Энэ эрхийг улсын эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн үнэ төлбөргүй тусалцаа үзүүлэх, хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх арга хэмжээ, нийтийн спорт, биеийн тамир, аялал, жуулчлалыг буй болгох**

ба хөгжүүлэх явдлаар хангана” гэсэн байна.

**Туркмены Үндсэн хуулийн /1992.05.18/ “Хүний ба иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө, үүрэг”** гэсэн II хэсгийн 36 дугаар зүйлд “Төрөөс шинжлэх ухаан, соёл, урлаг, ардын уран бүтээл, спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ” гэж заасан байна.

**Украины Үндсэн хуулийн /1996.06.28/ “Хүний ба иргэдийн эрх, эрх чөлөө, үүрэг”** гэсэн II хэсгийн 49 дүгээр зүйлд “Төрөөс биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар анхаарал санаа тавьж, эрүүл ахуй, халдваргүйжилтийн сайн сайхныг хангана” гэж заажээ.

#### 6. Исламын улс орны Үндсэн хууль

**Ираны Үндсэн хуулийн (1979.12.23)** 3 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Исламын Иран улсын Засгийн газар 2 дугаар зүйлд дурдсан зорилгод хүрэхийн тулд бүхий л бололцоогоо дайчлан ашиглана.

3. Үнэ төлбөргүй боловсрол, бүх нийтэд ба бүхий л түвшинд бие бялдарын хүмүүжлийг хангах” гэж тогтоожээ.

**Туркийн Үндсэн хуулийн /1982.11.07/ “Залуучууд ба спорт”** гэсэн IX бүлгийн. “Спортыг хөгжүүлэх” гэсэн 59 дүгээр зүйлд “Төрөөс аливаа насны турк иргэдийн бие махбодийн болон оюун санааны эрүүл мэндийг хөгжүүлэхийн тулд арга хэмжээ авч, олон түмний дунд спортын уралдаан тэмцээнийг дэлгэрүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Төрөөс

гарамгай тамирчдад дэмжлэг тусалцаа үзүүлэх болно” гэж тогтоожээ.

Бид судалгааныхаа явцад 32 /53.4% / улс орны Үндсэн хуулиас биеийн тамир, спортын талаар нэн илэрхий тодорхой заалт олж чадаагүй юм. Энэ нь тухайлбал Азербайджан, АНУ, Англи, Бельги, Босни Герцеговины, Ватикан, Герман, Грузин, Дани, Индонез, Исланд, Итали, Казахстан, Кипр, Латви, Лихтенштейн, Люсембург, Мальт, Монако, Норвеги, Словак, Словени, Узбек, Финлянд, Франц, Чех, Швед, Эстон, Югослав, Япон зэрэг улс орон юм.

Ийм байдал нь хэд хэдэн учир шалтгаантай гэж үзэж болох юм. Тухайлбал:

**АНУ-ын Үндсэн хуулийн IX нэмэлтэд** зөвхөн Үндсэн хуульд заасан тодорхой эрхийг ард түмний бусад эрхийг үгүйсгэх буюу хязгаарлах байдлаар тайлбарлах ёсгүй болохыг тогтоожээ.

**ХВНГУ-ын Үндсэн хуульд биеийн тамир, спортын талаар хууль тогтоох онцгой эрх хэмжээг Холбооны болон Холбоо, Земелийн аль нь ч шийдвэрлэж болох асуудалд хамааруулж үзээгүй болох нь энэ салбарын төрийн зохицуулалтын бүрэн эрхийг земельд олгосон хэрэг юм. ХВНГУ-ын төр нь Үндсэн хуульдаа заасанчлан эрх зүйт Социал төр учраас биеийн тамир, спортын асуудал Социал төрийн чиг үүрэгт хамаарагддаг учраас түүнийг Үндсэн хуульд тусгайлан томъёолоогүй байж болох талтай.**

Биеийн тамир, спортын салбар дахь эрх зүйн харилцааг зохицуулж буй хэм хэмжээг агуулсан гадаад зарим орны

Үндсэн хуульд хийсэн шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

- Биеийн тамир, спортын талаар хэм хэмжээ байгаа дийлэнхи Үндсэн хуульд /75,0% / иргэдийн эрх, эрх чөлөө, үүргийн тухай бүлэг, хэсэгт энэ асуудлыг байршуулсан онцлог ажиглагдаж байна.

- Үндсэн хуульд биеийн тамир, спортын тухай заахдаа нэлээд тохиолдолд (25%) биеийн тамир, спортын асуудлыг эрхлэн хариуцах бүрэн эрхийг төрийн төв, бүс нутаг, орон нутгийн байгууллагад олгох, энэ талын хуваарилалтыг зохистой хийхэд анхаарал тавьсан байна.

- Хэд хэдэн улсын Үндсэн хуульд /17,9% / биеийн тамир, спортыг хөгжүүлэх явдлыг төрийн нийгмийн /Социал/ зорилгын нэг хэмээн тодорхойлсон байна.

- Хэд хэдэн улсын Үндсэн хуульд /17,9% / биеийн тамир, спортын салбарын эрх зүйн зохицуулалтын асуудлыг нэг бүс удаа, мөн хэд хэдэн бүлэг /хэсэг/-т тогтоосон байна.

Биеийн тамир спортын тухай асуудал гадаадын нэлээд олон оронд Үндсэн хуулийн төвшинд зохицуулагддаг бөгөөд үүнээс үзэхэд энэ асуудал манай оронд ч Үндсэн хуулийн зохицуулалтын зүйл байх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.



# УКРАИНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ



Үндсэн хуулийн цэцийн ажилтан  
Э.ЛХАГВАСҮРЭН

Украины Үндсэн хуулийн шүүх нь Украин дахь Үндсэн хуулийн хяналтын цорын ганц байгууллага төдийгүй тус улсын хууль цаазын гол нүүр царай нь болдог байна. Улс гүрнүүдийн Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг жишгээр Украины Үндсэн хуулийн шүүх нь өөрийн орны Үндсэн хуулийг баталгаа- жуулан дээдэлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий шүүх эрх мэдлийн дээд байгууллага юм.

Украины Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны зарчим, арга хэлбэр, зохион байгуулалт, бүрэн эрхийг Украины Үндсэн хууль /1996.06.28/, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль /1996.10.16/, Үндсэн хуулийн шүүхийн хуралдааны дэг /1997.03.05/-ээр тодорхойлдог.

Украины Үндсэн хуулийн шүүх нь өөрийн үйл ажиллагаандаа хууль ёсыг дээдлэх, бие даасан хараат бус байх, ил тод байх, шүүгчид эрх тэгш байх, маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд авч хэлэлцэх, шийдвэрийг үндэслэлтэй гаргах зэрэг зарчмыг баримтлан ажилладаг байна.

Украины Үндсэн хуулийн шүүх нь нийт 18 шүүгчээс бүрдэнэ. Эдгээрийн зургааг Украины Ерөнхийлөгч, зургааг Дээд Рад буюу парламент, зургааг Украины шүүгчдийн их хурлаас 9 жилийн хугацаатай томилдог ба тэдгээрийг дахин улируулан томилж болохгүй. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэх хүний талаар Украины Ерөнхий сайд болон Хууль зүйн сайдтай зөвлөлдсөний үндсэн дээр зарлиг гаргаж томилдог ажээ.

Украины Дээд Рад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг депутатуудаас нууцаар санал хурааж томилно. Парламентад Үндсэн хуулийн шүүгчээр нэр дэвшүүлэх хүний тухай саналыг Парламентын дарга оруулах эрхтэй ба холбогдох хороо нь санал болгосон нэр дэвшигч бүрийн талаар дүгнэлт гаргаж танилцуулна. Депутатуудын талаас илүү буюу олонхийн санал авсан нэр дэвшигчийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр томилдог.

Украины шүүгчдийн их хурлаас нээлттэй санал хураалтаар төлөөлөгчдийг сонгох ба Шүүгчдийн их хурлаас сонгогдсон төлөөлөгчид Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг нууц санал хураалтаар, олонхийн санал авсан хүнийг томилно. Шүүгчдийн хуралдаанаас шүүгчийг томилох тухай шийдвэрт хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга, шүүгчид гарын үсгээ зурж баталгаажуулдаг байна.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийг зогсоосон тохиолдолд тухайн шүүгчийг томилсон Ерөнхийлөгч, Дээд Рад

1 сарын дотор, шүүгчдийн хурлаас 3 сарын дотор орны хүнийг дахин томилно.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдаан болон маргааныг хянан шийдвэрлэх хуралдаан дээр тусгай нөмрөг өмсөж, энгэрийн тэмдгээ зүүсэн байх ёстой юм.

## Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх

Украины Үндсэн хуулийн шүүх дараах маргааныг хянан үзэн шийдвэрлэж дүгнэлт гаргана. Үүнд:

1. Хууль, Дээд Рад, Ерөнхийлөгчөөс баталсан бусад шийдвэр, түүнчлэн Сайд нарын акт, Автономт Крымын Бүгд Найрамдах Улсын Дээд Радын эрх зүйн актын талаар;

2. Украины Үндсэн хуульд нийцсэн Украины олон улсын гэрээ болон Дээд Радад орсон бусад олон Улсын гэрээ хэлэлцээр Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар;

3. Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах тухай Үндсэн хуулийн 111, 151-д заасан ажлыг мөрдөх хянан шийдвэрлэхэд Үндсэн хуулийг сахин биелүүлсэн эсэх талаар;

4. Үндсэн хууль, бусад хуулийн талаар албан ёсны тайлбар гаргах;

Крымын БНУ-ын төр засгийн байгууллагуудаас гаргасан шийдвэр, бусад эрх зүйн актын талаар болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, мөн түүнчлэн ердийн шүүхийн эрх хэмжээнд хамааралтай бусад асуудлууд нь Украины Үндсэн хуулийн шүүхэд хамаарахгүй.

### Үндсэн хуулийн шүүхийн дарга, түүний орлогч, тэдгээрийн эрх хэмжээ

Украины Үндсэн хуулийн шүүхийн тусгай хуралдаанаар Үндсэн хуулийн шүүхийн даргад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүрэлдэхүүнээс нууц санал хураалтаар олонхийн санал авсан шүүгчийг сонгоно. Үндсэн хуулийн шүүхийн даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил. Тэрбээр Үндсэн хуулийн шүүхийг төлөөлөн бусад байгууллага албан тушаалтантай харьцах бөгөөд түүний үйл ажиллагааг зохион байгуулахаас гадна дараах эрхийг хэрэгжүүлдэг:

- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн коллеги болон Нарийн бичгийн дарга, тусгай комиссын ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих;

- Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдааныг зарлан хуралдуулах;

- Төсвийн төслийн талаархи санал гаргах, батлагдсан төсвийг зарцуулах;

- Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах;

- Үндсэн хуулийн шүүхийн дотоод ажлын дэгийг баталж хэрэгжилтэд хяналт тавих;

- Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бусад асуудлаар ээлжит болон ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулах;

- Үндсэн хуулийн шүүхийн нарийн бичгийн дарга нарын газрын ажилтнуудыг урамшуулах болоод тэдэнд сахилгын шийтгэл ногдуулах;

- Үндсэн хуулийн шүүхийн нэрийн өмнөөс албан ёсны мэдэгдэл хийх болон хуулиар олгогдсон бусад бүрэн эрх.

Үндсэн хуулийн шүүхийн дарга өөрийн бүрэн эрхийн хүрээнд захирамж гаргана.

Украины Үндсэн хуулийн шүүхийн дарга нь 2 орлогч даргатай байдаг. Орлогч дарга нар даргын даалгавраар түүний бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн шүүхийн даргын түр

эзгүйд эсвэл өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд түүнийг насаар ахимаг нь орлох бөгөөд 2 орлогч хоёул эзгүйд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн хамгийн ахмад шүүгч даргыг орлодог журамтай. Үндсэн хуулийн шүүхийн 2 орлогч даргыг Үндсэн хуулийн шүүхийн даргын санал болгосноор нийт шүүгчдийн дотроос нууцаар санал хураасны үндсэн дээр 3 жилийн хугацаагаар сонгоно.

### Украины Үндсэн хуулийн шүүхийн шүүгч, түүний бүрэн эрх

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ болон шинжлэх ухаан эсвэл сурган хүмүүжүүлэх ажлаар 10-аас доошгүй жил ажилласан, Украинд сүүлийн 20 жил амьдарсан, Украин улсын 40 нас хүрсэн иргэн байна. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлд харьяалалгүй байх, улс төрийн аливаа үйл ажиллагаанд үл оролцох, мөн шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх, оюуны бүтээлээс бусад өөр хөлсний ажил гүйцэтгэх, түүнтэй адилтгах албан тушаал давхар эрхлэхийг хориглоно. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа тангараг өргөсөн өдрөөс эхлэх бөгөөд “Украины Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн өндөр албан үүргийг үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглаж, Украины Үндсэн хуулийг дээдлэн сахиж, хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалахаа тангараглая” хэмээн Дээд Радын хуралдаан дээр ёслол төгөлдөр тангараг өргөдөг журамтай.

Аливаа маргаантай асуудлыг Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанаар авч хэлэлцэхийн тулд урьдчилсан бэлтгэл ажиллагааг Үндсэн хуулийн шүүхийн шүүгч гүйцэтгэнэ. Тэрбээр Украины Дээд Рад, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Ерөнхий Прокурор, Крымын

БНУ-ын төр засгийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, тэдгээрийн албан хаагч, олон нийтийн болоод хувийн хэвшлийн бүхий л байгууллага, аж ахуйн нэгж, улс төрийн нам, эвсэл, өөр бусад иргэдийн нэгдэл болоод иргэдээс тухайн асуудлаар зайлшгүй чухал баримт бичиг, материал болон бусад мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Үндсэн хуулийн шүүхээр шалгагдаж байгаа болон тухайн маргаантай асуудлаар шийдвэр гараагүй байхад Үндсэн хуулийн шүүхийн шүүгч хэрэг маргааны талаар нийтэд мэдээлэх, санал солилцох, ярилцлага өгөх эрхгүй.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийг дараах тохиолдолд зогсооно. Үүнд:

1. бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

2. 65 нас хүрсэн;

3. эрүүл мэндийн байдлын улмаас өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон;

4. шүүгчийн тангаргийг зөрчсөн;

5. гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдож, ялын тогтоол гарсан бол;

6. шүүгчид тавигдах шаардлагыг зөрчсөн;

7. Украины иргэний харьяаллаас гаргасан бол;

8. Сураггүй алга болсонд тооцсон болон нас барсныг шүүхээс зарласан тохиолдолд;

9. Шүүгчийн албан тушаалаас огцрох тухай өргөдөл гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийг зогсооно.

Мөн тухайн шүүгч нас нөгчсөн бол түүний бүрэн эрхийг зогсооно.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хэнээс ч хараат бус байж, гагцхүү Украины Үндсэн хуульд захирагдах үүрэгтэй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг Дээд Радын



зөвшөөрөлгүйгээр саатуулах, баривчлах, хорихыг хориглоно. Шүүгчид Үндсэн хуулийн шүүхийн хуралдаан дээр болон шүүгчийн коллегид хэлсэн үг ярианых нь төлөө ямар нэг хариуцлага хүлээлгэж болохгүй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Украины Шүүгчийн статусын тухай хуулийн дагуу цалин хөлс авах бөгөөд бусад материаллаг хангамжийг эдэлдэг.

### Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, зохион байгуулалт

Украины Үндсэн хуулийн шүүхэд *Нарийн бичгийн дарга нарын газар* ажилладаг. Эдгээр нь Үндсэн хуулийн шүүхийн дотоод зохион байгуулалтын, шинжлэх ухаан магадлан шинжилгээний, мэдээлэл лавлагааны болон бусад боловсон хүчний асуудлыг хариуцан ажилладаг. Нарийн бичгийн дарга нарын газрын дотоод журам, түүний бүтэц, орон тоог Үндсэн хуулийн шүүхээс батална. Нарийн бичгийн дарга нарын газрыг мэргэжлийн шүүгч удирдах ба тэрбээр ямар нэг нам олон нийтийн байгууллагын харьяалалгүй хүн байх ёстой. Нарийн бичгийн дарга нарын тэргүүлэгчийг Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанаас олонхийн саналаар томилно.

Мөн Үндсэн хуулийн шүүх нь *байнгын ба түр комисстой* байдаг. Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдаанаар байнгийн комиссыг байгуулж, уг комисс Үндсэн хуулийн шүүхийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулахад туслах үндсэн үүрэгтэй. Байнгын комиссын даргыг Үндсэн хуулийн шүүхийн дарга өөрийн бүрэн эрхийн хугацаанд томилно. Харин түр комиссыг Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор, нэмэлт судалгааны чиглэлээр Бүгд хуралдаанаас байгуулдаг.

### Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдаан, хуралдаан

Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдааныг нийт шүүгчийн 12-оос багагүй нь оролцсоноор хүчинтэйд тооцно. Бүгд хуралдааныг Үндсэн хуулийн шүүхийн даргын болон түүний орлогчид, шүүгчийн коллеги, байнгын комисс болон Үндсэн хуулийн шүүхийн 3-аас доошгүй шүүгчийн санаачилгаар хуралдуулдаг. Бүгд хуралдаанаар байнгын комиссын тухай дүрмийг батлах, түр комисс байгуулах тухай шийдвэр гаргах, комиссын тусгай бүтцийг батлах, эдгээр комиссын даргыг томилох, Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт, шийдвэрийн батлах зэрэг асуудлыг шийдвэрлэдэг байна.

Харин Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанаар Үндсэн хуулийн шүүхийн дэгийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, Нарийн бичгийн дарга нарын газрын тухай, архив, номын сан болон бусад бие даасан бүтэц, хэсгүүдийн дүрмийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн шүүхийн даргын нэр дэвшүүлснээр Нарийн бичгийн дарга нарын тэргүүлэгчийг томилох, түүнийг албан тушаалаас нь халах тухай шийдвэр гаргах, байнгын комисс байгуулах тухай шийдвэр гаргах, түүний тусгай бүрэлдэхүүнийг батлах, Үндсэн хуулийн шүүхийн тухайн жилийн санхүүжилтийн хэмжээний талаархи саналыг хянаж үзэх, төсөвт санал тусгуулах, Үндсэн хуулийн шүүхийн орон тооны хуваарь болон бүтцийг батлах, төсвийн зарцуулалтын талаархи улирал бүрийн мэдээллийг сонсох, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон даргын орлогч нарыг хугацаанаас нь өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай шийдвэр гаргах, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай хуульд заасан үндэслэлээр

шийдвэр гаргах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

Үндсэн хуулийн шүүх өөрийн бие даасан нэгдсэн *архивтай*. Хэргийн материал, үйл ажиллагааны бусад материалуудыг архивт хадгалдаг. Хэргийн материалыг 100 жил, харин Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр ба дүгнэлтийн эхийг архивт хугацаагүйгээр хадгалахаар тогтоосон байдаг. Архивт хэрэг материалыг хадгалах, хамгаалах, архивын материалтай танилцуулах болон бусад дүрэм, журмыг Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанаар баталдаг. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд зориулж хууль тогтоомжийн эмхтгэл, шинжлэх ухааны болон хууль зүйн онолын болоод бусад хэрэгцээтэй ном сэтгүүлээр хангах үүрэг бүхий *номын сан* Үндсэн хуулийн шүүхэд ажилладаг. Украины Үндсэн хуулийн шүүх өөрийн байгууллагын үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийг нийтэд мэдээлэх үүрэг бүхий хэвлэлийн байгууллагатай бөгөөд нь түүнийх нь нэр "Украины Үндсэн хуулийн шүүхийн мэдээч" юм.

### Украины Үндсэн хуулийн шүүхийн дэгийн тухай

Үндсэн хуулийн шүүхийн дэг нь 1997 оны 3 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан. Уг дэгээр Үндсэн хуулийн шүүхийн дарга болоод орлогчдыг томилох журам, байнгын болон түр комисс байгуулах журам, шүүгчдийн коллеги, нарийн бичгийн дарга нар, тэргүүлэгчийг томилох, шүүгчдийн коллегийн хуралдаан явуулах журам, Үндсэн хуулийн шүүхийн хуралдаан, бүгд хуралдаан, хуралдаанд бэлтгэх журам, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх журам, Үндсэн хуулийн шүүхийн дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт болон бусад асуудлыг зохицуулдаг.



## Иргэний эрх зүйн харилцаа дахь төлөөлөл

Удирдлагын Академийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант Ц. ОЮУНЧИМЭГ

### §1. Төлөөллийн тухай ойлголт, ач холбогдол

**И**ргэний эрх зүйн харилцааны субъект бүр эрх зүйн чадамжаа өөрөө биечлэн хэрэгжүүлж, хэлцэл зэрэг эрх зүйн үйлдлийг хийх шаардлагатай байдаг. Гэхдээ амьдралын нөхцөл байдлууд заримдаа субъектын энэ мэт бие даасан байдалд саад учруулдаг бөгөөд эдгээр саад нь эрх зүйн /хууль зүйн хариуцлага хүлээх чадваргүй, эрх зүйн этгээд болох насанд хүрээгүй байх/ болон бодит /өвчтэй байх, эрх зүйн мэдлэг, боловсрол дутмаг, оршин сууж буй газар нь үйл ажиллагаа явуулдаг газраас нь алслагдсан байх, ажлын зав зай, цаг хүрэлцэхгүй байх гэх мэт/ шинж чанартай байж болно. Эдгээр тохиолдолд иргэний эрх зүй дэх төлөөллийн институтыг ашиглан, эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нь тохиромжтой хийгээд зайлшгүй шаардлагатай ойлголт юм.

Төлөөлөл гэдэг нь 1 этгээд /төлөөлөгч/ нь түүнд олгогдсон эрх мэдлийн хүрээнд өөр этгээд /төлөөлүүлэгч/ -ийн нэрийн өмнөөс хэлцэл зэрэг эрх зүйн үйлдлийг хийж, түүний үр дүнд төлөөлүүлэгчийн иргэний эрх, үүрэг үүсэх, дуусгавар болох эсвэл өөрчлөгдөхийг ойлгоно. Өөр бусад этгээдийн нэрийн өмнөөс болон түүний эрх ашгийн үүднээс хэлцэл зэрэг эрх зүйн үйлдэл хийж буй этгээдийг төлөөлөгч гэнэ.

Иргэн ба хуулийн этгээд нь өөрөө биечлэн хийхээр хууль буюу гэрээнд зааснаас бусад хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болдог.

Төлөөлүүлэгч гэдэг нь өөрийн нэрийн өмнөөс эрх зүйн үйлдэл хийлгэж, түүнээс эрх зүйн ямар нэгэн үр дагавар үүсгэхээр хэн нэгэн этгээдэд бүрэн эрх олгох эрх бүхий этгээдийг хэлнэ.

Төлөөллийн харилцаанд гуравдагч этгээд гэсэн ойлголт бий бөгөөд төлөөлөгч этгээдтэй хэлцэл хийх зэрэг эрх зүйн харилцаанд оролцож буй этгээдийг гуравдагч этгээд гэнэ.

Төлөөллийн харилцааны утга учир нь төлөөлөгч олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хэлцэл зэрэг эрх зүйн үйлдэл хийснээр төлөөлүүлэгч ба гуравдагч этгээдийн хооронд эрх зүйн харилцааг үүсгэх эрх зүйн нотолцоо болдог юм.

Төлөөлөгчийн хийж буй үйлдлийн эрх зүйн үр дагавар нь төлөөлөгчид биш харин төлөөлүүлэгч этгээдэд бий болж, төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл зэрэг эрх зүйн үйлдлийг гүйцэтгэх бөгөөд харин бодит үйлдлийг /тухайлбал, ачаа буулгах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэх мэт/ төлөөлөл хэмээн ойлгодоггүй юм.

Төлөөллийг хэрэглэх хүрээ маш өргөн боловч хууль буюу гэрээнд зааснаар төлөөлүүлэгч өөрөө биечлэн гүйцэтгэх ёстой тийм үйлдэл, үйл ажиллагаа гэж бий.

Тухайлбал, Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалтад хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийхийг хориглосон, эсвэл хэлцлийн шинж чанараас шалтгаалан хэлцэл хийгч заавал биечлэн хийвэл зохино хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж

болохгүй гэсэн зохицуулалт бий. Өөрөөр хэлбэл, өөрөө биечлэн гүйцэтгэх ёстой тийм үйлдэл, үйл ажиллагааг бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэхийг хоригложээ.

Төлөөллийг хэрэгжүүлэх явцад эрх зүйн 3 төрлийн харилцаа үүсдэг байна. Үүнд:

1. төлөөлөгч, төлөөлүүлэгчийн хооронд үүсэх эрх зүйн харилцаа;
2. төлөөлөгч, гуравдагч этгээдийн хооронд үүсэх харилцаа;
3. төлөөлүүлэгч, гуравдагч этгээдийн хооронд үүсэх эрх зүйн харилцаа юм.

Төлөөлүүлэгч, гуравдагч этгээдийн хооронд үүссэн харилцаа нь төлөөллийн харилцааны бүтцэд бие даан оролцдоггүй бөгөөд харин төлөөллийг хэрэгжүүлсний үр дүнд үүсдэг бол эхний хоёр төрлийн эрх зүйн харилцаа нь төлөөллийн харилцааны хоёр этгээд /тал/-ийг төлөөлж, тэдгээрийн хооронд үүсдэг. Үүнд: төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн олгосон бүрэн эрхийг хүлээн авсан дотоод /төлөөлөгч ба төлөөлүүлэгчийн хоорондын/ харилцаа болон тухайн бүрэн эрхийн хүрээнд төлөөллийг хэрэгжүүлж буй гадаад /төлөөлөгч ба гуравдагч этгээдийн хоорондын/ харилцаа юм.

Төлөөлүүлэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байж болохоос гадна эрх зүйн чадамжгүй этгээд ч гэсэн бусдаар өөрийгөө төлөөлүүлэх эрхтэй байж, иргэн болоод хуулийн этгээд нь төлөөллийн харилцаанд

төлөөлүүлэгчийн статустайгаар оролцож болдог. Төлөөлөгч нь иргэн болон хуулийн этгээд байж болдог бөгөөд төлөөллийн харилцаанд иргэн төлөөлөгчөөр оролцож байгаа бол тэрээр иргэний эрхийн чадвар, чадамжтай байх ёстой бол хуулийн этгээдийн хувьд зөвхөн түүний үүсгэн байгуулсан баримт бичиг /хуулийн этгээдийг үүсгэн байгуулах гэрээ, дүрэм гэх мэт/ - т хуулийн этгээдийн төлөөллийн тухай заалт орсон, эсвэл энэ үйлдэл нь түүний үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусгагдсан бол төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж болно. Монгол Улсын Иргэний хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид үйл ажиллагаагаа үндсэн хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулна.

Төлөөллийн харилцааг төлөөлөлтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй этгээдийн үйлдэл, үйл ажиллагаанаас ялгах нь зүйтэй байдаг.

Төлөөлөгч нь элчээс ялгаатай. Учир нь төлөөлөгч бие даан санал илэрхийлдгээрээ элчээс ялгаатай, өөрөөр хэлбэл элч нь өөрийн үйлдлээр эрх зүйн ямар нэгэн үр дагавар үүсгэдэггүй, харин зөвхөн бичиг баримт, мэдээлэл, хэлцэл хийх зэрэг зөвшөөрөл, мэдэгдлийг өөр бусад этгээдэд дамжуулдаг. Яг иймэрхүү шинж чанараараа төлөөлөгч нь бусдын гарын үсгийг төлөөлөн зурагчаас ялгаатай байдаг бөгөөд өөрөөр хэлбэл: бичиг үсэг мэдэхгүй, тахир дутуу, эсвэл өөр ямар нэг шалтгааны улмаас гарын үсгээ зурж чадахгүй хэн нэгэн этгээдийн хүсэлтээр түүний хийж буй хэлцэлд тухайн хүний гарын үсгийг төлөөлөн зурах тохиолдол бий.

Бусдын гарын үсэг төлөөлөн зурагч нь өөрийн хүсэл зоригийг илэрхийлэхгүй бөгөөд харин гагцхүү тухайн хүний гэрээ, хэлцэл хийх тухайн хүсэл зоригоо илэрхийлснийг нь баталж байгаа явдал юм.

Төлөөлөгч нь зуучлагчаас бие даан хэлцэл хийдгээрээ ялгаатай. Харин зуучлагч нь харилцааны аль ч талтай гэрээ, хэлцэл хийдэггүй бөгөөд зөвхөн өөрийн үйлдлээрээ талуудын хооронд гэрээ, хэлцэл хийхэд тус дөхөм болдог /боломжийн түншүүдийг олж өгөх, гэрээ, хэлцлийн нөхцөлийн талаар тэдэнтэй тохиролцох гэх мэт/ бөгөөд харин гэрээ, хэлцэл хийх хүсэл зоригоо зөвхөн гэрээнд оролцогч талууд өөрсдөө илэрхийлнэ. Тухайлбал, маклер зуучлагчийн жишээ болно. Бусдын эрх ашгийг хуульд заасны дагуу төлөөлж байгаа ч гэсэн өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй этгээдийг төлөөлөгч гэж үзэхгүй.

Тухайлбал, Монгол Улсын Иргэний хуулийн 175.6-д зааснаар дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд, дамгуурлын үе дэх хэрэг гүйцэтгэгч, гэрээслэл биелүүлэгч нарыг төлөөлөгч гэж үзэхгүй.

## §2. Төлөөлөх бүрэн эрх, түүний үүсэх үндэслэл, төлөөллийн төрөл

Төлөөллийн харилцаа нь ямагт төлөөлүүлэгчийн олгосон бүрэн эрхэд үндэслэгдэнэ. Төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс төлөөлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хийсэн хэлцэл нь төлөөлүүлэгчийн эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх эсвэл дуусгавар болгоно. Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэгт төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно.

Хэрэв төлөөлөгч төлөөлүүлэгчийн олгосон бүрэн эрхийг хэтрүүлсэн, эсвэл эрх олгогдоогүй асуудлаар төлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бол төлөөлүүлэгч нь түүний нэрийн өмнөөс эрх зүйн харилцаа тогтоосон гуравдагч этгээдийн

өмнө хууль зүйн ямар нэгэн хариуцлага хүлээхгүй бөгөөд харин төлөөлөгч эрх зүйн тухайн сөрөг үр дагаврыг хүлээх нь зайлшгүй болдог. Төлөөлөх эрхгүй этгээдээс хийсэн, төлөөлөгч бүрэн эрхээ хэтрүүлсэн эсвэл эрх олгогдоогүй асуудлаар хийсэн хэлцлийг төлөөлүүлэгч хүлээн зөвшөөрвөл үүсэх эрх зүйн үр дагаврыг төлөөлүүлэгч хариуцаж, уг хэлцлийг хүчин төгөлдөр болгоход Монгол Улсын Иргэний хуулийн 68 дугаар зүйлийн зохицуулалт шаардлагатай. Түүнд зааснаар төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдын нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй дур мэдэн хэлцэл хийсэн бол гуравдагч этгээд нь төлөөлүүлсэн этгээдээс уг хэлцлийг дэмжсэн зөвшөөрөл хүсвэл тэрээр 14 хоногийн дотор олгох бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсан гэж үзнэ.

Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн үйлдэл хийх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг арилгана.

Бүрэн эрх гэж юу вэ? Төлөөлөгч түүнийг хаанаас авдаг болон хэн бүрэн эрхийн хязгаарыг тогтоох вэ?

Бүрэн эрх гэдэг нь төлөөлөгч төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл зэрэг эрх зүйн үйлдэл хийж, төлөөлүүлэгчид эрх зүйн үр дагавар бий болгох эрх юм. Төлөөлөгчийн бүрэн эрх төлөөлүүлэгч этгээдийн өөрийн хүсэлтээр эсвэл эрх зүйн актын үндсэн дээр бий болдог бүрэн эрх олгох хэд хэдэн үндэслэл бий.

1. Төлөөлүүлэгч төлөөлөгчийн тусалцааг авах хүсэл зоригтой байх, энэ хүсэл зориг нь тодорхой гэрээнд тусгагдах /тухайлбал, даалгаврын гэрээ гэх мэт/ эсвэл итгэмжлэл олгосноор илэр- хийлэгдэнэ. Итгэмжлэлд төлөөлүүлэгч нь гарын үсэг зурж, эрх бүхий этгээдээр гэрчлүүлснээр сая төлөөллийн харилцаа үүснэ.

2. Өөр этгээдийн нэрийн өмнөөс эрх зүйн үйлдэл хийхийг даалгасан албан тушаалд томилогдох /сонгогдох/. Тухайлбал, улсын асрамжийн газар асрагчаар ажиллах эрх бүхий этгээд асруулагчийнхаа өмнөөс эрх зүйн үйлдэл хийх бүрэн эрхтэй болох, өөрөө хэлбэл, хөдөл- мөрийн гэрээний үндсэн дээр тухайн албан тушаалд ажилласнаар тэрээр бүрэн эрхтэй болдог учир үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд энэ харилцаанд итгэмжлэл шаардлагагүй юм.

3. Өөр этгээдийн нэрийн өмнөөс эрх зүйн нэг эсвэл хэд хэдэн үйлдэл хийхийг зөвшөөрсөн захиргааны акт. Тухайлбал, асрамжийн баагууллага нь асрагчид асруулагчийн нэрийн өмнөөс хэд хэдэн үйлдэл хийхийг зөвшөөрч олгосон нэмэлт бүрэн эрх байж болно. Асрагч нь асруулагчийн нэрийн өмнөөс ахуйн шинжтэй жижиг хэлцлийг л хийх эрхтэй бөгөөд асрах байгууллага үндсэн бүрэн эрхээс гадна нэмэлт бүрэн эрхийг захиргааны актын үндсэн дээр олгож болдог.

4. Хуульд заасны дагуу төлөөлөх бүрэн эрх үүсэх. Тухайлбал, иргэний эрх зүйн бүрэн бус, зарим, чадамжгүй иргэнийг төлөөлөх бүрэн эрх нь тэдгээрийн эцэг, эхэд нь хадгалагдана гэж Монгол Улсын Иргэний хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан нь бий.

Төлөөлөгч болон түүний бүрэн эрх нь хууль эсвэл захиргааны актаар тодорхойлогдсон бол үүнийг хууль ёсны төлөөлөл гэнэ. Төлөөллийн энэ төрөл нь нэн түрүүнд эрх зүйн чадамжгүй /бага насныхан, сэтгэл мэдрэлийн өвчтэй гэдэг нь эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зэрэг/ хүмүүсийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байдаг юм. Хууль ёсны төлөөллийн хэрэгжилтийн үед төлөөлүүлэгч нь төлөөлөгчийг томилох, түүний бүрэн эрхийг тодор- хойлох, төлөөлөгчийн үйл ажиллагаанд нөлөөлөх болон бүрэн эрхийг нь цуцлах

боломжгүй байхгүй бөгөөд төлөөлүүлэгчийн хууль ёсны төлөөлөгч нь эцэг, эх, үрчлэн авагч, асран хамгаалагч байдаг.

Төлөөллийн өөр нэг хэлбэр нь төлөөлүүлэгч өөрийгөө төлөөлөх төлөөлөгчийг болон мөн түүний бүрэн эрхийг тодорхойлох сайн дурын /төлөөлүүлэгчийн хүсэлтээр хийгдсэн/ төлөөлөл юм. Энэхүү төлөөллийн бүрэн эрхийг ихэнхдээ итгэмжлэл өгөх замаар олгох бөгөөд энэ тохиолдолд төлөөлүүлэгч нь төлөөлөгчийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй байх бөгөөд гэрээ, итгэмжлэлийг цуцлах зэргээр төлөөллийн үйл ажиллагааг дуусгавар болгох эрхтэй байдаг.

### §3. Итгэмжлэл, түүний төрөл

“Итгэмжлэл” хэмээх ойлголт нь “бүрэн эрхтэй” гэсэнтэй ижил төсөөтэй мэт боловч тэрээр өөр утгатай бөгөөд “бүрэн эрхээ шилжүүлэх” гэсэн үг юм. Бүрэн эрхээ шилжүүлэх нь төлөөлөгч өөрийн эрхээ гуравдагч этгээдийн өмнө баталгаажуулсан байх явдал бөгөөд бүрэн эрхээ шилжүүлэхийн нэг хэлбэр бол итгэмжлэл юм. Нэг этгээд /итгэмжлэгч/ өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйлдэл, үйл ажиллагаа гүйцэтгэх бүрэн эрхийг нөгөө этгээд /итгэмжлэгдэгч/-д олгосноо бичгээр илэрхийлснийг итгэмжлэл гэнэ.

Итгэмжлэлийг бичиг /баримт/-ийн хэлбэрээр түүнд төлөөлүүлэгчээс төлөөлөгчид шилжүүлж буй бүрэн эрхийн агуулга болон хүрээ хязгаарыг зааж өгнө. Итгэмжлэл нь нэг талт хэлцэл бөгөөд төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн олгосон итгэмжлэлийн үндсэн дээр түүний эрх ашигт нийцсэн үйлдэл, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Итгэмжлэлийг хэд хэдэн шалгуураар ангилж болох бөгөөд үүнд:

1. төлөөлөх бүрэн эрхийн хугацаагаар:

а. хугацаатай итгэмжлэл;

б. хугацаагүй итгэмжлэл гэж ангилж болно.

Тухайн итгэмжлэлд төлөөлүүлэгч нь өөрийгөө төлөөлүүлэх хугацааг заасан байвал тэрхүү итгэмжлэлийг хугацаатай итгэмжлэл гэнэ. Хугацаатай итгэмжлэлийн хугацааг Монгол Улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.5-д 3 жилээс дээшгүй хугацаагаар тогтоосон.

Тухайн итгэмжлэлд төлөөлүүлэгч нь өөрийгөө төлөөлүүлэх хугацааг заагаагүй бол тэрхүү итгэмжлэлийг хугацаагүй итгэмжлэл гэнэ. Хугацаагүй итгэмжлэл нь олгогдсон өдрөөс хойш 1 жил хүчинтэй байхаар Монгол Улсын Иргэний хуулийн мөн зүйлээр зохицуулжээ.

Итгэмжлэлд тавигдах хууль зүйн шаардлага гэж бий бөгөөд энэ нь итгэмжлэл олгосон он, сар, өдөр, итгэмжлэлийн хугацаа, мөн итгэмжлэл олгосон этгээдийн гарын үсэг, хуульд заасан бол тухайн итгэмжлэлийг нотар- иатаар гэрчлүүлсэн байх явдал юм. Энэ шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна. Хуулийн этгээдийн олгосон итгэмжлэлд дээрх шаардлага тавигдахаас гадна тухайн итгэмжлэлд хуулийн этгээдийн эрх баригчийн гарын үсэг, тамга, тэмдэг нь дарагдсан байх бөгөөд хэрвээ хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын үсэг зурсан байх хууль зүйн шаардлага бий.

2. итгэмжлэлийг төлөөлөх бүрэн эрхийн хүрээгээр:

а. ерөнхий итгэмжлэл;

б. тусгай итгэмжлэл;

в. нэг удаагийн итгэмжлэл гэж ангилж болно.

Ерөнхий итгэмжлэл гэдэг нь төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн олгосон итгэмжлэлийн үндсэн

дээр эрхийн ямар нэг хязгаарлалтгүйгээр, түүний эрх ашигт нийцсэн бүхий л үйлдэл, үйл ажиллагаа, хэлцэл хийхийг ойлгоно. Тухайлбал, өмгөөлөгчийн хийж буй төлөөллийг энд дурдаж болно.

Тусгай итгэмжлэл гэдэг нь төлөөлүүлэгч нь өөрийн нэрийн өмнөөс тодорхой ямар нэгэн үйлдэл, үйл ажиллагаа хийхийг зөвшөөрч, төлөөлөгчид олгосон итгэмжлэлийг ойлгоно. Тухайлбал, жолоо шилжүүлэх тухай итгэмжлэл, хуулийн этгээдийн мөнгөний нярав хуулийн этгээдийг төлөөлж банкнаас мөнгө авах гэх мэт.

Нэг удаагийн итгэмжлэл гэдэг нь төлөөлүүлэгч нь өөрийн нэрийн өмнөөс тодорхой ямар нэг үйлдэл, үйл ажиллагаа хийхийг зөвшөөрч төлөөлөгчид олгосон итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөгч нэг л удаагийн үйлдэл хийгээд дуусгавар болдог итгэмжлэл юм. Тухайлбал; банкнаас мөнгө авах 1 удаагийн итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөгч нэг л удаагийн үйлдэл хийдэг бол тусгай итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөгч үргэлжилсэн хэд хэдэн удаагийн үйлдэл хийдгээрээ нэг удаагийн итгэмжлэл нь тусгай итгэмжлэлээс ялгаатай юм.

### 3. итгэмжлэлийг гэрчлэх этгээдээр:

а. нотариат гэрчлэх итгэмжлэл;

б. өөр бусад этгээд гэрчлэх итгэмжлэл гэж ангилж болно.

Нотариатаар гэрчлүүлэхээр хуульд заасан хэлцэлтэй холбогдсон итгэмжлэлийг нотариат гэрчлэхийг Монгол Улсын Иргэний хуулийн 64 дүгээо зүйлийн 64.2.4-д заасан нь бий. Тухайлбал, тээврийн хэрэгслийг шилжүүлэх тухай итгэмжлэл, гарын үсэг гэрчлэх гэх мэт.

### Итгэмжлэлийг гэрчлэх өөр бусад этгээд гэдэгт :

а/ цэргийн албан хаагчийн итгэмжлэлийг түүний алба хааж буй анги, байгууллагын удирдлага гэрчлэх /Монгол Улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэг/;

б/ хорих газар хүмүүжиж буй иргэний олгосон итгэмжлэлийг хорих байгууллагын дарга гэрчлэх /Монгол Улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэгт/

### 4. итгэмжлэлийг эрх шилжих байдлаар:

а. анхдагч итгэмжлэл;

б. үүсмэл итгэмжлэл;

Анхдагч итгэмжлэл гэдэгт итгэмжлэгчээс анхны итгэмжлэгчид олгосон итгэмжлэлийг ойлгоно. Итгэмжлэлд уг үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлж болохоор заасан, эсвэл итгэмжлэгчийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай байвал итгэмжлэлийг бусдад шилжүүлж болох бөгөөд түүнийг үүсмэл итгэмжлэл гэнэ.

Төлөөлөгч эрхээ бусдад шилжүүлсэн тухайгаа мөн итгэмжлэлийг шилжүүлэн авсан этгээдийн талаархи мэдээллийг төлөөлүүлэгчид мэдэгдэх үүргийг хуулиар хүлээсэн байдаг бөгөөд хууль зүйн энэ үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүсэх эрх зүйн сөрөг үр дагаврыг төлөөлөгч хариуцахаар зохицуулагдсан болно.

Монгол Улсын Иргэний хуулийн 67 дугаар зүйлд зааснаар дараах үндэслэлээр төлөөллийн харилцаа дуусгавар болно:

а/ төлөөлөгч бүрэн эрхээсээ татгалзсан;

б/ төлөөлүүлэгч өөрийн олгосон бүрэн эрхийг хүчингүй болгосон;

в/ хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол төлөөлүүлэгч буюу төлөөлөгч нас барсан, эсвэл эрх зүйн чадамжгүй болсон;

г/ итгэмжлэл олгосон хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон;

д/ бүрэн эрхийн хэрэгжүүдсэн;

е/ бүрэн эрх хэрэгжүүлэх хугацаа дууссан;

ё/ хуулиар тогтоосон төлөөлүүлэх үндэслэл дуусгавар болсон бол хуульд заасан журмаар тус тус дуусгавар болно.

Төлөөлүүлэгч нь итгэмж-лэлээ хүчингүй болгосноо төлөөлөгч буюу гуравдагч этгээдэд мэдэгдэх бөгөөд итгэмжлэл хүчингүй болсныг мэдээгүй буюу мэдэх бололцоогүй байхад төлөөлөгч бусад этгээдтэй хэлцэл хийсэн бол тэрхүү хэлцэл хүчин төгөлдөр байна.

Итгэмжлэгч хэдийд ч итгэмжлэлээ цуцлах, итгэмжлэгдэгч итгэмжлэлээс хэдийд ч татгалзах эрхтэй бөгөөд эдгээр эрхийг эдлэхгүй гэж тохиролцож байгуулсан итгэмжлэл хүчин төгөлдөр бус байхаар Монгол Улсын Иргэний хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэгт тусгажээ.



# ХӨРШИЙН ЭРХ

МУИС-ийн магистрант Б.ГЭРЭЛ

**Н**ийгэмд хүн бүр өөрийн Намьдралын сайн сайхан хийгээд жаргалтай, тогтвортой байдлыг хадгалан баталгаажуулахын төлөө амьдрах нь ойлгомжтой. Он цаг улиран өнгөрөх тутам хүн төрөлхтөнд тэдний өөрсдийн оюун ухаанаар бүтээсэн хөгжил дэвшил нь хүн бүрт өргөн сонголтыг бий болгож тэдэнд өөрсөд нь илүү нарийн түвэгтэй зохион байгуулалт шаардагдаж байна. Аливаа улсын Үндсэн хууль нь иргэнийхээ эдэлж болох бүхий л эрх боломжийг бататгаж бэхжүүлж өгөх зорилгыг агуулдаг билээ.

Хүний эрхийн суурь нь өмчтэй байх, түүнийгээ хамгаалуулах эрх юм. Манай оронд өрнөж буй нийгэм, эдийн засгийн шилжилтийн энэ үед бид аливаа өмчлөгчийн эрхийг бүх талаас нь хамгийн оновчтой арга замаар зохицуулах шаардлагатай юм. Ингэж чадвал бидний хүмүүнлэг иргэний нийгмийг улс эх орондоо бүтээн байгуулах үйлс зөв голдирлоороо цааш хөгжих чухал алхам болох ёстой.

Монгол Улсад урьд өмнө хөршийн эрхийн харилцааг хууль тогтоомжийн актаар зохицуулж байсан эсэхийг судалсан тусгай судалгаа байхгүй байна. Хүний нийгмийн оршин тогтнох эх үндсийн нэг нь хамтран амьдрах явдал юм. Хүн нийгэмд хамтран амьдарч байгаа тэрхүү нөхцөлд өөрсдийн аж төрөх, амьдрах

ахуй нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн удирдлага дор хамтын хөдөлмөр эрхэлж өөрсдийн хувийн өмч эд хөрөнгийг бий болгодог. Тиймээс айл өрхийн амьжиргааны үндэс нь хувийн мал, эд хөрөнгө байсан. Энэ үндсэн дээр зэргэлдээ орших өмчлөл, эзэмшил бүхий аливаа төрлийн өмчид тулгуурласан, аж ахуй, газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгөнд үндэслэж хөршийн эрхийн харилцаа хөндөгдөн гарч ирэх юм. Энэхүү харилцаа нь хүний нийгэм оршин тогтнож буй нөхцөлд байсаар ирсэн бөгөөд тодорхой хууль эрх зүйн зохицуулалт байгаагүй учир хөршийн эрхийн харилцаа хөндөгдөх нөхцөлд өөр хоорондоо тохиролцон зөвшилцөж зохицуулах ба боломжгүй нөхцөлд зэргэлдээ орших үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигчийн сөрөг нөлөөллийг таслан зогсоох, шаардах эрхийн үндэслэл, арилгах арга зам тодорхойгүй, энэ харилцаанд хэн нэг этгээдийн эрх зөрчигдөх явдал гарч байсан. Монгол Улсын Иргэний шинэ хуульд хөршийн эрх гэсэн зохицуулалт анх удаа орж байгаа нь өмчийн эрхийн харилцаанд нэлээд ач холбогдолтой юм.

**И**ргэний хуулийн 135.1-д зааснаар “хөрш залгаа эд хөрөнгөний нэг талын өмчлөгч буюу эзэмшигч нь өөрийн эд хөрөнгөө ашиглахад саад болохооргүй нөгөө талын зайлшгүй шаардлагатай нөлөөллийг хязгаарлаж

болохгүй гэж, 135.2-т” “Нөлөөлөл нь ноцтой боловч нөгөө тал нь өөрийн эд хөрөнгөө аж ахуйн ердийн зориулалтаар ашиглах зайлшгүй шаардлагаар ийнхүү нөлөөлж байвал Иргэний хуулийн 135.1-д заасан журам нэгэн адил үйлчлэх бөгөөд хэрэв энэ нөлөөлөл нь ердийн ашиглалтын үед байж болох хэвийн хэмжээнээс хэтэрсэн гэж үзвэл нөгөө тал нь ийнхүү нөлөөлж байгаа талаас мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр шаардах эрхтэй” гэжээ.

Үүнээс үзвэл нөгөө талын зайлшгүй шаардлагатай нөлөөлөл гэж юуг ойлгох, ноцтой биш нөлөөлөл, хэвийн хэмжээнээс хэтэрсэн, аж ахуйн ердийн зориулалт, ашиглалт гэж юуг ойлгож, юуг үндэслэж тогтоон шийдвэрлэж, дүгнэлт гаргах талаар бүрхэг заалт оруулсан гэж үзэж болох юм. Учир нь ихэнх улсад энэ асуудлыг техникийн талаас нь зохицуулсан хууль тогтоомжийн акт гаргасан байдаг байна. Жишээ нь, хот дотор нисэх онгоцны буудал баривал моторын дууны дээд хэмжээ ямар байх тухай тусгасан байдаг. Авто машин, үйлдвэрийн газруудын гаргаж болох хорт хий, утааны хэмжээг заасан, мөн шөнө ажилладаг цэнгээний газруудын гаргаж болох дуу чимээ зэргийг зохицуулсан байдаг. Эдгээр зохицуулалтууд нь өмчлөгчийн өмчлөх эрхээ хэрэгжүүлэх боломжийг нь хангахад чиглэсэн байдаг.<sup>1</sup>

1. Монгол Улсын шинэ иргэний эрх зүй, тэргүүн дэвтэр, 85 дахь тал.

Ийм зохицуулалт байдаг тохиолдолд саад болохуйц нөлөөлөл гэж ямар нөлөөллийг хэлэх вэ? гэдэгт хариулахад хялбар байна. Зохицуулах гэж байгаа харилцааныхаа мөн чанар, агуулга, хөгжлийн хандлагыг судлах ухаарах явдал чухал бөгөөд тэрхүү харилцааг ойлгохгүйгээр, судлахгүйгээр зохицуулах тухай бодох ч аргагүй юм.<sup>1</sup>

Хөршийн эрхийн ойлголт нь эртний Ромын эрх зүйгээс үүдэлтэй.

Ромд хөршийн төсвэрлэх хэмжүүрийн хэвийн үйл ажиллагааны тухай Р.Фон Иерингийн үндсэн үзэл баримтлалд "Хэрвээ миний хөрш замбараагүй байдлаас болж мэдрэлийн ядаргаа тусч, зовж байвал хүмүүст бүрэн дүүрэн зөвшөөрч болохуйц чимээ шуугианы хэмжээг тогтоох, мөн надад төгөлдөр хуур тоглохыг хориглоно" гэжээ. Энэ хэмжүүрийг өмчлөгчдийн хэвийн хэмжээний үйл ажиллагааны талаархи зонхилох байдлыг нийтэд үзүүлж тооцон зөвшөөрдөг ба энэ нь техникийн хөгжил дэвшлээр солигдон өөрчлөгддөг байх учиртай. Энэ нь хөрш зэргэлдээ өмчлөгчийн эрхийг хамгаалах, түүнийг зөрчихгүй байх үүднээс өөрийн өмчлөх эрхийг хязгаартай хэрэгжүүлж үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг тусгахыг хэлдэг байна. Мөн хөршийн дурын зохисгүй үйл ажиллагааны нөлөөллөөс хамгаалах зорилгоор ойролцоо жижиг дүрмийг баримтлан дагаж мөрддөг. Үүнд: гэрэл, дуу чимээ, утаа, хиншүү, үнэр нэвтрэх гэх мэт. Хөршийн ашиг сонирхлыг зөвшөөрч зохицуулах өмчийн эрх зүйн үндсэн зарчмыг баримталдаг байна.

Хэрвээ утааны эх үүсвэр нь өвлийн улиралд ажиллаж байгаа дулаацуулах халаалтын систем болдог бол хөршийн газарт нэвтрэх утааг зогсоох шаардлага тавьж болдоггүй. Мөн хөршийн нөлөөлөх чимээ шуугианы хэм хэмжээг тогтоох, төгөлдөр хуур тоглохыг хориглох тохиолдол зэргийг тодорхой зааж, зохицуулж байсан байна Эндээс авч үзвэл Монгол Улсын Иргэний хуулийн 134-140 дүгээр зүйлд тусгасан хөршийн эрхийн заалт нь өмчлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг бусдын өмчлөх эрхээр хязгаарлах ба зайлшгүй шаардлагатай аж ахуйн ердийн зориулалтын үед хэвийн хэмжээнээс хэтрээгүй бол хязгаарлахгүй байх нөхцөлийг тусгасан. Гэвч хуульд энэ талаар тодорхой нарийвчлан зохицуулах хэм хэмжээг тусгаагүй байх бөгөөд ердийн нийтлэг хэм хэмжээнд тулгуурлаж, тухайн нөлөөллийг саад болохуйц эсэхийг нь тодорхойж болох боловч энэ нь тодорхой тохиолдол, хэрэг маргааныг шийдвэрлэх үед хэн нэгэн этгээдийн зүй ёсны эрх ашгийг хохироож болох талтай юм. Иргэний хуулийн 135 дугаар зүйлийн 2-д хөршийн нөлөөллийг хориглон хязгаарлах бөгөөд зайлшгүй шаардлагатай хэвийн хэмжээнээс хэтрээгүй нөлөөлөл нөлөөллийг тусгасан байна.

Гэтэл хэвийн хэмжээнээс хэтрээгүй зайлшгүй нөлөөлөл гэж ямар нөлөөлөл болохыг тусгасан зохицуулалт байхгүй байна. Энэ үүднээс дээр дурдсанаар баар цэнгээний газар ажиллуулах, үйлдвэр үйл ажиллагаагаа зайлшгүй явуулах шаардлагатай тул түүнээс гарах дуу чимээ, тоос шороо, утааг хөрш залгаа үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч зайлшгүй шаардлагатайн

улмаас үйл ажиллагаа явуулж байгаа тул зөвшөөрөх үү? Эсвэл эрх зөрчиж байна гээд үйл ажиллагааг нь зогсоох уу? Тухайлбал, гуанз, баар цэнгээний газар, үйлдвэр лэлийн үйл ажиллагааг зогсоох гэх мэт. Иймээс энэхүү зөрчилтэй асуудлыг зохицуулах үүднээс энэ талаар Монгол Улсын Иргэний хуульд тодорхой тусгаж өгөх нь ач холбогдолтой юм.

Зарим судалгааны дүнгээс үзэхэд орон сууцны хороолол болон сууц эзэмшигчдийн бухимдлыг төрүүлж, эрхийг зөрчиж байгаа зөрчлийн гол хэлбэр нь орон сууцны доор гуанз, баар цэнгээний газар ажиллуулснаас гарах дуу чимээ, үнэр, барилга байгууламжийн үйл ажиллагаанаас үүсэх тоос шороо, бохирдол зэрэг зөрчил элбэг гарч байгааг үндэслэж дээрх заалтыг тодруулах шаардлагатай байна. Мөн Иргэний хуулийн 135 дугаар зүйлийн 3-т хөрш залгаа газрыг эзэмшигч нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой хохироож болох барилга байгууламжийг газар дээр буюу доор барих ашиглахыг хориглон нөгөө талын өмчлөгч буюу эзэмшигчээс эрх зөрчсөн үйлдлээ зогсоохыг шаардах эрхтэй гэж заасан бөгөөд энэ талаар Италийн Иргэний хуульд ч мөн адил тусгасан байдаг байна. Тухайлбал, барилгын хоорондын зай түүнийг барьж байгуулах журам, хананы заагийг зайлшгүй хамтарсан эзэмшигчид хилийн заагийг тогтоох нөхцөл болоод хүлээх үүрэг хариуцлага, хүлээхгүй байх нөхцөл зэргийг зохицуулж өгсөн байна.

Хөршийн эрх гэдэг нь зэргэлдээ оршин харилцан нөлөөлж болох газар болон

1. "Эрх зүй" сэтгүүл, 2000 он, №1 73 дахь тал

бусад үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөл эзэмшилдээ байлгах эрх бүхий этгээдүүдийн хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулах эрхийг хэлнэ. Хоёр талаас харилцан нөлөөлж болох хил залгаа эзэмшил газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийг хөрш залгаа эд хөрөнгө гэж үзнэ. /Иргэний хуулийн 134.1/. Хөршийн эрхийн харилцаа үүсэх үндэслэл нь хөрш зэргэлдээ орших газар болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч болон эзэмшигч хэн нэгний тодорхой нэг үйлдлээс нөгөө талын өмчлөгч эзэмшигчийн эрх зөрчигдсөн нөхцөлд үүсэх харилцаа болно.

**Хөршийн эрхийн харилцааны үндсэн шинж:**

1. Тус тусдаа өмчлөгч бүхий хоёр үл хөдлөх эд хөрөнгийн эрх.

Хөршийн эрхийн харилцаанд ямагт хоёр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өртөгддөг ба нэг талаас эрхээ хэрэгжүүлэх гэж буй өмчлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийн, нөгөө талаас өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд эрх нь хязгаарлагдсан өмчлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрх байна. Үүнд газар болон үл хөдлөх эд хөрөнгөнд хамаарах барилга байгууламж байна. Энэхүү хоёр үл хөдлөх эд хөрөнгө нь тус тусдаа өмчлөгчтэй байна.

2. Харилцаанд өртөгдөх объект гагцхүү үл хөдлөх эд хөрөнгө байна. Үл хөдлөх эд хөрөнгийн асуудал нь шууд газартай холбогддог. Газар нь доорх хоёр шинжийг өөртөө агуулдаг.

**А. Үл хөдлөх чанар.** Газар хөдлөлт хэмээх байгалийн үзэгдлээс бусад тохиолдолд газар үл хөдөлнө. Газрыг зөөж авч явах боломжгүй тул газар өмчлөгч

нь үргэлж өөрийн өмчлөлийн газар дээр байна гэж хэлэх аргагүй. Тиймээс газар өмчлөгчийн хууль ёсны эрхийг баталгаажуулъя гэхэд тухайн газрыг хэн өмчилж байгааг гаднаас нь хараад мэдэх хялбар бус байдаг. Ялангуяа газрыг өмчлөгч болон одоо эзэмшиж, ашиглаж буй субъект нь өөр өөр хүн бол энэ асуудал бүр ч ярвигтай болно. Ийм учраас өмчлөх эрх зэргийг дэвтэр болон компьютерийн файлд бүртгэж, сонирхсон хүмүүст үзүүлж байх механизм бий болжээ.

**Б. Газрын тасралтгүй үргэлжлэх чанар.** Газар нь тасралтгүй үргэлжлэх бөгөөд усаар бүрэн хүрээлэгдсэн хувийн өмчийн жижиг арлуудаас бусад нь заавал бусдын өмчлөлийн газартай хөрш залгаа байдаг. Иймээс газрыг ашиглах нь бусад хүмүүс, хүрээлэн буй орчинд ямар нэг нөлөөлөл үзүүлэх явдал их байдаг тул хөрш залгаа газрын ашиглалтад зохицуулалт хийх шаардлагатай болдог.

3. Үл хөдлөх эд хөрөнгө нь хил залгаа буюу зэргэлдээ оршин байх.

Иргэний хуулиар үл хөдлөх эд хөрөнгө нь хил залгаа газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийг хөрш залгаа эд хөрөнгө гэж үзэх нөхцөлийг заасан байна. Үүгээрээ сервитут эрхтэй холбогдоно. Хөршийн эрхийн харилцааны зохицуулалтын гол шинж газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрх нь нөгөө өмчлөгчийн эрхээр хязгаарлагдахыг өөрөөр хэлбэл бусдын өмчийн эрхийг хүлээн зөвшөөрөх үүргээр тодорхойлогдоно. Тиймээс энэхүү харилцаа нь үүргийн эрх зүйн зохицуулалтаар гэрээний тусгай төрлийн бүлэгт тусгагдаагүй шинэ гэрээг

талууд харилцан тохиролцож байгуулж болох талаар зөвшөөрсөн байх бөгөөд гэрхүү гэрээ нь хуульд үл харшлахыг шаарддаг. Хөршийн эрхийн харилцаа үүсэх үндэслэл болон эрхийг зөрчих хэлбэр болох чанга дуу чимээ, цонхоор тусах нарны гэрлийг хаах, тоос шороо босгох болон агаар бохирдуулсан бусад үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах гэх мэт өмчлөх эрхийг нь зөрчиж буй үйлдэл үйл ажиллагааг өмчлөгч хуульд зааснаар эрхээ хэрэгжүүлэх зорилгоор таслан зогсоохгүйгээр нөгөө талын өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцож төлбөр төлөх үүрэг ногдуулах аргаар хоорондоо гэрээ байгуулж болох юм. Тухайлбал, Иргэний хуулийн 134 дүгээр зүйлийн 2-т хөрш залгаа эд хөрөнгө өмчлөгч буюу эзэмшигч нь хуулиар тогтоосон эрх үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд нөгөө талын өмчлөгч эзэмшигчийн эрхийг харилцан хүндэтгэх үүрэгтэйг мөн 135 дугаар зүйлийн 1-д хөрш залгаа эд хөрөнгийн нэг талын зайлшгүй шаардлагатай нөлөөллийг хориглон хязгаарлаж болохгүйг заасан байна.

Хөршийн эрхийн харилцаанд дахь сервитутын эрх нь хөрш зэргэлдээ эд хөрөнгө өмчлөгч эзэмшигчийн хооронд үүсдэг бие даасан тусгай эрхийн харилцаа юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд хөршийн эрхийн харилцааг Иргэний хуулиар зохицуулах болсон нь том дэвшил бөгөөд цаашид уг зохицуулалтыг бусад улсын жишиг, өөрийн орны онцлогийг харгалзан зохицуулалтыг боловсронгуй болгох, иргэдэд шинэ зохицуулалтаар бий болгож байгаа эрхийнх нь талаар сурталчлах, хялбарчилсан сургалт зохион байгуулах шаардлага тулгарч байна.





## ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ХУГАЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний  
ажилтан П.БАТТОГТОХ

### 1. Нийгмийн хөгжлийг удаашруулагч хүчин зүйлсийн нэг бол хүнд суртал мөн

Монгол Улс 1990-ээд оны ардчилсан хувьсгалаар хүнд суртал, захиргаадальт ноёрхсон, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, улс төрийн тоталитари дэглэмийг халж, оронд нь иргэнийг дээдэлсэн, иргэндээ үйлчилдэг нийгмийг байгуулахаар шийдэж, үүнийгээ ч 1992 оны Үндсэн хуульдаа тусган хэлбэршүүлсэн нь том дэвшил болсон билээ. Гэхдээ Үндсэн хуульдаа тусгасан зорилгуудаа салбар хуулиуд болон хуульчилсан актуудаараа бататгаж, нарийвчлан зохицуулах учиртай. Гэвч шуудхан хэлэхэд өмнөх нийгэмд ноёрхож байсан хүнд суртал өнөөдөр ч гэсэн амь бөхтэйгээр хадгалагдаж

байгаа нь нийгмийн зарим салбарт ажиглагдсаар байна.

Ер нь хүнд суртал гэгч юу вэ? Яагаад бий болдог вэ? Ямар хор уршигтай вэ?

Хүнд суртал гэдэг нь: тухайн шийдвэрлэх ёстой, шаардлагатай асуудлыг удаашруулж, бусдыг чирэгдүүлж, эрх ашгийг нь хохирож буй буруутай, хариуцлагагүй үйл ажиллагаа юм. Хүнд суртал нь дараах шинжүүдийг өөртөө агуулдаг:

◆ Хүнд суртал нь тухайн асуудлыг шийдвэрлэвэл зохих хугацааны хүрээ хязгаарыг нарийвчлан тогтоогоогүй, мөн уг асуудлыг шийдвэрлэхийн тулд олон шат дамжлага дамждаг, уг асуудлыг шийдвэрлэх явцад буруутай үйл ажиллагаа гаргавал хэрхэх тухай хууль зүйн хариуцлагын боловсронгуй бус байдал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж нийгэмд оршиж байдаг ажээ.

◆ Хүнд суртал нь ихэвчлэн албан тушаалтнуудад хамаарагдаж, тэдний үйл ажиллагаанд илэрч байдаг юм. Албан тушаалтан гэдэгт төрийн улс төрийн болон захиргааны, тусгай албан хаагчид, мөн олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах болон гүйцэтгэх байгууллагуудын ажилтнууд хамаардаг. Ийнхүү албан тушаалтнууд хүнд суртал гаргах нь тухайн асуудлыг шийдвэрлүүлэх гэж буй

иргэнээс гадна төрийн аппаратын ажиллагааг удаашруулж, цалгардуулж, цаашлаад улсын эрх ашиг, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, энэ нь Үндсэн хуульд тусгагдсан зорилт болох “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг байгуулах”-д ноцтой саад болох зүйл мөн билээ.

◆ Мөн хүнд суртлын бас нэг хор уршиг нь авилгалын хөрсийг бүрдүүлж, түүнийг төрүүлж байдаг олон хүчин зүйлүүдийн нэг юм. Эдгээр нь улс, нийгэмд асар их хор уршигтай гэдэг нь тодорхой.

Хүнд суртлыг яаж арилгах вэ? Үүнийг хийхийн тулд нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүйн олон цогц үйл ажиллагааг зохистойгоор хэрэгжүүлэх учиртай. Жишээ нь: тухайн асуудлыг шийдвэрлэх хугацааг нарийн, үндэслэлтэй тогтоох, хугацаа хэтэрвэл уг албан тушаалтанд хууль зүйн ямар үр дагавар учрахыг тодотгон хэлбэршүүлэх, олон шат дамжлагыг цөөлөх, иргэдийн болон олон нийтийн хараа хяналт тавих, мэдээлэл өгөх, авах боломжийг өргөтгөх, мөн тодорхой асуудлуудыг хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн албан тушаалтны ажлын үзүүлэлтийг нь харгалзан урамшуулах, тэдний нийгмийн хангамжийг сайжруулах зэрэг олон механизм байж болно.

**2. Шуурхай шийдвэрлэх зарчим бол иргэний хэргийг шүүхэд шийдвэрлэх ажиллагаа дахь хүнд суртлыг арилгах нэг арга зам мөн**

Хүнд суртал нь нийгмийн зарим салбарт, ялангуяа процессын эрх зүйн салбарт нэн тод илэрч байгаа нь ажиглагдсаар байна. Процессын эрх зүйн салбарт захиргааны болон эрүү, иргэний процессын эрх зүй зэрэг багтдаг билээ. Захиргааны болон эрүүгийн процессын эрх зүй нь бусдаас нэлээд төвөгтэй нарийн ажиллагаатай бөгөөд энэ хүрээ дэх хүнд суртлыг арилгаж, хэргийг шуурхай шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгоход нэлээд төгс бодлого явуулах шаардлагатай.

Харин иргэний процессын эрх зүй буюу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /ИХШХША/ дахь зохицуулалт нь нэлээд онцлог бөгөөд энэ хүрээ дэх хүнд суртлыг хэрхэн арилгах вэ гэдэг үүднээс нарийвчлан авч үзэхийг зорилоо.

Иргэд санал, хүсэлт, өргөдөл, гомдлоо зохих байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэх, тухайн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, барагдуулах талаар эрх зүйн актуудад хэрхэн тусгасан байдлыг товч авч үзье:

**1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1948 он/, 8 дугаар зүйл:** “Үндсэн хууль бусад хуулиар олгогдсон эрх нь зөрчигдсэн хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”;

**2. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/, 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэг:** “Монгол

Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь уг өргөдөл гомдлыг шийдвэрлэх үүрэгтэй”;

**3. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:** “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ...эрхтэй”;

**4. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:** “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийнхээ өмнө хариуцна”;

**5. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/, 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:** “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана.”

**6. Төрийн албаны тухай хууль /2002 он/, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:** “... хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн.”

**7. Төрийн албаны тухай хууль /2002 он/, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад:** “ард түмэнд үйлчлэх” зарчмыг баримтлах тухай заасан байдаг;

**8. Шүүхийн тухай хууль /2002 он/, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт:** “Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ ....гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана.” гэж тус тус заажээ.

Эдгээр заалтууд нь хүний эрхийг хангах, тодруулбал: иргэд шүүхэд хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг бататгасан агуулгатай заалтууд бөгөөд шүүх аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ

хуульд заасан үндэслэл, хугацааг чанд баримтлах ёстой гэсэн мөн чанарыг илэрхийлж байна.

Ер нь хугацаа гэдэг бол ахин хэзээ ч эргэж ирэхгүй **үнэт зүйл** бөгөөд ялангуяа хүний амь, амьдралын асуудлыг шийддэг эрх зүйн харилцаанд юу юунаас ч илүү чухал зүйл билээ. Тогтоосон хугацааг чанд баримтлах нь сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ач холбогдолтой байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /ИХШХШТХ/-д тодорхой үйл ажиллагаануудыг явуулахад баримтлах хугацааг зарим талаар тодорхойлсон байдаг.

**ИХШХША дахь хугацаа гэдэг нь:** иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажил лагаар гүйцэтгэхэд чиглэсэн хуульд заасан буюу шүүхээс тогтоосон орон зайны агшин /цаг үе/ юм хэмээн тодорхойлсон байдаг.

**ИХШХША дахь хугацааг:**

● **хуулиар тогтоосон хугацаа:** хуулиар урьдчилан тогтоогдсон хугацаа бөгөөд аль нэг этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах шинжтэй байдаг онцлогтой.

● **шүүхээс тогтоосон хугацаа:** хуульд заагдсан хугацааны дотор тулгуурлаж шүүхээс өөрийн үзэмж санаачилгаар тогтоож байдаг хугацаа юм.

Одоо төгвөл ИХШХШТХ-д заагдсан хугацаатай холбогдсон заалтуудаас тухайн үед нь шуурхай хийх агуулгатай заалтуудад дүн шинжилгээ хийе:

“Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг өөрчлөх, устгах, бусдад шилжүүлэх,

нуун дарагдуулах зэргээр уг хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж болох үндэслэлтэй гэж үзвэл хэргийн оролцогч уг нотлох баримтыг хамгаалуулахаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд хүсэлт гаргаж болох ба уг хүсэлтийг шүүгч үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг хамгаалах тухай, хэрэг үндэслэлгүй гэж үзвэл татгалзах тухай захирамж гаргана. Уг захирамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэн даруй биелүүлнэ.” /50.1, 50.3, 50.4/

◆ “Хүнсний ба түргэн муудаж, гэмтэх бусад зүйлд үзлэгийг шүүхээс хэргийн оролцогчдод мэдэгдэж даруй хийнэ.” /45.2/

◆ “Шинэ нотлох баримт бүрдүүлэх ба хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад асуудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг бусад оролцогчийн саналыг сонсмогц шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.”

◆ “Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тусгаал, Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэврийг баталгаажуулахаар ... шүүгч захирамж гаргасан даруй гүйцэтгэх хуудас бичнэ...” /184.3/

◆ “Шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүгч үзсэн бол шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг дараах тохиолдолд албадан гүйцэтгүүлэхээр шүүгч захирамж гаргана.” /185.1/

Ийнхүү дээр дурдсан заалтуудад буй “нэн даруй”, “даруй” хэмээх хугацаа илэрхийлсэн ойлголтуудыг

ямар хэмжээний хугацаа гэж ойлгох талаар нэг мөр ойлголт хараахан тогтоогүй байна. Гэхдээ тухайн заалтуудыг агуулгыг авч үзвэл дээр дурдсан ажиллагаануудыг яаралтай хийх ёстой бөгөөд цаг хугацаа алдвал бусдын эрх, ашигт хохирол учрахаар шинжтэй байдал илэрч байгаа болно.

Иймд тухайн ойлголтуудыг нэг мөр байдлаар Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

Харин одоо ИХШХШТХ-д заагдсан хоногоор хэмжигдэх хугацаатай холбогдсон заалтуудаас анхаарал татсан нэг заалтад дүн шинжилгээ хийе:

◆ “Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэр, магадлалыг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар хэргийг хянуулахаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно.” /120.2/

Энэ заалтын агуулгаас үзвэл шүүхийн шийдвэр, магадлалд гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг тогтоохдоо тухайн шүүхийн шийдвэр, магадлалыг зохигчид /тэдний төлөөлөгчид/ гардаж авснаас хойш хугацааг тоолж байгаа бөгөөд энэ нь учир дутагдалтай санагдана.

Хэдийгээр ИХШХШТХ-ийн 119 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: “Шийдвэрийг гаргаснаас хойш 7 хоногийн дотор бичгээр үйлдэж, бүрэн эхээр зохигчид хүргүүлнэ.” гэсэн заалт байдаг боловч тухайн шийдвэрийг зохигчдод /тэдний төлөөлөгчдөд/ хүргүүлэх үүрэг бүхий шүүхийн

ажилтан уг үүргээ биелүүлэхгүй байвал яах вэ?

Мөн хэдийгээр тухайн шүүхийн ажилтан нь шүүхийн шийдвэр, магадлалыг хүлээлгэж өгөхийг оролдовч тухайн шүүхийн шийдвэр, магадлалыг зохигчид /тэдний төлөөлөгчид/ уг хуульд заасан хугацаандаа гардаж авахгүй байгаад байвал яах вэ, ямар үр дагавар үүсэх вэ гэдэг асуудал гарч ирж байна.

Одоогийн мөрдөж буй ИХШХШТХ-аар бол зохигчид эсвэл зохигчдын аль нэг тал нь тухайн шүүхийн шийдвэр, магадлалыг гардаж авахгүй хичнээн ч хугацаагаар алга болж болох “боломжийг олгосон нь” нөгөө талынхаа эрх, ашгийг хохироох, улмаар шүүхийн шийдвэр биелэгдэхгүй саатах зэрэг гацаанд оруулах сөрөг байдлыг үүсгэж байна.

Гэхдээ энэ асуудал практик дээр хэрхэн зохицуулагдаж буй байдлыг судлахад, нэхэмжлэл нь хангагдсан нэхэмжлэгч шүүхийн шийдвэр гарсны дараа шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтээ тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгчдээ гаргасны үндсэн дээр уг шүүгч шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай захирамж гаргаж байгаа бөгөөд үүний дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх хариуцагч буюу төлбөр төлөгч шүүх дээр очиж тухайн шийдвэр, магадлалаа гардан авч, улмаар давж заалдах гомдол гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түдгэлзүүлж байгаа байдал ажиглагдаж байна.

Энэхүү олон шат дамжлагатай нүсэр ажиллагаа нь нэхэмжлэгч буюу төлбөр авагчийг чирэгдүүлж,

цаашлаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нэг мөр, тууштай явагдахад саад болж байгаа болно. Үүнээс гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тодорхой хэмжээгээр хийгдэж байх үед төлбөр төлөгч тал нь шүүхийн шийдвэр, магадлалыг гардан авч дээд шатны шүүхэд давж заалдан тухайн шийдвэр, магадлалыг өөрчлүүлэх буюу хүчингүй болгосон тохиолдолд өнөөх хийгдсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ямар ч ач холбогдолгүй болж, хөрөнгө зардал, цаг хугацаа алдсан зүйл болж хувирч байна.

Энэ бүхнээс дүгнээд үзэхэд шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлж буй зохигчид анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол бүрэн, эцсийн байдлаар нэг мөр гарсны хойно дараагийн шат болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа уруу шилжих нь зүйтэй гэж үзэж байна. Өмнө нь үйлчилж байсан ИХШХШТХ-д энэ талаархи асуудлыг тодорхой төвшинд, талуудын эрх, ашгийг хамгаалсан байдлаар хуульчлагдсан, харьцангуй сайн заалтууд байсан гэж миний хувьд үзэж байгаа болно.

Иймээс дээр дурдсан сөрөг байдал, гацаанаас гарахын тулд шүүхийн шийдвэр, магадлал гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг тооцохдоо хуучин мөрдөж байсан ИХШХШТХ-ийн зохицуулалт болох “шүүхийн шийдвэр, магадлалыг гарсан өдрөөс хойш /зохигчид гардаж авсан өдрөөс хойш биш/ тэдгээрт гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг тоолох” журмыг сэргээх нь зүйтэй санагдана. Учир нь шүүхээр

хэрэг, маргаанаа шийдвэрлүүлж буй зохигчид нэгэнт л өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалуулахаар шүүхэд хандаж байгаа болохоор шүүхийн шийдвэр, магадлал гарсан өдөр болон тэдгээрт гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаагаа өөрийнхөө эрх ашгийн үүднээс өөртөө ашигтайгаар хэрэглэх бололцоо нээлттэй байх юм. Хэрэв тухайн зохигчид тодорхой хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн шийдвэр, магадлалд гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаандаа амжиж гомдол гаргаж чадаагүй бол энэ тухайгаа зохих дээд шатны шүүхэд нь хүсэлт гаргаж асуудлаа шийдвэрлүүлэх бололцоотой байх явдал бөгөөд энэ талаархи зохицуулалт өмнөх ИХШХШТХ-д бас байсан билээ.

Мөн ИХШХШТХ-д тусгагдсан зарим а ж и л л а г а а н у д а д баримтдах тодорхой хугацаа заагаагүй заалтууд байгаа бөгөөд тэдгээр заалтуудад дүн шинжилгээ хийж үзье:

◆ “Тухайн хэрэг нь арбитра харьяалагдах хэрэг бол шүүх тогтоол, шүүгч захирамж гарган нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаана.” /20.2/

◆ “Хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэд шилжүүлэх тухай шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах хугацаа өнгөрмөгч уг хэргийг шилжүүлнэ. Хэрэв гомдол гарсан бол уг гомдлыг хянан шийдвэрлэсэн тухайн шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хэргийг шилжүүлнэ.” /21.1/

◆ “Шүүгч /нотлох баримтыг хамгаалуулах тухай/ хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг

хамгаалах тухай, хэрэв үндэслэлгүй гэж үзвэл татгалзах тухай захирамж гаргана.” /50.3/

◆ “Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас болон давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө түүнээсээ татгалзвал, түүнчлэн хяналтын шатны шүүх зохигч, гуравдагч этгээдийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж, шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн тохиолдолд тус тус зохигч, гуравдагч этгээдийн шүүхэд төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох захирамж гаргана.” /59/

◆ “Харьяаллын дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ. Харин талуудын тайлбарыг үндэслэн дараах шалтгаанаар шүүх хуралдааны өмнө буюу шүүх хуралдааны явцад шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар өөр шүүхэд шилжүүлж болно.” /20.1/

◆ “Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролдогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ.” /38.6/

◆ “Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон тохиолдолд хэргийг адил шатны өөр

шүүхээр шийдвэрлүүлэхээр тухайн шатны Ерөнхий шүүгч захирамж гаргаж шилжүүлнэ.” /93.2/

◆ “Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж захирамж гаргана.” /92.6/

◆ “Шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг хэргийг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.” /92.7/

◆ “Бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчилж болно.” /124.1/

◆ “Шүүгч ..... гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.” /130.1/

◆ “Иргэнийг нас барсан гэж зарласан шийдвэр гарсны дараа иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд зохих тэмдэглэл хийлгэхээр шийдвэр гаргасан шүүх байгаа газрын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн байгууллагад уг шийдвэрийг явуулна.” /139.3/

◆ “Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоосон шийдвэр гарсны дараа бүртгэлд зохих залруулга хийлгэхээр иргэний бүртгэлийн байгууллагад уг шийдвэрийг явуулна.” /150.3/

◆ “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол давж заалдах журмаар

хянан хэлэлцсэн шүүх тухайн хэргийг дахин шийдвэр лүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана.” /168.3/

◆ “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд шүүхийн хуралдаанд хэлэлцүүлнэ.” /176.3/

◆ “Танхимын шүүх хуралдааны тогтоолд гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч хэргийн хамт Улсын дээд шүүхэд ирүүлнэ.” /176.6/

◆ “Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.” /181.1/

◆ “...төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан ... тохиолдолд шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг дараах тохиолдолд албадан гүйцэтгүүлэхээр шүүгч захирамж гаргана.” /185/

◆ “Гүйцэтгэх хуудсыг дахин олгох тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч шийдвэрлэнэ.” /188.2/

Ийнхүү дээр дурдсан а ж и л л а г а а н у д ы г хэрэгжүүлэхдээ чухам хэд хоногийн дотор хийж гүйцэтгэх нь тодорхой бус байгаа нь өнөөх удаашралт, хүнд сурталыг бий болгох хөрс суурийн нэг шалтгаан, нөхцөл болж байгаа юм.

Ийнхүү ИХШХШТХ дахь хугацаатай холбогдсон заалтуудыг хянаж үзвэл

доорх дутагдлууд илрэн гарч ирж байна:

- ИХШХШТХ-д заасан “даруй”, “тэр даруй” гэсэн ойлголтуудыг хэрхэн ойлгох нь тодорхой бус байна,

- ИХШХШТХ-д зохигчид болон бусад этгээдүүд тухайн шүүхийн шийдвэр магадлалыг гаргаж авснаас хойш гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг тоолж байгаа нь практикт хүндрэл учруулж байна,

- ИХШХШТХ-д заасан зарим ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ тухайн албан тушаалтнуудад тодорхой хугацаа баримтлах үүрэг олгоогүй байна. Өөрөөр хэлбэл зарим чухал ажиллагаануудыг ямар хугацааны дотор хийж гүйцэтгэх нь тодорхой бус байна,

- ИХШХШТХ-д тухайн шүүгч болон шүүхийн бусад ажилтнууд өөрөөс хамаарах шалтгаанаар хуулиар тогтоосон хугацаагаа чанд баримтлаагүй бол хэрхэх тухай, хууль зүйн ямар хариуцлага хүлээх тухай шууд, тодорхой, нарийн заалт алга байна.

Энэ бүгдийг үндэслэн дараах дүгнэлтүүдийг санал болгож байна:

1. И Х Ш Х Ш Т Х - д “хэрэг, маргааныг шуурхай шийдвэрлэх” гэсэн зарчим хуульчлан оруулах;

Ийнхүү зарчим хуульд оруулж тусгах нь дараах ач холбогдолтой билээ:

- үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдамж болдог;

- үйл ажиллагаа нь хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийн шалгуур болдог;

## Шүүгчийн ёс зүй



ХЗҮТ-ийн захирал, Академич  
Ж.АМАРСАНАА

### Шүүгчийн ёс зүйн тухай ойлголт

Шүүгчийн ёс зүй нь шүүгч бүрийг хүний амьдралд ухаалаг, шударга, хүмүүндэг хандахыг шаарддаг.

Хэрэв зураач муухай зураг зурсан бол түүнийг хэн ч худалдаж авахгүй, зохиолч тааруу зохиол бичсэн бол түүнийг хэн ч уншихгүй. Харин шүүгч хүн хэзээ ч тийм гологдол гаргах ёсгүй, хэзээ ч

алдаа гаргах учиргүй. Яагаад гэвэл, шүүгчээс хүний нэр төр, эрүүл мэнд төдийгүй, амь нас, амьдрал хамааралтай байдаг.

Ёс зүйд үүрэг, хариуцлага, хүн чанар, нэр төр, амьдралын утга учир, хүний жаргал, зовлон гэх зэрэг олон асуудал хамаарагддаг.

Ёс зүйн алдаагүй ажиллах нь шүүгчийн үүрэг. Эс тэгвээс шүүгчийн алдааны төлөө хүмүүс хэтэрхий өндөр үнэ төлөх болно.

Сайн шүүгч байна гэдэг бол юуны өмнө сайн хүн байх ёстой.

Ажлаа хуулийн дагуу, ёс зүйн дагуу эрхлэн явуулахын тулд энэ тэргүүнээ хуулийг, ёс зүйн дүрмийг чанд баримтлах хэрэгтэй.

Бүрэн төгс боловсруулсан дүрэм гэж байхгүй. Шүүгчид ёс зүйн дүрмээ цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчлөн сэлбэж, шинэчилж байх нь зүйтэй. Ёс зүйн дүрмээ шүүгчид ухаалгаар ашиглаж (хэрэглэж) байвал зохистой.

Энэ явцдаа түүнийг боловсронгуй болгох, сайжруулах талаар байнга ярилцаж, зөвлөлдөж байх шаардлагатай юм.


Ёс зүйн хэм хэмжээг ганцхан өдөр л бий болгочих аргагүй. Энэ бол шүүгчийн хараат бус байдлыг бий болгохын төлөө шүүгчдийн удаан хугацааны эрмэлзэл, чин хүсэл, хөдөлмөр, тэмцлийн үр дүн мөн.

Ёс зүй бол шүүгчийн хараат бус байдлын даацын гол тулгуур юм.

Учир нь шүүгчийн хараат байдал нь хууль тайлбарлагчийнх нь хувьд хяналтгүй, иргэдийг хуулийн шаардлагын тухай үнэн зөв ойлголтгүй, эрх мэдлийн хил зааггүй, өөрийнх нь үүрэггүй болгодог.

Шүүгч бусдын хүсэл эрмэлзлийг нухчин дарахгүй, өөрөө хийрхдэггүй байх үүднээс ёс зүй юунд тулгуурлагдгийг анхаарах ёстой.

Шүүгчийн ёс зүй бол шүүх эрх мэдлийн тулгуур мөн.



Ёс зүйн хүрээ нь гол төлөв “нүгэл”, хуулийн хүрээ нь “гэм зэм” гэсэн ойлголтыг хамаардаг.

Албаны ёс зүй:

Төр, түүний байгууллага өөрийн зүй ёсны шаардлагад албан хаагчдын мэдлэг чадваргүй, сэтгэлгүй байдлаар нь дамжин орж ирж болох хувийн болон бусад явцуу ашиг сонирхлоос хамгаалах хяналтыг тогтоосон хэм хэмжээ.

Мэргэжлийн ёс зүй:

Тухайн салбарын мэдлэг, мэргэжилдээ үнэнч байж, хувийн эрх ашгийг огоорон мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа гүнээ ухамсарлаж, үүргээ чанд биелүүлэх талаар тогтоосон хэм хэмжээ.

### Шүүгчийн үүрэг

Шүүгч нь шүүх хуралдаанд оролцогч талуудын хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэдэг. Үүний зэрэгцээгээр нийгэмд эмх цэгцтэй байдал, дэг журам тогтооход ач холбогдол бүхий хууль дээдлэх явдлыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна. Шүүх зорилгодоо хүрэхийн тулд өөрийн практик үйл ажиллагааны чанараас үүдэлтэй ёс суртахууны хүч дээр тулгуурлана.

Төрийн эрх мэдлийн салаа мөчрийн дунд шүүх нь материаллаг утгаараа хамгийн сул нь юм. Шүүхийн нийгэм дэх үүрэг нь өөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс идэвхитэй туслалцааг шаарддаг. Парламент нь тохиромжтой санхүүжилтээр хангах бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд туслалцаа үзүүлэх шаардлагатай.

Ийнхүү шүүх эрх мэдлийн харьцангуй сул байдлыг нөхөхийн тулд шүүгч нь олон түмний итгэлээс гарч буй хязгааргүй ёс суртахууны хүчийг эзэмших ёстой. Энэхүү

мэдрэгдэшгүй, хэмжээлшгүй, үнэлэгдэшгүй ёс суртахууны хүч нь ямар ч хүчээс дутуугүй хүчтэй. Бид сэтгэлийн энергийг материаллаг ертөнцийн дээд хүч болох атомын энергээс хүчтэй гэж үздэг. Гэвч олон нийтийн итгэлийг хүлээхийн тулд шүүгчид нь өөрийн үйл ажиллагаагаар ийнхүү итгэлийг хүлээнэ гэдгийг харуулах ёстой.

Олон нийтийн дунд итгэл олж авахын тулд шүүх эрх мэдэл нь Шүүхийн тухай хуульд заасны дагуу бие даасан байх ёстой.

Эдгээр нь шүүгч болгоны эзэмших ёстой чанар юм. Шүүх эрх мэдлийн гишүүн нь бие даасан байх ёстой. Шүүгч нь шударга ёс болон бие даасан байдлын илрэл байх ёстой. Шүүгч шүүх эрх мэдлийн ноён нуруу болж байх учиртай.

### Хариуцлага

Ёс зүй гэдэг нь хууль, дүрмийг зүгээр л нэг дуулгавартай нь аргагүй дагаж, ёс зүйн зарчмыг нэг бүрчлэн сахих явдлаар төдий биш, харин шүүгчийн нийгмийн

өмнө хүлээх хариуцлагаар илэрдэг.

Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний хил зааг нь энэ үндэслэлийг бататгаж өгөхөд үйлчлэх учиртай.

Хариуцлагатай байх нь шүүгчийн хараат бус байдлын тулгын чулуу юм.

Хариуцлагаа ухаарсан, хариуцлагатай шүүгч өөрийгөө хамгаалах бүрэн чадвартай байдаг. Хариуцлага мэдэрч, түүнийг дээшлүүлэхээс илүү хүчтэй хамгаалалт шүүхэд байхгүй. Хариуцлагатай байхын тулд шүүгч нар өөрсдөө боловсруулж, өөрсдөө хүлээн зөвшөөрч, өөрсдөө сайн дурын үндсэн дээр дагаж мөрддөг ёс зүйн дүрмээ ягштал баримталж ажиллах ёстой.

Ёс зүйг эрхэмлэх нь өнөөдөрөөр үл барам ирээдүйн өмнө хүлээх хариуцлага юм.

Хариуцлагатай байна гэдэг нь сэтгэл зүрх, дотоод итгэл мэдрэмж, үнэний зориг, шударга ёсыг шүүгч өөртөө цогцлоон бүрдүүлэхийг хэлнэ. Хариуцлагыг тогтоон төлөвшүүлэх чухал хүчин зүйл бол шүүмжлэлийг хүлээж авах,

дотроо цэвэрших, эрүүл саруул эрчийг бүрдүүлэх явдал юм.

Шүүгч нь хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, тэдгээрийн өөрчлөлт, Дээд шүүхийн шийдвэрийг байнга судалж мэдсэн байх шаардлагатай бөгөөд энэ нь түүний хариуцлагын асуудал юм.

Хүн бүрийн мэдэж байх ёстой хуулийг үл тоомсорлох

явдлыг шүүгчид үл тэвчих ёстой.

Шүүгч нь үргэлжилсэн сургалтад тогтмол, заавал хамрагдаж байх ёстой бөгөөд эс тэгвээс шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэл нь шүүгчийн ур чадваргүй, хариуцлагагүй ажиллагаанаас болж үгүй болно.

### Шүүгчид хүлээлгэх хууль зүйн хариуцлага

#### А. Албан тушаалаас чөлөөлөх

А. • Биеийн эрүүл мэндийн (үүний дотор сэтгэцийн эрүүл мэндийн) байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

• Ажил хэргийн чадвар, мэргэшлийн төвшингийн хувьд шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан.

Б. • Шүүгчээс огцруулах Сахилгын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон;

• Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн;

• Шүүгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэл тогтоол хүчин төгөлдөр болсон.

#### Шүүгчийн биеэ авч явах ёс зүй

• Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд ямар нотлох баримтыг үндэслэх, ямар хууль хэрэглэх эрхийг гагцхүү шүүгч эдэлдгийн хувьд энэхүү өндөр хариуцлага бүхий албан тушаалдаа хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.

#### Б. Огцруулах

• Шүүгч хуулийг чанд сахин мөрдөж, албаны үүргээ гүйцэтгэхдээ болон биеэ авч явахдаа зохисгүй байдал гаргахгүй байх үүрэгтэй бөгөөд энэ нь түүний ажил мэргэжлийн болон хувийн зан байдлын аль алинд хамааралтай.

“Зохисгүй байдал гаргахгүй байх гэдэг” нь шүүгч алба хашиж байхдаа хаана ч байсан, хэзээ ч шүүх, шүүгчийн өндөр нэр хүндийг хамгаалж явах үүрэгтэй ба энэ үүргээ зөрчиж хамт ажиллагчид болон бусадтай хэрүүл хийх, цээртэй үг хэллэг хэрэглэх, хараах, жижгээр танхайрах, агсам тавих, шүүхэд эрүүл бус сэтгэл зүйн уур амьсгал бий болгох зэргээр зөрчил гаргаж шүүх, шүүгчийн нэр хүндэд нөлөөлсөн байх үйлдэл гаргахыг хэлнэ.

Шүүгч бүр олон нийтийн хяналтад байгаа гэдгээ ухамсарлан иргэдийн хувьд хязгаарладаггүй ч шүүгчийн хувьд мөрдвөл зохих эрхийн хязгаарлалтыг сахин биелүүлэх ёстой.

Шүүгч аливаа асуудалд шударга байдлаар хандаж, шүүн таслах ажлын талаар бусдад буруу ойлголт төрүүлэхээс зайлсхийх, шүүгчийн хувийн үзэл бодол нь шүүхийн албан ёсны байр суурь мэтээр ойлгогдохоос сэргийлэх зорилгоор дараах хязгаарлалтыг сахица:

• Бусдын зан төлөв, ёс суртахуун, нэр төр, алдар хүндийн талаар ам, бичгээр тодорхойлох;

• Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй мөрдөх, дотно харилцаатай байсан хүмүүс, эсвэл өмнө нь ажиллаж байсан буюу эрх ашгийг нь ямар нэг хэлбэрээр хамгаалж байсан байгууллага, хуулийн этгээдийн хооронд үүссэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд оролцохгүй байх;

• Хэрэг, маргаан нь шүүхээр хянан шийдвэрлэгдэх гэж байгаа хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, бусад хүнтэй хувийн харилцаанд орохгүй байх;

• Өөрийн бүтээлийг хэвлэн нийтлэх, гэрээ байгуулах зэрэг хувийн зүгээс хийж буй аливаа үйл ажиллагаандаа шүүгчийн буюу шүүхийн нэр хүндийг ашиглахаас зайлсхийж, зөвхөн иргэний байр сууринаас хандах.

#### Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны ёс зүйн шаардлага

• Шүүн таслах үйл ажиллагаа нь шүүгчийн өөр бусад бүх ажлаас ямагт илүү эрхэм чухал байна.

• Шүүгч нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шин-



жээч, яллагдагч, шүүгдэгч, нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч зэрэг хэргийн аль ч оролцогчтой харилцахдаа алагчлалгүйгээр тэгш, хүндэтгэлтэй хандаж, шүүгчийн зүгээс хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг өөрийн ажил хэрэг, үг яриагаар төрүүлж чадахуйц сэтгэл зүй, мэдлэг, харилцааны соёлыг эзэмшсэн байх үүрэгтэй бөгөөд шүүхэд ажиллаж байгаа хэн бүхнээс ийнхүү харилцахыг шаардах эрхтэй.

- Хэргийн оролцогчид болон бусад хүмүүстэй албаны хувьд харилцахдаа хүнийг доромжлох, үндэслэлгүй хүлээлгэх, чирэгдүүлэх, хувийн сонирхолтойгоо ойлгуулахыг эрмэлзэх, сэтгэл зүйн тавгүй байдалд оруулах, ашигласан зандрах, айлгаж сүрдүүлэх, дарамтлах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бусаар авирлахыг хориглоно.

- Эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг, маргааны тухай болон талуудын тавьсан үндэслэл, гаргах шийдвэрийн талаархи саналаа урьдчилан илэрхийлэх, олон нийтэд мэдээлэхийг цээрлэх ёстой.

- Хэрэг, маргааныг хуульд заасан хугацааны дотор шийдвэрлэж хуульд зааснаас өөр шалтгаан, үндэслэлээр шийдвэрлэхгүй удаашруулах, шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулах ёсгүй.

- Мэргэжлийн удирдлагаар хангах, шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах зэрэг үүргийг хуулиар шүүгчид олгосон бол шүүгч түүнийг хариуцлагатайгаар гүйцэтгэх үүрэгтэй.

### Хэрэг шүүн шийдвэрлэхээс бусад үйл ажиллагаанд хэрэгжих шүүгчийн ёс зүй

- Шүүгч дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

А. Өмгөөлөл, арбитрын үйл ажиллагаа эрхлэх (Энэ нь садан төрлийн хүмүүс болон гэр бүлийн гишүүдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулж өгөхөд хамаарахгүй);

Б. Арьсны өнгө, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, үзэл бодол, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа явуулдаг аливаа төрийн бус байгууллагын гишүүн байх, өөрөө шашны зан үйлийг эрхэлж уншлага хийх, мэргэ төлөг тавих, өргөл барьц авах, шүүх хуралдааны танхимд шашны сурталчилгаа, зан үйл явуулахыг дэмжих, түүнчлэн ийм байгууллагын зорилго, бодлогыг дэмждэг, эсэргүүцдэг тухайгаа нийтэд ямар нэг хэлбэрээр илэрхийлэх;

В. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, түүнд шууд хамаарах эрх зүйг боловсронгуй болгохоос бусад асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох;

Г. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс 3 жилийн дотор өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх.

- Шүүгч эдийн засгийн үйл ажиллагааны талаар дор дурдсан хязгаарлалтыг хүлээн зөвшөөрч, сахин биелүүлнэ:

А. Албаны үүргээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх, шүүгчийн албан тушаалыг ямар нэг байдлаар ашиглахыг санаархсан аливаа хэлцэл хийхээс зайлсхийх;

Б. Шүүгчийн ёс зүй, нэр төрд харшилж болох аливаа хөрөнгө оруулалт болон зээл авах, хувьцаа эзэмших зэрэг эдийн засгийн бусад ашиг сонирхлоос татгалзах;

В. Албаны үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон олж авсан аливаа мэдээллийг өөрийн бизнесийн аливаа хэлцэл, үйл ажиллагаанд ашиглахгүй байх;

Г. Шүүгч хувийн зорилгодоо хэргийн оролцогч болон тэдгээрийг төлөөлөх хүмүүсийн тусламжийг авах, үйлчлүүлэх, ямар нэгэн давуу тал, хөнгөлөлт эдлэхийг хориглох бөгөөд үүнд юуны өмнө машинд нь сууж явах, хамт амралт зугаалгад явах, дайлуулах, ямар нэгэн төлбөр төлүүлэх болон эдгээртэй адилтгах үйлдэл хамаарагдана.

Д. Шүүгчийн цалингаас өөр орлогын эх үүсвэр нь шүүгчийн албаны үүргээ гүйцэтгэхэд нь нөлөөлж байна гэсэн хардлага сэжиг төрүүлэхээргүй бол хуулиар зөвшөөрсөн хүрээнд мэргэжлийн ажил эрхэлсний цалин хөлс, хуульд заасан нөхөн олговрыг авч болно.

### Улс төр ба шүүгчийн ёс зүй

- Шүүгч улс төрийн дараах үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

А. Улс төрийн аливаа намын удирдах болон бусад орон тооны ба орон тооны бус албан тушаал эрхлэх;

Б. Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчийг дэмжиж, эсвэл эсэргүүцэж нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийнх нь сурталчилгаанд оролцох;

В. Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт олж өгөхийг эрмэлзэх, хандив өргөх.

- Шүүгч нь сонгуульд аль нэг намаас буюу бие даан нэр

дэвшихээр шийдсэн бол сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

• Шүүгч улс төрийн үйл ажиллагаанд оролцож, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа дахин шүүгчээр ажиллахыг хүсвэл хуульд заасан хугацааны дараа шүүгчийн сонгон шалгаруулалтад орно.

### Шүүгчийн ёс зүйн эх сурвалж

#### 1. Үндсэн хууль (1992 он)

Үндсэн хуульд: “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, “... шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж заасан нь шүүгчийн ёс зүйн үндсэн шаардлагын эрх зүйн тулгуур зохицуулалт юм.

#### 2. Төрийн албаны тухай хууль (2002 он)

• Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ.(11.1)

• Уг хуулийн 5.1.3-т заасан албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ.(11.2)

1. Төрийн тусгай албан тушаал (5.1.3)

2. Бүх шатны шүүхийн шүүгч (8.1.1)

3. Төрийн албаны тухай хуулийн 5.1.3-д заасан албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно. (10.3)

• Төрийн жинхэнэ албан хаагч нь төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх нийтлэг үүрэгтэй. (13.1.5)

• Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл (15):

❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах;

❖ Нутгийн удирдлагын байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;

❖ Албан тушаал эрхэлдэг төрийн байгууллагад, эсвэл шууд удирдлага, хяналтад нь ажилладаг байгууллагад гурав дахь этгээдийн төлөөлөгч буюу итгэмжлэгдсэн этгээд байх;

❖ Хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа, дэмжлэг авах;

❖ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага зөвшөөрснөөс бусад тохиолдолд албаны үүргээ гүйцэтгэхийг зогсоосон өдрөөс хойш 2 жилийн дотор сүүлийн 5 жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаалынхаа дагуу шууд холбоотой ажилладаг байсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид албан тушаал эрхлэх.

#### 3. Шүүхийн тухай хууль (2002)

• Шүүгчид зэрэг дэв олгохдоо албан тушаал, хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа, ажил хэргийн чадвар, мэргэшлийн төвшин, ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзан үзнэ. (33.3)

• Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Шүүхийн сахилгын хороонд хүсэлт гаргах бүрэн эрхтэй. (35.1.6)

• Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэх хүсэлтийг Шүүхийн сахилгын хороонд гаргах бүрэн эрхтэй. (37.1.7)

• Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэх хүсэлтийг Шүүхийн сахилгын хороонд гаргах бүрэн эрхтэй. (37<sup>1</sup>.1.7)

• Шүүгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл (44 дүгээр зүйл)

❖ албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд шүүгчийн хувьд оролцох;

❖ ажил хаялт болон шүүхийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

❖ албан тушаалынхаа бүрэн эрхээ шашны, эсвэл шашингүйн үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;

❖ хуульд өөрөөр заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн болон бусад байгууллагад орон тооны болон

орон тооны бус ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх;

❖ өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн удирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх.

#### Шүүгчийн ёс зүйн дүрэм

• Монгол Улсын шүүгчийн ёс зүйн дүрэм (1997 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн 3 дугаар тогтоолоор батлагдсан анхны дүрэм )

• Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм (2002 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн 15 дугаар тогтоолоор батлагдсан)

• Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм (2003 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Шүүгчдийн зөвлөлийн 1 дүгээр тогтоолоор батлагдсан)

• Монгол Улсын шүүхийн шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

• Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ. (Шүүхийн тухай хууль, 45 дугаар зүйл)

• Улсын дээд шүүхийн шүүгч, аймаг, нийслэл, захиргааны шүүхийн Ерөнхий шүүгчдээс бүрдсэн Шүүгчдийн зөвлөл нь Шүүгчийн ёс зүйн дүрмийг батална. (Шүүхийн тухай хууль, (67.1; 67.3.1)

#### Шүүгчийн сахилгын хороо

Шүүхийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын

хороонд гомдол, бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч хүсэлт гаргах эрхтэй. (Шүүхийн тухай хууль, 49.1)

#### Шүүгчийн сахилгын хорооны дүрэм

Монгол Улсын Ерөнхий лөгчийн 2002 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 191 дүгээр зарлигаар батлагдсан.

Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий орон тооны бус байгууллага. Шүүхийн дэргэд хууль зүйн өөр өөр мэргэжлийн (шүүгч, прокурор, өмгөөлөгч, хууль зүйн багш зэрэг) болон хуульч бус хүмүүсээс бүрдсэн Сахилгын хороо байгуулсан бөгөөд энэ нь шүүхийг хөндлөнгөөс шалгаж, сэлбэж байдаг. Шүүх эрх мэдэл шүүгчийг самууруулдаг. Онцгой эрх мэдэл онцгой самууруулдаг. Тийм учраас ардчилсан нийгэмд шүүх эрх мэдлийг бусад эрх мэдэлтэй харилцан тэнцвэржүүлж, хянаж шалгаж чаддаг тогтолцоо байх хэрэгтэй бөгөөд үүний нэг хэсэг нь өөр өөр субъектээс нэр дэвшүүлж байгуулсан Сахилгын хороо юм.

#### Сахилгын хэрэг

• Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн дараах гомдол, хүсэлт нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх үндэслэл болно:

1/ иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага гомдол гаргасан;

2/ бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч хүсэлт гаргасан.

• Сахилгын хорооны гишүүн нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх үндэслэлтэй эсэхийг тогтооход шаард

лагатай гэж үзвэл нэмэлт баримтыг холбогдох этгээдээс гаргуулан авч судлах бөгөөд 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

• Сахилгын хорооны гишүүн нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, эсвэл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана. Хэрэв сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захир-амжийг эс зөвшөөрч гомдол гаргавал 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

• Ажлын алба Сахилгын хорооны гишүүнээс даалгасны дагуу сахилгын хэргийг шалгах ажиллагааг 30 хоногт багтаан дуусгаж, сахилгын хорооны дарга шалгалтын баримттай тацилдана. Хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай бүрдсэн байна гэж үзвэл уг хэргийг Сахилгын хорооны анхан шатны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гарган, хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнийг томилж, хуралдаан болох газрыг товлон зарлана.

• Сахилгын хэргийг анхан шатны журмаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

• Сахилгын хэрэг үүсгэгдсэн шүүгч хэргийн баримттай танилцах, сахилгын хорооны хуралдаанд оролцох, тайлбар гаргах эрхтэй.

• Сахилгын хороо сахилгын хэргийг хянан хэлэлцээд олонхийн саналаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

1/ Сахилгын шийтгэл оногдуулах;

2/ Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;

3/ Шүүгчид эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

■ Сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэн гаргасан тогтоолыг гомдол, хүсэлт гаргасан этгээд, эсвэл сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч эс зөвшөөрвөл Сахилгын хорооны тогтоолыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гомдлоо Сахилгын хороонд гаргах эрхтэй.

■ Сахилгын хороо давж заалдах гомдлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор нийт гишүүний гуравны хоёроос доошгүй ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэж магадлал гаргана.

■ Давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны магадлал эцсийнх байна.

■ Шүүгч сахилгын шийтгэл хүлээснээс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээгээгүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.

■ Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн бол Сахилгын хороо түүнийг огцруулах саналаа Шүүхийн ерөнхий зөвлөлд гаргана.

■ Шүүгчийн гаргасан сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулахгүй.

#### Шүүгчийн хараат бус байдал

Хараат бус байдал нь ёс зүйтэй үлэмж холбоотой.

Шүүх хуралдаанд оролцогч талууд шударга, ёс зүйгээ мэддэг шүүгчтэй учирч байна гэдгийг мэдэрч байх ёстой.

Шүүгч хуулийг мэргэжлийн өндөр төвшинд тайлбарлаж,

хэрэгжүүлэхийн тулд хууль зүйн өндөр мэдлэгтэй байх учиртай.

Хамгийн чухал нь шүүх хуралдаанд оролцогч талууд шүүгчийн шударга байдалд итгэлтэй байхуйцаар биеэ авч явах шаардлагатай.

Шүүгч нь үргэлж бүрэн чөлөөтэй, өөрийн ашиг сонирхолгүй, бие даасан байдалтай байхыг эрмэлзэх хэрэгтэй.

Маргаан хянан шийдвэрлэх үеэр гаргах шүүгчийн зан авир, хандлага нь шүүх ажиллагаанд холбоотой хүмүүсийн хувьд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдгийг ямагт санаж байх нь зүйтэй.

Олон намын тогтолцоо оршиж байгаа өнөө үед шүүгчийг "улс төржихөөс" сэргийлэхгүйгээр хариуцлагатай, ёс зүйг баримталдаг, шударга шүүх ажиллаж чадахгүй.

Тухайн хэрэг, маргаан улс төрийн шинжтэй, улс төрийн үр дагавартай байсан ч хуулийн дагуу, эрх зүйн үүднээс харж, нотолж хэргийг шийдвэрлэж байх нь шүүгчийн ёс зүйн эрхэм үүрэг мөн.

Хараат бус байна гэдэг нь үнэн чанартаа зөвхөн хуульд захирагдахыг л хэлж буй хэрэг юм. Хуульд захирагдах нь шүүгчийн ёс зүйн хамгийн чухал шаардлага юм.

#### Хөрөнгө, орлогын мэдүүлэг

Шүүгч хууль тогтоомжид заасны дагуу өөрийн болон гэр

бүлийнхээ орлого, ер төлбөр, хөрөнгө оруулалтын талаар зохих журмын дагуу үнэн зөв, бүрэн мэдүүлж байх үүрэгтэй. (Шүүгчийн ёс зүйн дүрэм. 16 дугаар зүйл)

#### Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах

■ Шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч, түүнд хяналт тавих нь авлигаас урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээ мөн.

■ Хөрөнгө, орлогын мэдүүлэгт шүүгчийн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, банкны хадгаламж, мал, орлогын эх үүсвэр болох бусад хөрөнгө, нийт орлого, түүний эх үүсвэрийг тусгана.

■ Хөрөнгө, орлогын мэдүүлэгт тухайн шүүгч өөрийн өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгөө үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн албан ёсны тодорхойлолтыг хавсаргана.

■ Хөрөнгө, орлогын мэдүүлгийг шүүгчийн албан тушаалд томилогдсоны дараа 30 хоногийн дотор болон шүүгчээр ажиллаж буй хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс 15-ны хооронд гаргана.

■ Дээрх хугацаанаас өмнө орлогод нь онцгой өөрчлөлт орсон бол шүүгч мэдүүлгийг бүртгэх байгууллага, албан тушаалтанд хоёр сарын дотор энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

#### Авлигын тодорхойлолт

Хээл хахууль авах, хувьдаа болон бусад ашиг хонжоо олох зорилгоор шүүгчийн албан тушаалын байдал, боломжоо ашиглах, ийнхүү ашиглуулахаар түүнд шан харамж буюу хөнгөлөлт, давуу талыг иргэн, хуулийн этгээд олгох үйлдэл.

### Шүүгчдэд хориглох зүйл

Шүүгч хувийн ашиг хонжоо олох зорилгоор дараахь үйлдэл хийхийг хориглоно:

- Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;

- Албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс бэлэг, мөнгөн шагнал, шан харамж авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үйлчлүүлэх зэрэг хууль бусад хангамж эдлэх;

- Албаны бус зорилгод шүүхийн байгууллагын бусад эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглах;

- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэх, бусдад зуучлан хөтлөх;

- Албан ажлын байдлаа ашиглан зээл, үнэт цаас, эд хөрөнгө олж авах давуу эрх эдлэх, энэ талаар бусдад давуу байдал олгох, бусдын эрхийг хязгаарлах;

- Албан тушаалынхаа эрх мэдэл, түүнд үндэслэн бусадтай тогтоосон ажил төрлийн холбоо, харилцааг ашиглан өөрийн албан үүргийн хүрээнд үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд шахалт үзүүлэх;

- Албан тушаалын хувьд ижил зэрэг дэвийн болон доод шатны шүүхийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг оролдох;

- Шүүн таслах эрхээ ашиглаж хууль бус орлого, ашиг хонжоо, давуу тал олох зорилготой бусад үйлдэл хийх.

### Олон нийтийн санал бодол

Шүүгч нь хараат бус байдлыг нурааж эвдэх гэсэн аливаа оролдлогын эсрэг тун сэрэмжтэй, няхуур байх ёстой. Ийм хандлагатай ямар ч дарамт шахалтыг тэвчих нь зүйтэй.

Нотлох баримт болон хуулийг нягтлан тодорхойлох ажиллагаанд маш няхуур нямбай хандахгүй бол олон нийтийн санал, шүүмжлэлээс айж бодитой бус шийдвэр гаргахад хүрнэ.

Өнөө үед шүүгчдэд нөлөөлөх маш нарийн бөгөөд хүчтэй арга бол шийдвэрлэгдээгүй байгаа хэргийн талаар олон нийтийн дунд санал бодлын эргэцүүлэл бий болгох, хэлэлцүүлэг үүсгэх явдал юм.

Хэвлэл мэдээллийнхэн хохирогчийн шударга шүүхээр шүүлгэх эрхэд айхтар хортой нөлөө үзүүлэхгүй байгаа ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн санал бодлоор дамжуулан шүүгчийн шийдвэрт нөлөө үзүүлэхгүй байх талаар шүүгч нэг бүр анхаарч ажиллах хэрэгтэй юм.

Нөгөө талаар шүүгч нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрийгөө сайшаан магтах зорилгоор ашиглаж болохгүй. Хэвлэл мэдээлэлд шунаж буй шүүгч нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүч шүүгчийн шийдвэрт нөлөөлдөг гэсэн сэтгэгдлийг нийгэмд төрүүлж болзошгүй байдаг.

Шүүгдэгчийн нэр усыг зарлаж, гэрэл зургийг нь тавьж, дүрс зургийг нь гаргасны бүх буруу энэ баримтыг нийтэлж байгаа хүнд

оногдох боловч энэ нь бас ийм нөхцөлийг бүрдүүлж өгсөн шүүгчид хамаатай.

Шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх хуралдаанд оролцогчдыг (энд зөвхөн тэдний нэр төр төдийгүй амь бие, эрүүл мэнд ч хамааралтай) хамгаалахын тулд шүүх хуралдаан дээр фото зураг авах болон видео бичлэг хийхийг аль болох хориглох нь зүйтэй.

Ядаж одоо мөрдөж байгаа, тухайн шатны Ерөнхий шүүгчийн зөвшөөрөлтэй л зураг авч, видео бичлэг хийж болох журмыг хатуу мөрдөх, Ерөнхий шүүгч нь энэ талаар аль болохоор цааргалж байвал зүгээр юм.

Шүүгч хэргийн талаар ярилцлага өгөхийг аль болох тэвчих нь зүгээр.

- Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн, нэвтрүүлсэн шүүгчийн талаархи санал шүүмжлэл үндэслэлтэй бөгөөд хууль болон ёс зүйн дүрмийг зөрчсөн байвал түүнд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

- Хэрвээ шүүгчийн талаар үндэслэлгүй нийтлэл хэвлүүлсэн, нэвтрүүлсэн бол тухайн шүүгч, эсвэл түүний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага шүүхэд хандаж шүүгчийн хохирсон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээлгэх, эд хөрөнгийн бус гэм хорын хохирлыг арилгуулахыг шаардах эрхтэй.



## Шүүхийн шийтгэх тогтоолын үндэслэл БА ШҮҮХЭЭС ГАРАХ ДҮГНЭЛТ



Улсын дээд шүүхийн  
шүүгч Д.БАТСАЙХАН

Ардчилсан нийгмийн гол тулгуур болох шүүх эрх мэдэл, түүний нэр хүнд шүүгчдээс хамаарах нь тодорхой. Тийм ч учраас шүүгч та биднийг эхлээд өөрийгөө боловсруулж, төлөвшүүл, тэгээд бусдын хэргийг шүүж цэгнэхийг шаардаж байна. Хэдийгээр манай ард түмэн "Адгийн зарга 10 хоног" гэж шүүх эрх мэдлийн байгууллагыг шүүмжлэн удаан ажиллагаатай хүнд сурталтай, иргэдийг хамгаалагч биш, эрх баригчдад үйлчилдэг, хахууль авдаг, хүмүүст ялгавартай үйлчилдэг, хэн нэг мөнгөтэй юм уу, дээгүүр албан тушаалтнуудад зөөлөн ханддаг гэх мэтийн таагүй ойлголт сүүлийн 10 жилийн хугацаанд олон нийтэд түгэх нь ердийн үзэгдэл болжээ.

Энэ нь Монгол Улсын төрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа нь ойлгомжтой тул төр болон хуульдаа, мөн шүүхдээ иргэд итгэл найдвартай байх нь төрийн

засаглалын тогтвортой байдалд чухал ач холбогдолтой нь ойлгомжтой.

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д "Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх"-ыг хуульчилж өгсөн. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, шударга шүүхээр, шүүх хурлаар асуудлаа нээлттэй хэлэлцүүлэх эрхтэй байна гэдэг нь хүний амьдралын нэг гол хэмжүүр юм. Тэгвэл эрүүгийн шүүх хуралдааны хууль зүйн үндэслэлтэй байх талаар саналаа солилцье.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар шүүхийн шийтгэх тогтоол гэдэг нь Монгол Улсын нэрийн өмнөөс гарч, хүний амьд явах эрх, эрх чөлөө, өмч хөрөнгөд нь хуулиар халдаж, хууль эрх зүйн хэм хэмжээ тогтоож байдгаараа асар их хүчтэй, нэн хариуцлагатай шийдвэр гэдгийг шүүгч хүн цаг ямагт санаж байх нь зүйн хэрэг юм. Тийм ч учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байхад хуулийн бүх шаардлагад нийцүүлэн шүүхэд гаргасан нотлох баримтыг шүүх хуралдаанд тал бүрээс нь бүрэн бодитой шинжилсний үндсэн дээр гаргасан тогтоолыг хууль ёсны үндэслэлтэй тогтоол гэж хүлээн зөвшөөрөх ёстой байдаг.

Шүүхийн шийтгэх тогтоол гаргах үед шүүх, шүүгч заавал

шийдвэрлэвэл зохих асуудлууд байдаг. Үүнд :

Шүүгдэгч этгээдийн хувийн байдал, хэрэгт оролцсон оролцоо, шүүхийн өмнө хэлж байгаа үгэнд хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдал илэрвэл шүүх нь талуудын хүсэлтээр шүүхийн хэлэлцүүлгийг сэргээж явуулах ба шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай, гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэх, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлэх нөхцөл байдал, ял ногдуулах үндэслэл, ямар ял ногдуулбал зохих, түүнийг эдлүүлэх эсэх, хорих ял ногдуулсан бол ямар дэглэмд, эд мөрийн баримтыг хэрхэх, шүүгдэгчийн авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэх, иргэний нэхэмжлэлийг хангах, хангавал хэнд, ямар хэмжээгээр олгох, хэрэв иргэний нэхэмжлэл гаргаагүй бол эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэтийн олон асуудлыг шийдвэрлэсэн байх шаардлагатай.

Шүүхийн тогтоол нь тодорхой, ойлгомжтой бичигдсэн байх бөгөөд удиртгал, тодорхойлох, тогтоох гэсэн 3 хэсгээс бүрддэг.

Удиртгал хэсэгт: Монгол Улсын нэрийн өмнөөс тогтоолыг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа ба шүүх хуралдааны бүрэлдэхүүн, шүүх хуралд оролцогч талуудын хууль зүйн нэр, албан

тушаалыг бичиж, шүүгдэгчийн биеийн байцаалтыг бүрэн хэмжээг тодорхой бичсэний дараа үйлдсэн гэмт хэрэг нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ямар зүйл ангид хамаарч буйг бичиж байх ёстой.

**Тодорхойлох хэсэгт:** Энэ хэсэгт тухайн гэмт хэргийн үйлдсэн газар, цаг, арга, түүний улмаас учирсан хохирлын хэмжээ гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл, шүүхээс өгөх дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримтын үнэлэл, бусад нөхцөл байдал, шүүгдэгчийн эрх зүйн хэм хэмжээ, түүний шалтгаан нөхцөлийг маш тодорхой ойлгомжтой бичигдсэн байх шаардлагатай. Яагаад вэ? гэвэл энэ нь тухайн шүүгдэгчийн гэм бурууг шүүхээс тогтоож байгаа хууль зүйн үндэслэлийг нотлох баримт болдгоороо нэн хариуцлагатай шийдвэр бөгөөд хэрвээ эргэлзээ төрүүлэх зүйлийг оруулж бичсэн, нотлох баримт таамаглалд үндэслэж шийдвэрлэсэн шүүхийн тогтоол хүчингүй болох нь ойлгомжтой.

**Тогтоох хэсэгт:** Энэ хэсэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ямар зүйл, хэсгийг удирдлага болгож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар зүйл хэсэгт дурдсанаар ялын ямар төрөл, хэмжээ, ял шийтгэлийг ногдуулж байгааг тодорхойлж, хорих ял эдлэх дэглэм, урьдчилан хоригдсон хугацааг тооцож, шүүхээс гарах таслан сэргийлэх арга хэмжээ буюу шүүхээс авах бүхий л шийдвэрийн

үндэслэлийг хуульчилж шийдвэрлэсэн байна.

“Шүүхийн тогтоолыг шүүх бүрэлдэхүүн, шүүгч уншиж сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно” гэж шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд асар их хүчтэй заалт оруулсан байгааг анхаарах нь зүйтэй.

Эрүүгийн шүүхийн шийтгэх тогтоолуудыг судалж үзэхэд шүүхийн шийтгэх тогтоолыг хэлбэрдэх, ёс төдий хандах, учир утгагүй, ойлгомжгүй зүйл бичих, хууль буруу хэрэглэж ноцтой зөрчих гэх мэтийн асар их зөрчил шүүгчийн хайнга, хариуцлагагүйн улмаас хүчингүй болж, олон жил, сар болж, иргэдийг чирэгдүүлж байгааг юу гэж ойлгох вэ? Үүнийг зөвхөн шүүх, шүүгчийн ажлын хариуцлагаас гадна Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн хүрээнд багтаж байдаг хууль, хяналтын байгууллагын ажлын хариуцлагатай холбох нь зүйн хэрэг.

Шүүх, шүүгч нь аливаа хэрэг маргааныг гагцхүү хуульд захирагдаж төрийн нэрийн өмнөөс нотлох баримт, нотолгоонуудад тулгуурлан ажил, мэргэжилдээ үнэнч байж, албан үүргээ шударгаар гүйцэтгэх нь шүүгчийн ёс зүйн үндсэн зарчим бөгөөд тийм ч учраас шүүгч бид тангараг өргөдөг. Эрх зүйн өндөр соёлтой, ухаалаг байх нь шүүгчийн дагаж мөрдөх нэг гол шалгуур юм. Иймд бидний дийлэнх нь тун явцуу хүрээнд хэдэн хуулийн хооронд сэтгэж, өдөр тутмын нэр их ажилдаа дарагдсаар цаг үеэсээ хол хөндий хоцрогдож, амьдарч

байгааг ч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Тиймээс юуны түрүүнд шүүгчид бид боловсрол, мэдлэгээ дээшлүүлмээр байна. Тэгэхгүй бол эзэмшсэн боловсрол, авсан мэдээллийн ялгаа ихсэх тусам цаг үеийн нөхцөл байдлыг дагаад шинэ төрлийн гэмт хэрэг ихсэж, ялангуяа албан тушаалын, эдийн засгийн, зохион байгуулалтын шинжтэй хэргүүд зонхилж, шүүгчид бидэнд хүндрэл бэрхшээл улам их тулгарах болж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй.

Даяарчлагдан буй дэлхий ертөнц ч шүүгчдийг арай өргөн хүрээтэй сэтгэх, шүүгч их мэдлэгтэй байхыг шаардаж байна. Чухамхүү боловсрол, мэдээлэл муутай шүүгч мэргэжлийн ур чадвараараа гологдож байдгаас прокурор, өмгөөлөгчдөд дарлуулж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн шүүмжлэлийн бай болдог.

Шүүгч хүн хэрэг маргааныг шийдвэрлэхгүй удах, хүнийг олон дахин дуудаж чирэгдүүлэх, цэгцтэй хариу өгөхгүй байх, хэн нэгэн хэсэг бүлгийн эрх ашигт үйлчилж, бусдыг хохироох зэрэг зүй бус үйлдэл нь зөвхөн тухайн шүүгчийн төдийгүй нийт шүүхийн байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлнө.

Тэгэхээр шинэ зууны шүүгч хүн харьцааны өндөр соёлтой, өргөн мэдлэгтэй байж, хүнтэй ажиллаж чадах чадварыг төгс эзэмшиж шүүхэд ажиллах шаардлагатай байна.



## МӨРДӨН БАЙЦААЛТЫН АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ



Нийслэлийн прокурорын газрын  
хяналтын прокурор **Ё.САГСАЙ**

**М**өрдөн байцаалтын ажиллагаа бол үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн илрүүлэх зорилготой, ээдрээ төвөгтэй, хойшлуулшгүй шуурхай ажиллагаа шаардсан, танин мэдэхүйгээс таньж мэдэхэд чиглэгдсэн, төрийн эрх бүхий байгууллагаас, зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу эрхлэн хэрэгжүүлдэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хамгийн гол хэсэг юм.

Мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай шударга, хуульд нийцүүлэн явуулснаар үйлдэгдсэн гэмт хэргийг богино хугацаанд бодитойгоор илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэгт өртөгдсөн этгээдийн зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Шинэ Эрүүгийн байцаан шийтгэх Хуулиар Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан мөрдөн байцаалтын харяалалтай хүндэтэр, хүнд, онц хүнд хэргүүдэд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах болсон нь энэхүү ажиллагаанд туйлын хариуцлагатай хандахыг зүй ёсоор шаардаж байна.

Мөрдөн байцаах ажиллагааны явцад хуульд заасан үндэслэл, журмыг зөрчих нь хүний эрхийг ноцтойгоор зөрчигдөхөд хүргэж болох сөрөг үр нөлөөтэй тул мөрдөн байцаалтын ажиллагааг хуульд, зөвхөн хуульд, заасан үндэслэл журмын дагуу явуулах шаардлага тавигддаг. Ийм ч учраас мөрдөн байцаалтын ажиллагаанд хууль хэрхэн хэрэгжиж байгаад тавих хяналтыг Монгол Улсын Үндсэн хуульд заасан чиг үүргийн хүрээнд прокурор хэрэгжүүлдэг.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь нэг талаар мөрдөн байцаалтын ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх Хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулах, нөгөө талаар энэхүү ажиллагаанд хүний эрхийг хамгаалах баталгаа болж хэрэгждэг.

Мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн явц, байдалд

прокурор хяналт тавих өөр нэг шаардлага бол тухайн хэргийг анхан шатны шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс яллах үүргийг прокурор хүлээсэн байдагтай шууд холбогдоно.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд хэр зэрэг хяналт тавьж, хэргийн нөхцөл байдлыг хэр зэрэг мэдэрч, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтыг хэрхэн судалж, үнэлж чадсанаараа улсын яллагчийн үүргийг чадварлаг гүйцэтгэж, шүүх хуралдааны мэтгэлцээнд яллах нотлох баримтыг үндэслэлтэй зөв гаргаж, шүүгдэгчид ял, хариуцлага хүлээлгэх нь зайлшгүй юм байна гэсэн итгэл үнэмшлийг шүүхэд төрүүлж чадна.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь дээрх нөхцөл, байдлуудтай нөхцөлдөж байж сая үр дүнтэй хэрэгжиж чадна.

Гэхдээ прокурор нь эрүүгийн хэргийг шүүхийн өмнө яллахын тулд мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьдаг мэтээр өрөөсгөлөөр ойлгож болохгүй.

Прокурорын хяналтыг мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийг чанд сахиулах, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хам-



гаалах, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хууль зөрчсөн, хүний эрхэд үндэслэлгүйгээр халдсан зөрчил гаргуулахгүй байх, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьсны үр дүнд болгож түүний явц үр дүнд гарах шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гаргахын тулд хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. Үүний тулд:

1. Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь юуны түрүүнд уг ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль бусад хуулийн шаардлагыг чанд сахиулахад чиглэгдэнэ. Үүний тулд мөрдөн байцаалтын ажиллагааг эрхлэн хэрэгжүүлж байгаа этгээд хуульд заасан үндэслэл, журмыг өчүүхэн төдий зөрчсөн байвал түүний гаргасан шийдвэрийг хүчингүйд тооцож байх шаардлага хуулиар тавигдаж байна.

Прокурор энэхүү үүргээ хэрхэн хэрэгжүүлснээс шууд хамаарч мөрдөн байцаалтын ажиллагаанд хууль нэг мөр хэрэгжих, хүний эрхийг баталгаатай хангах, эрүүгийн хэргийг шударга шийдвэрлэх гол нөхцөл бүрдэнэ.

Ийм ч учраас мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих эрх хэмжээ эдэлдэг прокурор бүр мөрдөн байцаагчийн гаргасан хууль зөрчсөн үйл ажиллагаа, шийдвэр нэг бүрийг цаг алдалгүй хүчингүй болгож, хуулиа чанд сахиулах талаар ихээхэн хариуцлага хүлээдэг байх ёстой.

Ингэж байж прокурор мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийг чанд сахиулж чадна. Хуульд заасан үндэслэл журмыг зөрчсөн мөрдөн байцаагчийн шийдвэрийг хүчингүй болгосноороо прокурор санаа амарч, хууль хэрэгжүүлээ гэж тайвширч бас болохгүй. Тухайн зөрчлийг гаргасан мөрдөн байцаагчтай хариуцлага тооцдог байх нь хуульд нийцнэ. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх Хуулийн 8.2-т “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 8.1-ийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, түүнд хариуцлага хүлээлгэнэ” гэснээр тайлбарлагдана. Энэ зорилтыг прокурор хангаснаар мөрдөн байцаалтын ажиллагаа хууль ёсны байх зарчмыг хангана.

2. Мөрдөн байцаалтын ажиллагаанд хүний эрхийг хангуулах явдал нь прокурорын хяналтын нэн тэргүүнд тавигдах зорилтын нэг мөн. Энэхүү зорилгоор прокурор нь мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах, эрх ашиг сонирхол нь зөрчигдсөн тохиолдолд түүнийг сэргээн эдлүүлэх, хүний халдашгүй эрхийг хөндсөн үйл ажиллагаа явуулахад хянаж зөвшөөрөл олгох, хуульд заасан тохиолдолд шүүгчид танилцуулж зөвшөөрөл авах асуудлыг шийдвэрлэж байх бүрэн эрхийг хуульчилсан байна. Энэ нь дараах байдлаар илэрч хэрэгжиж болох талтай.

Эрүүгийн байцаан шийтгэх Хуулийн 10.3-д зааснаар прокурор нь:

- Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон;
- Хуульд зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа;
- Шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа этгээдүүдийг нэн даруй суллах эрхийг хуулиар эдэлнэ. Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөнд халдсан, хязгаарласан ажиллагаа явуулах нөхцөлд хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгох, прокурор нь сэжигтэн, яллагдагчийг яллах болон эрүүгийн хариуцлагыг хүндрүүлсэн нөхцөл байдлыг тогтоолгоод зогсохгүй, тэднийг цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн илрүүлэхэд хяналтаа чиглүүлэх үүрэгтэй байгаа нь прокурорын хяналт хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэгдэж байдгийн илрэл юм.

3. Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үндэслэл байгаа эсэхийг хянах нь прокурорын хяналтын зайлшгүй хэрэгжих нэг нөхцөл мөн. Энэ нь зарим тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнөх шатанд ялангуяа Эрүүгийн байцаан шийтгэх Хуулийн 172 дугаар зүйлд заасан хойшлуулшгүй ажиллагааны үед ч хэрэгждэг гэдгийг дурдах нь зүйтэй. Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагааны хууль зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгохоос эхлээд уг хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа

явуулж болохгүй тохиолдлууд байгаа эсэх, хэргийн талаар прокуророос заавал хянавал зохих асуудлууд бүрэн хангагдсан эсэх, зэргийг хэрэг нэг бүр дээр заавал хянасан байх ёстой. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үндэслэл байхгүй байхад мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас болж хүний эрхийг ноцтойгоор зөрчих, хохироох явдал гарч болзошгүй юм гэдгийг ямагт санаж ажиллах нь чухал болж байна.

4. Шинэ Эрүүгийн байцаан шийтгэх Хуулиар мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих талаар прокурорын эдлэх эрх хэмжээг ихээхэн өргөтгөж, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад гарах шийдвэрүүдийг үндсэндээ прокурор гаргах болсон нь прокуроруудын өмнө шинэ үүрэг, хариуцлагыг бий болгож байна. Иймээс прокурор нь мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхийг хянаад зогсохгүй, гаргах шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлд онцгой анхаарал хандуулах шаардлагатай болж байна. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх, яллагдагчаар татсан тогтоолыг батлах, яллах дүгнэлт үйлдэх зэрэг прокурорын шийдвэр нь гагцхүү тухайн хэргийн талаар хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэсэн, хуульд заасан үндэслэл журмын дагуу үйлдэгдсэн, хууль ёсны байх нь юунаас чухал юм. Прокурорын байгууллагын тухай хуулиар дээрх шаардлагыг үндэслэн

прокурорын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянаж байх хяналтын механизм тогтоож өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл мөрдөн байцаалт явуулсан хүнд, онц хүнд хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн, яллахаас татгалзсан прокурорын гаргасан шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг дээд шатны прокурор хянаж байхаар хуульчилсан юм. Энэ нь мөрдөн байцаалтын ажиллагааны талаар гаргасан прокурорын шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй байх шаардлагыг хангуулахад чиглэгдсэн нэг алхам болсон гэж үзэж байна.

5. Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь хуулийн заалтын утга агуулгыг зөв ойлгож, бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байж сая утга агуулгаараа хэрэгжиж чадна. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх Хуулийн 58,59 дүгээр зүйлд зааснаар сэжигтнээр баривчлагдсан этгээдийг зөвхөн шүүгч захирамж гаргаж суллах ёстой. Гэтэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар баривчилсан хугацаа дуусмагц баривчлах байрнаас тэднийг гаргаж явуулах зөрчил байсаар байна.

Ийм зөрчил гаргуулахгүй байлгахад л прокурорын хяналт чиглэх учиртай. Түүнчлэн мөрдөн байцаалтын ажиллагааг дууссаны дараа мөрдөн байцаагч нь яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгчид

мэдэгдэж энэ тухай тэмдэглэл үйлдсэн байх ёстой. Энэ нь дээрх этгээдүүдэд хэрэг танилцуулахын өмнө заавал хийгдвэл зохих мөрдөн байцаалтын ажиллагаа юм. Гэтэл энэхүү ажиллагааг хийж гүйцэтгэдэг мөрдөн байцаагч бараг байхгүй гэж хэлж болно. Энэ мэт зүйлд прокурор хяналтаа хандуулж чадвал мөрдөн байцаалтын нарийн чимжлүүр ажиллагааг хийлгэж чадах юм аа. Цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авах, түүнийг хүчингүй болгох, өөрчлөх асуудлыг мөрдөн байцаагчийн саналыг харгалзан уг хэргийн ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурор эсвэл дээд шатны прокурорын тогтоолоор шийдвэрлэх журмыг шинэ Эрүүгийн байцаан шийтгэх Хуулиар тогтоосон байна. Ялангуяа нэгэнт авсан Таслан сэргийлэх арга хэмжээ /цагдан хорихоос бусад/-г өөрчлөх, хүчингүй болгох эрх нь зөвхөн прокурорт харьяалагдах болсныг сайтар ойлгож хэрэгжүүлмээр байна.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангуулах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх баталгаа болдог.

Энэ ч утгаараа прокурорын хяналт нь хүний эрхийг хамгаалах тогтолцоонд, түүний дотор Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах, хамгаалахад чухал байр суурь эзэлдэг юм.

## Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд прокурорын гүйцэтгэх үүрэг



Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх  
**Б.ЦЭРЭНБАЛТАВ**

2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Монгол Улс Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг соёрхон баталсан 61 дэх орон болсноор Олон улсын эрүүгийн шүүхэд шүүх прокурорын үйл ажиллагаанд тусалцаа үзүүлэх, хамтран ажиллах хүсэлтийг биелүүлэх, Ромын дүрэмд тусгасан хамтын ажиллагааны бүхий л хэлбэрийг хэрэгжүүлэх боломжийг үндэсний хуульд тусгасан журам бий болгох зэрэг үүрэг хүлээж байна.

Энэ утгаараа үндэсний хууль тогтоомж, ялангуяа Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хуулийн холбогдох заалтуудыг Ромын дүрэмд нийцүүлэх зарим асуудал зүй ёсоор урган гарч байгаа юм.

1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар прокурорын байгууллагыг шүүх эрх мэдлийн хүрээнд хамааруулж, Үндсэн хуулийн

56 дугаар зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасан нь прокурорын байгууллагын чиг үүргийг тодорхойлж, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг баталгаажуулсан юм.

Прокурорын байгууллага нь өмнөх тогтолцооны үед төрийн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих үүргийг гүйцэтгэж, төрийн хянан шалгах механизмын нэг гол цөмийг бүрдүүлж байсан бол шинэ Үндсэн хууль батлагдсанаар прокурорын байгууллагын тогтолцоо, хяналтын чиг үүрэгт ихээхэн өөрчлөлт орсон юм.

Шинэчлэгдсэн хуулиудад прокурорын хувьд шинээр орсон зарчмын шинэчлэлүүд дотор прокурорын үүрэг, эрх хэмжээг өргөтгөх, прокурорт тавигдах шаардлагыг өндөржүүлэх, үйл ажиллагаагаа хараат бус байдлаар явуулах баталгааг хангах явдал гол байр суурийг эзэлж байна.

Монгол Улсад хэрэгжиж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2002 онд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын гол хуулиудыг шинэчлэн баталснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн үйл ажиллагааны горимд зарчмын шинжтэй нэлээд өөрчлөлт орсон нь прокурорын байгууллагын чиг үүргийг жинхэнэ утгаар нь бүрэн зөв тогтооход дөхөмтэй алхам болсон байна.

Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хуулийг зөв хэрэглэх баталгаа болоод зогсохгүй хүний эрхийн баталгаа болж байх ёстой. Ялангуяа гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан, цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа эрхээ хязгаарлуулсан хүмүүс, түүнчлэн гэрч, хохирогчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үндсэн баталгаа прокурорын хяналт байх учиртай.

Дэлхий нийтийн жишгээс Дүгээхэд прокурорын чиг үүргийн эрх зүйн зохицуулалт нь аливаа улс орны Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрэлддэг. Прокурорын тухай хууль, тогтоомжийн эх сурвалж нь олон улсын гэрээ болон үндэсний хууль, хууль тогтоомжууд бөгөөд энэ утгаараа ОУЭШ-ийн Ромын дүрэм нь энэхүү харилцааг зохицуулж буй эрх зүйн эх сурвалжийн нэг болох үндэсний хууль тогтоомжийн нэг адил үйлчлэх юм.

Юуны өмнө шинээр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь эрх зүйт төрийн зарчимд нийцсэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид болон уг ажиллагааг хэрэгжүүлэгчдийн эрхийг хангаж чадсан олон заалтыг тусгасан байна.

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүтцийн хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат буюу яллах, шүүн шийдвэрлэх үүрэг бүхий

шүүх хуралдаан гэсэн 2 үе шатнаас бүрдэж байгаа нь ОУЭШ-ийн Ромын дүрэмтэй нийцэж байгаа юм.

Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны яллагч тал бөгөөд түүний эдлэх бүрэн эрх, хүлээх үүргийн талаархи багц зохицуулалтыг хуульд тусгаж чадсан байна.

Хуульд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг хянах боломжийг олгох үүднээс зарим ажиллагаанд прокурор зөвшөөрөл өгөх, оролцогчдын зүгээс прокурорт гомдол гаргах, түүнийг прокурор хянан шийдвэрлэх, шаардлагатай бол прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүргийг прокурор хүлээсэн байна.

2.Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын өмнө хүлээсэн үүрэгтэй.

Ромын дүрмээр хохирогч болон гэрчийн аюулгүй байдал, бие махбодийн болон сэтгэл санаа, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн халдашгүй байдлыг хамгаалахаар хуульчилсан байна.

Манай үндэсний хууль тогтоомжид хүний халдашгүй бүрэн эрх, иргэний орон байрны халдашгүй байдлыг хангах, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмууд тусгалаа олсон хэдий ч гэрч, хохирогчийг хамгаалах асуудал төдийлөн тодорхой тусгагдаагүй, энэ талаар прокурорын хүлээх үүрэг ч бүрхэг байдаг бөгөөд голлон тэднийг байцаах журам, нөхцөлийг тодорхойлсон байна.

Ромын дүрмийн 54 дүгээр зүйлийн 1-д прокурор процессын явцад хохирогч болон гэрчийн нас, хүйс, эрүүл мэндийн зэрэг хувийн байдлыг харгалзан үзэх, ашиг сонирхлыг нь хүндэтгэх, мөн хүчингийн хэрэг, хүйсээр ялгаварлан гадуурхах,

хүүхдийн эрх зөрчигдсөн эсэхийг анхааралдаа авахыг үүрэг болгожээ.

Мөн дүрмийн 68 дугаар зүйлийн 1-д заасны дагуу прокурор нь хохирогч болон гэрчийн аюулгүй байдлыг хангах, тэдний бие махбодь, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, хувийн амьдралд нь оролцохгүй байх шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй болохыг заажээ.

Ромын дүрмийн 54 дүгээр зүйлийн 1-д эрүүгийн хариуцлагын үнэн бодитой байдлыг тогтоохын тулд мөрдөн байцаалтыг сунгаж явуулахыг заажээ. Ингэхдээ гэм буруутай буюу гэм буруугүй болохыг гэрчилсэн нөхцөл байдлыг мөн нэгэн адил анхаарч үзэх тухай онцлог заалтыг тусгасан байна.

Манай эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид зөвхөн мөрдөн байцаалтын хугацаа, түүнийг тооцох, сунгах журам, үе шат, хугацаа сунгах эрхийг эдлэх прокуроруудын талаар зааж, дээр дурдсан дүрмийн заалтыг холбож тусгаагүй байна. Түүнчлэн дүрмийн 67 дугаар зүйлийн 2-т зааснаар яллагдагчийн гэм буруугүйг гэрчлэх, эсхүл хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлын тухай мэдээ баримтын талаар нэн даруй шийдвэрлэж байх тухай заасан нь яллагдагчийн эрх ашгийн үүднээс прокурор нотолгоо гаргах ойлголт байна.

Энэхүү Ромын дүрмийн заалт Монголын нөхцөлд төдийлөн хэрэгжихгүй байгаа бөгөөд прокурор, ялангуяа шүүх хуралдаанд зөвхөн яллах талыг баримталдаг арга барил байсаар байна.

3.Ромын дүрмийн 75 дугаар зүйлийн 1-д яллагдагчаар учруулсан хохирлыг ямар аргаар, хэрхэн төлүүлэх тухай шүүх шийдвэрлэх, өгөгдсөн нөхцөлд тохирсон зайлшгүй арга хэрэглэх тухай, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 2-т

хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэх үндэслэлүүдийг тогтоож өгчээ.

Гэтэл хохирогчдоод учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд прокурор ямар нөхцөл боломжийг бүрдүүлэх асуудал үндэсний хууль тогтоомжид тусгасан зүйл ховор байна. Ялангуяа зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал ойлгомжгүй хэвээр байгаа юм.

4.Ромын дүрэмд заасан хүнд, онц хүнд хэргүүд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн тохиолдолд Монгол Улс прокурорт мөрдөн байцаалт явуулах талаархи хүсэлт тавьж шийдвэрлүүлэх ёстой.

Энэ талын нарийн зохицуулалт үндэсний хууль тогтоомжид байх шаардлагатай. Үүнд:

- Хүнд ноцтой гэмт хэргийг эрх ямба, дархан эрх эдэлж буй албан тушаалтан үйлдсэн;

- Гэмт этгээд Монголын нутаг дэвсгэрийг орхин зугтсан;

- Монгол Улсын Эрүүгийн хуулиар зохицуулагдаагүй гэмт хэрэг үйлдэгдсэн;

- Монголын шүүх ба ямар нэгэн хүчин зүйлийн нөлөөгөөр хэрэг шийдвэрлэх чадваргүй болсон тохиолдол зэргийг ойлгож болох юм.

5.Ромын дүрмийн оролцогч талуудын томоохон үүрэг бол 9 дүгээр бүлэгт заасан "Шүүх эрх мэдэлд нь хамаарагдах гэмт хэргийн мөрдөн байцаалт болон мөрдөлт явуулахад Шүүхтэй бүх талаар хамтран ажиллана" гэжээ. Үүнд, сэжигтнийг баривчлах болон хүлээлгэн өгөх, яллагдагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, Олон улсы эрүүгийн шүүхийн прокурорт газар дээр нь мөрдөн байцаалт явуулах эрх олгох, нотолгоо гаргуулах, эд хөрөнгө хураах, хохирогч, гэрчүүдийг хамгаалах зэрэг тогтоол шийдвэрүүдийг гүйцэтгэх асуудлууд багтаж байна.

Шинэчилсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар бүлэгт гадаад улсын холбогдох байгууллагын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон олон улсын бусад гэрээ хэлэлцээрийн дагуу ажиллах арга механизмыг тусгажээ. Энэхүү заалт нь Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, хэлэлцээрийн журмын дагуу гадаад орны холбогдох байгууллагаас тавьсан хүсэлтийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал ба газар нутгийн бие даасан байдалтай зөрчилдөхгүй нөхцөлд гүйцэтгэх асуудлыг журамласан байна.

6. Ромын дүрмийн 59 дүгээр зүйлд зааснаар аливаа этгээдийг урьдчилан саатуулах буюу хорих болон хүлээлгэн өгөх тухай хүсэлтийг хүлээн авсан оролцогч улс тухайн этгээдийг өөрийн хууль тогтоомж болон Ромын дүрмийн 9 дүгээр бүлгийн дагуу баривчлахад чиглэсэн алхмуудыг нэн даруй хийнэ. Тухайн этгээдийг баривчилсны дараа эрх бүхий шүүхийн байгууллагад нэн даруй хүргэж тогтоолыг тухайн этгээдийн хувьд гаргасан, түүнийг зүй ёсны ажиллагааны дагуу баривчилсан болон тухайн этгээдийн эрхийг хангасан эсэхийг тодорхойлно.

Манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн "Гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг биелүүлэх үүрэг"-ийн тухай 405 дугаар зүйлд заасан. Энд гадаад оронд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн эсхүл Монгол Улсын ба гадаадын нутаг дэвсгэрт шүүн таслагдсан гадаадын харьяат болон харъяалалгүй этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлтийг биелүүлэх журмыг тусгасан байдаг. Мөн 408 дугаар зүйлийн 1-д зааснаар "шилжүүлэн өгөх үндэслэл

байгаа тохиолдолд эрүүгийн хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг баривчилж болно", цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлээгүй бол прокурорын тогтоолоор суллаж болно. Эрүүгийн хэрэгт сэжиглэгдсэн гадаадын харьяат болон харъяалалгүй этгээдийг гадаад оронд шилжүүлэхдээ үндэсний Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шаардлагатай нотлох баримтыг хамт явуулахаар заажээ.

Хуулийн дээрх заалт нь Монгол Улсын нэгдэн орсон гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх талаархи 2 талт болон олон талт гэрээг хэрэгжүүлэх журмыг илэрхийлнэ.

**М**онгол Улсын иргэнийг Мөөр улсад "шилжүүлэн өгөх"-ийг Үндсэн хуулийн 15.2-т хориглосон байдаг. Энэхүү заалтыг Эрүүгийн хуульд тодруулж "Монгол Улсын иргэнийг эрүүгийн гэмт хэрэгт мөрдөн байцаах, яллах зорилгоор гадаад оронд шилжүүлж болохгүй" гэж заасан. Үүнд гадаад оронд гэмт хэрэг үйлдсэн гадаадын харьяат иргэд, харъяалалгүй хүмүүсийг өөр оронд шилжүүлж болохоор тусгасан байна. Иймээс Монгол Улсын иргэдийн хувьд өөр оронд шилжүүлэхээс татгалзах бүрэн үндэслэлтэй. Үүнээс гадна өөр бусад үндэслэлээр татгалзаж болно. Жишээлбэл сэжигтэн этгээд нь хууль ёсоор байнга оршин суугч байх, эсхүл буруутгаж буй гэмт хэрэг нь Монгол Улсын хууль тогтоомжид гэмт хэрэгт тооцогддоггүй байх гэх мэт.

Гэхдээ Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд оролцогч улсуудын зүгээс тус шүүхтэй хамтран ажиллах үүргийн дагуу сэжигтэн этгээдийг иргэний харъяалал үл харгалзан хүлээлгэн өгөх тухай заасан байдаг. Энэ талаар Ромын дүрмийн 89.1-д нутаг дэвсгэрт нь оршиж буй этгээдийг үндэсний журам,

дүрмийн дагуу баривчилж, хүргүүлэх хүсэлтийг оролцогч улсуудад тавих эрхийг Олон улсын эрүүгийн шүүхэд олгосон.

Монгол Улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд, Олон улсын эрүүгийн шүүхэд Монголын иргэнийг "хүлээлгэн өгөх" тухай тодорхой заалт байхгүй байна. Гэхдээ Үндсэн хуульд тусгагдсан хориг нь Олон улсын эрүүгийн шүүхэд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг "хүлээлгэн өгөх"-д хамаарахгүй. Энэ нь өмнө өгүүлсэнчлэн Ромын дүрэмд нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомжийн адил хүчин төгөлдөр үйлчлэх зарчимтай уялдаж байгаа юм. Олон улсын эрүүгийн шүүхэд сэжигтэн этгээдийг хүлээлгэн өгөх асуудлаар Үндсэн хуулийн заалтыг тайлбарлахад эргэлзээтэй байгаа тохиолдолд Монголын иргэнийг хүлээлгэн өгөх Үндсэн хуулийн тусгайлсан заалтыг бий болгох хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, энэхүү чухал ойлголтыг хуульчлан зохицуулах нь Олон улсын эрүүгийн шүүхтэй бүрэн дүүрэн хамтран ажиллах зорилгод нийцнэ.

Олон улсын эрүүгийн шүүхээс тавьсан хүсэлтийг биелүүлэх бололцоо олгох тодорхой журмууд одоо мөрдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгалаа олжээ. Тухайлбал 401-403 дугаар зүйлүүдэд гадаадын зохих байгууллагуудаас тавьсан хүсэлтийн дагуу мөрдөн байцааж яллах ажиллагааг олон улсын гэрээнд заасан эрүүгийн байцаан шийтгэх журмын хэм хэмжээтэй уялдуулах бөгөөд үүнд гадаадын байгууллагын төлөөлөгчийг байлцуулахыг зөвшөөрдөг байна.

## Олон улсын шинжтэй иргэний хэргийг шүүхээр шийдвэрлэх нь



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор Т.МЭНДСАЙХАН

**Ү**ндэсний шүүхийн хэрэг харьяалан шийдвэрлэх эрх мэдэл. Аливаа улс гүрэн оршин тогтнох, хөгжин бэхжихэд олон улсын нөхцөл байдал чухал хүчин зүйл болно. Үндэснийхээ эрх ашиг сонирхлыг хамгаалан бататгахын тулд бусад улс гүрэнтэй зөвшин тохиролцож, харилцан хамтран ажиллахыг эрмэлзэх нь улс бүрийн өмнө тулгардаг нийтлэг зорилт юм<sup>1</sup>. Төрийн бүрэн эрхийн хэмжээнд өөрийн вутаг дэвсгэр дээр хууль тогтоох, хэрэг шүүн шийдэх эрх нь тухайн улсын хууль үйлчлэх хүрээг тогтоох нэгэн гол иш үндэс болно. Мөн төрийн бүрэн эрхийн зарчмаас урган гардаг улс гүрний тэгш эрхийн зарчмын дагуу аливаа улсын эрх мэдэлд хамаарах хэргийг өөрийн нь зөвшөөрөлгүйгээр өөр улсын шүүхэд авч хэлэлцэхийг хориглох журам үйлчилнэ. Шүүх ба захиргааны байгууллагаас өөрийн эрх мэдлийн хэмжээнд хэрэг

захиран шийдвэрлэхийг хэрэг шүүн шийдэх эрх (jurisdiction) гэнэ<sup>2</sup>.

Олон улсын шинжтэй иргэний хэрэг үүссэн үед аль улсын шүүхэд тухайн хэрэг харьяалагдах эсэх буюу үндэсний шүүхийн бүрэн эрхийн асуудал юуны өмнө хөндөгдөнө. Монгол Улсын хувьд олон улсын улсын шинжтэй иргэний хэрэг гэдэгт дараах төрлийн хэргийг хамааруулан үзэх нь зүйтэй<sup>3</sup>:

- гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын байгууллага, хуулийн этгээд, нэхэмжлэгч, хариуцагчаар оролцсон иргэн, өв залгамжлал, гэр бүл, хөдөлмөрийн хэрэг маргаан;

- гадаад улсад байгаа эд хөрөнгө, оюуны өмчийн асуудлаар Монгол Улсын иргэн, байгууллага хоорондоо маргалдаж иргэний хэрэг үүсгэсэн тохиолдол;

- гадаад улсад бий болсон хууль зүйн фактын /эрүүгийн хэрэг, осол, байгалийн гамшиг г.м./ улмаас Монгол Улсад иргэний хэрэг үүсгэсэн тохиолдол;

- гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагч, гишүүдийн хоорондын маргаан эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон Монгол Улсын төрийн байгууллага хоорондын маргаан бүхий иргэний хэрэг.

Олон улсын харилцаа өргөжиж байгаатай уялдан үндэсний шүүхээр олон улсын шинжтэй иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явдал нэмэгдэж байна. Улс гүрнүүд харилцан тохиролцоо замаар олон улсын гэрээний үндсэн дээр шүүхийн эрх мэдлээ тодорхойлох арга, шалгуурыг тогтоох оролдлого XIX зууны эцсээс эхэлсэн аж. Тухайлбал, Гаагийн бага хурлын хүрээнд боловсруулсан Иргэний процессын талаарх конвенцууд болох Иргэний процессын асуудлаарх 1954 оны; Хүүхдийн тэтгэлгийн үүргийн тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай 1958 оны; Иргэний болон худалдааны хэргийн талаарх нотлох баримтыг гадаад улсад цуглуулах тухай 1970 оны; Иргэний болон худалдааны хэргийн талаарх шүүхийн ба шүүхийн бус баримт бичгийг гадаад улсад гардуулах тухай 1965 оны; Гадаад улсын шүүхэд хандах ажиллагааг хөнгөвчлөх тухай 1980 оны конвенцуудыг нэрлэж болно.

Улс орнуудын эрх зүйн тогтолцооны харилцан холбоо, харилцан ажиллагааг бүрдүүлэхэд дээрх олон улсын эрх зүйн зохицуулалт чиглэнэ. Үүний зорилго нь гадаадын этгээдийн иргэний эрх зүйн эрх, эрх чөлөө болон түүнийг хамгаалах процессын хоорондох зөрчлийг багасгах явдал юм. Европын орнуудад энэ үйл явц нэлээд

<sup>1</sup> М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр Олон улсын эрх зүй. УБ., 1999 он, 26 дахь тал.

<sup>2</sup> Contemporary international law: a concise introduction/ Werner Levi. -2-nd ed. 1991, P.107; М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр Олон улсын эрх зүй. УБ., 1999 он, 50 дахь тал; Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002 он, 117 дахь тал

<sup>3</sup> Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс. УБ., 2002 он, 4-5 дахь талд дурдсан "гадаад элемент" гэдэг ойлголтыг харьцуулан үзнэ үү.

өргөн хүрээтэй явагдсан бөгөөд 1968 онд Европын эдийн засгийн холбооны гишүүн орнууд Брюсселийн конвенцыг байгуулсан нь их ач холбогдолтой болсон<sup>1</sup>. Хожим энэ конвенцын үндсэн дээр Луганогийн протокол байгуулагдаж үүнд европын бусад олон улс орнууд нэгдэн орсон байна. 1968 оны 9 дүгээр сарын 27-нд байгуулагдсан Иргэний болон худалдааны хэргийн талаархи шүүхийн бүрэн эрх, шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх тухай Брюсселийн конвенц нь хамрах хүрээ, нарийвчлалтаараа үлгэр жишээ конвенц болсон юм. ЗСБНХУ задарсны дараа түүний бүрэлдэхүүнд байсан улс орнуудын хооронд "Аж ахуйн үйл ажиллагааны улмаас үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" 1992 оны Киевийн конвенц, "Эрх зүйн туслалцаа үзүүлэх ба иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай" 1993 оны Минскийн конвенц байгуулагдсан<sup>2</sup>.

Ер нь гадаадын этгээдийн шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах асуудлаас олон улсын иргэний процесс эхтэй гэж үздэг. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш эрхтэй байна" гэж онцлон заасан юм. Монгол Улсын шүүх олон улсын шинжтэй хэргийг харьяалан шийдвэрлэх эрх мэдэлтэй эсэхээ тодорхойлох шаардлагатай тохиолдол сүүлийн үед улам өргөжиж байна. Өөрөөр хэлбэл, шүүхээр хэрэг шийдвэрлэх олон улсын харьяалал ба Монгол Улсын шүүхийн хэрэг харьяалах бүрэн эрхийн асуудал улам ихээр хөндөгдөх боллоо. Монгол Улсын

хувьд 1958 онд ЗСБНХУ-тай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан нь энэ чиглэлийн анхны олон улсын гэрээ байв. Үүнээс хойш олон улс оронтой ийм төрлийн гэрээг байгуулж байгаа бөгөөд эдгээр гэрээнээс ОХУ, Казакстан улс, Польш, Болгар, Унгар зэрэг улстай байгуулсан гэрээ шүүхийн харьяаллын асуудлыг илүү тодорхой зохицуулсан юм. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай гэрээ 1999 онд шинэчлэгдэн байгуулагдаж, улмаар удахгүй хүчин төгөлдөр болох ажлууд хийгдэж байна.

**Ш**үүхийн харьяаллыг тогтооход арбитрын харьяаллын асуудлыг мөн анхааран үзэх хэрэгтэй байдаг. Учир нь арбитрын харьяалал нь шүүхээр тухайн маргааныг шийдвэрлэхээс татгалзах нэг үндэслэл болно. Иймд манай улсын хувьд арбитрын харьяалалтай холбоотой 1972 оны Москвагийн конвенц<sup>3</sup>, БНХАУ-тай байгуулсан 1988 оны бараа нийлүүлэх ерөнхий нөхцөлийн талаархи гэрээ болон Гадаад худалдааны арбитрын тухай хууль нь шүүхийн харьяалалд хамаарах чухал эх сурвалж юм. Хэрэв олон улсын эрх зүйн зохицуулалт байхгүй, мөн арбитрын харьяалал үүсэхгүй тохиолдолд үндэсний хууль тогтоомжийн журмыг мөрдөнө. Орчин үед ихэнх улс орнууд процессын хууль тогтоомжоо шинэчлэн өргөжүүлж, "Олон улсын иргэний процесс" хэмээн нэрлэгддэг нэлээд дэлгэрэнгүй бие даасан эрх зүйн институтыг аажмаар бүрдүүлэх боллоо.

Мэдээж улс бүрийн олон улсын иргэний процесс нь онцлог шинжтэй боловч тэдгээрийн зарим зүйл өнөөдөр ихэнхи улс оронд нийтлэг шинжтэй болж байна. Жишээ нь эрх зүйн туслалцаа, шүүхийн даалгавар биелүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, нийтийн эрх ашгийн зарчим, зохигчид шүүх, хэргийн харьяаллыг сонгох боломж г.м.

Үндэсний иргэний процесст хэрэглэдэг шүүхийн газар нутгийн харьяаллын журмыг олон улсын шинжтэй хэрэгт ч нэгэн адил баримтлахыг чухалчилдаг. Зарим тохиолдолд талууд шүүхээ сонгох боломжийг олгож, хэрэв талууд шүүхээ сонгохоор харилцан тохиролцоогүй бол хариуцагч, эсхүл түүний эд хөрөнгө тухайн улсад оршин байгаа үед өөрийн шүүхээр харьяалан шийдвэрлэхийг зохистой гэж үздэг.

Монгол Улсын 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн "Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа ба олон улсын хууль тогтоомж" хэмээн нэрлэгдэх VII хэсэгт олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны талаархи зохицуулалт тусгагдсан байна. Энэ хуулийн 189.2.-т зааснаар Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн харьяалалд хамаа-руулан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна:

- нэхэмжлэлийн хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг;

- нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан ба тэдгээрийн аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг;

<sup>1</sup> Internationales Privat- und Verfahrensrecht: Textaufgabe/ von Eric Jayme; Rainer Hausmann. – 10., neubearb. und erw. Aufl. – Muenchen: Beck, 2000, S.368

<sup>2</sup> Нешатаева Т.Н. Международный гражданский процесс: Учеб. пособие. – М.: Дело, 2001, С.352, 357

<sup>3</sup> Тыньель А. и др. Курс международного торгового права./Тыньель А., Функ Я., Хвалев В. – 2-ое изд. – Мн.: Амалфей, 2000, С.628

- гэрээгээр хүлэсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нэхэмжлэл гаргасан ба тухайн үүргийг Монгол Улсад гүйцэтгэх ёстой байсан;

- бусдад гэм хор учруулсны улмаас Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн этгээдэд хохирол учруулсан;

- хуулийн этгээдийн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх салбар буюу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны улмаас маргаан үүссэн;

- Монгол Улсын иргэн буюу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн эцэг тогтоох ба тэтгэмж төлөхтэй холбогдсон нэхэмжлэл гаргасан;

- Нэхэмжлэлийн зүйл нь өв залгамжлах эрх, өв залгамжлуулагчаас эд хөрөнгийг хуваах, гэрээслэл, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой бөгөөд өв залгамжлуулагч нас барахаасаа өмнө Монгол Улсад амьдардаг буюу оршин суудаг байсан, эсхүл тухайн өв хөрөнгө Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа.

Тухайн шүүхийн улсын *ordres public* буюу үндэсний эрх ашиг, мөн хэрэг маргаан тухайн улстай илүү холбоотой байдлыг харгалзан үзэж олон улсын иргэний процесст шүүхийн онцгой харьяаллыг тогтоох явдал элбэг. Монгол Улс өөрийн шүүхийн онцгой харьяалалд хамаарах хэргийн төрлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 190 дүгээр зүйлд тодорхойлжээ. Мөн энэ хуулийн 192 дугаар зүйлд гэр бүлийн холбогдолтой хэргийн харьяаллыг тогтоох шалгуур үндэслэл, 193 дугаар зүйлд Монгол Улсын шүүхэд үл хамаарах онцгой тохиолдлууд тусгагдсан байна. Өмнө дурдсан 190 дүгээр зүйл нь Брюсселийн конвенцын онцгой харьяалал тогтоосон 16 дугаар зүйлийн заалтуудтай үндсэндээ нэгэн ижил болжээ. 1994 оны Иргэний

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд маргааны талууд маргаан шийдвэрлэх шүүхээ сонгох боломж олгосон заалт байсныг 2002 оны хуульд үргэлжлүүлэн авахаас татгалзжээ. Ийм боломжийг Европын холбооны Брюсселийн конвенцод (конвенцын 17 дугаар зүйл) тусгасан байна. Харин ОХУ улстай 1999 онд хийсэн эрх зүйн туслалцааны тухай гэрээний 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар зохигчид шүүхийн харьяалах эрх мэдлийг тохиролцон өөрчилж болно.

Олон улсын шинжтэй иргэний хэрэгт гадаад улсын хууль, олон улсын гэрээг хэрэглэх шаардлага үндэслэл. Аливаа улсын шүүхийн бүрэн эрхийг тодорхойлох, хэрэглэгдвэл зохистой эрх зүйг сонгох, гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх арга журмууд харилцан уялдаа холбоотой байдаг. Шүүн шийдэх эрхийг эхэлж тогтоосны дараа энэхүү эрхийг эдлэгч нь тухайн хэрэг маргааныг ямар улсын хуулийн үндсэн дээр шийдвэрлэхээ өөрөө шийдэх эрхтэй болно. Иймд хуулийн үйлчлэх хүрээг тогтоохоос өмнөх асуулт бол шүүн шийдэх эрхийг хэн эдлэх вэ гэдэг асуулт юм. Заримдаа шүүн шийдэх эрх болон хуулийн үйлчлэх хүрээ зэрэг, эсхүл хуулийн үйлчлэх хүрээ нь нөгөөхөөсөө үл хамааран тусдаа хөндөгдөж болох талтай.

Олон улсын иргэний хэргийн шүүхийн харьяалал болон тухайн хэрэгт хэрэглэгдэх эрх хоорондоо харилцан нөлөөлөх дараах хувилбарууд байж болно:

- Аливаа шүүгч өөрийн улсын (*lex fori*) зөрчилдөөний хэм хэмжээг эхэлж баримтална. Монгол Улсын шүүгч Монгол Улсын үндэсний хуулиар тогтоосон эсвэл Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон зөрчилдөөний хэм хэмжээ (ЗХХ)-г хэрэглэх учиртай. Улс орнуудын ЗХХ тэр бүр ижил биш учир

шүүхийн харьяалаас хамаарч хэргийг шийдвэрлэхэд хэрэглэгдэх хууль тодорхойлогдоно. Тодруулж хэлбэл, шүүхийн харьяаллыг эхэлж тогтооно, дараа нь энэхүү шүүх өөрийн үндэсний ЗХХ-ний үндсэн дээр хэрэглэгдэх хуулийг тодорхойлно.

- Шүүхийн харьяалал, хэрэглэгдэх эрх хоёр зэрэг тодорхойлогдох тохиолдол бий. Жишээ нь, Гаагийн бага насны хүүхдийг хамгаалах тухай 1961 оны конвенцын дагуу хэргийг харьяалсан шүүх өөрийн (*lex fori*) материаллаг хуулийг хэрэглэнэ.

- Мөн хэрэглэгдэх хуулиас хамаарч шүүхийн харьяаллыг тогтоох тохиолдол байж болно. Жишээ нь, Германы шүүхийн практикт өв залгамжлалын хэрэгт эхлээд хэрэглэгдэх эрхээ тодорхойлоод, хэрэв германы хууль хэрэглэгдэхээр болсон үед германы шүүх уг хэргийг харьяалан шийдвэрлэдэг. Талуудын аль нэг нь илэрхий байдлаар гадаад улсын хууль хэрэглэх хүсэлт тавиагүй бол шүүх өөрийн (*lex fori*) хуулийг хэрэглэнэ. Энд шүүхийн харьяалал нь хэрэглэгдэх хуулийг шууд тодорхойлох боломжтой ба үүний цаана факультатив ЗХХ-ний тухай яригдана. Гэвч ийм ЗХХ-г ихэнх улс орнууд үл зөвшөөрнө. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай 1999 оны гэрээний 23 ба 25 дугаар зүйлд хэрэглэгдэх хууль ба шүүхийн харьяалал нэг улсынх зэрэг байх боломжийг тусгасан байдаг.

Шүүхийн харьяаллыг буруу тогтоосон, хэрэглэгдэх хуулиа зөв сонгон тодорхойлж чадаагүй байдал хожим шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэхэд бэрхшээл учруулна. Харин шүүхийн харьяалал тогтоогдож, хэрэглэх хуулиа сонгосны дараа хамгийн бэрхшээлтэй асуудал нь гадаад



улсын хуулийг хэрэглэх явдал байдаг. Түүнчлэн процессыг явуулахад хэрэглэх хуулийн тухай асуудал ч мөн огт маргаангүй биш юм.

Олон улсын шинжтэй хувийн эрх зүйн хэрэг маргааныг зөв оновчтой шийдвэрлэхийн тулд тухайн харилцаанд илүү нягт холбоо бүхий гадаад улсын хуулийг хэрэглэж болохыг олон улс орон хүлээн зөвшөөрч үндэсний хууль тогтоомждоо энэ талаархи зохицуулалтыг тусгах болжээ. Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн 540.1.-д "Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад ... гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно" гэж заажээ. Түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд ийм төрлийн зохицуулалт агуулагдсан байдаг. Улс орнуудын дотоодын эрх зүйд зөрчилдөөний (зөрөөтэй!) хэм хэмжээг гэж нэрлэгдэх онцгой хэм хэмжээ байдаг. Зөрчилдөөний хэм хэмжээ нь гадаад элемент бүхий иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэгдэх эрх зүйг сонгох арга журмыг агуулж, улмаар аль нэг улсын эрх зүй рүү холболт буюу ишлэл хийх аргыг ашигладаг байна. Ихэнхи улс оронд үндэсний зөрчилдөөний хэм хэмжээг тодорхойлсон хууль тогтоомж болон зөрчилдөөний эрх зүй хөгжсөн байдаг. Гадаад улсын хуулийг хэрэглэх асуудал зөрчилдөөний эрх зүйн<sup>2</sup> үүсэл хөгжилтэй салшгүй холбоотой. Учир нь, зөрчилдөөний эрх зүй нь гадаад улсын хуулийг

хэрэглэхийг хүлээн зөвшөөрч, түүнийг сонгох арга журмыг боловсруулахад чиглэж байлаа. Орчин үеийн зөрчилдөөний эрх зүйн түүх дундад зууны хожуу үед дээд Италийн хотуудад эхэлсэн гэж судлаачид үздэг. XIII дугаар зууны үед статутын сургаал үүссэнээр зөрчилдөөний эрх зүйн суурь тавигдаж, энэ нь XIX дүгээр зууны дунд үе хүртэл онолын үндэслэлийн хувьд үл хөндөгдсөн юм. Германы эрдэмтэн Савигни 1849 онд статутын сургаалыг өөрчилж, холболтын боловсронгуй тогтолцоог агуулсан орчин үеийн ОУХЭЗ-н эх үндсийг тавьсан билээ.

**З**өрчилдөөний хэм хэмжээний гол онцлог нь аль нэг улсын эрх зүй рүү ишлэл хийхээс, уг харилцааг шууд зохицуулдаггүй оршино. Өөрөөр хэлбэл, гадаад улсын оролцоо (гадаад элемент<sup>3</sup>) бүхий иргэний эрх зүйн харилцаанд аль улсын хууль хэрэглэх нь зохимжтойг заасан буюу түүнийг сонгох арга журмыг агуулсан хэм хэмжээг зөрчилдөөний хэм хэмжээ гэнэ. Ийм онцлог, уг гарал нь зөрчилдөөний хэм хэмжээний бүтэц болон түүний хэрэглэгдэх нөхцөлийг тодорхойлно. Бие даасан зөрчилдөөний хэм хэмжээ нь ихэвчлэн хоёр элементээс бүрдэнэ<sup>4</sup>. Үүнд:

а) Эрх зүйн харилцааны төрөл, зүйлийг заасан хэсэг буюу холболтын зүйл<sup>5</sup>. Үүнийг материаллаг эрх зүйн дэд салбар, институт болон эрх зүйн зарим ойлголт, хэллэгийн нэрээр ихэвчлэн тодорхойлсон байдаг. Жишээ нь, эрх зүйн чадвар, гэр бүл, өмч, хэлцэл, гэм хор г.м.

б) Эрх зүйн тодорхой харилцааны төрөлд хэрэг-лэгдэх эрх зүйг тодорхойлсон хэсэг буюу холболт<sup>6</sup>. Холболт нь тусгайлсан арга, журмын тусламжтайгаар хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлно. Энэхүү тодорхой-лолтын арга нь олон янз байх бөгөөд тухайн эрх зүйн харилцаа аль улстай илүү нягт холбоотой байх шалгуурыг үндсэндээ өөртөө агуулна. ОУХЭЗ-д түгээмэл ашигладаг хэд хэдэн ийм арга буюу холболтын дүрмүүд<sup>7</sup> байна.

А. Зөрчилдөөний хэм хэмжээнүүд тэр бүр хялбар бүтэцтэй байх нь ховор. Холболт нь холбоосоос гадна түүнийг тодруулсан нэмэлт зүйлсээс бүрдэж болно. Зөрчилдөөний хэм хэмжээг зөв тайлбарлан хэрэглэхийн тулд түүнийг зарим шинж онцлогоор төрөлжүүлэн ангилах нь практик ач холбогдолтой<sup>8</sup>. Тухайн хэрэг, тохиолдолд хэрэглэгдэх эрх зүйг шууд тодорхойлж чадах арга, журмыг агуулж байгаа эсэхээс хамааран зөрчилдөөний хэм хэмжээг биеэ даасан (шууд) ба биеэ даагаагүй (шууд бус) гэж хувааж болно. Зарим улс орнууд тухайлбал, Франц улс, Герман улс (1986 он хүртэл) зөрчилдөөний хэм хэмжээнд ихэвчлэн өөрийн улсын эрх зүйг хэрэглэх тохиолдлыг заагаад, харин гадаад улсын хууль хэрэглэх тохиолдлыг зохицуулах боломжгүй гэж үзээд орхигдуулдаг байна. Зөвхөн өөрийн улсын хууль хэрэглэх тохиолдлыг агуулсан ийм зөрчилдөөний хэм хэмжээг нэг талын гэж нэрлэнэ. Түүнчлэн зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэгдэх дарааллын журмаар

<sup>1</sup> Док. В.Чимид "зөрөөтэй хэм хэмжээ" гэж нэрлэх нь зүйтэй гэж үздэг.

<sup>2</sup> Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс. УБ., 2002 он, бүлэг 3

<sup>3</sup> ОХУ-ын эрдэмтэд "иностранний элемент", ХБНГУ-ын эрдэмтэд "Auslandsberuehrung", АНУ-ын эрдэмтэд (Currie) "governmental interest" гэж нэрлэдэг.

<sup>4</sup> Ермолаев В.Г., Сиваков О.В. Международное частное право: / Курс лекций – М.: Былина, 2000.г. с.43, Junker, Internationales Privatrecht, 1998, Pp.90-91

<sup>5</sup> Манай зарим судлаачид "нөхцөл", "багтаамж" эсвэл "харилцааны төрөл", ОХУ-ын эрдэмтэд "объем", ХБНГУ-ын эрдэмтэд "Anknuepfungsgegenstand" гэж нэрлэдэг.

<sup>6</sup> ОХУ-ын эрдэмтэд "привязка", ХБНГУ-ын эрдэмтэд "Anknuepfungsmoment" гэж нэрлэдэг.

<sup>7</sup> ОХУ-ын эрдэмтэд "формула прикрепления" гэж нэрлэдэг ба ХБНГУ-ын эрдэмтэд тусгайлан нэрлээгүй байна.

<sup>8</sup> Firsching/Hoffmann. Internationales Privatrecht, 5. Aufl. 1997. Pp.157, Junker, Internationales Privatrecht, 1998. Pp.94

нь үндсэн, туслах, туслахын туслах г.м. ангилна<sup>1</sup>. Зөрчилдөөний хэм хэмжээнд зөвхөн ганц төдийгүй олон тооны холбоосыг зэрэг хэрэглэх нь элбэг байдаг. Эдгээр зэрэг орсон холбоосууд хоорондоо ямар харилцаатай байхаас хамаарч аль нэг улсын хуулийг хэрэглэх хүрээ тодорхойлогдоно<sup>2</sup>. Энэ байдлаар нь кумулятив, альтернатив, аксессор г.м. холболтыг ангилан үзэх нь зүйтэй.

Зөрчилдөөний хэм хэмжээний үндсэн дээр шилжүүлэг хийгдэж байвал энэхүү шилжүүлгийн хамрах хүрээ ямар байхыг тогтоох асуудал багагүй маргаантай байдаг. Шилжүүлгийн хамрах хүрээ нь хоёр янз байх боломжтой: нэгд, гадаад улсын зөвхөн материаллаг хэм хэмжээ руу шилжүүлэг хийх (шууд); хоёрт, гадаад улсын материаллаг хэм хэмжээнээс гадна зөрчилдөөний хэм хэмжээ руу хамтад нь шилжүүлэг хийх (нөхцөлт). Нөхцөлт шилжүүлгийн үед буцааж болон цааш нь шилжүүлэг хийх (*renvoi*) асуудал яригддаг<sup>3</sup>.

*Renvoi* үүсдэг гол шалтгаан бол улс орнууд нэг ижил төрлийн харилцаанд зориулагдсан ЗХХ-нд өөр өөр холбоос хэрэглэсэн байдаг явдал юм. Эрх зүйн харьцуулалтаас үзэхэд зарим улс орон буцааж шилжүүлэг хийхийг хүлээн зөвшөөрөөд харин цааш нь гуравдагч улс руу шилжүүлэг хийхийг зөвшөөрдөггүй. Дүгнэж хэлбэл, аливаа зөрчилдөөний хэм хэмжээ нь үндэсний эрх зүй эсвэл аль нэг гадаад улсын эрх зүй рүү шилжүүлэг хийнэ. Үндэсний хуулиа хэрэглэхээр бол дотоодын

материаллаг хэм хэмжээний дагуу холбогдох хэрэг тохиолдлыг шийдвэрлэнэ. Гадаад улсын хуулийг хэрэглэх тохиолдолд зөрчилдөөний хэм хэмжээгээр хийх шилжүүлгийн утга, хамрах хүрээг харгалзан *Renvoi* бий болох эсэхийг тогтоох шаардлагатай болно. Нөхцөлт шилжүүлгийн тохиолдолд гадаад улсын зөрчилдөөний эрх зүйг, шууд шилжүүлгийн үед гадаад улсын материаллаг эрх зүйг хэрэглэхэд хүрнэ. Гадаад улсын зөрчилдөөний болон материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд дотоодын эрх зүйг хэрэглэдгээс ялгаатай онцлог зүйлс бий<sup>4</sup>.

Гадаад улсын хуулийг олж мэдэх, агуулгыг зөв тогтоох үед энэхүү гадаадын хууль нь тухайн улсын хувьд харгалзан үзэх ёстой нөхцөл байдал, факт (үйл баримт) байх уу, эсхүл үндэсний хуулийн адил хууль байх уу гэдэг гол зангилаа асуулт юм. Хэрэв факт бол нотлогдох боломжтой болох ба талуудад энэ үүрэг ногдоно<sup>5</sup>. Мөн шүүх гадаадын хуулийг өөрөө олж авах, улмаар хэрэглэх шаардлагагүй болох бөгөөд талуудын олж ирсэн гадаадын хуулийг нотлох баримтын төвшинд үнэлэн үзэх болно. Зөвхөн гадаадын хуулийг дотоодын хуулийн адил хууль хэмээн үзэх тохиолдолд түүнийг олж, агуулгыг зөв тогтоох, зөв тайлбарлан хэрэглэх асуудал яригдана<sup>6</sup>.

ОУХЭЗ-н нэгэн чухал зорилго бол олон улсын шийдвэрийн зохицолдооныг хангах явдал байдаг. Гадаадын хуулийг тухайн гадаад улсад хэрхэн үр ашигтай хэрэглэдэг тэр байдлаар өөр улсад

хэрэглэх нь өмнөх зорилгыг хэрэгжүүлэх гол нөхцөл болно. Иймээс шүүх арбитр гадаад улсын хуулийг хэрэглэхдээ түүний хэм хэмжээний агуулгыг тэдгээрийн албан ёсны тайлбар, хэрэглэдэг практикт нийцүүлэн хэрэглэх нь зохимжтой. Гадаадын хууль хэрэглэснээр дотоодын хуулиас өөр үр дагаварт хүрч болох ба энэ нь хүлээн зөвшөөрөгддөг. Харин дотоодын эрх зүйн үндсэн чухал зарчмууд буюу *ordre public* зөрчигдвөл хязгаарлалтын асуудал яригдах учиртай юм. Олон улс орон өөрийн ОУХЭЗ-н талаарх хуульдаа *ordre public*-заалтыг оруулсан байдаг.

Сүүлийн үед олон улсын худалдаа, тэвэр, төлбөр тооцоо болон бусад түгээмэл харилцааны талаархи эрх зүйн зохицуулалтыг олон улсын төвшинд ижилтгэх, нэгдмэл гэрээ, конвенц боловсруулах үйл явц эрчимтэй өрнөж, түүнд Монгол Улс нэгэн адил идэвхтэй оролцож байна. Иймээс иргэний эрх зүйн хүрээнд хамаарах олон улсын гэрээг судлах, шүүх арбитрын практикт түүнийг зөв тайлбарлан хэрэглэх явдал тулгамдсан шинжтэй боллоо. Олон улсын иргэний эрх зүйн зохицуулалтын нэгэн арга болох олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааг шууд зохицуулахад чиглэсэн олон талт болон хоёр талт гэрээнд Монгол Улс идэвхтэй оролцож ирсэн юм. Тухайлбал, Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн орнуудын 1957 оны бараа нийлүүлэх ерөнхий нөхцөл (олон удаа редакц орсон) болон БНХАУ, БНАСАУ-тай байгуулсан бараа нийлүүлэх ерөнхий нөхцөл зэргийг дурдаж болно. Мөн 1997 онд Монгол Улс нэгдэн орсон "Бараа худалдах,

<sup>1</sup> Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс. УБ., 2002 он, 137 дахь тал

<sup>2</sup> Т.Мэндсайхан, мөн тэнд, 134-137 дахь тал.

<sup>3</sup> Junker, Internationales Privatrecht, 1998. Pp.175-178, 179-182, Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүйн үндэс. УБ., 2002. т.141, Богуславский М.М. Международное частное право: Учебник.-2-ое изд.-М.: Междунар. Отношения, 1994. с.90

<sup>4</sup> Богуславский М.М. Международное частное право: Учебник.-2-ое изд.-М.: Междунар. Отношения, 1994. с.94, 373

<sup>5</sup> П.Норт, Дж.Чепир. Международное частное право. Прогресс. 1982. с.149, Ермалов В.Г., Сиваков О.В. Международное частное право: / Курс лекций - М.: Былина, 2000. с.96

<sup>6</sup> Firsching/Hoffmann. Internationales Privatrecht, 5. Aufl. 1997. Pp.102;

Богуславский М.М. Международное частное право: Учебник.-2-ое изд.-М.: Междунар. Отношения, 1994. с.374, Ермалов В.Г., Сиваков О.В. Международное частное право: / Курс лекций - М.: Былина, 2000 г, с.101

худалдан авах гэрээний тухай” 1980 оны Венийн конвенц гадаад худалдааны хүрээнд чухал ач холбогдолтой болохыг онцлон хэлэх хэрэгтэй.

Улс орнууд харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хөрш улс, иргэн, худалдааны өргөн харилцаатай бусад улстай ихэвчлэн хоёр талт гэрээ байгуулдаг практик олон улсын харилцаанд ихэд дэлгэрчээ. Монгол Улс анх ЗСБНХУ-тай 1958 онд Иргэний ба эрүүгийн хэрэг, гэр бүл, гэрлэхтэй холбогдсон хэргийн талаар хуулийн туслалцаа үзүүлэх тухай гэрээ (1958.08.25.) байгуулсан. Энэ гэрээг 1988 онд, 1999 онд тус тус шинэчлэн байгуулсан юм. Өнөөдрийн байдлаар 18 улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хоёр талт гэрээг байгуулаад байна. Эрх зүйн туслалцаа үзүүлэх буюу ялангуяа иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээнүүд олон улсын хувийн эрх зүй, олон улсын иргэний процесст онцгой ач холбогдолтой. Түүнчлэн манай улс иргэний эрх зүйн хүрээнд хамаарах олон тооны олон улсын гэрээнд нэгдэн орсон буюу ийм хоёр талт гэрээг байгуулаад байна. Олон улсын гэрээ ба Монгол Улсын иргэний эрх зүйн зохицуулалтын харьцааны талаар Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн 2.2 ба 539.2.-д тусгагдсан байна. Олон улсын гэрээ ба олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэх боломжийг 1994 оны шинэчлэн найруулсан Иргэний хуульд шууд тусгаагүй байсан, харин 2002 оны Иргэний хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг цаашид албан ёсоор эх сурвалжийн төвшинд үнэлэн үзэх боломжтой болжээ. Мөн энэхүү хуулийн 542.1.-д “...олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм

хэмжээг хэрэглэж болно” гэж заасан билээ. Монгол Улсын Гадаад худалдааны арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Арбитр ямар ч хэргийг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан гэрээ, тухайн хэлцлийн талаар тогтсон заншлын хэм хэмжээг нэгэн адил баримтална” хэмээн заасан нь заншлын хэм хэмжээнд ач холбогдол өгсний нэг жишээ юм. Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг агуулсан олон улсын зарим байгууллагын баримт бичгүүд Инкотермс-2000, Аккредитив, Инкассо, банкны баталгааны талаарх үлгэрчилсэн дүрмүүд нь

манай улсын хувьд эрх зүйн эх сурвалж болох ач холбогдолтой.

Шүүхийн практикаас. 1998-2002 онуудад Нийслэл ба дүүргийн шүүхэд олон улсын холбогдол бүхий 82 иргэний хэрэг шийдвэрлэгджээ<sup>1</sup>. Судалгаанаас үзэхэд Баянзүрх болон Сүхбаатар дүүрэгт олон улсын иргэний эрх зүйн маргаан харьцангуй олон гарчээ. Тухайн дүүрэгт оршин байгаа гадаадын иргэд, байгууллагын тооноос хамаарч дүүрэг бүрт харилцан адилгүй хэрэг маргаан гарчээ. Судалгаанд хамрагдсан шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн нийт тоо 1999 оныг эс тооцвол жил тутам дунджаар 14 орчим байгаа бөгөөд өсөж буурах тенденцийг тогтооход бэрхшээлтэй байна.

	1998	1999	2000	2001	2002	Бүгд
Нийслэлийн шүүх	2	1	2	-	-	5
Баянгол дүүргийн шүүх	-	-	-	5	3	8
Баянзүрх дүүргийн шүүх	6	9	8	-	7	30
Сонгинохайрхан дүүргийн шүүх	2	1	2	-	-	5
Сүхбаатар дүүргийн шүүх	2	10	5	8	2	27
Чингэлтэй дүүргийн шүүх	-	4	-	-	-	4
Хан-Уул дүүргийн шүүх	-	1	-	-	2	3
Дүн	12	26	17	13	14	82

Ямар боловч гадаадын иргэд, байгууллага эрхээ хамгаалуулах зорилгоор Монгол Улсын шүүхэд хандах, Монгол Улсын иргэн, байгууллага ч мөн гадаадын этгээдийн эсрэг нэхэмжлэл гаргах явдал бодитой болж, түүний тоо хэмжээ харьцангуй өндөр болсныг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй болов уу. Эдгээр 82 хэргийг шийдвэрлэх явцад Монгол Улсын шүүхийн хэрэг харьяалан шийдвэрлэх эрх хэмжээ, хэргийг шийдвэрлэхэд хэрэглэсэн хууль, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл зэрэг асуудал хөндөгдсөн байдлыг судалж тодруулав.

Шүүхэд гадаад эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, судалж хэлцлийн улмаас үүссэн маргаан ихэвчлэн шийдвэрлэгддэг боловч гэр бүл, хөдөлмөрийн болон гадаадын ба дотоодын хөрөнгө оруулагчдын хоорондын маргаан сүүлийн жилд нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Гадаадын хуулийн этгээдийн хоорондын маргаан шийдвэрлэсэн тохиолдол судалгаанд хамрагдсан шүүхийн практикт гараагүй. Иргэний эрх зүйн харилцааны төрлөөс хамааруулан шүүхийн практикийг дараах байдлаар бүлэглэн авч үзлээ:

<sup>1</sup> Энэ тоо судалгааны аргачлалаас хамаарч өөрчлөгдөж болохыг анхаарна уу.

Эрх зүйн харилцан төрөл	1998	1999	2000	2001	2002	Бүгд
Гэрээ, бүгд	4	17	6	5	5	37
үүнээс:						
I. худалдах худалдан авах гэрээ	2	5	1	4	1	13
II. зээл						
III. ажлын гүйцэтгэх гэрээ	1	8	2	1	4	16
IV. түрээс			1			1
V. бусад	1	4	2			6
Гэм хор учруулснаас үүсэх үүрэг	1		2	1	2	6
Гэр бүл, бүгд		2	2	1	4	11
үүнээс:						
VI. гэр бүл цуцлах		1	1		4	6
VII. хүүхдийн эцгээр тогтоолгох						
VIII. хүүхдийн тэтгэлэг тогтоолгох	2	1				3
			1	1		2
Өв залгамжлал						
Эд хөрөнгийн эрх, бүгд, үүнээс:						
гадаадын хөрөнгө оруулагчдын	3	4	5		2	14
хоорондын маргаан		3				3
Хөдөлмөрийн харилцаа	2	3	1	3	1	10
Бусад			1	3		4
Дугуй	12	26	17	13	14	82

1998 онд Монгол Улсын иргэн, эмэгтэйн нэхэмжлэлтэй БНХАУ-ын иргэнд холбогдох хүүхдийн эцгээр тогтоолгох, хүүхдийн тэтгэвэр, хохирол гаргуулах хүсэлт бүхий гэр бүлийн нэгэн маргааныг шүүхээр шийдвэрлэжээ. Энэ хэрэгт БНХАУ-ын хуулийг хэрэглэх байсан эсэхэд шүүх ямар нэг анхаарал хандуулаагүй ба нэхэмжлэгчээс гаргасан "хүүхдэдээ тэтгэвэр бөөнд нь авна, учир нь хариуцагч гадаадын иргэн учраас хэзээ ч явчихаж магадгүй, мөн сэтгэл санааны хохирол учирсан" гэдэг хүсэлтийг огт харгалзан үзээгүй байна. Мөн АНУ-ын нэгэн компанийн

төлөөлөгчийн газарт холбогдох цалин гаргуулах нэхэмжлэл шүүхэд ирсэн байдаг. Шүүх энэхүү компани, түүний төлөөлөгчийн газрын эрх зүйн чадвар, бүрэн эрхийг эхлэн тодорхойлох асуудлыг шалган үзэлгүй хэргийг шийдвэрлэжээ. Түүнчлэн БНХАУ-ын иргэний нэхэмжлэлтэй монгол иргэнд холбогдох зээлээр өгсөн мөнгөө гаргуулах тухай хэргийг шүүх шийдвэрлэхдээ Монгол Улсын 1994 оны Иргэний хуулийн 434 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 8-д заасны дагуу зээлдүүлэгч талын буюу БНХАУ-ын хуулийг хэрэглэх байсан боловч Монгол Улсын материаллаг эрх зүйн хэм

хэмжээг (Иргэний хуулийн 229 дүгээр зүйл) шууд хэрэглэсэн байдаг. Зээлсэн мөнгийг буцааж өгөх тухай зохицуулалт аль ч улсын хуульд байдаг учир хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй буюу өөр хүсэлт гаргаагүй бол шүүх *lex fori* дагуу шийдвэрлэснийг буруутгах боломжгүй билээ. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын дархан эрхэд хамаарах нэгэн хэрэг 1998 онд шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Аливаа төр, түүний төлөөлөгчийн газар гадаад улсын шүүх эрх мэдэлд үл хамаарах иммунитет эдэлдэг. Гэхдээ төр өөрөө шүүхэд нэхэмжлэл гаргавал эсхүл бусад зарим тохиолдолд бүрэн эрхээсээ татгалзсан гэж үздэг. Олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас Монгол Улсын "Гутал" ХК-д (хуучнаар Арьс импекс компани) олгосон зээлийн гэрээнд Монгол Улсын Төв банк (хуучнаар Улсын банк) батлан даалт гаргасан ба улмаар зээлийн төлбөрийг гүйцэтгэсэн байна. Дараа нь Төв банк "Гутал" ХК-ийн эсрэг регресс нэхэмжлэл гаргаж 1998 онд шүүхээр шийдвэр-лүүлжээ.

1999 онд гадаадын хөрөнгө оруулагчид болон дотоодын хөрөнгө оруулагчдын хоорондох 4 маргааныг нийслэл, дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн байна. Хэрэв ийм төрлийн маргааны талууд арбитрын хэлэлцээр хийсэн бол маргаан арбитрын журмаар шийдвэрлэгдэх боломжтой. Гадаадын хөрөнгө оруулалтын маргаанд хууль сонгох асуудал бараг хөндөгддөггүй ба хөрөнгө оруулалт хэрэгжиж буй улсын хуулиар буюу дээрх тохиолдолд Монгол Улсын хууль хэрэглэгдэнэ. БНХАУ, ОХУ, Турк улсын иргэд, байгуул-лагын нэхэмжлэлтэй зээлийн гэрээний маргаан нэлээд олноор шүүхээр шийдвэрлэгджээ. 1999 онд ийм төрлийн 5 хэрэг шүүхэд ирсэн. Зарим маргааны хувьд хөөн хэлэлцэх хугацааг аль улсын

хуулиар тооцох вэ гэдэг асуулт тавигдаж болох байсныг шүүхийн шийдвэрт харгалзан үзээгүй байдаг. ОХУ-ын 3 иргэний хөдөлмөрийн хөлс нэхэмжилсэн, Чех улсын нэгэн иргэний монгол хүүхдийн эцгээр тогтоолгох хүсэлт бүхий нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэхдээ Монгол Улсын хөдөлмөрийн хууль болон гэр бүлийн тухай хуулийг үндэслэсэн байдаг. Тэвэр зуучийн Монгол транс компанийн нэхэмжлэлтэй Монгол Улсад байнга амьдран суугч Солонгос улсын иргэнд холбогдох гээвэрлэлтийн хөлс гаргуулах тухай хэргийг шүүх хэлэлцээд хэргийг хэрэгсэхгүй болгож, Солонгос улсын Сүүл-Моторс компаниас нэхэмжлэх нь зүйтэй гэж үзжээ. Энэхүү шийдвэрийг гаргахад тээвэрлэлтийн хөлс төлөх үүрэг ямар үндэслэлээр, ямар улсын хуулийн дагуу үүсэж болохыг шүүх тодруулаагүй орхиг-дуулсан. БНХАУ-ын Өвөр-монголын иргэний нэхэмжлэлээр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, нөхөн олговор олгох тухай хуулийн дагуу нөхөх олговор олгуулах хүсэлтийг шүүхээс хангасан тохиолдол байгаа нь Монгол Улсад гадаадын иргэдийн эрх ашиг сонирхол зохих ёсоор хангагдсан жишээ юм.

2000 онд гадаад улсын иргэд, байгууллагын оролцоо бүхий нэлээд олон хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн. Эдгээрээс гэр бүлийн нэг маргаан, олон улсын бараа худалдаатай холбоотой хоёр маргааныг тодруулбал ОУХЭЗ-н үүднээс илүү сонирхолтой юм. ОХУ-ын иргэн "А" Чех улсын иргэн "Б" –тэй 1983 онд Чех улсын Брно хотод гэрлэлтээ бүртгүүлсэн. Нөхөр болох "Б" гэрлэлтээ батлуулснаас хойш

Монголд ирээгүй, одоо Чехэд амьдардаг. Харин А Монгол Улсад байнга амьдран суудаг ба 1985 онд амралтаараа Чех улсад очоод буцаж ирснээс хойш нөхөртэйгээ уулзаагүй. "А" шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ Б-г сураггүй алга болсонд тооцож, гэрлэлтээ цуцлуулах хүсэлт тавьсан. Шүүх "А"-ийн нэхэмжлэлийг гэр бүл болсон тухай нотлох баримт хэрэгт авагдаагүй гэх үндэслэлээр хангахаас татгалзсан байна. Энэ бол ОУХЭЗ-н онолд хөндөгддөг "өмнөх асуулт" буюу гэр бүл цуцлахын тулд гэр бүл болсон эсэхийг шалгах, улмаар хэрэглэгдэх хуулийг гэрлэлт, гэр бүл цуцлалтын хувьд өөр өөрөөр тодорхойлж болох асуудал бүхий тохиолдол юм. Энэ тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу Чех улсын холбогдох байгууллагаас зохих туслалцаа авах боломжийг шүүх болон нэхэмжлэгч тал ашиглахаас татгалзсан байна. Монгол Улсын "М" компани Японы "Т" компанитай автомашин худалдах, худалдан авах гэрээ хийж төлбөрийг бараа хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор баталгаат аккредитивээр хийхээр тохиролцжээ. Дараа нь "М" компани Сэргээн босголт банкттай баталгаат аккредитивын гэрээ байгуулж зохих барьцаа тавьсан байна. Гэрээний дагуу автомашин нийлүүлэгдсэн боловч СББанк санхүүгийн байдал дордсны улмаас аккредитивын төлбөрөө төлөлгүй удаасан учир Японы "Т" компани нь "М" компани болон СББанкны эсрэг нэхэмжлэл гаргажээ. Шүүхээс баталгаат аккредитивын гэрээ болон энэхүү гэрээний үүрэгт Японы "Т" компани хэрхэн оролцох, СББанк "Т" компанийн өмнө үүрэг хүлээсэн эсэх асуудлыг тодруулан үзэлгүй, "М" компанийг үүргээс

чөлөөлж, СББанкны эрх хүлээн авагчаар нэхэмжлэлийн шаардлагыг хангуулах шийдвэр гаргасан байна.

Нийслэлийн шүүх ОХУ-ын Полисервис нэгдлийн нэхэмжлэлтэй Монгол Улсын хоёр компанид холбогдох автомашин худалдах, худалдан авах гэрээний маргааныг харьяалан авч шийдвэрлэхдээ 1972 оны Москвагийн Конвенцыг хэрэглэж уг маргааныг арбитраж харьяалах эсэх асуудлыг хөндөж үзээгүй байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай нэгэн компани Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаатай холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргасныг 2001 онд хянан шийдвэрлэсэн тохиолдол гарчээ. Түүнчлэн Монгол Улсад байнга амьдран суудаг Бельги улсын нэгэн иргэн Франц улсын иргэний эсрэг 167 ам.долларын үнэтэй эд зүйл гаргуулах нэхэмжлэл шүүхэд гаргасан байдаг. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч хангасан бөгөөд энэ нь хоёр гадаадын иргэний хоорондох маргаан шийдвэрлэсэн ховор тохиолдлын нэг байв.

Сүүлийн жилд БНХАУ-ын болон ОХУ-ын иргэдтэй холбоотой гэр бүл цуцлах, гэр бүлийн дундын өмчийг хуваах, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох маргаан тасрахгүй байна. Тухайлбал, 2002 онд гэр бүлийн ийм төрлийн 3 хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ. Үүнээс Голланд улсын иргэнд холбогдох гэр бүл цуцлах, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай Монгол Улсын иргэн эмэгтэйн нэхэмжлэлтэй хэргийг Хан-Уул дүүргийн шүүх хянан хэлэлцээд гэрлэлтийг цуцалсан ба эцэг болох Голланд

эрийн амьдран суугаа бүс нутагт (Монгол Улсын Улаанбаатар хот) тогтоогдсон амьжиргааны доод төвшингийн хэмжээгээр сар бүр хүүхдийн тэтгэлгийг хүүхдийн 16 нас (суралцаж байгаа бол 18 нас) хүртэл хугацаагаар тогтоожээ. Хэрэв голланд эр нутаг буцсан тохиолдолд энэхүү шийдвэр хэрхэн биелэгдэх вэ, мөн Голланд улсын харьяат хүний тэжээн тэтгэх үүргийг түүний харьяалсан улсын хуулиар шийдвэрлэвэл магадгүй хүүхдэд ашигтай байсан эсэх, хожим энэ хүүхдийн өвлөх эрх хэрхэн хөндөгдөж болох зэрэг олон асуулт нээлттэй үлдэх болно. 2002 онд Австри улсын "Тиролер Поден" компани өөрийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааж гэм хор учруулсан гэдэг үндэслэлээр нэгэн сонины эсрэг гаргасан нэхэмжлэл шүүхэд иржээ. Сүхбаатар дүүргийн шүүх

үг нэхэмжлэлийн дагуу иргэний хэрэг үүсгэхдээ Австрийн "Тиролер Поден" компанийн харьяалагдах улс болон эрх зүйн чадварыг тодруулах ажиллагаа явуулаагүй байдаг. Мөн Голланд улсын "Интердарм" компанийн төлөөлөгчийн газрын нэхэмжлэлтэй хэрэгт Баянзүрх дүүргийн шүүхээс дээрх төрлийн ажиллагаа хийгдэгүй юм.

Шүүхийн харьяалах эрх хэмжээний хувьд үзвэл 2000-2002 онд бүгд 3 нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзан арбитра болон бусад улсын шүүхэд хандах нь зүйтэй гэж үзээд буцаажээ.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг нэхэмжлэгч, болон хариуцагчийн харьяалагддаг улсаар бүлэглэж үзэх нь Монгол Улсын олон улсын эрх зүйн туслалцааны талаархи бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

урьд эдгээр нь англи, америкийн эрх зүйн орнууд юм. Түүнчлэн эх газрын эрх зүйн системтэй орнууд, тухайлбал, ХБНГУ-д шүүхийн өмнө гаргасан шийдвэр болон түүнд дурдсан үндэслэлийг хожим ижил төстэй хэрэг тохиолдлыг шийдэх, хуулийн заалтыг нэг мөр тайлбарлах, хуулиар зохицуулагдаагүй харилцаанд жишиг болгох зорилгоор их өргөн харгалзан үздэг байна. Монгол Улсын хувьд шүүхийн практикийг нэгтгэн, хуулийг нэг мөр зөв ойлгож хэрэглэх үүднээс Монгол Улсын Дээд шүүхээс албан ёсны хуулийн тайлбар гаргахыг Үндсэн хуулиар (тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт) зөвшөөрчээ.

Нийгмийн амьдралын бүхий л харилцааг хуулиар зохицуулах боломжгүй бөгөөд зохицуулалт үгүй эсвэл зохицуулалт нь бүрэн тодорхой бус хэрэг маргааныг шүүх, арбитра олон дахин шийдвэрлэх явцад нэгэн жишиг тогтох боломжтой. Учир нь, шүүх аливаа маргааныг зохицуулсан хууль байхгүй гэдэг үндэслэлээр шийдвэрлэхээс татгалзах эрхгүй байдаг (Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.6 дахь заалт). Түүнчлэн шүүх, арбитра нэг удаа эрх зүйн онол сэтгэлгээний болон шударга ёсны хувьд хүлээн авахуйц үндэслэл бүхий шийдвэр гаргасан нь цаашид их нөлөө үзүүлж болно. Ер нь шүүхийн нэр хүнд, шүүгчдийн мэдлэг чадвар, хувийн нөлөөнөөс шүүхийн практикийн үр нөлөө хамаарах талтай. Ийм байдлыг шүүхийн эрх мэдэл бүрэн утгаараа хэрэгжсэн улс орнуудын шүүхийн практикт хандах хандлагаас мэдэж болно.

Улс	Нэхэмжлэгч		Хариуцагч	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
I. ОХУ	19		7	
II. БНХАУ	8		10	
III. БНСолонгос Улс	3		5	
IV. Чех улс	3		-	
V. Турк	2		-	
VI. Япон	4		-	
VII. ХБНГУ	1		1	
VIII. Болгар	2		-	
IX. Монгол	29		41	
X. Бусад	11		16	
Бүгд	82	100	80	100

Дээрх хүснэгтээс үзэхэд БНСУ, Япон болон ХБНГУ-ын харьяат иргэн, байгууллагатай холбоотой маргаан багагүй тоогоор гарч байгаа явдлыг харгалзан эдгээр улстай иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого явуулах нь зүйтэй болно.

Гадаад улсын хуулийг хэрэглэх асуудал ихээхэн бэрхшээлтэй болох нь өнөөгийн шүүх арбитрын практикаас

харагдаж байгаа юм. Энэхүү бэрхшээлтэй байдал нь олон улсын шинжтэй хувийн эрх зүйн харилцааны зохицуулалтын аргын олон хувилбарт түвэгтэй техник ажиллагаа болон гадаад улсын хуулийг олох, түүний агуулгыг тогтоох, хэрэглэхтэй холбоотой хуульчдын мэдлэг, чадвар, шүүх арбитрын ажлын нөхцөл боломжоос шалтгаална.

Зарим улсад эрх зүйн актын зэрэгцээ шүүхийн прецедент нь эрх зүйн эх сурвалж болно. Юуны

## КОНСУЛЫН ХИЙХ НОТАРИАТЫН ҮЙЛДЭЛ



Гадаад хэргийн яамны  
мэргэжилтэн А.ТӨМӨР

Улс гүрнүүд харилцан тохиролцсоны үндсэн дээр консулын харилцаа тогтоодог. Сүүлийн үед консулын байгууллагын эрхлэх ажлын хүрээ улам бүр өргөжин тэлж, худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны төдийгүй, зарим тохиолдолд улс төрийн асуудлаар харилцаа холбоо тогтоон хэрэгжүүлдэг болж байна. Манай улсын консулын төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааны хамрах хүрээ ч мөн адил өргөжин тэлж байна. 2003 оны байдлаар дипломат төлөөлөгчийн 35 газар (үүний 8 нь Ерөнхий консулын газар), мөн 29 улсад Өргөмжит 45 консул ажиллаж байна. Харин элчин сайдын яамны консулын газар, хэлтэс нь суугаа орны засаг захиргааны байгууллагатай элчин сайдын яамны нэрийн өмнөөс харилцдаг юм.

Томилсон улс, түүний иргэд, байгууллагын эрх ашгийг өөрийн хариуцсан тойрогтоо хамгаалах, хоёр улсын хооронд эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухаан, технологийн

салбарын хамтын ажиллагаа хөгжүүлж, дэмжлэг үзүүлэхэд консулын төлөөлөгчийн газрын үндсэн чиг үүрэг оршино.<sup>1</sup>

Консулын газар консулын тойрогт оршин суугаа өөрийн иргэдийн бүртгэл хөтлөх, өөрийн улсын иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгч тусалцаа үзүүлэх, өөрийн иргэдэд паспорт олгох, хугацааг нь сунгах, хүчингүй болгох, гадаадын иргэдэд виз олгох, гарын үсэг, баримт бичгийн баталгаа гаргах, өөрийн улсын иргэдийн гэрлэсэн, төрсөн, нас барсныг бүртгэх зэрэг нотариатын үйлчилгээ үзүүлэх, насанд хүрээгүй хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, суугаа улсын хууль тогтоомжийг тухайн тойрогт буй өөрсдийн иргэдэд тайлбарлан таниулах ажил эрхэлдэг. Эдгээр ажлыг суугаа улстай тохиролцсоноор гурав дахь орны нэрийн өмнөөс явуулж бас болдог байна.

Дипломат төлөөлөгчийн газар нь үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ өөрийн улсын хууль дүрэм, олон улсын хувийн эрх зүйг удирдлага болгодог. (1963 оны Венийн Конвенцоор консулын харилцааг зохицуулах ерөнхий хүрээг тогтоосон ба тодорхой асуудлыг голдуу хоёр талт гэрээгээр зохицуулдаг юм. Үүнд хоёр улсын хооронд байгуулсан эрх зүйн тусалцааны тухай гэрээ, хоёр улсын хооронд байгуулсан консулын конвенцыг оруулж болох юм.)

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 10 дугаар сарын 31-нд баталсан Монгол Улсын консулын дүрэмд Консулын албаны эрх зүйн байдал, консулыг томилох, консул бүрэн эрхээ хэрэгжүүлэх журам, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбогдсон асуудал, харьяатын болон иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх асуудлаар консулын гүйцэтгэх үүрэг, нотариатын үйлчилгээний талаар тусгасан байна. Консул нь Нотариатын тухай Монгол Улсын хууль, эрх бүхий байгууллагаас баталсан нотариатын үйлдэл эрхлэн хийх журмыг удирдлага болгон нотариатын үйлдэл хийдэг. Тухайлбал:

1. Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл (гэрээ, гэрээслэл, итгэмжлэл) – ийг батлан гэрчлэх;
2. өв залгамжлах эрх, гэрээслэлийг гэрчлэх;
3. өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох;
4. гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрхийг гэрчлэх;
5. баримт бичгийн бүрэн буюу хэсэгчилсэн хуулбарын үнэн зөвийг гэрчлэх;
6. баримт бичгийн гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх;
7. баримт бичгийн орчуулгын үнэн зөвийг гэрчлэх.

Түүнчлэн Консулын төлөөлөгчийн газар ч нотариатын дээр дурдсан үйлчилгээ үзүүлдэг. Зарим тохиолдолд өөрийн тойрогт буй хүнд өвчтөн, хэвтэрт байгаа

1. Международное право. Словарь-справочник. М., 1997 г., с.103

этгээдийн оршин байгаа газарт очиж нотариатын үйлчилгээ үзүүлж болдог. Хэрэв консул нэмэлт мэдээ, баримт бичиг гаргуулах буюу баримт бичгийг шинжлүүлэх шаардлагатай бол Монгол Улсын хууль тогтоомжид заасанчлан нотариатын үйлдэл хийх хугацааг хойшлуулах эрхтэй байдаг.

Консул нотариатын үйлчилгээ хийхээс өмнө хуулиа сайн судалсны үндсэн дээр үйлдэл хийхгүй бол буруугаар ашиглуулах магадлал өндөр байдаг юм. (Жишээ нь: хуурамч баримт бичиг бүрдүүлэх, зүсээ хувиргах г.м.) Мөн өөрийн орны хуулийг судлах нь түүнд харшлахаар нотариатын үйлчилгээ хийхээс татгалзах үндэслэл болно. Нотариатын үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан шалтгааныг үйлчлүүлж буй этгээдэд мэдэгдэх бөгөөд эс зөвшөөрвөл журмын дагуу үйлчлүүлэгч гомдол гаргах эрхтэй байдаг.

Нотариатын үйлчилгээ үзүүлж буй консул өөртэй нь болон гэр бүлийн гишүүн, төрөл садангийн холбоотой асуудлаар нотариатын үйлдэл хийхээс татгалзана. Харин гадаадын иргэн баримт бичиг хөтлөх хэлийг мэдэхгүй тохиолдолд баримт бичгийн эхийг түүнд орчуулж өгөх үүрэгтэй. Учир нь консул нотариатын баримт бичгийг монгол хэлээр хөтлөх журамтай байдаг.

Нотариатаар батлагдах хэлцэл, өргөдөл бусад баримт бичигт үйлчлүүлэгч консулын дэргэд гарын үсэг зурах бөгөөд консулын дэргэд байгаагүй тохиолдолд гарын үсэг зурсан этгээд тухайн баримт бичигт гарын үсэг зурснаа өөрөө батламжлах ёстой. Хэрэв гарын үсэг зурсан баримт бичиг нь Монгол Улсын хууль

тогтоомжид нийцэхгүй бол консул тийм үйлчилгээ хийхээс татгалзах эрхтэй байдаг.

Нотариатын үйлчилгээ хийхдээ Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц болон Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид үндэслэн өргөмжит консул нотариатын үйлдэл хийх эрхтэйг өргөмжит консулын тухай 2003 оны Гадаад хэргийн сайдын тушаалаар баталсан журамд<sup>1</sup> заасан байдаг.

Өргөмжит консул гэж Монгол Улсын гадаад харилцаа эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гадаадын тодорхой улс, бүс нутагт Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу томилсон Монгол Улсын болон хүлээн авагч орны иргэнийг хэлдэг. Гагцхүү өргөмжит консул (олон улсын эрх зүйд орон тооны бус консул ч гэдэг)<sup>2</sup> нь тухайн улсын болон Монгол Улсын төрийн албан хаагч, өөр улсын өргөмжит консул байж болохгүй.

Өргөмжит консул нь:

- Өргөмжит ерөнхий консул

- Өргөмжит консул зэрэгтэй байдаг бөгөөд энэ нь нотариатын үйлдэл хийхэд ямарваа нэгэн ялгавар, төвшин тогтоодоггүй.

Өргөмжит консулыг хариуцах тойрогтоо нэр хүндтэй, Монгол Улсад хандах хандлага, санхүүгийн чадавхи, Монгол Улстай хамтран ажиллаж байсан туршлага, ажлын үр дүн, хүлээн авагч улсын зөвшөөрлийг үндэслэн

Гадаад хэргийн сайд тохоон томилдог. Монгол Улсын өргөмжит консул хоёр жилээр томилогддог байна. Тэрхүү хугацаанд Монгол Улсын байгууллага, иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үүрэг хүлээж ажилладаг байна. Тэр дундаа дор дурдсан нотариатын үйлчилгээ хийнэ:

1. өв залгамжлалын эд хөрөнгийг хамгаалах;

2. баримт бичгийн хувь, хуулбарын үнэн зөвийг гэрчлэх;

3. гарын үсэг, тамга тэмдгийн үнэн зөвийг гэрчлэх;

4. орчуулгын үнэн зөвийг гэрчлэх;

5. иргэдийн амьд мэнд байгаа болон оршин суугаа газрыг гэрчлэх;

6. баримт бичгийн хугацааг гэрчлэх;

7. гэрээслэлийг гэрчлэх.

Өргөмжит консул нь нотариатын үйлчилгээг албан байрандаа буюу тойргийнхоо хүрээнд өөр газарт хийж болох бөгөөд нотариатын үйлчилгээтэй холбогдсон нууцыг чандлан хадгалах үүрэг хүлээдэг байна. Нотариатын болон бусад бичиг хэргийг монгол<sup>3</sup>, эсхүл англи буюу хүлээн авагч улсын төрийн хэлээр хөтөлж болно.

Консулын хураамж, нотариатын болон бусад үйлчилгээний төлбөрийг Монгол Улсын хууль тогтоомжид заасан тарифын дагуу хүлээн авагч улсын болон чөлөөтэй хөрвөх валютаар авч Гадаад хэргийн яамны мэдэгдсэн дансанд шилжүүлж, энэ тухайгаа Гадаад хэргийн яамны консулын асуудал эрхэлсэн нэгж болон түүний удирдлагад улирлаар тайлагнаж байдаг.

1. Гадаад хэргийн сайдын 2003 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 33 тоот тушаалаар баталсан "Өргөмжит консулын тухай журам"

2. Международное право. Словарь-справочник. М., 1997 г., с.104

3. Монгол Улсын Төрийн албан ёсны хэлний тухай хууль. УБ., 2003 он.



## Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилт



ШУА-ийн Бага чуулганы гишүүн,  
Хууль зүйн шинжлэх ухааны  
доктор, профессор С.ЖАНЦАН

Монгол Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлж буй Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх, ардчиллыг гүнзгийрүүлэх зорилгоор 2002 онд Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баталж, мөрдөөд жил гаруй хугацаа өнгөрч байна.

Эдгээр хуулийг хэрэгжүүлэх явцад зарим хэм хэмжээг эргэж харах, өөрчлөх боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд эдгээрийг хэрхэн шийдвэрлэх нь эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн енөөгийн тулгамдсан асуудал мөн.

Нэг. Эхлээд Эрүүгийн хуультай холбоотой нэн даруй

шийдвэрлэх ёстой асуудлыг авч үзье.

Эрүүгийн эрх зүйн нэг тулгуур ойлголт бол гэмт хэрэг бөгөөд түүний бүх шинж хуульчлагдсан байх ёстой. Гэтэл одоогийн хуульд /16.1/ гэмт хэргийн тодорхойлолт өгөхдөө гэм буруутай байх шинжийг орхигдуулсан нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн бусад хэм хэмжээтэй зөрчилдөхөд хүргэжээ. Иймд *Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ* гэж хуульчлах шаардлагатай юм.

Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд заасан *үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн, 71 дүгээр зүйлд заасан хохирогчтой эвлэрсэн* гэсэн 2 үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн этгээд хөнгөн гэмт хэрэг давтан үйлдвэл хэрхэх нь тодорхойгүй байгаагаас хууль хэрэглэх практикт бэрхшээл учруулж байна. Иймд Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "хуульд заасан" гэдгийг *"энэ хуулийн 70, 71 дүгээр зүйлээс бусад зүйлд заасан"* гэж өөрчлөн найруулах нь зүйтэй юм.

Гэмт хэргийн олонлог нь гэмт хэрэг давтан үйлдэх, нийлмэл гэмт хэрэг рецидив гэмт хэрэг гэсэн 3 хоорондоо харилцан шүтэлцээ бүхий төрөлтэй байдаг. Гэтэл Эрүүгийн хуулийн 18, 19 дүгээр зүйлд "давтан" нийлмэл гэмт хэргийн ойлголтыг

хуульчлаад, рецидив /ялтай давтан/ гэмт хэргийг орхигдуулсан хийдлийг арилгах зайлшгүй шаардлагатай байна.

Хохирлын хэмжээг тодорхойлсон Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийг "Гэм буруу" гэсэн бүлэгт оруулсан нь байрлалаа олоогүй. Иймд "Гэмт хэрэг" гэсэн 5 дугаар бүлэгт хуульчлах шаардлагатай.

Захиалагчийг гэмт хэрэгт хамтран оролцогчдын бие даасан төрөл болгон хуульчилсан нь оновчгүй байна. Өмнөх Эрүүгийн хуулиудад өөрийн хүсэл зоригоо илэрхийлж, бусдаар гэмт хэрэг үйлдүүлсэн тохиолдлыг "зохион байгуулагч" эсхүл "хатгагч" гэж үзэж, хариуцлага хүлээлгэж ирсэн уламжлалаа хадгалах шаардлагатай учраас "захиалагч" гэсэн оролцогчийг Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлээс хасах нь зүйтэй.

Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл хэмээх гэмт хэрэгт хамтран оролцохын хэлбэрүүд нь зарчмын ялгаагүй, тэр тусмаа гэмт бүлэглэл /байгууллага/ байх шинжүүд орхигдсон. Иймд гэмт бүлэглэл гэдэгт *зохион байгуулалтын шаталсан пирамид/ бүтэцтэй, удирдах бүрэлдэхүүн, гишүүнчлэл, хяналт, мэдээлэл, тагнан турших, хамгаалах албатай төрийн албан тушаалтны оролцоотой/хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагад өөрийн төлөөлөлтэй/, өөрийн хатуу*

*тогтсон дүрэм, тангараг, холбоо, харилцааны хэрэгсэл, зэвсэг, техникээр хангагдсан хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж ашиг орлогынхоо эх үүсвэрийг бүрдүүлдэг, хэд хэдэн улс үндэстэн дамнасан шинжтэй мэргэшсэн гэмт хэрэгтнүүдийн нэгдлийг ойлгох нь зүйтэй.*

“Аргагүй хамгаалалт” хэмээх гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг хуульчлахдаа довтолгооны эсрэг хийгдсэн хамгаалалтад хамаарах чухал нөхцөл болох аргагүй хамгаалалтын “хэр хэмжээ хэтрээгүй” байх чухал шинжийг Эрүүгийн хуулиас хассан нь довтолгоонд өртөх хүний эрх, халдашгүй байдлыг хамгаалах ач холбогдолтой ч гэсэн аль ч талаараа оновчтой болоогүй байна. Учир нь манай нөхцөлд ямар ч гэрчлэх хүнгүй үед 2 этгээд нэгийгээ хутгалж алчихаад “*хохирогч над руу хутга бариад дайрахад нь би хамгаалсан*” гэж мэдүүлсэн, “хамгаалалт хийсэн” гэж байгаа этгээд үнэн хэрэг дээрээ хохирогчийг алах гэмт санаа зорилгоо гүйцэлдүүлсэн тохиолдолд өнөөдрийн хуулиар аргагүй хамгаалалт хийсэнд тооцохоос өөр замгүй болж байна. Энэ өөрчлөлттэй уялдуулан Эрүүгийн хуулиас хассан “аргагүй хамгаалалтыг хэтрүүлж бусдыг алах” гэмт хэргийг дахин хуульчлах нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Согтуурал буюу мансуурлын байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй” гэсэн заалт нь хуулийн 70, 71 дүгээр зүйлийн агуулгатай зөрчилдөж согтуурсан, мансуурсан байдалд хөнгөн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас

чөлөөлөгдөхгүй байх үндэслэл бий болж байна.

Бидний судалгаанд хамрагдсан хууль хэрэглэгчийн олонхи нь торгох ялын хэмжээ хэт их байгаагаас хэрэгжүүлэх боломжгүй байдал үүсэх болсныг тэмдэглэсэн нь үндэстэй гэж үзнэ. Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой зүйл, хэсгийн санкцад заасан торгуулийн хэмжээг эргэж харах нь зөв юм.

Албадан ажил хийлгэх ялыг ямар хугацааны дотор эдэлж дуусгах тухай заалт хуульд үгүйлэгдэж байна. Энэ ялыг /100-500 цаг/ баривчлах ялаар солиход баривчлах ялын доод хэмжээнд хүрэхгүй байна. Иймд энэ ялыг баривчлах ялаар солих тохиолдлын талаархи хуулийн заалтыг өөрчлөн найруулах шаардлагатай. Тухайлбал, албадан ажил хийлгэх ялын 100 цаг, баривчлах ялын 1 сартай, 500 цаг нь 6 сартай тэнцэж байх учиртай. Эрүүгийн хуульд албадан ажил хийлгэх ялыг цалин хөлө олгохгүйгээр эдлүүлэхээр заасан байхад, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт цалин, хөлс олгох тухай хуульчилсан нь хоорондоо илт зөрчилдөж, хэрэглэхэд бэрхшээл учруулж байна.

Албадан ажил хийлгэх ялыг 16 насанд хүрээгүй этгээдэд ногдуулах нь хүүхдээр албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон Хөдөлмөрийн хуулийн 109.1 дэх хэсэг, манай улс нэгдэн орсон “Хүүхдийн эрхийн тухай конвенц”, Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйлийн агуулгад нийцэхгүй байна. Иймд Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт 16 насанд хүрээгүй этгээдэд энэ ялыг хэрэглэхгүй байхаар хуульчлах нь зүйтэй байна. Албадан ажил хийлгэх, баривчлах ялыг 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, бага насны

хүүхэдтэй ганц бие эцэгт ногдуулахгүй гэж заасан нь гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдэнд зөвхөн торгох болон хорих ялыг ногдуулахаар байна. Эдгээр ялыг ийм хүмүүст ногдуулах нь тохиромжгүй бөгөөд ихэнх тохиолдолд боломжгүй нь харагдаж байна.

“Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал” гэсэн Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд нэрлэж зааснаас бусад хөнгөрүүлэх нөхцөл байдлыг шүүх харгалзах боломж олгосон заалт нэмж оруулах нь энэрэнгүй ёсны зарчимд нийцнэ.

Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгчийн цагдан хоригдсон хугацааг гянданд ял эдлэх хугацаанд оруулж тооцохгүй” гэж заасан нь хүнлэг энэрэнгүй ёсны зарчимд харшилж байна. Учир нь манай урьдчилан хорих байрны нөхцөл гяндангийн хорих ерөөнийхөөс бүх талаараа муу байгаа гэдгийг харгалзах ёстой. Бүх тохиолдолд шүүгдэгчийн цагдан хоригдсон хугацааг ял эдэлсэнд тооцож байх ёстой.

Хууль хэрэглэж буй практик ажиллагаа нь хэд хэдэн шийтгэл тогтоолоор ял ногдуулах тохиолдолд сүүлчийн шийтгэх тогтоолоор ногдуулсан баривчлах ял дээр өмнөх шийтгэх тогтоолоор ногдуулсан хорих ялыг нэмж нэгтгэхэд эдлэх ялыг хаана эдлүүлэхийг тодорхой зааж хуульчлаагүйгээс тодорхой бэрхшээл учирч байна. Иймд эрүүгийн хуульд эдгээр ялыг нэмж нэгтгэсэн тохиолдолд тус тусад нь эдлүүлэх тухай заалт оруулах замаар шийдвэрлэж болох юм.

Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд оногдуулах ялын дээд хэмжээ нь энэ хуулийн

*тусгай ангид тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын гуравны хоёроос хэтрэхгүй*” байхаар заасан. Энэ нь тухайн хүнд төрлийн ялын дээд, доод хэмжээний алиных нь хувиар тооцохыг тодорхойлох боломжгүй байдалд хүргэж байна. Иймд 60 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Хүнд төрлийн ял” гэдгийн ард “дээд хэмжээний” гэж өөрчлөн найруулахыг шаардаж байна.

Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хохирол болсон эсэхээс үл хамааран энд заасан хүмүүст хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулахаар байна. Гэтэл Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт болохоор ял тэнсэхэд хохирол төлсөн, гэм хорыг арилгасан байхыг шаардаж байна. Иймд Эрүүгийн хуулийн 63.1-д “гэмт хэрэг үйлдсэн” гэдгийн ард “хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан” гэж найруулах нь зохимжтой юм.

Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй үндэслэл болж байна. Холбогдох байгууллага, албан тушаалтнууд энэ үндэслэлээр хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татахгүй байгаа учир иргэд ялангуяа, хохирогчдын бухимдал, дургүйцлийг төрүүлж, түүнчлэн ял хариуцлага гарцаагүй байх зарчимтай зөрчилдөх боллоо. Иймд энэ зүйлийн “1 жил” гэснийг “3 жил” болгох нь тохиромжтой байна.

Эрүүгийн хуулийг гардан хэрэглэж байгаа байгууллага албан тушаалтнуудын дунд явуулсан судалгаа тодорхой төрлийн хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт оногдуулах

ялын санкц гэмт хэргийн хор аюул, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан ялыг ялгавартай тохируулж, хэрэглэх боломжийг хаагдуулж байгааг харууллаа. Энэ нь тодорхой төрлийн гэмт хэрэгт ногдуулж буй хорих ялын доод, дээд хэмжээг нарийвчлан авч үзэхийг шаардаж байна. Тухайлбал, хулгайлах, булаах, дээрэмдэх болон хүч хэрэглэсэн гэмт хэргийн хувьд ногдуулах хорих ялын доод хэмжээ хэтэрхий өндөр байна.

Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд ял хөнгөрүүлэхэд харгалзах бүх нөхцөл байдлуудыг тоочих боломжгүй, бодит байдлыг харгалзан шүүх ял ногдуулахдаа хуульд заагаагүй хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг харгалзах боломж олгож байсан өмнөх хуулийн зохицуулалтыг сэргээх нь зүйд нийцнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хүн бүр нас, хүйс ямар байснаас үл шалтгаалан бүгд хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй. Гэтэл Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэйд 15 жилээс дээш хугацаагаар хорих, мөн хуулийн 53 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй тухай заалтууд Үндсэн хуулийн дээр дурдсан тулгуур зарчимд харшилж байгаа юм.

Насанд хүрээгүйгээс бусад хүмүүсийн хувьд ямар нэгэн ялгаваргүйгээр дурдсан хугацааны хорих ял, цаазаар авах ялыг хэрэглэж болох нь манай улс нэгдэн орсон олон улсын пактаас харагддаг. Тухайлбал, “Иргэний болон улс

төрийн эрхийн тухай олон улсын Пактын 3 дугаар зүйлийн хэсгийн 5-д “Гэмт хэрэг үйлдсэн 18 нас хүрээгүй этгээдэд цаазаар авах ял ногдуулахгүй бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд уг ялыг ёсоор гүйцэтгэхгүй” гэж зааснаас тодорхой байна. Иймд нас, хүйс ялгаваргүйгээр онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд 15 жилээс дээш хугацаатай хорих ял, цаазаар авах ял хэрэглэх боломжийг хуульчлах нь энэрэнгүй ёсонд харшлахаар байгаа ч шударга ёсонд нийцэхгүй гэж үзэж болохоор байна.

Хүнийг санаатай алах гэмт хэргийн онц хүндрүүлэх нөхцөл байдал /Эрүүгийн хуулийн 91.2/ “Өс хонзонгоор” алахыг хамааруулснаар энэ зүйлийн 1 дэх хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээх тохиолдол гарахгүйд хүргэж байна. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 7-д уулгалан довтлох, дээрэмдэх гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг алахыг ялын онц хүндрүүлэх нөхцөл байдалд хамааруулсан нь шунахай сэдэлтэйгээр алахтай давхцаж байгаа учир хасах саналтай.

Шүүхийн практикт хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн сэтгэл санааны гэнэтийн цочирдлын байдалд бусдын бие махбодод хүнд гэмтэл учруулбал Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэхэд хүрч байгаа тохиолдол түгээмэл байна. Ийм учраас санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочирон, давчидсанаас бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах гэсэн гэмт хэргийг шинээр хуульчлах шаардлагатай.

Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлд заасан “бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах” гэмт хэргийг хуульчлахдаа өмнөх хуульд

байсан “хүнд гэмтэл учруулсны улмаас хохирогч нас барсан” гэсэн хүндрүүлэх нөхцөл байдлыг хуулиас хассан нь зөвтгөж боломгүй бүдүүлэг алдаа болсон гэж үзнэ. Учир нь хүний бие махбодод аливаа гэмтэл, тэр тусмаа хүнд гэмтэл учруулах нь ихэвчлэн харилцан зодооны явцад, алах гэсэн санаа зорилгогүйгээр үйлдэгддэг болохыг практик нэгэнт нотолсон зүйл. Энэ хууль үйлчилж эхэлснээс хойш хүнд гэмтлийн улмаас хохирогч нас барсан бүх тохиолдлыг Эрүүгийн хуулийн 91дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчилж, хариуцлага хүлээлгэхээс өөр арга замгүй боллоо. Энэ алдааг нэн даруй залруулах нь шударга, энэрэнгүй байх Эрүүгийн хуулийн зарчимд нийцнэ.

Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тодорхой хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр байгаа боловч энэ гэмт хэргийг гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн 55-аас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээд үйлдвэл дээр дурдсан ялуудыг ногдуулж болохгүй нь Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 4; 51дүгээр зүйлийн 4 дэх заалтаас тодорхой байна. Иймд Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт богино хугацааны хорих ял оногдуулахаар нэмж хуульчлах шаардлагатай.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэргийн шинжид “Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан” байхыг хамруулсан боловч 117 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан

үйлдэл, эс үйлдэхүй нь агуулгаараа гэмт хэрэг биш болж байгаа нь учир утгагүй зүйл юм.

Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлийн “зандалчлах” гэдэг нэр томъёо нь энэ гэмт хэргийн агуулга, шинж чанарт огтхон ч нийцээгүй гэж үзэж байна. Иймд энэ гэмт хэргийг “Террор үйлдэх” 178 дугаар зүйлд заасан гэмт хэргийн нэрийг “Террор үйлдэх тухай санаатай худал мэдээлэх” гэж томъёолох шаардлагатай.

Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлийн диспозицийг “Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж хууль ёсны мэт болгох зорилгоор тэдгээрийг санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан, бусдад их хэмжээний хохирол учруулсан бол...” гэж найруулах, энэ гэмт хэрэг ногдуулах ялыг чангатгах шаардлагатай байна. Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг хязгаарласан болон хориглосон эд зүйл ямар хэмжээтэй болохыг тодорхой хуульчилж өгөөгүйгээс нэг литр спиртийг нууж нэвтрүүлбэл гэмт хэрэгт тооцогдож байгаа нь утгагүй зүйл юм. Ийм хүндрэлээс гаргах гарц олох зорилгоор Улсын дээд шүүх энэ зүйлийг тайлбарласан тогтоолдоо “хязгаарласан болон хориглосон эд зүйлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний өнөөдрийн доод хэмжээ болох 40.000 төгрөгтэй дүйцүүлсэн нь хуулиар хэм хэмжээ тогтоогоогүй байхад тайлбар хийсэн” гэж үзэхээр байна.

Амьдрал дээр баривчлах ялыг эдлүүлэх байр, хорих газраас оргосон, ял эдлэхээс зайлсхийсэн ялтнуудыг хаана байгааг мэдсээр байж нуун далдлах тохиолдол түгээмэл байдгийг харгалзан Эрүүгийн хуулийн 247 дугаар зүйлд

нэрлэж заасан гэмт хэргүүдийн тоонд Эрүүгийн хуулийн 261, 262 дугаар зүйлийг хамааруулах нь зүйтэй байна.

Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн нэрийг манай улс 2000 онд нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын агуулгад нийцүүлэх үүднээс “Эрүүдэн шүүх аргаар мэдүүлэг авах” гэж өөрчлөх саналтай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээж эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хамгаалах чиг үүргийг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлнэ.

Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуульд цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрх, нийгмийн хэв журмыг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан.

Төр түүний байгууллага, онцолбол, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй цагдаагийн байгууллага, ажилтан энэ үүргээ баталгаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлөөр бүрэн хангагдсан байх учиртай. 2002 оны 9 сарын 1-нээс өмнө үйлчилж байсан Эрүүгийн хуульд цагдаагийн ажилтныг албан үүргээ биелүүлж байгаагай нь холбогдуулан доромжлох, эсэргүүцэх, хүч хэрэглэх, амь биед халдах

үйлдэл, эс үйлдэхгүйг тус тусад нь гэмт хэрэгт тооцон хатуу хариуцлага тооцож байсан. Гэтэл шинэ Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйлийн агуулгаас харахад гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, дэг журам, иргэдийн амгалан тайван байдлыг гардан сахиулдаг маш их эрсдэлтэй, өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтнүүдийн бууны ам, хутганы ирэн дээр байдаг цагдаагийн албан хаагчдын хуульд нийцсэн үйл ажиллагаа, амь бие, эрүүл мэндийг Эрүүгийн хуулиар хамгаалах асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, улсын байцаагч нарынхтай адилтган үзэж хуульчилсан нь тодорхой байна.

Ингэж хэрхэвч болохгүй бөгөөд манай хуулийн уламжлал олон улсын жишгийг харгалзан гэмт хэрэгтэй тэмцэж, нийгмийн хэв журам хамгаалж буй цагдаагийн ажилтнуудыг Эрүүгийн хуулиар тусгайлан хамгаалах шаардлагатай юм. Иймд Эрүүгийн хуульд “Цагдаагийн ажилтныг доромжлох”, “Цагдаагийн ажилтныг эсэргүүцэх”, “Цагдаагийн ажилтанд хүч хэрэглэх /саад хийх/”, “Цагдаагийн ажилтныг албан үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан санаатай алах” үйлдэл, эс үйлдэхүйнүүдийг тусгайлан хуульчлах нь зүйтэй байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль хэрэгжих болсноор төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах аливаа үйл ажиллагаа хэрэгжих нөхцөл, боломж хаагдсантай уялдуулан Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлийг хүчингүй болгох нь зүйтэй юм.

Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн тайлбарт албан тушаалтны онцгойрох

шинжүүдийг захирамжлах зохион байгуулах, захиргаа аж ахуйн бүрэн эрхтэй уялдуулан авч үзэх шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн 301 дүгээр зүйлд заасан олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтолох гэмт хэргийн тайлбарт хэт хавтгайруулсан агуулгаар гадаад улсын гадаад худалдааны байгууллагын ажилтнуудыг олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст хамааруулсан нь манай улс 1975 онд нэгдэн орсон “Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгсдийг шийтгэж цээрлүүлэх тухай” Нью-Йоркийн Конвенц (1973 он)-ын үзэл санаанд нийцэхгүй байна.

Энэ гэмт хэрэгт ногдуулах ял нь зөвхөн 5-аас дээш 25 жил хүртэл хугацааны хорих ял байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Иймд олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийн аюулгүй байдлын баталгааг бүрэн хангах шаардлага, өмнө хуулийнхаа уламжлалыг харгалзан цаазаар авах ял хэрэглэхээр хуульчлах шаардлагатай юм.

Хоёр. Одоо эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн асуудалд та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хүний эрхийн үндсэн зарчим, манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүд болон нийтээр хүлээх жишиг, стандартад нийцсэн илт ололттой, шинэлэг, хүний эрхийг хамгаалахад албан тушаалтны дур зоргын авирлалт, хууль бус үйлдлээс хамгаалахад чиглэгдсэн олон чухал заалт хуульчлагдан хэрэгжиж байгаа боловч нэн даруй шийдвэрлэх асуудал ч тулгараад байна.

Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлд:

а/ Анх удаа гэмт хэрэг үйлдсэн;

б/ Хохирогчтой сайн дураараа эвлэрсэн;

в/ Учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан байх гэсэн эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх гурван нөхцөлийг заасан байхад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25 дугаар зүйлд “Хохирогчтой сайн дураар эвлэрсэн” ганц үндэслэл заасан байна. Иймд энэ зүйлд үлдсэн хоёр үндэслэлийг хуульчилж материаллаг хуультай нийцүүлэх шаардлагатай юм. Тухайлбал, 25.1-д гэмт хэрэг анх удаа үйлдсэн нь хөнгөн гэмт хэргийн ангилалд багтаж байгаа, хохирогчтой сайн дураараа эвлэрсэн, учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан гэсэн болзуудыг оруулахын хамт “прокурор”, “шүүгч” гэж хэрэгсэхгүй болгох эрх бүхий субъектуудыг зааж өөрчлөн найруулах нь зүйтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “зөвхөн яллагдагчийн эрхшээлд байгаа” гэж заасан нь 1 дэх хэсгийн заалттайгаа зөрчилдөж байгаа учир 25.2-ын “яллагдагчийн” гэдгийг “яллагдагч, шүүгдэгчийн” гэж өөрчлөн найруулмаар байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт мөрдөн байцаалт явуулах хүнд, онц хүнд гэмт хэргүүдийн дотор Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтай хулгайлах гэмт хэргийг оруулан хуульчилсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдөж байгааг залруулах хэрэгтэй юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн талаар

хуульчдын дунд явуулсан бидний судалгаанаас харахад шүүн таслах ажиллагаа дахь иргэдийн төлөөлөгчдийн оролцоо, эрх үүрэг оновчтой бус байгаа нь харагдлаа. Иргэдийн төлөөлөгч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулах ялын талаар саналаа бичгээр гаргаж байгаа нь хангалтгүй байна. Тэр шүүгдэгчийн гэм буруу, ялын талаарх саналаа шүүх хуралдаан дээр уншиж танилцуулдаг, шүүхийн шийдвэрийг давж заалддаг эрх олгосон заалт шинээр оруулмаар байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтнийг хорьж мөрдөх 14 хоногийн хугацаанд баривчилсан 3 хоног орох эсэх нь тодорхой зохицуулагдаагүйгээс бэрхшээл үүсч байна. Иймд эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69.1-д “баривчилсан хугацааг сэжигтнийг цагдан хорьсон хугацаанд оруулж тооцохгүй” гэж шууд зааж өгөх хэрэгтэй.

Хүний эрхийг хөнддөг асуудал бол хорих хугацаа, түүнийг сунгах талаар хуульд заасан журам байдаг. Шинэ хуульд хорих дээд хугацааг зарим онц хүнд гэмт хэргийн хувьд 30 сараар /ЭБШХуулийн 69.9/, хорьж мөрдөх хугацааг 24 сараар /ЭБШХуулийн 69.3/ тогтоосон.

Хуучин хуульд хүндэвтэр гэмт хэрэгт холбогдогчийг хоёр сараас дээш хугацаагаар хорихыг хориглодог байсан бол /95 дугаар зүйл/ шинэ хуулиар энэ хугацаа 24 сар болж даруй 12 дахин өссөн. Хүүхдийг 18 сараар /ЭБШХуулийн 366.4/ хорьж мөрдөхөөр хуульчилсан нь Монгол Улсын олон улсын гэрээний “аль болох ахар богино хугацаанд” хорих шаардлагатай илт зөрчилдөж байна.

Өмнөх хуулиас хүний эрхийн хувьд илт дордуулсан

өөр ийм асуудал бол хорьж мөрдөх хугацааг сунгах журам юм. Хуучин хуулиар хоёр сараас дээш хугацааг сар тутамд тогтоол үйлдэж сунгуулах шаардлагатай байсан бол одоогийн хуулиар заавал сар тутамд биш, хэдэн сараар ингэж сунгуулах боломжийг /Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69.5/ холбогдох албан тушаалтнуудад олгож байна.

Шинэ хууль сэжигтнээр тооцох журмыг /35.1/ тогтоосон атлаа ямар хугацаатай сэжигтнээр тооцогдох, хэзээ дуусгавар болохыг заагаагүй учраас хэргийг илэртэл сэжигтэн байх магадлалтай болж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гэмт хэрэгт сэжиглэж бусдыг баривчлах, хорих үндэслэлийг тодорхой хуульчилсан атлаа буцаагаад суллах, хорих, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх байдал, журмыг орхигдуулснаар удаан хугацаагаар хоригдох, бусад эрх нь зөрчигдөх боломжтой юм.

Сэжигтнийг баривчлах үндэслэлийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд тодорхойлсноос харахад “хүнд гэмт хэрэгт холбогдогчийг заавал баривчилж байхаар хуульчилсан нь зөвтгөж боломгүй хүний эрхийг ноцтой хөндөхөд хүргэж болох зүйл юм.

Прокурорууд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг үгийг иш үндэс болгон бүх таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй мэтээр ойлгож, шүүгчийн гаргасан цагдан хорих шийдвэрийг өөрчлөн шүүгчийн эрх эдэлж байгааг зөвтгөж боломгүй.

Албадан ирүүлэх ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн даалгаснаар зөвхөн цагдаагийн

байгууллага гүйцэтгэх талаархи хуулийн заалтаас шалтгаалан тагнуулын мөрдөн байцаах алба, хилийн тагнуулын алба, прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь шаардлагатай хүнийг албадан ирүүлэхэд бэрхшээл учирч, хугацаа алдахад хүрч байгааг анхаарах нь чухал юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах тохиолдлын тоонд а/ урьд сонгосон ял дээр өөр ял нэмж сонсгох, б/ уг хэрэгт холбогдуулан өөр этгээдийг эрүүгийн хариуцлагад татах үндэслэл байгаа бөгөөд түүнийг тусгаарлах боломжгүй байх зэргийг нэмж хуульчлах шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 317 дугаар зүйлд давж заалдах шатны шүүх шүүгдэгчид хүнд ялтай хууль хэрэглэх шаардлагатай гэж үзвэл анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож хэргийг мөрдөн байцаалтад буцаах эрхтэй байгаа нь энэ хуулийн 230 дугаар зүйлтэй зөрчилдөж байна. Шүүгдэгч нь шүүхээс оргон зайлах нь Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг бөгөөд тухайн этгээдэд заавал шинээр ял нэмж сонсгох, хэргийн нэмэлт мөрдөн байцаалтад буцаах шаардлагатай болж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 240 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүгдэгч нь Монгол улсын хилийн гадна байгаа бөгөөд шүүхэд хүрэлцэж ирэхээс зайлсхийсэн бол хэргийг түүнийг байхгүйд хэлэлцэж болно” гэсэн заалтыг “яллагдагч, шүүгдэгч нь шүүхээс оргон зайлсан бол энэ хуулийн 230-р зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн

*байцаалтад буцаана*” гэж өөрчлөн найруулмаар байна.

Мөрдөн байцаалт явуулсан бүх хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянаж шийдвэрлэхэд анхан шатны шүүхийн ачаалал мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа төдийгүй тухайн хэрэг нь хөнгөн, хүндэтгэр гэмт хэргийн ангилалд хамаарч байгаа боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлд заасан тусгай харьяаллаар мөрдөн байцаалт явуулсан бол заавал гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр байна. Энд хөнгөн, хүндэтгэр гэмт хэргээс гадна зарим төрлийн 10 жил хүртэлх хорих ял ногдуулж болох хүнд гэмт хэргийг шүүгч дангаараа шийдвэрлэж байх боломж олгомоор байна.

Прокурорын хэрэг хянах болон яллах дүгнэлт үйлдэх хугацаа нь хэрэг бүртгэх хугацаанд орох эсэх нь тодорхойгүй. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 182.2-ыг удирдлага болгож, 178 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “3” гэсэн заалт нэмж, түүнд *“энэ хэргийн 178 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан хугацааг эрүүгийн хэрэг үүсгэснээс эхэлж хэргийг прокурорт шилжүүлж, эсхүл хэрэгсэхгүй болгох хүртэлх үеийг оролцуулан тооцно”* гэж хуульчлах боломжтой.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 247 дугаар зүйлд шүүхээс хэргийг түдгэлзүүлэх үндэслэл, журмыг заасан боловч сэргээх үндэслэл, журмыг орхигдуулсан хийдлийг арилгах нь зүйтэй. Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хооронд нь харьцуулан судалж үзэхэд процессын хэм хэмжээ нь материаллаг хууль болох Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй зөрчилдсөн

тохиолдол олон байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэж заасан байхад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлд “... гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол эрүүгийн хэрэг үүсгэхгүй...” гэж материаллаг хуулийн заалтаас зөрөөтэй хуульчилжээ. Нэг ижил ойлголтыг хоёр хуульд өөр өөрөөр томъёолсон тохиолдол ч байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд “Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа” Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24.1.2-т үүнийг хоёр хэлэлцэх хугацаа гэсэн байна. Зүй нь Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн нэр томъёотой яв цав тохирч байх учиртай.

Материаллаг хууль болох Эрүүгийн хуульд эрх зүйн үндэс нь хуульчлагдаагүй хэм хэмжээ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд олон байгаа нь тогтоогдож байна. Жишээ нь: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлд “Албадан ажил хийлгэх ял, баривчлах, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх журмыг хуульчилсан бол энэ тухай ямар нэгэн заалт Эрүүгийн хуульд үгүйлэгдэж байна. Эрүүгийн хуулийн 77.1-д “өршөөл үзүүлэх тухай” Монголд Улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтанг ял эдлэхээс чөлөөлж болно гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334.1-д өршөөл үзүүлж, ялаас хугацааны өмнө суллах тухай заалт бий боловч өршөөл үзүүлж, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай заалт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24, 208, 248 дугаар зүйлүүдэд

хараахан хуульчлагдаагүй байна.

Насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн шинжтэй арга хэмжээ хэрэглэх нөхцөл, журам эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 10 дугаар хэсгийн 42, 43 дугаар бүлэгт байхгүй байна. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлд заасан боловч энэ үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заагаагүй байна.

Энэ бүх бодит байдлаас дүгнэлт хийхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг боловсруулах, батлах үед Эрүүгийн хуультай нийцүүлэх талаар хууль тогтоогч сул анхаарсан нь харагдаж байна.

а/ Дээр дурдсан тулгамдсан асуудлууд нь юуны өмнө Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим хэм хэмжээг боловсронгуй болгох, хийдлүүдийг арилгах, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг Эрүүгийн хуультай чанд нийцүүлэх;

б/ Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилт, хэрэглэхэд учирч буй маргаантай асуудал, бэрхшээлийн талаар хууль хэрэглэж буй шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нарын саналыг асуулгаар авч, хуулийг боловсронгуй болгоход харгалзах

в/ Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын агуулгыг зөв ойлгоогүйгээс буруу хэрэглэхэд хүрч байна. Иймд Улсын дээд шүүх дээр дурдсан хуулиудын хэм хэмжээг нэн даруй албан ёсоор тайлбарлах замаар нэг мөр ойлгож хэрэглэх нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна.

## ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРАХ ОЮУН САНААНЫ ГЭМ ХОРЫН АСУУДАЛ



ХЗУТ-ийн эрдэм  
шинжилгээний ажилтан  
Ц.ОДГЭРЭЛ

**Х**үний эрх, эрх чөлөө хэмээх хөндлөнгийн сөрөг нөлөөлөлд өртөмтгий баялгийн хамгаалалтын хүрээ нь нийгмийн харилцааны салбар, хэсэг бүрт хүрч үйлчлэхүйц нарийн зохицуулалттай байх ёстой.

Өдрөөс өдөрт шинэ харилцаа үүсэж байдаг нийгмийн амьдралын онцлогоос хамаарч хүний эрх, эрх чөлөөг хуулийн хүрээнд бүрэн хамгаалахад бодит болон субъектив хүчин зүйлийн элдэв саад бэрхшээл, таагүй нөлөөлөл тулгарсаар байдаг. Эдгээрийн нэг нь эрүүгийн гэмт хэрэг юм. Манай улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж заасан ба үүнээс хүний эрх, эрх чөлөөтэй шууд

холбоотой хэсгийг салган авч тайлбарлахыг оролдъя.

Тухайн тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, бодит болон сэтгэл зүйн хохирол учруулсан байдал нь уг үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг мөн эсэхийг тодорхойлох нэг шалгуур болдог. Практикт хохирлын бодит хэлбэрийг илүүд үзэж тооцон хохирол нөхөн төлүүлэх арга хэмжээг түлхүү байдлаар авч хэрэгжүүлдэг боловч түүний цаана бодит бус, мөнгөний нэгжээр шууд илэрхийлэхэд төвөгтэй сэтгэл зүйн хохирол учирч үлддэг билээ. Энэ бол гэмт хэргийн улмаас үүсэж буй бодит бус хохирлын тухай асуудал юм.

Бодит бус хохирол нь дан ганц эрүүгийн гэмт хэргийн хувьд ч бус хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, гэмт хэргийн шинж чанаргүй бусад үйлдэл, эс үйлдэхүйн үед мөн үүсэж байдаг бөгөөд үүнийг шүүх иргэний журмаар хянан шийдвэрлэж буй практик сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа нь эрх зүйн харилцаанд гарч буй эерэг үзүүлэлт гэж хэлж болох юмаа.

Манай эрх зүйн шинжлэх ухаан бодит бус хохирол байдаг болохыг нэгэнт хүлээн хүлээн зөвшөөрч хуульчлан шүүхээр шийдвэрлэх болсон энэ үед уг хохирлыг чухам эрх зүйн ямар зөрчлийн үед тооцож байх,

ямар арга хэрэглэн хохирлын үнэлгээг гаргах гэх мэтчилэн дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэх цаг нэгэнт болсон гэж үзэж байна.

Нэр төр сэргээх асуудлыг үүний нэг илрэл гэж үзэж байна.

Эрүүгийн гэмт хэргийн улмаас хохирогч болон түүний ойр дотны хүмүүс сэтгэл зүйн хувьд таагүй нөлөөлөлд автаж, түүнээс улбаалан сэтгэцийн янз бүрийн хямралд орох, хөдөлмөрийн бүтээмж буурах, тасалдах, эрүүл мэнд муудах зэрэг сөрөг үзэгдлүүд илрэх магадлал маш өндөр байдаг болох нь судалгааны дүнгээс харагддаг.

Гэхдээ үүсэж гарч болзошгүй сөрөг үр дагаврыг бүгдийг тооцон хохирол хэмээн барагдуулах нь биелэхэд бэрхшээлтэй учир энэ талаар оновчтой хуульчлан зөв үнэлэх явдал ихээхэн ач холбогдолтой байна. Мөн энэ байдлыг төлөвшүүлэн тогтооход бусад орны жишиг, дотоодын эрх зүйн харилцааны зохицуулалт, тэдгээрийг хэрэгжүүлэгч албан тушаалтны мэдлэг, чадвар маш чухал юм.

Нийгмийн сэтгэл зүйн хувьд ийм төрлийн эрх зүйн зохицуулалт гарч ирэх нөхцөл бүрдсэн нь мөн судалгаанаас харагдаж байсан.



Гэмт хэргийн улмаас хүнд бодит бус хохирол хэрхэн учирч байдаг талаар судлахад ялангуяа хүний эрх, эрх чөлөөнд халдсан гэмт хэргийн улмаас хүнд бодит бус хохирол ихээхэн учирч байдаг ба Монголын ард түмний уламжлалт зан заншил, ойр дотны хүндээ хандах сэтгэл нь үүнд ихээр өртөх нэг үндэслэл болж байдаг. Энэ нь бидний хамтаар аж төрөх ёстой холбоотой болов уу. Эхний ээлжинд гэмт хэргийн улмаас учирсан бодит бус хохирлыг онц хүнд, хүнд гэмт хэрэгт хохирогч болсон хүн, түүний ойрын хамааралтай хүнд хамаатуулан тооцож арилгуулж байхаар хуульчлах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийн хүнийг санаатай алах гэмт хэрэгт хохирогч болсон хүн байа гэж бодъё. Гэр бүлийн хэн нэгнийгээ хүний гарт зэрлэгээр хорлуулсан хүн монгол сэтгэлгээгээр бодоход хэсэг хугацааны турш хэвийн сэтгэл зүйтэй байж чадахгүй байх аа. Өнөөгийн практикт хохирсон буюу амь үрэгдсэн хүнийг оршуулахад гарсан зардлыг л арай ядан гаргуулж буй нь үнэхээр байж боломгүй зүйл мэт. Тухайн хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон этгээдийн мөнгө, эд хөрөнгийг тусгай ажиллагаагаар илрүүлэн тогтоож хохирогчийг оршуулахтай холбоотой зардал болон түүний ард оюун санааны хүнд дарамтад үлдсэн гэр бүлийн гишүүн, хуульд заасан ойрын төрөл садны хүмүүст тодорхой шатлалаар сэтгэл зүйн хохирол арилгах нь тэднийг эрүүл мэндээ хамгаалуулах эрхээр хангаж

байна гэж ойлгож болох юм. Хүн байгалийн бусад амьтнаас хэл, сэтгэхүйгээр ялгаатай байснаар хөгжиж өнөөгийн байдалд хүрч байгааг эрдэмтэд нэгэнт нотолсон бөгөөд дээрх хоёр үзүүлэлтийн нэг болох сэтгэхүй нь эрүүл, хэвийн байж түүний дараагийн амьдралын өөдрөг төсөөлөл бий болно. Хэн нэг балмад хүний үйлдлээс болж хүний амь үрэгдэж, гэр бүлийн болон ойр дотны хүмүүс сэтгэл санаагаар хохирон үлдэнэ гэдэг нь хүний эрх, эрх чөлөөнд шууд халдаж байна гэсэн үг юм. Үнэлж, хэмжиж болох бодит хохирол, зардлыг тогтоон гэм буруутай этгээдээс гаргуулж байгаагаар адил хүний оюун санааны хохирлыг шинжлэх ухааны үндэслэлтэй аргаар тогтоон үнэлж тухайн хүнийг "хэвийн сэтгэл зүй"-д оруулах нөлөөлөл үзүүлэх арга зам эрэлхийлэх нь нийгмийн харилцаанаас урган гарч байна. Ийм байдлаар анхаарч хандах зүй ёсны шаардлага гарч буй хэд хэдэн гэмт хэрэг Эрүүгийн хуульд байгаа нь харагдаж байна. Дурдвал, Эрүүгийн хуулийн 91 /хүнийг санаатай алах/, 126 /хүчиндэх/, 112 /хүн барьцаалах/, 100 /гарчлаах/, 96 /бусдын бие, махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/ дугаар зүйл.

**Х**үний сэтгэл санаа тайван бус, шаналгаа, зовиуртай байснаас болж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, хөдөлмөрийн бүтээмж үр дүнгүй байх зэрэг үр дагавар үргэлжлэх аюултай юм. Оюун санааны гэм байгаа эсэхийг шинжлэн тогтоож, үүсээд байгаа нөхцөл байдлыг ямар хугацаанд авч үзэх, түүнийг арилгахын тулд ямар арга

хэмжээ авч болох, эдгээрийг мөнгөн үнэлэмжээр үнэлэх хэмжээ, үндэслэл зэргийг энэ чиглэлээр судалгаа явуулдаг шинжлэх ухааны байгууллага, мэргэжлийн эмч, мэргэжилтэн гаргаж болох юм.

Миний бодлоор, хохирогчийн сэтгэл зүйд нөлөөлөх боломжийг судалж, түүнийг хэрэгжүүлэхийн тулд ямар хэмжээний мөнгөн хөрөнгө зарцуулагдахыг тооцох аргачлал гаргаж мөрдөх нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ үйл ажиллагааг эрх зүйн харилцаанд хэвшүүлэхийн тулд гэмт хэргийн улмаас тухайн этгээдэд бий болсон "сэтгэл зүйн байдал"-ыг шинжлэх, үнэлж дүгнэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд зохих газраас эрх олгож, тэдний дүгнэлтийг эрүүгийн хэрэгт нотлох баримт болгох шаардлагатай байна. Хүний сэтгэл зүйн хэвийн байдал, түүний өөрчлөлт, үр дагаврыг шинжлэх ухааны үүднээс судлах чадвар бүхий эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн нар манай улсад эртнээс бэлтгэгдсэн гэхэд хэн ч эргэлзэхгүй байх аа. Манайд одоогоор сэтгэцийн байдал шалгуулах процесс ажиллагаа явагддаг ба энэ нь зөвхөн тухайн /ихэвчлэн гэмт хэрэгт холбогдсон хүн/ хүнийг эрх зүйн чадвар, чадамжтай эсэхэд дүгнэлт өгөх зорилготой байна.

Ийнхүү хийгдэж буй ажиллагаандаа түшиглэн оюун санааны гэм хорыг тогтоох шинжилгээ хийх бүрэн боломжтой байна.



## Хүүхэд, эмэгтэйчүүдийг хил дамжуулан худалдах асуудал ба хүний эрх



Хүний эрх, хөгжил төвийн  
тэргүүн Г.УРАНЦООЖ

### Хүүхэд, эмэгтэйчүүдийг

худалдах гэмт хэрэг нь хууль хэрэгжүүлэх асуудлаар олон улсын, хамтын ажиллагааг шаарддаг. Монгол Улс нь НҮБ-ын гишүүн, түүнчлэн хүний эрхийн 30 гаруй гэрээнд нэгдсэнийхээ хувьд хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар үүрэг, хариуцлага хүлээсэн юм.

Монгол Улсын соёрхон баталсан болон батлаагүй хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдах явдалтай тэмцэхтэй холбогдсон хүний эрхийн гэрээнүүдэд дүн шинжилгээ хийлээ.

“НҮБ-ын Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тухай Конвенц (2000)”-ын “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг, худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Нэмэлт протокол” (цаашид “Палермогийн протокол” гэх) болон “Хүүхдийн эрхийн конвенц”-ын “Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуун явдалд татагдахаас

хамгаалах тухай Нэмэлт протокол (2000) (цаашид “ХЭК-ын Нэмэлт протокол” гэх) хоёрын хооронд тодорхой хамаарал байна.

Палермогийн протокол нь хүн худалдах гэмт хэргийн асуудлыг тал бүрээс нь авч үзсэн олон улсын анхны хэлэлцээр юм. Мөн “хүн худалдах” гэсэн нэр томъёог тодорхойлсон анхны баримт бичиг болно. Энэ протоколоор хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхийн тулд гэмт этгээдүүдийг шийтгэх, хохирогчийг хамгаалах олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай байгааг цохон тэмдэглэсэн.

ХЭК-ын Нэмэлт протокол нь хууль болон хуулийн хэрэгжилтэд, мөн хүүхэд төвтэй шүүх ажиллагаа бий болгохын төлөө ихээхэн ахиц дэвшил гаргахыг уриалсан байна. Үүгээр “хүүхдийг худалдах”, “хүүхдийн биеийг үнэлүүлэх” болон “хүүхдийг садар самуун явдалд уруу татах” зэргийг тусгайлан тодорхойлж өгсөн байна.

Үүнээс гадна Хүүхдийн эрхийн Конвенц (ХЭК), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (ЭЯГБХУЖ) зэрэгт хүн худалдах явдлыг гэмт хэрэг хэмээж хүн худалдах, бэлгийн мөлжлөг, биеийг нь үнэлүүлэх, албадан хөдөл-мөрлүүлэх, хууль бусаар хүүхэд үрчлэх болон боолчлолыг хориглож, улс орнуудын төр гэмт хэргийн шууд болон шууд бус хохирогчын эрхийг хангах, олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо өөрчлөхийг заасан.

### ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЗАРИМ ЗААЛТ

1. Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдах нь хүний эрхийн ноцтой гэмт хэрэг мөн.

- Хүний эрхийг зөрчих нь хүн худалдах гэмт хэргийн шалтгаан, үр дагавар юм. Тийм учраас аливаа арга хэмжээний гол цөм нь хүний бүх эрхийг хамгаалах асуудал байна. (Хүний эрх ба хүнийг худалдах асуудалтай холбогдсон ерөнхий удирдамж, шаардлагатай зарчим, НҮБ-ын ХЭДКГ, 2002 он)

- Гишүүн улсууд хүн худалдах явдлаас, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд онцгой анхаарал хандуулан, урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар хариуцлага хүлээнэ. (Палермогийн протокол, 2 дугаар зүйл)

Хүний эрхийн олон улсын гэрээнд тусгагдсан эрх, үүрэг, хариуцлага нь энэхүү протоколын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхгүй. (Хүний эрх ба хүн худалдах асуудалтай холбогдсон ерөнхий удирдамж, зарчим, НҮБ-ын ХЭДКГ)

- Аливаа улс хүн худалдах явдлыг хориглох, энэ гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах ёстой. АНУ-ын Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах Акт, 1999 он, (Бүлэг.8 (а-1))

2. Хүн худалдах гэмт хэргийн тодорхойлолт

- “Хүн худалдах” гэдэг нь мөлжлөгийн зорилгоор заналхийлэх, хүч хэрэглэх, дарамтлах, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, асрамж хяналтад нь байдаг хүнийг ашиглахын тулд хариуцагч

## Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх талаарх олон улсын гэрээний зарим заалт

этгээдэд нь мөнгөн болон бусад урамшуулал олгох, хүнийг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авахыг; "Мөлжлөг" гэдэг нь, бусдын биеийг үнэлүүлж мөлжих болон бусад хэлбэрийн бэлгийн мөлжлөгө, албадан хөдөлмөр болон үйлчилгээ, боолчлол, боолчлолтой адил төрлийн үйл ажиллагаа, бусдын эрхшээлд байлгах болон эд эрхтэнг нь салгахыг хэлнэ. *(Цаашид Палермогийн протоколын 3 дугаар зүйл)*

"Секс худалдаа" гэдэг нь сексийн худалдааны зорилгоор хүнийг худалдах, худалдан авах, элсүүлэх, орогнуулах, тээвэрлэх, шилжүүлэх, хүлээн авахыг хэлнэ. "Хүн худалдах хүнд хэлбэр" гэдгийг албадан болон хүчээр, хуурч мэхлэх замаар 18 нас хүрээгүй хүнийг худалдааны секст хамруулах, хүчээр эрхшээлдээ байлгах, реопаге, эсвэл боолчлох ба боолчлолтой төстэй бүх хэлбэрээр ашиглах зорилгоор худалдах, худалдан авах, элсүүлэх, орогнуулах, тээвэрлэхийг хамруулан ойлгоно. *(АНУ-ын Хүн худалдах хэргийн хохирогчдыг хамгаалах Акт, Бүлэг 3 (1) ба (2), 1999 он)*

### 3. Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах

Гишүүн орнууд шүүх хурлыг нууцаар явуулж, хүн худалдах хэргийн хохирогчдын хувийн нууц, онцлог байдлыг нь хамгаална. *(Палермогийн протокол, 6 дугаар зүйл)*

Гишүүн орнууд нутагт нь буцаах асуудал шийдэгдэх хүртэл хүлээгдэж байгаа худалдагдсан ядуу хүмүүсийг түр хугацаанд орогнуулах, халамж үзүүлэх талаар зохих арга хэмжээ авах шаардлагатай. *(Хүн худалдах, бусдын биеийг үнэлүүлж мөлжих явдлыг таслан зогсоох тухай конвенц, 19 дүгээр зүйл, 1 дүгээр хэсэг)*

### 3. Эрх зүйн хүрээ хангалттай байх нь

Гишүүн орнууд үндэсний хууль тогтоомждоо хүн худалдах явдал, хүн худалдахаар завдах болон хамтран оролцох нь гэмт хэрэг мөн болохыг тусгах талаар хууль зүйн болон бусад арга хэмжээг авна. *(Палермогийн протокол, 5 дугаар зүйл)*

Гишүүн орнууд бусдын биеийг үнэлүүлэхэд зуучилсан, энэ зорилгоор мөлжсөн, мөн төднийг орогнуулах байр бэлдсэн, эзэмшиж байгаа, мэдсээр байж санхүүжүүлсэн хүмүүсийг шийтгэх арга хэмжээ авна. *(Хүн худалдах, бусдын биеийг үнэлүүлж мөлжих явдлыг таслан зогсоох тухай конвенц, 2 дугаар зүйл)*

Аливаа улс гэмт хэргийн аюултай шинж чанарыг сайтар харгалзан үзэж тохиромжтой ял шийтгэлийг оногдуулна. *(АНУ-ын Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах Акт, 1999 он, Бүлэг 8а-3)*

### 4. Хууль сахиулах механизмыг бэхжүүлэх нь

Хууль сахиулах байгууллага, цагаачлалын асуудал хариуцсан болон бусад холбогдох төрийн байгууллага нь өөрсдийн дотоодын хууль тогтоомжтой холбогдолтой асуудлаар мэдээлэл солилцон хамтран ажилллах бөгөөд энэ нь хүнийг элсүүлэх арга барил, тээвэрлэх зам, хүн худалдах хэрэгт оролцсон хүн, бүлгүүдийн хоорондын харилцаа холбоог тодорхойлох болон энэ талаар боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Гишүүн орнууд хүн худалдах явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хууль сахиулагч, цагаачлалын албаны болон бусад албан тушаалтнуудад сургалт явуулах буюу сургалтыг улам бэхжүүлнэ. ... ТББ-ууд болон бусад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ.

*(Палермогийн протокол, 10 дугаар зүйл)*

### 5. Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь

#### - Эрэлтийг бууруулах

Хүн худалдахад хүргэдэг, хүнийг мөлжих, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг мөлжих бүхий л хэлбэрийг даамжруулж байгаа эрэлтийг бууруулах зорилгоор эрх зүйн, боловсролын, нийгмийн болон соёлын шаардлагатай арга хэмжээ авах.

#### - Шалтгааныг арилгах

Ядуурал, буурай хөгжил, боломж дутуу байх зэрэг хүн худалдах гэмт хэрэгт өртөмтгий болгож байгаа хүчин зүйлсийг багасгах бүхий л арга хэмжээг авах, үүнд хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг оруулна. Үр нөлөөтэй бодлого, хөтөлбөр боловсруулах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэх. *(9 дүгээр зүйл. Палермогийн протокол)*

Хүмүүнлэгийн бус гадаад тусламж, туслалцаа үзүүлэхгүй байх

АНУ нь хүн худалдах гэмт хэргийг багасгах зорилгоор ... наад захын стандартыг хангаагүй улс орнуудад хүмүүнлэгийн бус туслалцаа үзүүлэхгүй байх бодлого баримтална. *(АНУ-ын Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах Акт, 1999 он, Бүлэг 8а (14))*

### 6. Хүүхэд худалдахын эсрэг

Гишүүн орнууд хүүхдийг хууль бусаар шилжүүлэх буюу гадаадаас эх оронд нь буцаахгүй байхтай тэмцэх талаар арга хэмжээ авна. *(Хүүхдийн Эрхийн Конвенц (ХЭК), 11 дүгээр зүйл)*

Хүүхдийг улс хооронд үрчлэх үед тухайн хүүхэд зохих хамгаалалт, стандартыг эдлэх

эрхийг Гишүүн орнууд баталгаажуулна. Энэ үед түүнийг төвхнүүлэн суурьшуулах явдал нь үүнтэй холбоотой хүмүүст эдийн засгийн зүй бус ашиг хонжоо олоход хүргэхгүй байхыг баталгаажуулна. (ХЭК), 21 дүгээр зүйл)

◆ Гишүүн орнууд хүүхэд бол эдийн засгийн мөлжлөгөөс болон түүний эрүүл мэндэд хор аюул учруулах буюу боловсрол олоход нь саад болох, эсвэл түүний эрүүл мэндэд болон бие бялдрын, оюун ухааны, оюуны ёс суртахууны хийгээд нийгмийн хөгжилд хор уршиг учруулж болзошгүй аливаа ажил эрхлэх явдлаас хамгаалагдах эрхтэйг хүлээн зөвшөөрнө. (ХЭК), 32 дугаар зүйл)

◆ Гишүүн орнууд хүүхдийг хулгайлах, худалдах буюу тэднийг худалдах зорилгоор хууль бусаар хил нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. (ХЭК), 35 дугаар зүйл)

◆ Гишүүн орнууд цагаач иргэд болон гадаад руу шилжин явж байгаа хүмүүсийг, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг ирж байгаа, гадагш явж байгаа газар нь болон замын туршид хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авна. (Хүн худалдах, бусдын биеийг үнэлүүлж мөлжих явдлыг таслан зогсоох тухай конвенц, 17 дугаар зүйл)

◆ Гишүүн орнууд хүүхэд худалдах, хүүхдийн биеийг үнэлүүлэх, садар самуунд ашиглахыг хориглоно. (ХЭК-ын Нэмэлт протокол, 1 дүгээр зүйл)

◆ Гишүүн улс бүр хүүхдийг бэлэгсийн мөлжлөгөөр ашиглах, ашиг орлого олох, хүүхдийг албадан хөдөлмөр эрлүүлэх, хүүхдийн биеийг нь үнэлүүлэх, садар самуунд ашиглах зорилгоор хүүхдийг зарах, өгөх, дамжуулах, хүлээн авах явдлыг өөрсдийн эрүүгийн хууль тогтоомжоороо бүрэн зохицуулна. (ХЭК-ийн Нэмэлт протокол, 3 дугаар зүйл)

◆ Гишүүн улсууд эрүүгийн байцаан шийггэх үйл ажиллагааны бүхий л үе шатанд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна.

(ХЭЗ-ын Нэмэлт протокол, 8.1 дүгээр зүйл)

Гишүүн орон бүр хүүхдийг худалдах, хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглахыг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлнэ. (Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай конвенц (182 дугаар конвенц), 1.3 дугаар зүйл)

◆ Хүүхдийг эдийн засаг, нийгмийн дарлал, мөлжлөгөөс хамгаална. (Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай олон улсын Пакт (ЭЗНСЭОУП), 10.3 дугаар зүйл)

◆ Гишүүн орнууд хүүхдийг болон тэдний хөдөлмөрийг мөлжих зорилгоор эцэг эх, асран хамгаалагчаас нь хүүхдийг урамшуулалтайгаар болон урамшуулалгүйгээр өөр бусдад шилжүүлэн өгөх аливаа үйлдэл, зохион байгуулалтыг устгах бүхий л үйл ажиллагаа, шаардлагатай хууль зүйн болон бусад арга хэмжээг авна. (Боолчлол, боолын худалдаа болон боолчлолттой адил төрлийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг устгах тухай нэмэлт конвенц (1956), 1 дүгээр зүйл)

◆ Аливаа улс хүүхдийг санаатайгаар сексийн худалдаанд ашигласан аливаа үйлдэлд хамгийн хүнд хэлбэрийн гэмт хэргийнх нь хувьд тохирох ял шийтгэл оногдуулна. (АНУ-ын Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг, хамгаалах Акт, 1999 он, Бүлэг 8 (а-3))

#### 7. Эмэгтэйчүүдийг худалдахаас сэргийлэх

◆ Оролцогч улсууд нь эмэгтэйчүүдийг худалдах тэднийг садар самуун явдалд ашиглан мөлжих, бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд бүхий л зохистой арга хэмжээ авна. (ЭЯГБХУК, 6 дугаар зүйл)

◆ Гишүүн орнууд ажил хайж байгаа хүмүүсийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийн биеийг үнэлүүлэхээс сэргийлэх зорилгоор

ажил олгогч байгууллагуудыг хяналтандаа байлгах шаардлагатай арга хэмжээг авна. (Хүн худалдах, бусдын биеийг үнэлүүлж мөлжих явдлыг таслан зогсоох тухай конвенц, 20 дугаар зүйл)

#### 8. Боолчлол болон боолчлолтой төстэй заншилыг хориглох нь

◆ Хэнийг ч боолчлол буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй, боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно. (Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ), 4 дүгээр зүйл)

◆ Хэнийг ч боолчлолын байдалд байлгаж болохгүй, боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно. (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП), 8.1 дүгээр зүйл)

#### 9. Хуурамч гэрлэлт

◆ Эрэгтэй, эмэгтэй хоёр гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдэлнэ. Гэрлэлт хоёр хосын чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөл дээр үндэслэнэ. (ХЭТТ; 6 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП), 10.1 дүгээр зүйл, ИУТЭОУП; 23.3 дугаар зүйл, ЭЯГБХУК), 6.1 дүгээр зүйл)

#### 10. Хүний аюулгүй байдал

◆ Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй. (ХЭТТ), 3 дугаар зүйл)

◆ Хүн бүр эрх чөлөөтэй байх болон халдашгүй дархан байх эрхтэй. ... Хуулиар тогтоосон үндэслэл, журмаас бусад аль ч тохиолдолд хэнийг ч хорьж болохгүй. (ИУТЭОУП, 9.1 дүгээр зүйл)

#### 11. Эрүү шүүлтийн эсрэг

◆ Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь

доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно. (ХЭТТ; 7 дугаар зүйл, ИУТЭОУП, 5 дугаар зүйл.)

◆ Нэг ч хүүхдийг тамлан зовоож, хэрцгий харгислах, хүний ёсноос гадуур харьцах, нэр төрийг нь гутааж харьцах буюу шийтгэхгүй. (ХЭК), 37 дугаар зүйл.)

### 12. Ялгаварлан гадуурхахын эсрэг

◆ Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүйгээр адилхан эдлэх ёстой. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. (ХЭТТ), 2 ба 7 дугаар зүйл)

◆ Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх үүрэгтэй. (ИУТЭОУП, 3 дугаар зүйл)

◆ Энэ Протоколд заасан арга хэмжээг авахдаа хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг ялгаварлан гадуурхахгүй. Эдгээр арга хэмжээг авахдаа олон улсын төвшинд хүлээн зөвшөөрсөн ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг дагаж мөрдөнө. (Палермогийн протокол, 14 дүгээр зүйл)

### 13. Орогнол хайх эрх

◆ Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж өөр улс оронд орогнох боломжийг эрэлхийлэх, тийнхүү орогнох эрхтэй. (ХЭТТ, 14 дүгээр зүйл)

Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдийг тэдгээрийн амьдрал, эрх чөлөөнд арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, нийгмийн тодорхой бүлгийн гишүүн буюу улс төрийн үзэл бодлын улмаас аюул занал нүүрлэсэн орны хил рүү ямар ч байдлаар албадан гаргах буюу буцааж болохгүй. (1951 оны Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенц, 33 дугаар зүйл)

### 14. Зорчих эрх

◆ Гишүүн орнууд хүний чөлөөтэй шилжин суурьших

<sup>1</sup> Sex trafficking

эрхийг зөрчилгүйгээр хүн худалдах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх шаардлагыг хангах үүднээс хилийн шалган нэвтрүүлэх албыг бэхжүүлнэ. (Палермогийн протокол, 11.1 дүгээр зүйл)

### 15. Эрүүл байх эрх

◆ Хүн бүр хоол хүнс, хувцас, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм, ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхнийхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. (ХЭТТ, 25 дугаар зүйл.)

◆ Хүн бүр бие бялдрын болон оюуны талаар дээд зэргийн эрүүл байх эрхтэй. (ИУТЭОУП, 12 дугаар зүйл)

◆ Оролцогч улсууд хүүхдийн дээд зэргийн эрүүл байх эрх, эрүүл мэндийг нөхөн сэргээх, өвчин анагаах хэрэгслийг ашиглах хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө. (ХЭК, 24 дүгээр зүйл)

Дээр дурдсан бүх гэрээ нь төрд хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд дараах арга хэмжээ авах үүрэг хүлээлгэдэг. Үүнд:

◆ Хүн худалдах явдлыг гэмт хэрэг болохыг тусгасан шаардлагатай хууль тогтоомжийг батлан гаргах, нэмж өөрчлөх, гэмт этгээдэд хүнд хэлбэрийн шийтгэл оногдуулах гэмт хэрэгтэнг шилжүүлэх эрх олгох;

◆ Хүн худалдах гэмт хэргийн улмаас хохирсон бүх хохирогчдыг тусгайлан хамгаалах (хохирогчийн хувийн нууцийг хамгаалах, шүүн ажиллагаанд хохирогчийг оролцуулах, хохирогчдод материаллаг, сэтгэл зүйн болон нийгэмшүүлэх туслалцааг үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах, нөхөн төлбөр, оршин суух зөвшөөрөл олгох, эх оронд нь сайн дураар нь буцаах, дахин хохирохоос нь хамгаалах гэх мэт);

◆ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, (хүн худалдах гэмт хэрэг гарах үндэс

шалгааныг бууруулах, таслан зогсоох, хүн худалдахад хүргэдэг хүнийг мөлжих, хэлбэрийг даамжруулж байгаа эрэлтийг арилгах асуудлаар бүхий л шаардлагатай нийгэм, эдийн засгийн арга хэмжээг авах гэх мэт);

◆ Хил, хилийн боомтын асуудлаар шаардлагатай арга хэмжээг авч явуулах, хил, гаалийг шалгах, төмөр зам, усан боомт, онгоцны буудал, автобусны зогсоолыг хянах, худалдаа арилжааны тээврийн хэрэгслийг энэ гэмт хэрэг үйлдэхэд ашиглахаас сэргийлэх, худалдааны тээврийн үйлчилгээ болон бусад тээврийн компаниуд бүх зорчигчдоо замын шаардлагатай баримт бичигтэй яваа эсэхийг шалгаж байхыг үүрэг болгох);

◆ Бусад улс орнуудтай хамтран ажиллах, хилийн шалган нэвтрүүлэх газруудын хоорондын шууд хамтын ажиллагааны сувгийг бий болгох, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх, хохи-рогчийг авран гаргах, эх оронд нь буцаах асуудлаар хамтран ажиллах);

◆ Хууль сахиулах байгууллагуудыг чадавхийг сайжруулах, (хууль сахиулах байгууллагуудад тусгай сургалт явуулах, мэдээлэл солилцох орчинг бүрдүүлэх);

◆ Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдын хүний эрхийг хангах, хүндэтгэх;

◆ Хүүхдийн ба жендэрийн мэдрэмжтэй хандлагыг бий болгох, (мөрдөн байцаах, хэргийг шүүх болон хохирогчийг аврах, эх оронд нь буцаах, нийгэмшүүлэх үйл ажиллагаанд баримтална.



## Ардчилсан нийгэмд өмгөөллийн эзлэх байр суурь

Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч **Б.ГАНБААТАР**

Эдийн засгийн шинэчлэлийн гол суурь нь эрх зүйн тохирох орчин болох тухай судлаачид тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл эрх зүйн тогтолцоо эдийн засаг, нийгмийн хөгжилд ямар үүрэг гүйцэтгэж болохыг харж болно гэсэн үг. Зарим судлаачдын санал бодлоо илэрхийлдгээр намын хүнд суртал, төр засаг хоёр холилцон, хуульд нэвтрэх зайгүй тийм шинж чанар Ленинист тогтолцооны онцлог гэж тайлбарладаг байв.

Манай улс 1990-ээд онд засаг төр нь хуульд биш, намын үүрэг даалгаварт захирагддаг байсан нийгмийн тогтолцоог халж, төр нь хуульд захирагддаг, эс захирагдвал огцордог эрх зүйт төрийн зарчмыг хөгжүүлснээр ардчилсан нийгмийг эргэлт буцалтгүй сонгосон орны нэг билээ.

Эрх мэдэл, хүчний тэнцвэр, хүний эрх, эрх чөлөөний хамгаалалт, нээлттэй нийгмийн баталгааг 1992 оны шинэ Үндсэн хууль, түүний үзэл санаатай холбон тайлбарлаж болно. Ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрхийг хамгаалах, эрх зүйт төрийг сонгодог утгаар нь

төлөвшүүлэхэд хууль зүйн мэргэжлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хувийн өмгөөлөл, хууль зүйн товчоодын хөгжил асар их үүрэгтэй болох нь өндөр хөгжилтэй улс орны хувьд нэгэнт тогтсон жишиг ажээ.

Шинэ Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1994 онд Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль батлагдаж, хувийн өмгөөллийн эрх зүйн орчны анхны үндэс суурь тавигдсан юм. Энэ бол ардчилсан нийгмийг эх барих үед түүнтэй хамт төрж, өсч бойжиж, Монгол Улсад өмгөөллийн үйл ажиллагааны нэн шинэ түүхийн хуудсыг нээсэн нэгэн цаг үе гэж ойлгож болох юм. Өмнөх тогтолцооны үед өмгөөлөл, хууль зүйн туслалцаа, өмгөөлөгчийн эрх хэмжээ, ажлын хүрээ хязгаар нь эрүүгийн бацаан шийтгэх ажиллагаанд урьдчилсан мөрдөн байцаалт дуусч, хэргийг яллагдагчид танилцуулах үеэс оролцох байдлаар зөвхөн эрүүгийн хэрэгт өмгөөлөл явуулах; иргэний шүүх хуралдаанд бараг оролцдоггүй шахам ийм л дүр зурагтай байв.

Гэтэл өмгөөлөгч нь жинхэнэ утгаараа хуульч мэргэжил анх үүсэхэд буй болсон, эмчтэй ямагт жишин үздэг хүмүүнлэг мэргэжлийн нэг төрөл болон хөгжиж ирсэн өнө эртний түүхтэй ажээ. Эдүгээ дэлхийд 4 сая өмгөөлөгч байдгаас 850 мянга нь АНУ-д 450 мянга орчим нь Европын холбооны орнуудад, 400 мянга орчим нь Энэтхэгт, 300 мянга орчим нь Бразилд, ойролцоогоор 2 сая 500 мянга нь бусад улс орнуудад байдаг гэсэн тоо байна. Эрх зүйн шинэтгэлийн үйл явц, нийгмийн өөрчлөлтийг бие даасан, чөлөөт, мэргэжлийн чадвар сайтай өмгөөлөгчгүйгээр төсөөлөхийн аргагүй болсон нь ардчилсан нийгэмд өмгөөллийн эзлэх байр суурь түүний туулсан зам, түүхэн уламжлалт хөгжилтэй салшгүй холбоотой юм.

Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хууль болон ёс зүйн шаардлагад нийцүүлэн бүхий л арга хэрэгслээр тууштай хамгаалах үүрэгтэй. Нэгэнтээ Оросын нэрт өмгөөлөгч А.Ф.Кон хэлэхдээ “Өмгөөлөл

бол үнэний төлөө тэмцэл юм. Үнэнийг нөмрөхөөр айсууд худалтай тэмцэх нь бидний мэргэжлийн ажил, үүрэг мөн” гэжээ. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагатай бөгөөд алдаж болохгүй энэ хүндтэй үүргийг нэр төртэй биелүүлэх үндсийн үндэс нь өмгөөлөгч хүний хувьд хууль зүйн мэдлэг боловсрол, мэргэжлийн өндөр чадвар эзэмшихээс гадна ёс зүйн хэм хэмжээгээ хатуу сахих явдал юм.

Монгол Улсад өнөөдөр 800 орчим өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас 500 гаруй өмгөөлөгч, 42 хууль зүйн товчоо нийслэлд үйл ажиллагаа явуулж байна. Өмгөөлөгчийн нарийн чимхлүүр, ур ухаан шаардсан ярвигтай ажлын арга зүйг системтэй олгох, хүний эрх, төрийн хууль тогтоомжийг сурталчлах, олон түмний хүртээл бобох, тэдний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх, хууль зүйн нарийн мэргэжлийн туслалцааг хүмүүст хүссэн үед нь цаг алдалгүй өгдөг байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход Монголын Өмгөөлөгчдийн Холбоо их үүрэг гүйцэтгэх учиртай.

**Ө**мгөөлөл, хууль зүйн туслалцааны цар хүрээ улам бүр өргөжиж байна. Хууль зүйн туслалцааны хэв маяг нь зөвхөн эрүүгийн хэрэгт төдийгүй, иргэний маргаан, эрх зүйн эрсдлээс хамгаалахад өргөн цар хүрээтэй ажиллах шаардлага бий болж

байна. Үүний нотолгоо нь ардчилсан нийгэмд эрх зүйн тогтолцоо эдийн засгийн хөгжилд ямар үүрэг гүйцэтгэдгийг авч үзэж болох юм. Эдийн засгийн хөгжил нь бидний ойлгож ирснээр нийгэм дэх хэсэг бүлэг хүмүүст баялаг хуримтлагдана гэхээсээ илүү нийгэм дэхь иргэдийн амьжиргааны төвшин дээшлэх үндэс гэж үздэг. Амьжиргааны төвшин дээшилснээр өндөр цалин бүхий ажлын байр, хувцас, хүнс, эрүүл мэнд, боловсрол зэрэгт зарцуулах иргэдийн чадамж дээшлэхийн нэр юм. Эдийн засгийн наад захын энэ мэт энгийн зарчмууд нь хувийн аж ахуйд суурилсан бизнесийг хөгжүүлэх үндэс болдог жамтай. Өндөр хөгжилтэй, ардчилсан нийгэмд бизнес эрхлэгчид үйлчлэх санхүү, хуулийн мэргэжлийн үйлчилгээийг тогтолцоо хэдийнээс төлөвшиж, зах зээлд бэлхнээ болсон байдаг ажээ.

Манайх шиг хөгжиж буй улс орнуудад ч энэ нь хүртээлтэй бөгөөд үүний тулд хууль зүйн бүх салбарын хөгжил нэн шаардлагатай болно. Өөрөөр хэлбэл бизнесийн нарийн ажиллагаанд мэргэшсэн, туршлагажсан хуулийн мэргэжилтэн буюу өмгөөлөгчийг бэлтгэх шаардлагатай.

Дэлхийн эдийн засгийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхахад нийгэм, эдийн засгийн болон эрх зүйн шинэтгэлийн зохистой орчныг бүрдүүлэх явдал хууль тогтоох

байгууллагын үндсэн зорилт мөн. Нийгэмд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагаа ухамсарлан, өсч буй хэрэгцээг хангахад хувийн өмгөөллийн бие даасан, хараат бус байдлыг хангах нь чухал юм.

Хууль тогтоох ажиллагаа нь шүүхэд учирч болох бэрхшээлийг урьдчилан олж харах, нийгмийн харилцааг хуулийн тохирсон зохицуулалтай болгож төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Иргэний, ардчилсан нийгэм нь эрхүйн тогтолцонд суурилсан эдийн засгийн хөгжлөөр тодорхойлогддог ийм цаг үед өмгөөллийн хөгжил, хууль зүйн товчоодын төлөвшил чухал үүрэг гүйцэтгэх нь улам бүр мэдрэгдсээр...



## НОТАРИАТЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Монголын Нотариатчдын танхимын мэдээллийн  
албаны ажилтан П.ОТГОНЖАРГАЛ

**М**онголын Нотариатчдын Танхимын дүрмийн 6 дугаар зүйлд зааснаар Монголын Нотариатчдын Танхимын дэргэдэх мэдээллийн алба нь нийт нотариатчдыг шаардлагатай мэдээлэл, лавлагаа, гарын авлага, бусад материалаар хангаж, нотариатчидтайгаа байнга уялдаа холбоотой хамтран ажиллах үүрэгтэй юм. Энэ үүргийнхээ дагуу Мэдээллийн албаны ажилтнууд нотариатчдад хүргэвэл зохих мэдээ мэдээллийг цаг тухайд нь хүргэж байхаар шамдан ажиллаж байдаг билээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 280 дугаар тусгаар үндсэн дээр Монголын нотариатчдын танхимд одоогийн байдлаар Улаанбаатарт 88, хөдөө орон нутагт 60 нотариатч нэгдэж үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Нотариатч нь нотариатын үйлдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай Нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар, Нотариатын үйлчилгээний хөлс зардлын жишиг болон холбогдох бусад хууль тогтоомж, нотариатын танхимаас хүргүүлж байгаа мэдээлэл, зөвлөмжийн дагуу нэгдсэн нэг ойлголтоор нотариатын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэгтэй.

Иймээс нотариатч хүн хуульд заасны дагуу нотариатын үйлдлийг

мэргэжлийн өндөр төвшинд бие даан, хууль тогтоомжид нийцүүлэн хийх, иргэн, хуулийн этгээдээс эрхээ хэрэгжүүлэх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахад нь үйлчлэх, тэдэнд эрх үүргийг тайлбарлан өгч нотариатын үйлдэл хийснээс үүдэн гарах үр дагаврыг урдчилан сануулж зөвлөгөө өгөх үүргээ ухамсарлан нотариатын үйлдлийг зохих журмын дагуу шаардлага хангасан нөхцөлд гэрчилж байх, гэрчилж байгаа гэрээ, хэлцэл, итгэмжлэл зэргийн утга агуулга хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж байх, иргэдийг хохироож чирэгдүүлэлгүй түргэн шуурхай үйлчилж байх шаардлагатай.

**Нотариатч нарын  
гаргаж байгаа алдаа  
дутагдлыг арилгах  
дараах зөвлөгөөг өгч  
байна**

- Нотариатын үйлдлийг гэрчлэхдээ нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нь Нотариатын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тогтоож, иргэний үнэмлэх, холбогдох бичиг баримтыг тулган харж шалгах зайлшгүй шаардлагатай байдаг. Хэрэв үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх, гадаад паспортод ямар нэг зөрчил илэрвэл нотариатчдын танхимд хандан ерөнхийлөгчийн албан ёсны албан бичгийн дагуу Иргэний бүртгэл, мэдээллийн төвөөс лавлагаа авч шалгуулж болно.

- Нотариатч та бүхнийг тамга, баталгааны тэмдгийнхээ хадгалалт, хамгаалалтыг сайжруулахыг анхааруулж байна. Учир нь нотариатчийн тамга, баталгааны тэмдгийг хуурамчаар хийж, нотариатын үйлдлийг хууль бусаар гэрчлэх явдал 2002-2004 оны хооронд нэлээд олон удаагийн үйлдэл дээр гараад байгаа бөгөөд энэ асуудал нь хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа болно.

“Нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар”-ын 6.1-д “Нотариатч гэрчилсэн бичиг баримт дээр соёмбо бүхий нотариатчийн тамганы дугаарыг тод гаргаж, баталгааны тусгай тэмдгийн дардас дээр өөрийн нэр, гарын үсгийг гаргацтай бичнэ. Энэ шаардлагыг хангаагүй үйлдэл хүчингүйд тооцогдоно” гэж заасан. Иймээс та бүхэн тамганы дугаар, баталгааны тэмдгийн бичилтийг тод дарж, баталгааны тэмдгийн бичээсийг журмын дагуу нэрээ гаргацтай бичин он, сар, өдрөө болон бүртгэлийн дугаараа бичих нь зүйтэй байна.

Таны тамга, баталгааны тэмдгийн дардас элэгдэж муудан тамганы дугаар, баталгааны тэмдэг дээрх бичээс нь тод гарахгүй байгаа бол танхимаас албан бичиг хийлгэн тамга, тэмдгийн үйлдвэрт очиж тамгаа яаралтай солиулахыг сануулж байна.

- Ямар нэг бичиг баримтыг гэрчлэхдээ бичиг баримтын стандартын шаардлага хангасан эсэхийг анхаарах. /А4-ийн тал цаасан дээр гарын



үсгийн баталгаа хийсэн тохиолдол байсан/

- Нотариатын тухай хуулийн 4.3-д "Нотариатын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хавсран эрхэлж байгаа сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон нотариатын үйл ажиллагаа эрхэлж байгаа хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрыг нотариатчийн үүрэг гүйцэтгэгч гэнэ" гэж заасан байдаг. Иймээс гадаад оронд байдаг үл хөдлөх эд хөрөнгө хамтран эзэмшигчдийн зөвшөөрлийг нотариатын үүрэг гүйцэтгэгч болох тухайн оронд оршин суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон Консулын газар эсвэл тухайн орны нотариатчаар гэрчлүүлсэн бичиг баримтыг хүчин төгөлдөр бичгээр өгсөн зөвшөөрөл гэж үзнэ. Ямар ч тамга, тэмдэггүй мөн факсаар дамжиж ирсэн материалыг шаардлага хангах үндэслэл бүхий зөвшөөрөл гэж үзэхгүй байхыг мэдэгдье. Эх хувиараа ирсэн албан бичгийн тамга тэмдгийн үнэн эсэх нь эргэлзээтэй байвал Гадаад Хэргийн Яамны тухайн консулын газраас лавлагаа авч болно.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Консулын дүрмийн нэгдүгээр бүлгийн 12-т "Консулын алба нь тогтоосон загвараар үйлдсэн тамга хэрэглэнэ" гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 41 дүгээр тогтоолын дагуу Гадаад хэргийн яамны консулын хэлтэс, хилийн чанадад байгаа консулын байгууллагуудын шинээр хийлгэсэн тамганы дардасыг та бүхэнд мэдээллээр хүргүүлсэн билээ.

Ажлын онцлог, шаардлагыг харгалзан тогтоосон загварт

англи хэлээр нэмэлт бичилт хийсэн бөгөөд Гадаад хэргийн яамны консулын хэлтэс, хилийн чанадад суугаа консулын байгууллагаас лавлагаа тодорхойлолт гаргаж өгөх, нотариатын үйлчилгээ, консулын баталгаа хийхэд тус тамгыг дарж баталгаажуулсан байх юм.

Гадаад хэргийн сайдын тушаалаар консулын тамга хэрэглэх заавар баталж, тамгыг Дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлсэн бөгөөд 2003 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглэж эхэлсэн.

- Гэрээ, хэлцэл, итгэмжлэл, гарын үсгээр хийхдээ байгаа бичиг баримтын эх хувийг холбогдох бусад материалын хамт өөртөө авч үлдэн архивт хадгалах шаардлагатай. Энэ нь тухайн асуудалтай холбоотой аливаа маргаан үүссэн тохиолдолд холбогдох байгууллагад нотлох баримтын шаардлагыг бүрэн дүүрэн агуулсан байх.

- Гадаадын иргэд оролцсон ямар нэг нотариатын үйлдэл гэрчлэхдээ юуны өмнө тухайн гэрчлүүлж байгаа бичиг баримтын монгол орчуулга заавал байх ёстойн зэрэгцээ Нотариатын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу орчуулагчийг заавал байлцуулах шаардлагатай юм. Орчуулагчийн бичиг баримтыг /орчуулагчийн үнэмлэх/ хавсаргаж авч үлдэх ёстой. Гадаадын хүмүүсийн орон нутгийн хаягийг заавал бичиж авах хэрэгтэй. Монгол дахь хаяг, мөн тухайн орон нутаг дахь хаягийг шаардаж аль алинийг нь авах. /Үндсэн харъяалал, гадны хаяг, Монгол дахь хаяг/

- Аливаа гэрээг гэрчлэхдээ түүний утга агуулга нь хуульд нийцэж буй эсхийг хамгийн түрүүнд анхаарах. Түрээсийн гэрээ, хөлслөх гэрээний ялгааг өөрсдөө сайтар ойлгож

үйлчлүүлэгчдэд энэ талаар тайлбарлан ялгавартай гэрчилж өгөх. Хэдийгээр энэ 2 гэрээний нотариатын үйлчилгээний хураамж ижил боловч зориулалтаараа өөр гэдгийг үйлчлүүлэгчдэд заавал тайлбарлан улмаар зөв маягт бөглүүлэн гэрчилж байх.

-Үл хөдлөх эд хөрөнгийн бүрдлийг гэрчлэхдээ бичиг баримтыг бүрэн бүрдүүлж гэрчлэхгүй ганц нэгээр буй салангид материалыг Үл хөдлөх эд хөрөнгийн бүрдэл гэж гэрчилж байгаа нь иргэдийг илт хохироосон зохисгүй зүйл бөгөөд үүнээс үүдэн сөрөг үр дагавар их гарч байна. Иймээс үл хөдлөх эд хөрөнгийн бүрдлийг гэрчлэхдээ "Үл хөдлөх эд хөрөнгийн тухай бичиг баримтыг нотариатч гэрчилсэн тэмдэглэл" маягтыг хэрэглэж бүрдэл хэлбэрээр зохих журмын дагуу гэрчилж занших шаардлагатай байна. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бичиг баримт гэрчлэх үйлдэл хийсэн тухай нотариатч уг тэмдэглэл маягтыг хөтлөн тэмдэглэлд хуулбарын баталгааны тэмдэг дарж, бусад материалд зөвхөн тамга дарж гарын үсгээ зурсан байхыг цаашид баримтлан ажиллах нь зүйтэй байна. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар иргэн үл хөдлөх эд хөрөнгөө бүртгүүлж гэрчилгээ авахын тулд мэдүүлж гаргах бөгөөд мэдүүлэгтээ дараах материалыг хавсаргах юм. Үүнд:

1. Тухайн этгээд уг үл хөдлөх эд хөрөнгөтэйг нотолсон баримт бичиг;

2. Газар өмчлөх эрхийг бүртгүүлэхэд тухайн газрын кадастрын зураг болон өмчилж авсан газрын үнийг сум, дүүргийн төсөвт төлсөн тухай баримт;

3. Тухайн газрыг уг этгээдэд өмчлүүлсэн тухай эрх

бүхий байгууллагын шийдвэр болон түүнээс олгосон гэрчилгээ;

4. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ болон гэрчилгээний хуулбар;

5. Барилга байгууламжийн план зураг, 4 талаас нь бүтэн харуулсан гэрэл зураг

6. Улсын тэмдэгтийн хураамж эсхүл үйлчилгээний хөлс төлсөн баримт;

7. Өмчлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

8. Бүртгүүлэхийг хүссэн этгээдийн өргөдөл зэрэг багтана.

Дээрхи материалуудыг нотариатч үл хөдлөх эд хөрөнгийн бүрдлээр гэрчлэх юм. Өмнө нь энэ бүрдэлд хөрөнгийн үнэлгээний компаниар үнэлүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, тайлан хавсаргадаг байсан. Шинээр батлагдсан хуулиар хөрөнгийн үнэлгээний тайланг хавсаргах шаардлагагүй болсон.

Иймээс дээрхи материалуудыг бүрэн гүйцэд байгаа эсэхийг нарийн нягт шалгасны үндсэн дээр нотариатын үйлчилгээг үзүүлэх шаардлагатай. Нөгөө талаар иргэдэд үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахад ямар материал бүрдүүлэх шаардлагатай талаар зөвлөгөө өгч ажиллах нь зүйтэй.

Үл хөдлөх эд хөрөнгөө бүртгүүлэхийг хүссэн иргэд, аж ахуйн нэгжийн өргөдөлд үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хэмжээ, зориулалт, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч иргэний овог, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, өмчлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр оршин байгаа газар, улсын бүртгэлийн дугаар, түүнийг төлөөлөх этгээдийн овог эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар,

тухайн үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээ, өмчлөх эрхийг бүртгүүлэх болсон үндэслэл, үл хөдлөх эд хөрөнгийн үнэ зэргийг тодорхой тусгуулах шаардлагатай.

Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бичиг баримт гэрчлэх үйлдлийн бүртгэлийг хөтлөхдөө :

■ Гэрчлүүлж буй үл хөдлөх эд хөрөнгийн төрөл, зориулалт;

■ Уг хөрөнгийг өмчлөгч нь иргэн бол овог, эцгийн нэр, нэр, иргэний үнэмлэх, регистрийн дугаар;

■ Хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар;

■ Улсын бүртгэлийн дугаар болон гэрчилгээний дугаар

■ Хаяг, байршлыг тэмдэглэнэ.

- Нотариатчид гэрчилж байгаа гэрээслэлээ сар бүр Нотариатчдын танхимд бүртгүүлж, энэхүү гэрээслэлийн бүртгэлийг ҮХЭХ-ийн бүртгэлийн газар сар бүр бүртгүүлэх ажлыг Нотариатчдын танхим хийгээд 3 жил болж байна. Иймээс нотариатчид сар бүр өөрийн гэрчилсэн гэрээслэлээ Танхимдаа бүртгүүлж байхыг мэдэгдье. Орон нутгийн нотариатчдын хувьд тухайн тойргийн салбарын дарга нар гэрээслэлийг нэгтгэн аймгийн Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлж байх нь зүйтэй.

- Хууль ёсоор өв залгамжлах эрхийн гэрчилгээг олгохдоо өвлүүлэгч нас барснаас хойш 1 жилийн дараа олгоно гэсэн хуулийн заалтыг баримталж байхыг анхааруулья. Иргэний хуулийн 531.3-т "Гэрчилгээ олгох тухай хүсэлт гаргасан буюу өвлөгдсөн эд хөрөнгийг авсан этгээдээс өөр өвлөгч байхгүй нь лавтай

баримтаар нотлогдвол гэрчилгээг нэг жилийн хугацаа өнгөрөхөөс өмнө олгож болно" гэсэн заалтыг баримтлан гэрчилгээ олгож болох боловч ингэхдээ уг гэрчилгээг олгохтой холбоотой бүхий л нотлох баримтыг бүрэн дүүрэн бүрдүүлж хожим энэ асуудалтай холбоотой маргаан гарвал өөрийн хийсэн үйлдлийг аль ч байгууллага, иргэдийн өмнө хамгаалж чадна гэсэн итгэлтэй байж хийх нь зүйтэй болов уу.

- Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ авахтай холбогдуулан бүрдүүлж байгаа материалууд /ҮХЭХ-ийн бүрдэл/ нь үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэхтэй холбоогүй учир дүүрэг хамаарахгүйгээр гэрчилж болно.

- Гэрээ гэрчлэхдээ гэрээний талуудаас гадна хамтран өмчлөгчдийн нэрсийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж гарын үсэг зуруулж байх. Гэрээний бүртгэлд хэн нь зээлдэгч, зээлдүүлэгч, бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийг тодорхой бичих. Мөн иргэний үнэмлэх болон холбогдох бичиг баримтыг хувиалан авч архивын материалдаа хавсаргаж байх.

- Нотариатч бүр өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох, гэрээслэл бичих нотариатын үйлдлийг хийхээс зайлсхийх явдал нэлээд байна. Нотариатч хүн Нотариатын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 11 дахь хэсэгт заасны дагуу 11 төрлийн үйлдлийг гэрчлэх ёстой бөгөөд дээрх үйлдлийг гэрчилдэггүйгээс иргэдийг чирэгдүүлж байгааг анхааруулж байна. Учир нь энэ талаар Нотариатчдын танхимд өргөдөл, гомдол сүүлийн үед их ирэх боллоо.

## ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН НЭР ТОМЪЁОНЫ ДАГАЛГА

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ю.ЭНХТҮВШИН

<p>Барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /агентлаг/</p>	<p>Государственное агентство по вопросам товарного знака и географического указания</p>	<p>State Agency on trademark and geographical indication</p>
<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны Өмчийн Газар</p>		
<p>Оюуны өмчийн газрын чиг үүрэг</p>	<p>Функция Ведомства интеллектуальной собственности</p>	<p>Functions of the Intellectual Property Office</p>
<p>Аж үйлдвэрийн өмчийн мэдүүлгийг хүлээн авч, хянан шийдвэрлэх, хуулиар харъяалуулсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, гэрчилгээний загварыг тогтоох, улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, тэдгээртэй холбоотой мэдээллийг хэвлэн нийтлэх ба хуулийн дагуу дээрхи мэдүүлгийг хүчингүй болгох үүрэг</p>		
<p>Барааны тэмдгээр бүртгүүлэх зүйл</p>	<p>Регистрируемый товарный знак</p>	<p>Registrable trademarks</p>
<p>Үг, дүрс, үсэг тоо, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр эсхүл тэдгээрийг хосолсон байдлаар илэрхийлэгдэх зүйл</p>		
<p>Барааны тэмдэгт тооцохгүй зүйл</p>	<p>Предмет, не считающий товарным знаком</p>	<p>Non-considerable trademarks</p>
<p>Нийтэд дэлгэрсэн нэр томъёо, дүрс, үл ялгагдах үсэг, тоо, тэмдэгт, бараа, үйлчилгээний үндсэн нэр, барааны тоо, хэмжээ, жин, чанар, зориулалт, үнэ, үйлдвэрлэсэн газрын нэр, арга, хугацаа зэргийг тайлбарласан үг дүрс, барааны гаднах хэв маяг, сав, баглаа боодлын ердийн хэлбэр, газрын зураг болон газрын зураг дээр заасан байрлал</p>		
<p>Барааны тэмдэгт бүртгэхгүй зүйл</p>	<p>Предмет, не регистрируемый товарным знаком</p>	<p>Non-registrable trademarks</p>
<p>Монгол Улсын болон гадаад улсын сүлд, далбаа, төрийн бэлгэдэл, төрийн болон төрийн бус, түүнчлэн олон улсын байгууллагын бүтэн ба товчилсон нэр, нэрд гарсан хүний бүтэн ба товчилсон нэр, хөрөг зураг, гарын үсэг, Монгол Улсын түүхэн хүмүүсийн нэр, хөрөг, зураг, Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр, болон төрийн одон медаль, бараа, үйлчилгээний чанар, чансаа, гарал үүсэл болон хэрэглэгчийг төөрөгдөлд оруулж болзошгүй, ижил төстэй тэмдэг</p>		

Барааны тэмдгийн мэдүүлэг гаргах	Подача заявки на товарный знак	Filing of trademark applications
<p>Барааны тэмдгийг бүртгүүлэх тухай хүсэлт, мэдүүлэг гаргагчийн овог нэр болон хуулийн этгээдийн хаяг, зохион байгуулалтын хэлбэр, мэдүүлэг гаргасан он, сар, өдөр, мэдүүлэг гаргагч итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бол түүний овог нэр, хаяг, мэдүүлэг гаргагч буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг, барааны тэмдгийн дүрс, барааны тэмдэг нь кирилл, латинаас өөр үсгээр илэрхийлэгдсэн бол тухайн тэмдгийн кирилл үсгээр галигласан хөрвүүлэг, гадаад үгээр илэрхийлсэн бол түүний орчуулгыг мэдүүлэгт тусгасан бүртгүүлэх хүсэлт</p>		
Мэдүүлгийн анхдагч огноог тогтоох	Установление приоритета заявки	Filing the registering data of applications
<p>Оюуны өмчийн газар мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж, шаардлага хангасан гэж үзвэл мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтоох хугацаа</p>		
Мэдүүлэгт шүүлт хийх	Проведение экспертизы в заявке	Examination of trademark applications
<p>Мэдүүлгийн анхдагч огноог тогтоосны дараа тухайн тэмдэг барааны тэмдэгт тооцогдох эсэх, бүртгэж болох эсэхэд Оюуны өмчийн шинжээчид хайлт хийх үйл ажиллагаа</p>		
Барааны тэмдгийг бүртгэх, гэрчилгээ олгох	Регистрация товарного знака и выдача свидетельства	Registration of trademarks, issue a certificate
<p>Оюуны өмчийн газар эзэмшигчийн овог, нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, барааны тэмдгийн дүрс, бараа, үйлчилгээний жагсаалт, мэдүүлгийн анхдагч огноо, гэрчилгээ хүчинтэй байх хугацааг зааж, барааны тэмдгийг бүртгэх шийдвэр гаргасныг нотлох үйл ажиллагаа</p>		
Барааны тэмдгийн хүчинтэй байх хугацаа, түүнийг сунгах	Срок действия товарного знака и его продление	Period of validity a trademark registration, renewal of registration
<p>Анхдагч огнооноос эхлэн 10 жилийн хугацаанд хүчинтэй байх, эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн хугацааг тухай бүр 10 жилээр сунгах барааны тэмдгийн бүргэлийн ажиллагаа</p>		
Барааны тэмдгийн хураамж	Пошлина регистрации товарного знака	Trademark registration fees
<p>Барааны тэмдгийн гэрчилгээ олгох, бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгахад төлөх тэмдэгтийн хураамжийн хуульд заасан хувь хэмжээ</p>		

Хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх, гэрчилгээ олгох	Проведение экспертизы заявки коллективного и сертификационного знаков и выдача свидетельства	Issue of certificate, and examination application on collective and a certification marks
Хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн мэдүүлэгт Оюуны өмчийн газраас хайлт хийх, бүртгэх, нотолж шийдвэр гаргах үйл ажиллагаа		
Газар зүйн заалт, түүнд тавих шаардлага	Географическое указание и требование к ним	Geographical indications and requirements related there to
Барааны гарал үүслийг тодорхойлсон тухайн газар нутгийн нэрийг газар зүйн заалтаар бүртгэх шаардлага		
Газар зүйн заалтыг бүртгэхгүй зүйл	Нерегистрируемый предмет географического указания	Non-registrable geographical indication
Монгол Улсад бүртгэгдсэн адил бараанд хэрэглэх газар зүйн заалт буюу барааны тэмдэгтэй ижил, буюу бүртгэгдсэн нэг төрлийн бараанд хэрэглэх газар зүйн заалт, барааны тэмдэгтэй ижил буюу төсөөтэйгээс хэрэглэгчийг төөрөгдөлд оруулж болзошгүй заалт		
Газар зүйн заалтын мэдүүлэг гаргах	Подача заявки географического указания	Filing of applications for geographical indications
Мэдүүлэг гаргагчийн овог, нэр, хаяг, харъяалал, байнга оршин суудаг буюу үйлдвэрлэл явуулдаг улсын нэр, мэдүүлэг гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, зохион байгуулалтын хэлбэр, мэдүүлэг гаргагч итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр хаяг, газар зүйн заалтын нэр, тухайн газар нутгийн газар зүйн байршил, барааны нэр, барааны онцлог шинж чанарын тодорхойлолт болон газар зүйн нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай хэрхэн холбогдсон тухай тайлбарыг тусгасан хүсэлт		
Газар зүйн заалтын мэдүүлэгт хавсаргах зүйл	Приложение к заявке географического указания	Enclosure of to the application for geographical indications
Тухайн газар нутагт үйлдвэрлэл эрхэлдгийг нотолсон аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын тодорхойлолт, мэдүүлгийг гадаадын иргэн, хуулийн этгээд гаргаж байгаа бол тухайн газар зүйн заалтыг уг бараа анх үүссэн, анх үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутагт хамгаалагдсныг нотолсон баримт, мэдүүлгийг дотоодын хуулийн этгээд гаргаж байгаа бол улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
Газар зүйн заалтыг бүртгэх, гэрчилгээ олгох	Регистрация географического указания и выдача свидетельства	Issue of certificate and registration of geographical indications
Газар зүйн заалтыг бүртгэх шийдвэр гарган түүнийг бүртгэж, газар зүйн заалт хэрэглэгчийн овог нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, газар зүйн заалтын нэр, онцлог шинж чанар, барааны нэр, мэдүүлгийн анхдагч огноог заасан бүртгэл хийж, гэрчилгээ олгох Оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагаа		

Барааны тэмдэг эзэмшигчийн эрх	Право обладателя товарного знака	Rights of trademark owners
Тухайн тэмдгийн хувьд бүртгэгдсэн тэмдгээ өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, лицензийн гэрээгээр бусдад ашиглуулах, эзэмшүүлэх, мөн бусад этгээд хууль бусаар тэмдгийг ашиглавал уг үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар шаардах эрх зүйн боломж		
Барааны тэмдгийг ашиглах	Применение товарного знака	Use of trademarks
Барааны тэмдгийг бараа түүний сав, баглаа боодол, үйлчилгээнд хэрэглэсэн, барааны тэмдэг бүхий барааг нийлүүлсэн, худалдаанд гаргасан, үйлчилгээ үзүүлсэн, барааны тэмдэг бүхий барааг хилээр нэвтрүүлсэн, барааны тэмдгийг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернет сурталчилгаанд хэрэглэгдэх үйлдэл		
Барааны тэмдэг эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, барааны тэмдэг эзэмших эрх дуусгавар болох	Передача права обладателя товарного знака к другому лицу, прекращение права обладателя товарного знака	Transfer of trademark owners rights to others and expiration of trademark rights
Өв залгамжлал болон бусад хэлбэрээр барааны тэмдэг эзэмших эрхээ бүх буюу зарим бараа, үйлчилгээний хувьд бусдад шилжүүлж болох ба уг эрхээ хууль буюу гэрээгээр бусдад бүрэн шилжүүлсэн, эзэмшигч нь нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан, хуулийн этгээд татан буугдсанаар дуусгавар болох эрх		
Лицензийн гэрээ	Лицензионный Договор	Licensing agreement
Барааны тэмдгийг бүх буюу зарим бараа, үйлчилгээний хувьд ашиглах талаар сонирхогч этгээд эзэмшигчтэй нь байгуулсан бөгөөд барааны тэмдгийг ашиглах хэлбэр, хүрээ, хугацаа, холбогдох бараа, үйлчилгээнд тавих чанарын шаардлага, хяналт, барааны тэмдэг ашигласны төлөө төлөх төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх хураамж, гэрээ, үйлчлэх нутаг дэвсгэрийн хүрээг тусгасан зөвшөөрлийн хэлцэл		
Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх	Право пользователя географического указания	Users Rights of geographical indications
Өөрийн бараанд газар зүйн заалтыг ашиглах, энэ талаар Оюуны өмчийн байгууллагаас лавлагаа, нотолгоо гаргуулж авах, түүнчилэн бүртгэгдсэн газар зүйн заалтыг бусад этгээд тухайн газар нутагт үйлдвэрлээгүй бараанд хэрэглэснээс барааны гарал үүслийн хувьд төөрөгдөлд оруулж болзошгүй бол уг үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсэн эрхээ хамгаалуулах, хохирлыг арилгуулахыг шаардах эрх		
Газар зүйн заалтыг ашиглах	Применение географического указания	Use of geographical indications
Бараа түүний сав, баглаа боодолд хэрэглэсэн, газар зүйн заалт бүхий барааг хилээр нэвтрүүлсэн, тухайн бараатай холбоотой үйл ажиллагаанд хэрэглэгдэх албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернет сурталчилгаанд ашиглах үйлдэл		

Газар зүйн заалтын бүртгэлийн хүчинтэй байх хугацаа дуусгавар болох	Действие срока регистрации географического указания и прекращение его	Validity of registration of geographical indications and expiration registration
Гагцхүү уг барааны онцлог шинж чанар нь тухайн газар зүйн нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай шууд холбоогүй болох тохиолдол		
Барааны тэмдгийн олон улсын бүртгэл	Международная регистрация товарного знака	International registration of trademarks
Монгол Улсад мэдүүлгийг шууд хүлээн авах, шүүлт хийх, бүртгэх журамтай нэгэн адил байх ба анхдагч огноог олон улсын бүртгэлийн огноогоор, эсхүл нутаг дэвсгэрийн хүрээг нэмэгдүүлэх тухай хүсэлтийн огноогоор тогтоосон бүртгэл		
Үндэсний тэмдгийг олон улсын бүртгэлд бүртгүүлэх	Зарегистрирование международной регистрации национальных знаков	Register of domestic trademarks to the International registration
Барааны тэмдгээ бүртгүүлсэн буюу бүртгүүлэхээр мэдүүлсэн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн Монгол Улсад үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг болон байнга оршин суудаг аливаа этгээд барааны тэмдгийн олон улсын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагаар дамжуулан Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Олон улсын товчоонд хүсэлт гаргах үйл явц		
Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох, хүчингүй болсонд тооцох	Аннулирование регистрации товарного знака и географического указания, считать недействительными	Invalidity and cancellation of registration of trademarks and geographical indications
Барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор хугацаа сунгуулах тухай хүсэлт гаргаагүй, барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч нь бүртгэгдсэн барааны тэмдгийг эзэмших, газар зүйн заалтыг хэрэглэх эрхээсээ татгалзсан тухай бичгээр мэдэгдсэн, мөн татан буугдсан бөгөөд эрхээ буюу лицензийн гэрээгээр бусдад шилжүүлээгүй ба ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр барааны тэмдгийг 5 жилийн турш ашиглаагүй бол барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг Оюуны өмчийн байгууллага хүчингүйд тооцож шийдвэр гаргах үйл ажиллагаа		
Гомдол маргааныг шийдвэрлэх	Решение апелляции и споров	Consideration of appeals and disputes
Барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбогдсон, анхдагч ба давамгайлах огноо тогтоохтой холбогдсон, тэдгээрийн улсын бүртгэлтэй холбогдсон гомдол маргааныг шийдвэрлэх Оюуны өмчийн байгууллага, шүүхийн үйл ажиллагаа		

<p>Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</p>	<p>Принятие мер к ответственности нарушителя законодательства товарного знака и географического указания</p>	<p>Liability for Beach of legislation on trademark and geographical indications</p>
<p>Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Оюуны өмчийн хяналтын улсын байцаагч зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийг торгох, барааны тэмдэг, газар зүйн заалтыг хууль бусаар ашигласнаас олсон орлогыг барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчид олгох буюу барааг худалдсанаас олох орлогыг улсын орлого болгож, үйлдвэрлэл, үйлчилгээг нь зогсоох үйл ажиллагаа</p>		
<p>Патент олгох зүйл, шалгуур</p>	<p>Объекты изобретения и их критерии</p>	<p>Objects of Inventions and its patentability</p>
<p>Шинэ бүтээлийн түвшин агуулсан тухайн мэргэжлийн хүнд ялгагдах давуу шинж чанартай, үйлдвэрлэлд ашиглах боломжтой, цоо шинэ үйлдвэрлэх арга ажиллагаа, бүтээгдэхүүн, шинэ бүтээл</p>		
<p>Шинэ бүтээлд тооцохгүй зүйл</p>	<p>Непатентуемые объекты</p>	<p>Non- patentabilities</p>
<p>Нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга, цахим тооцоолуурын хөтөлбөр, алгоритм, аж ахуйн үйл ажиллагаа, оюуны үйлдэл, тоглоом зэрэгт хамаарах хуваарь, дүрэм, аргачлал, нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл, хүн, мал амьтны эмчилгээ, оношлогооны арга, бичил биетээс өөр амьтан, ургамал, болон тэдгээрийг гаргаж авах биологийн арга</p>		
<p>Оюуны өмчийн газар</p>	<p>Ведомство интеллектуальной собственности</p>	<p>Intellectual Property Office</p>
<p>Монгол Улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг</p>		

...oOo...





## Чой.Лувсанжавын нэрэмжит Хэл Иргэншлийн дээд сургууль



Чой.Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн дээд сургууль Монголын утга зохиолын үнэт өв болсон монгол бичгээр тулгуур хийж, монгол судлалын суурь мэдлэгийг эзэмшүүлж, англи, япон хэл, соёл судлалыг хослуулан сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлдэг.

Тус сургууль Та бүхний хүссэн дизайн, хэлбэрээр лого болон зар сурталчилгааг монгол бичгээр чанартай хийж байна.

**БАЙРШИЛ:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

7 дугаар хороо, 11 дүгээр хороолол

 **353524, 353525, 350162**

E-mail: Soyombo\_L@chinggis.com